Гүйцэтгэгч учирч болзошгүй аваар ослын хариуцлагыг хүлээх ба тэдгээрээс үүдэн гарах аливаа заргаас Захиалагчийн эрх ашгийг хамгаалж, нөхөн төлбөрийг олгуулна. Хүн, амьтан, ажил, эд хөрөнгө, газар, объектууд гэмтэх, эвдрэх, таагүй байдал үүсэх буюу аваар осолд өртөх магадлалтай байвал Инженер тэсрэх бодис хэрэглэх асуудлыг зохицуулах, хориглох эрхтэй бөгөөд ингэсэн тохиолдолд Гүйцэтгэгч нь Захиалагчийн эсрэг ямар нэг зарга үүсгэхгүй. Гүйцэтгэгч тэсэлгээ хийхээр төлөвлөх бүртээ урьдчилан анхааруулга өгөх ба аюултай бүсэд хүн, амьтан орж ирэх, хөдөлгөөн явахаас сэргийлж, зам дээр болон өөр шаардлагатай газарт туг, бүрээ, шүгэл бүхий хүнийг зогсоож ажиллуулна. Гүйцэтгэгч тэсэлгээ хийхдээ гол замын орчимд зөвшөөрөгдөх зайны дотор хөдөлгөөнийг орон нутгийн цагдаагийн болон Замын Цагдаагийн байгууллагатай хамтран хянаж зохицуулна. Гүйцэтгэгчийн тэсэлгээний ажил хариуцсан хяналтын инженер нь Монгол улсын эрх бүхий байгууллагаас олгосон, шаардлагатай бүх төрлийн тэсэлгээг хийх эрхийн лицензтэй байх ба тэрхүү лицензийг Инженерт танилцуулж баталгаажуулна.

Гүйцэтгэгч нь Инженерийн болон Монгол улсад мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангахуйц баригдсан, тохиромжтой газарт байрлах агуулахад тэсрэх бодисыг хадгална. Тухайн газарт “Тэсрэх аюултай” гэсэн тод хараар бичсэн тэмдгийг байрлуулна.

Гүйцэтгэгч бүх урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авч, тэсрэх бодистой хэрхэн харьцах, хэрэглэх тухай мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмыг дагаж мөрдөх ба тэсэлгээ хийх үед дагаж мөрдөх аргачлалыг тайлбарлан бичсэн самбарыг Инженерийн шаардлагад нийцүүлэн бэлтгэж, талбайд байрлуулна.

Гүйцэтгэгч нь, шаардлагатай төвшинөөс илүү ухагдах, газарт ан цав үүсэх, нурах зэргээс сэргийлж, тэсэлгээ хийх нүхний тоо, байршил, чиглэл, гүн, хоорондын зай, нэг нүхэнд хэрэглэх тэсрэх бодисын хэмжээ, төрөл болон тэсэлгээ хоорондын тасалдлын тоо, давтамж зэргийг сонгоно. Тэсэлгээ хийж, сул материалыг зайлуулсны дараа гадаргууг тэгш үлдээх зорилгоор сүүлийн нүхнүүдийг ухалт хийх эцсийн төвшинөөс шаардагдах хэмжээгээр дутуу

ухна.

Чухал ач холбогдол бүхий байгууламжийг хамгаалах үүднээс тэсэлгээ хийхийг хориглосон газарт болон авто зам, төмөр зам, өндөр хүчдэлийн болон холбооны шугам зэргээс 400 м-ээс дотогш зайнд тэсэлгээ хийх бол Гүйцэтгэгч нь:

- a) Холбогдох байгууллагад тэдний эзэмшлийн газрын хүрээнд тэсэлгээ хийх гэж байгаа тухайгаа мэдэгдэж, тухайн байгууллагын төлөөлөгчийг байлцуулах зэргээр тэдгээрийн зүгээс тавьж буй шаардлагыг хангаж чадна гэдгээ баталгаажуулна,
- b) Инженер ба холбогдох байгууллагын зөвшөөрөлтэйгээр, тэсэлгээнээс шидэгдэх шороо чулуунаас шалтгаалж тэдгээр байгууламжид гэмтэл үүсгэхээс сэргийлэх үүднээс тэсэлгээ хийх газрыг бүтээх буюу зөвшөөрөгдсөн бусад аргаар хамгаалах,
- c) Тасалдалттай тэсэлгээ хийх байдлаар, эсвэл тэсэлгээнд хэрэглэх цэнэгийн хэмжээг хязгаарлах замаар аливаа байшин, барилга, байгууламжууд руу цацагдах чулуу шорооны шидэгдэлтийн хурдыг аль болох бага байлгах аргаар хянаж, зохицуулна,
- d) Тохиромжтой доржилт хэмжигчийг талбайд байлгах ба Инженерийн хүсэлтээр хэрэглэхээр төлөвлөж буй цэнэг нь энэхүү техникийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг багаж ашиглан үзүүлнэ.

Эдгээр хязгаарлалтыг Гүйцэтгэгчээс хэрэгжүүлж байгаа байдал болон Инженерийн өгсөн аливаа зөвшөөрлийн аль нь ч тэсрэх бодис хэрэглэснээс шалтгаалан байшин, барилга байгууламжуудад учирсан хохирлын хувьд Гүйцэтгэгчийн хүлээх үүрэг, хариуцлагаас чөлөөлөхгүй. Дээр дурдсаныг үл харгалзан, Инженер хүссэн тохиолдолд Гүйцэтгэгч, тэсэлгээ хийхээ зогсоож, бусад зөвшөөрөгдсөн аргуудыг хэрэглэн хадны ухалтыг үргэлжлүүлэн хийнэ.

Тэсэлгээний галыг цахилгаанаар асаах бол цагаасаа өмнө тэсрэлт явагдахаас сэргийлэн урьдчилсан арга хэмжээг авна. Хэрвээ цахилгаан дамжуулах шугамын ойролцоо тэсэлгээ хийх бол цэнэгийг байрлуулахаас өмнө эрх бүхий хяналтын байцаагч тэсэлгээ хийх талбайд ямар нэг сул цахилгаан гүйдэл байгаа эсэхийг шалгана.

Эрх бүхий хяналтын байцаагч ба нэг мэргэжсэн туслах ажилчин хоёроос бусад бүх хүмүүс галын кабель утсыг цахилгааны утсанд залгахаас өмнө аюулгүй газарт очно. Галын кабель утсыг цэнэглэгчид залгах нь хамгийн сүүлийн ажил байна. Тэсэлгээ хийх газрын эргэн тойронд дуу цахилгаантай бороо орж, аянгатай байвал галын утсыг цэнэглэхийг үл зөвшөөрнө.

Тэсэлгээ хийсний дараа эрх бүхий хяналтын байцаагч буюу бусад хариуцсан хүн тухайн газрыг шалгах, мөн цэнэг баарч тэсэлгээ хийгдээгүй бол урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авахаас нааш аюултай бүс рүү ямар ч хүнийг оруулахгүй.

Гүйцэтгэгч, тэсэлгээ бүрийн тэсэлгээ хийх цаг, байршил, хэрэглэсэн тэсрэх бодисын төрөл, тэсэлгээний ажилд хэрэглэсэн бусад хэрэгслүүдийн хэмжээ, үлдэгдэл болон бусад холбогдох мэдээллийг агуулсан тэсэлгээний ажлын бүртгэл, тэмдэглэлийг нягт нямбай хөтлөх ба сар бүр тайлангаа Инженерт танилцуулна. Өмнөх долоо хоногийн ажилтай холбогдуулан эдгээр бүртгэл тэмдэглэлийн хувийг долоо хоног бүр Инженерт хүргүүлнэ.

Гүйцэтгэгч ажлынхаа төсөвт бүх тэсрэх бодисыг хангах, тээвэрлэх, хадгалах, тэдгээртэй харьцах, ухалт хийх, хяналт тавих болон энэхүү техникийн шаардлагын нөхцөлүүдийг дагаж мөрдөхтэй холбоотой зардлыг оруулан, гэхдээ эдгээрээр хязгаарлагдахгүйгээр, тооцсон гэж үзнэ.

118. ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖ, ШУГАМ СҮЛЖЭЭГ ХАМГААЛАХ

Гүйцэтгэгч, газар доор буюу дээр хийгдсэн аливаа Инженерийн байгууламж, шугам сүлжээг (цаашид Инженерийн байгууламж гэх) эвдэж гэмтээсэн тохиолдолд хариуцлагыг

хүлээж, Захиалагчийн эсрэг гарсан аливаа зарга болон хохирлыг барагдуулна. Гэмтэлд өртсөн бүх Инженерийн байгууламжийг нөхөн сэргээх ажлыг өөрийн зардлаар хийж гүйцэтгэх хариуцлагыг хүлээнэ.

Хуучин Инженерийн байгууламжийн ойр орчмын газарт ухалтын ажил эхлэхээс өмнө болон энэ ажил нь Инженерийн байгууламжуудад нөлөөлөхүйц шинжтэй байвал, Гүйцэтгэгч, тэдгээр Инженерийн байгууламжуудыг эзэмшигч буюу тэдгээрийг ажиллуулж буй холбогдох байгууллагуудад мэдэгдэж, Инженерийн заавраар, ажлаа үргэлжлүүлэхээс өмнө, тэдгээр байгууламжийг хэрхэн хамгаалах, сэргээн засварлахаар төлөвлөсөн өөрийн ажлын төлөвлөгөөгөө холбогдох байгууллагуудад танилцуулж зөвшөөрөл авна.

Гүйцэтгэгч, дараах бүх Инженерийн байгууламжийн, гэхдээ зөвхөн тэдгээрээр хязгаарлагдахгүйгээр, байршил болон холбогдох эд ангиудыг нарийвчлан тогтоох үүрэгтэй. Үүнд:

- цахилгаан, холбоо, гэрэлтүүлгийн кабель шугам, шилэн кабель,
- өндөр хүчдэлийн цамхгийн шон, кабелийн суваг хоолой,
- ус дамжуулах шугам,
дулаан дамжуулах шугам.

Тэдгээр Инженерийн байгууламжууд, шугам сүлжээг булж далдалсан байвал, Гүйцэтгэгч эзэмшигч байгууллагуудаас нь тэдгээрийн байршил, булсан гүн зэргийн талаарх мэдээллийг авна. Гүйцэтгэгч, цахилгаан ба цахилгаан соронзон багажийн аль тохирохыг ашиглан гараар туршилтын нүх болон шуудуу ухах зэрэг аргаар цааш хайгуул хийнэ. Ил гарсан Инженерийн байгууламж, шугам сүлжээг хэрхэх асуудлыг Инженер ба холбогдох байгууллагуудтай зөвлөлдөж, шийдвэрлэнэ. Эрсдэлтэй байж болох Инженерийн байгууламжуудыг бүрэн ил гаргах ба гарсан ухмалыг нурахаас хамгаална. Ил гарсан шугам сүлжээг барилгын ажил эхлэхээс өмнө газар дээр нь сайтар хамгаална. Ажилтай залгаа суурилуулсан аливаа байгууламжийг ажил дуусах хүртэл газар дээр нь аюулгүй байлгах ба дараа нь аюулгүй, тогтвортой байдалд нь буцааж суурилуулна.

Барилгын ажил дууссаны дараа шугам, хоолой, кабель шугамыг шороогоор булаах, дүүргэлт хийж нягтруулна. Ухмал, буцаан дүүргэлт, дахин суурилуулах (шаардлагатай үед) зэрэг ажлыг зохих дүрэм, журмын дагуу эзэмшигч байгууллагуудын зааварчилга, хяналтын дор хийж гүйцэтгэнэ. Ажлын шаардлагын дагуу хийсэн ухалтаас шалтгаалан замын гадаргуугийн эцсийн төвшинг өөрчлөх бол, тэдгээр хаалтын таг, худаг, үзлэгийн худгийн тагуудын төвшин ба тэдгээрийн амсрыг Инженерийн тавьсан шаардлагад нийцүүлэн тохирох байдлаар өөрчилнө.

Гүйцэтгэгч, зурагт үзүүлээгүй хэдий ч талбайгаас илрүүлсэн Инженерийн байгууламж, шугам сүлжээний талаар Инженерт яаралтай мэдэгдэнэ. Хэрвээ, Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үүдэн Инженерийн байгууламжид хохирол учирч магадгүй байвал, Инженерийн зүгээс эдгээр хохирлоос урьдчилан сэргийлэх үүднээс засварлаж болох аливаа арга хэмжээг Гүйцэтгэгч авна.

Өндөр хүчдэлийн цахилгааны шугам нь кран болон бусад овор ихтэй техник хэрэгслийн эд ангиар дамжин газарт “богино холбоо үүсгэх” аюултай тул Гүйцэтгэгч нь цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугамын ойролцоо ажиллаж буй бүх хүмүүст аюулгүй зайг баримтлан ажиллах тухай таниулж, зааварчилга өгсөн байна. (Хүснэгт 1-1, 1-2)-т өндөр хүчдэлийн дамжуулах шугам ба нам хүчдэлийн түгээх шугамуудын хувьд баримтлах аюулгүй зайг санал болголоо. Эдгээр саналуудыг үл харгалзан, Гүйцэтгэгч, тэдгээрийн үйл ажиллагааг хариуцсан холбогдох мэргэжлийн байгууллагуудтай зөвлөлдөн, төрөл бүрийн хүчдэлийн

цахилгаан дамжуулах шугамаас гадагш баримтлах аюулгүй зайг өөртөө зориулан тогтооно.

Аливаа урьдчилан сэргийлэх арга хэмжээний болон цахилгааны шугамд ажил ойрхон байгаагаас шалтгаалан зайлшгүй хийгдэх ажлын зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

Хүснэгт 1-1: Өндөр хүчдэл дамжуулах шугамаас дооших, санал болгож буй цэвэр зай

Цахилгаан дамжуулах шугамын хүчдэл, кВ	Зай, м
138	7.8
230	8.4
345	9.4
500	10.0

Хүснэгт 1-2: Нам хүчдэлийн түгээх шугамаас дооших, санал болгож буй зай

Цахилгаан дамжуулах шугамын хүчдэл, кВ	Зай, м
0 - 750	1
750 - 38,000	1
38,000 - 86,000	1.5

Гүйцэтгэгч нь дээрх шаардлагуудыг үл харгалзан, гэхдээ, өөрийнхөө үүрэг, хариуцлагыг бууруулахгүйгээр, аливаа ажил, Инженерийн байгууламжууд ил гарсан, тэдгээрийг илрүүлсэн буюу гэмтээсэн тохиолдолд, Инженерт яаралтай мэдэгдэнэ.

Ажлын төлөвлөгөөг боловсруулах, зохицуулах болон хэрэгжүүлэхтэй уялдан, аливаа Инженерийн байгууламжид хийгдэх өөрчлөлтийн бүх зардлуудыг Гүйцэтгэгч хариуцна.

119. ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖИЙГ ШИЛЖҮҮЛЭХ

Зураг дээр үзүүлсэн Инженерийн байгууламжийн байршил, эд ангиудыг үл харгалзан, өгсөн мэдээллийг баталгаажуулах, нарийвчлан тогтоохын тулд Гүйцэтгэгч, нэмэлт хайгуул судалгаа хийнэ.

Гэрээний нөхцөлд болон энэхүү техникийн шаардлагын зүйл (104)-ийн шаардлагуудын дагуу ажлын хөтөлбөрөө боловсруулж байх явцдаа, Гүйцэтгэгч техникийн шаардлагын зүйл (120)-д тодорхойлсны дагуу ажлын талбайд ба эргэн тойронд байгаа Инженерийн байгууламжийг илрүүлэх, байршлыг тогтоох, хамгаалах, шилжүүлэх болон холбогдох байгууллагуудад мэдэгдэх шаардлагатай хугацааг тооцож үзсэн байна. Гүйцэтгэгч, аливаа Инженерийн байгууламжийг шилжүүлэх буюу өөрчлөх, шаардлага гарсан тохиолдолд холбогдох байгууллагуудтай холбоо, харилцаатай ажиллах хариуцлагыг хүлээнэ. Хэрвээ Гүйцэтгэгч, Захиалагчаар дамжуулан Засгийн газрын дэмжлэг тусалцаа авах бол, энэ асуудалтай холбогдсон шаардлагуудыг Инженерт мэдэгдэнэ.

120. ЗАХИАЛАГЧТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ

Хөдөлгөөний хяналт болон ажлыг гүйцэтгэхтэй холбогдсон бусад асуудлуудын талаар орон нутаг, төмөр зам, цагдаагийн болон Захиалагчийн холбогдох албаны хүмүүстэй харилцан зөвшилцөж ажиллана.

121. ГАЗАР АВАХ

Зураг төсөл, энэ техникийн шаардлагад заасны дагуу орон нутгийн засаг захиргаа, байнгын ажил явагдах газар нутгийг Гүйцэтгэгчид ямар ч үнэ төлбөргүй олгоно. Энэ нь барилгын ажилд ашиглагдах машин тоног төхөөрөмжүүд ажиллахад шаардагдах боломжийн хэмжээний зайг тооцож оруулсан барилгын ажил явагдах бодит газраар хязгаарлагдана. Энэ техникийн шаардлагын зүйл (602)-г заасан шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах талбай, орд газар, тэдгээрт хүрэх зам, замын зурвасын гаднах түр зам, талбайн лаборатори, Инженерийн ажлын болон орон сууц, хяналтын байр, Гүйцэтгэгчийн түр суурин, ажлын байр, агуулах, засварын газар, орон сууц, түр барилга болон бусад зорилгод ашиглах бүх газрын зөвшөөрөл авах асуудлуудыг Захиалагч хариуцна.

Талбайн лаборатори, Инженерийн ажлын болон сууцны байр, хяналтын байр зэргийг барихаар Гүйцэтгэгчийн зүгээс хангах газрын байршил, тэдгээрийн бүдүүвчийг харуулсан талбайн төлөвлөгөөг Инженерт танилцуулж зөвшөөрөл авна. Захиалагч өөрийн үүрэг хариуцлагаа биелүүлэх үүднээс Гэрээний хэрэгжилтийн явцад газар авах шаардлагатай бол Гүйцэтгэгч газар эзэмшигчийг тогтоож, Инженерийн заавраар хариуцсан холбогдох байгууллагуудын үнэлсний дагуу газрын болон түрээсийн төлбөр, ажлын шаардлагаар ямар нэг байгууламж, эд хөрөнгийг буулгах, шилжүүлэх буюу байгаа газрыг шилжүүлэх зэрэгт олгох нөхөн төлбөрийг төлнө. Үүнтэй холбоотой Гүйцэтгэгчийн хүлээх хариуцлагыг энэ техникийн шаардлагын зүйл 603-д тодорхой тайлбарласан байгаа. Хэдийгээр Гүйцэтгэгч эхний үед газар худалдаж авах төлбөрийг төлж болох боловч тэдгээр бүх газрууд нь Захиалагчийн өмч байна. Хэрвээ Гүйцэтгэгч, Захиалагчаар дамжуулан Засгийн газрын дэмжлэг тусалцаа авах бол 28-аас доошгүй хоногийн өмнө энэ асуудалтай холбогдсон шаардлагуудыг Инженерт урьдчилан мэдэгдэнэ.

Шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах талбай, орд газар, тэдгээрт хүрэх зам, замын зурвасын гаднах түр зам, талбайн лаборатори, Инженерийн ажлын болон орон сууц, хяналтын байр, Гүйцэтгэгчийн өөрийн түр суурин, ажлын байр, агуулах, засварын газар, орон сууц, түр ажил болон бусад зорилгоор ашиглахад шаардагдах бүх газрын хувьд Гүйцэтгэгч холбогдох хөрөнгө эзэмшигчидтэй хамтран шаардлагатай бүх зохион байгуулалтыг хийж, орон нутгийн хууль тогтоомжийн дагуу тэдгээртэй уялдаж гарах төлбөрүүдийг төлнө.

Ажлыг хэрэгжүүлж дуусгах үед болон хэрэгжсэний дараа ба Инженерийн зүгээс зааварчилгаа өгсний дагуу, Инженер бодитой бөгөөд боломжтой гэж үзсэн тохиолдолд, Гүйцэтгэгч нь Инженерийн шаардлагыг хангасан хэмжээнд бүх газруудыг ашиглалтын өмнөх байдалд нь эргүүлэн оруулна.

Гүйцэтгэгч ямар нэг зорилгоор газрыг худалдаж авах хүсэлт гаргаад, дараа нь тэр газар ашиглагдахгүй бол нөхөн төлбөр, худалдан авах болон уг газрыг дахин эзэмшүүлэх зэрэгтэй холбоотой бүх зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

122. УСАН ХАНГАМЖ

Гүйцэтгэгч, барилгын ажил болон бүх байшин, сууц, ажлын байр, талбайн лаборатори, хяналтын байр, агуулах, засварын газар ба ажилчдын байрны хэрэгцээнд зориулан хангалттай хэмжээний цэвэр усаар тогтмол хангана. Тэрээр усны шугам хоолой, орон нутгийн усны гол шугамд холбох, тоолуур, насос, усны саваар хангах, шаардлагатай газарт усыг зөөвөрлөх, ус ашигласны төлбөр, зардлыг төлөх, ажил дуусахад усан хангамжийн холбогдолтой

байгууламжийг зохих байдлаар нь буулгах зэрэг бүх арга хэмжээг авна.

Гүйцэтгэгч орон нутагт хэрэгжиж буй хууль тогтоомжийн дагуу байгалийн усны нөөцийг ашиглаж болох ба энэхүү нөөцийг ашиглаж буй бусад хэрэглэгчидтэй хийсэн маргааны улмаас ямар нэг зарга үүссэн тохиолдолд Гүйцэтгэгч өөрөө зохицуулна. Гадаргын усны байгалийн нөөц байхгүй буюу ямар нэг шалтгааны улмаас хангалтгүй байвал, Гүйцэтгэгч орон нутгийн хууль тогтоомжийн дагуу өөрийн зардлаар газрын гүний эх үүсвэрээс худаг гаргаж ашиглах ажлыг зохион байгуулна.

Ус нь ажилд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй, ямар нэг хөвөгч хатуу биет, бодисыг агуулаагүй, цэвэр байна. Барилгын ажил болон бүх байшин, сууц, ажлын байр, талбайн лаборатори, хяналтын байр, агуулах, засварын газар ба ажилчдын байрны хэрэгцээнд зориулан барилгын талбайд хангах ус нь Инженерийн болон нийтийн эрүүл мэндийн асуудал хариуцсан холбогдох байгууллагын шаардлагыг хангасан, унданд хэрэглэх боломжтой, чанартай ус байна. Ундны усны чанарыг Байгаль орчны яамнаас (БОЯ) /хуучин нэрээр/ боловсруулсан усны чанарын үзүүлэлтүүдийн дагуу хянана.

123. МАТЕРИАЛ БА ХИЙЦ ХЭСГҮҮД

Ажилд хэрэглэгдэх материалууд нь энэхүү техникийн шаардлагын нөхцөлүүдийг хангана. Хэрвээ Гүйцэтгэгч өөр хувилбар техникийн шаардлагын дагуу ижил буюу илүү өндөр стандартын материал хангахыг илүүд үзвэл, санал болгож буй хувилбарыг техникийн шаардлагын хуулбар хувь болон санал болгосон материалын техникийн иж бүрэн шаардлагын хамт Инженерт хүргүүлнэ.

Эдгээр материалуудыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар Инженерийн зөвшөөрсөн лабораторид шинжилж, баталгаажуулна. Гэрээнд өөрөөр заагаагүй бол, ажилд хэрэглэх бүх бараа, материал, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, үйлчилгээ зэргийг Гүйцэтгэгч хангана. Энэхүү техникийн шаардлагын дагуу ажилд хэрэглэх материалыг олох, нөөцийг тогтоох, хангах, тээвэрлэх, хадгалах зэрэг ажлыг Гүйцэтгэгч дангаараа хариуцна.

Ажилд хэрэглэх ямар нэг материал, хийц хэсгүүдийн захиалгыг өгөхөөс өмнө Гүйцэтгэгч, тэдгээр материал, хийц хэсгүүдийг авахаар төлөвлөж буй пүүс компанийн нэр, тэдгээрийн эх үүсвэр, бүтээгдэхүүний талаарх үйлдвэрлэгчийн тодорхойлолт, тэдгээрийн чанар, жин, бат бэх болон бусад холбогдох мэдээллийг Инженерт танилцуулна. Гүйцэтгэгч нь үйлдвэрлэгчийн тэдгээр материал болон хийц хэсгүүдийн дээжийг мөн шаардлагатай бол адил төстэй материал, хийцийн дээжүүдэд хийсэн сүүлийн шинжилгээний сертификатуудыг Инженерт танилцуулна.

Инженер шаардсан тохиолдолд ажилтай холбоотойгоор бүх шаардагдах материал, хийц хэсгүүдийн үнийн санал болон захиалгын хувийг Гүйцэтгэгч түүнд танилцуулна.

Хэрвээ байнгын ажилд ашиглахаар төлөвлөсөн буюу эсвэл аль хэдийн ашиглагдаж буй бараа, материал нь холбогдох техникийн шаардлагыг хангахгүй байна гэж Инженер үзвэл, тэдгээр бараа материалыг хэрэглэхийг хэдийд ч хүчингүй болгох эрхтэй бөгөөд зөвшөөрөгдөх чанар бүхий бараа материалаар солих зааварчилгаа өгнө. Үүний үр дүнд гарах нэмэлт зардал болон чанаргүй хийгдсэн ажлын зардлыг, солих шаардлагатай бараа материал авах бүх зардлын хамт Гүйцэтгэгч гаргана.

124. ЦОНОГ БА ШИНЖИЛГЭЭНИЙ НҮХНЭЭС АВСАН МАТЕРИАЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Инженерийн бэлтгэсэн материалын тайланг оролцуулаад, Инженерийн зүгээс тендерт

оролцогчдод зориулж гаргасан ямар нэг мэдээллийг Гэрээний бүрдэл хэсэг гэж үзэхгүй. Ажлын талбайд Инженерийн оролцоотойгоор ухсан цооног, шинжилгээний нүх болон бусад судалгааны мэдээлэлд үндэслэн өөртөө гаргасан аливаа дүгнэлтийнхээ хариуцлагыг Гүйцэтгэгч дангаараа хүлээнэ.

Талбайд ухмалын ажил эхэлж, цаашид үргэлжлэх явцад тодорхой болох мэдээлэл дээр үндэслэн, газрын төвшнөөс дооших газар шорооны ажлын болон суурийн төвшинг Инженер тааруулан өөрчилж болно.

Гэрээний нөхцөлд тодорхойлсны дагуу Гүйцэтгэгч ажлын талбайг хянах, шалгах үүрэгтэй.

125. МАТЕРИАЛ, ХИЙЦ ХЭСГҮҮДИЙГ ХАДГАЛАХ

Бүх материал, хийц хэсгүүдийг техникийн шаардлагад нийцэх байдлаар ажлын талбайд хадгална. Гүйцэтгэгч бүх ажил, материал болон хийц хэсгүүдийг цаг агаар, үер ус болон бусад гаднын нөлөөнд өртөхөөргүй байдлаар хадгалж, хамгаална.

126. ШИНЖИЛГЭЭНИЙ СЕРТИФИКАТ

Энэхүү техникийн шаардлагын дагуу буюу эсвэл Инженерийн зааварласны дагуу, Гүйцэтгэгч нь ажилд хэрэглэх материал ба хийц хэсгүүдийг үйлдвэрлэгчийн шинжилгээний сертификатуудтай хамт түүнд танилцуулна. Тэдгээр шинжилгээний сертификатууд нь материал ба хийц хэсгүүд энэ техникийн шаардлагын дагуу шинжлэгдсэн гэдгийг батлах бөгөөд хийгдсэн бүх шинжилгээний хариуг багтаасан байна. Гүйцэтгэгч, талбайд хүргэгдсэн материал ба хийц хэсгүүдийг ялгах хангалттай аргуудыг зохих шинжилгээний сертификатуудын хамт хангана.

127. ГЭРЭЛ ЗУРАГ

Энэхүү техникийн шаардлагын дагуу Гүйцэтгэгчийн хангасан зургийн аппаратаар Инженер барилгын ажлын явцын зургийг авна.

128. ЗАМЫН МЭДЭЭЛЛИЙН САМБАР

Гүйцэтгэгч зурагт үзүүлсэн, эсвэл Инженерийн зааварласан ширхэг, дизайн, өнгө, хэмжээгээр замын мэдээллийн самбарыг хийж, суурилуулан, арчилж хамгаална. Инженерийн зааварласан цэгүүдэд замын самбаруудыг суурилуулна.

Замын мэдээллийн самбаруудыг Гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичиг олгосноос хойш 56 хоногийн дотор суурилуулсан байна. Гүйцэтгэгч тэдгээр замын самбарыг баталгаат засварын хугацаа дуусах үед буцааж авна.

129. ТАЛБАЙН ЕРӨНХИЙ БАЙГУУЛАМЖУУД

Захиалагчтай байгуулсан Гэрээний нөхцөлүүдээр зохицуулна.

130. ТАЛБАЙН ЛАБОРАТОРИ, ХЯНАЛТЫН ИНЖЕНЕРИЙН БАЙР СУУЦ БА АЖЛЫН БАЙРЫГ ХАНГАХ ХУГАЦАА

Гэрээний дагуу хангагдах бүх байр сууц, ажлын байр, талбайн лабораториудыг бэлэн ашиглаж болохуйц байдалтайгаар гэрээний нөхцөлүүдийн дагуу Инженер ажил эхлэх зөвшөөрөл олгосноос хойш 30 хоногийн дотор Инженерт хүлээлгэн өгнө.

Инженерийн ажлын байр, сууц, талбайн лабораторийн барилгын гадуур 0,25 гектараас багагүй талбайтай, хашаа барьж хамгаална. Хашааны хаалга нь дотор талаас онгойлгодог

цоожтой байна.

Инженерийн ажлын байр, талбайн лабораторийг бүрэн ашиглалтад оруулж, бэлэн болгон, зохих хэмжээнд ажиллах боломжтой гэж Инженерийн зүгээс зөвшөөрөл олготол барилгын ажил эхлэхийг үл зөвшөөрнө.

Хэрвээ Гүйцэтгэгч, тогтоосон хугацаанд байр сууц эсвэл ажлын байр эсвэл талбайн лабораторийг хүлээлгэн өгч чадахгүй бол Инженерийн зүгээс шаардлагатай гэж үзсэн хувилбар арга хэмжээг авна. Эдгээр арга хэмжээнд зочид буудал, түрээсийн байр зэргийг ашиглах, бусад тохиромжтой барилга байшинг худалдаж авах зэрэг орж болно. Инженерийн зүгээс авсан эдгээр түр арга хэмжээний зардлыг, 25%-ийн удирдлагын зардлын хамт Гүйцэтгэгч Инженерт нөхөн төлнө.

131. ТАЛБАЙН ЛАБОРАТОРИ ТҮҮНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БА ИНЖЕНЕРТ ЗОРИУЛСАН ОРОН СУУЦ, АЖЛЫН БАЙР, ТЭДГЭЭРИЙН ТАВИЛГА ТОНОГЛОЛЫН ДААТГАЛ, ЭЗЭМШИЛ

Гүйцэтгэгч болон Инженерийн дээрх холбогдолтой зүйлсийг Гэрээний хэрэгжилтийн нийт хугацааны туршид даатгалд даатгуулна.

Гэрээний хугацаа дууссаны дараа урьдчилсан төлбөрийн дагуу хангагдаж, нөхөн төлөгдсөн зүйлсийн эзэмших эрхийг Захиалагчид буцаж очно.

132. ТАЛБАЙН ЛАБОРАТОРИ БА ИНЖЕНЕРИЙН АЖЛЫН БАЙРНЫ ТАВИЛГА, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР АРЧЛАЛТ

Захиалагчийн зааврыг баримтална.

133. ТҮР СУУРИНГ БУУЛГАХ

Захиалагчийн зааврыг баримтална.

134. ИНЖЕНЕРИЙГ АЖИЛЛАХ НӨХЦӨЛ БОЛОМЖООР ХАНГАХ

Захиалагчийн зааврыг баримтална.

135. МАШИНААР ХАНГАХ

Захиалагчийн зааврыг баримтална.

136. ИНЖЕНЕРИЙН ИЛҮҮ ЦАГИЙН ТӨЛБӨР

Захиалагчийн зааврыг баримтална.

137. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ

Барилгын ажлын үед замын дагуух гол, горхи зэрэг усны эх үүсвэрүүд зарим тохиолдолд хөндөгдөж магадгүй. Баригдаж буй замын дагуу байгаа гол горхийг эргийн хамгаалалт хийх буюу бусад зөвшөөрөгдсөн аргыг ашиглан хамгаална. Гүйцэтгэгч нь Инженерийн ба орон нутгийн удирдах байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр гол горхи буюу, гүний худгуудаас ус авч болно. Гүйцэтгэгч Монгол улсын гадаргын усны чанарын хяналтын стандартын дагуу шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд ингэснээр барилгын үйл ажиллагаанаас шалтгаалан усны чанарт өөрчлөлт гарахгүй байх боломжтой.

Асфальтобетон хольцын үйлдвэр, чулуу бутлуур ба буталсан чулуу холих төхөөрөмжүүдийг ажиллуулахдаа байгаль орчны хяналтын талаарх Засгийн газрын хууль тогтоомжийг чанд мөрдөх бөгөөд тэдгээрийг хүн ам суурьшсан газраас 1.0 км-ээс хол зайд байршуулна. Тоосжилт үүсэхээс сэргийлж газар шорооны ажил, түр овоолго, түр зам ба суурь ба суурийн доод үеийг тогтмол усална. Агаарын чанар нь орчин тойрны агаарын чанарын

тухай Монгол улсын стандартын шаардлагыг хангах ёстой.

Барилгын ажилд хэрэглэгдэж буй бүх тоног төхөөрөмж, үйлдвэр завод, технологийн машин механизм нь холбогдох дуу чимээний стандартыг дагаж мөрдөнө. Барилгын ажлын тоног төхөөрөмж нь 90 дБ(А)-аас бага дуу чимээ гаргана гэсэн стандартын шаардлагыг хангана. Суурин газраас 150 м-ээс ойр зайд явагдаж буй дуу чимээтэй барилгын ажлыг оройны 10:00 цагаас өглөөний 6:00 цагийн хооронд зогсооно. Дуу чимээний төвшинг тогтоосон хязгаарт байлгах үүднээс бүх машин тэрэг, барилгын ажлын техникүүдийг тогтмол хянаж, дуу намсгагчаар ханган, жолооч, операторууд чихэвч зүүсэн эсэхэд онцгойлон анхаарал тавина.

Байгаль орчны чанар, барилгын ажилчдын эрүүл мэнд, ажлын талбайн нөхцөл байдал, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал зэргийг дараах хүснэгтэд буй үзүүлэлтүүдээр хянана. Үүнд:

Хүснэгт 1-3

Бүрэлдэхүүн хэсэг	Үе шат	Зүйл
Агаар	Барилгын	Бохирдлын элементүүд (SPM), CO,
Ус	Барилгын ажлын үе шат	Физик, хими, биологийн шинж чанар
Дуу чимээ	Барилгын ажлын үе шат	Дуу чимээний төвшин
Ажилчдын эрүүл мэнд	Барилгын ажлын үе шат	Эрүүл мэндийн үзлэг
Ажлын талбайн нөхцөл байдал, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал	Барилгын ажлын үе шат	Ажлын талбайн нөхцөл байдал/түр

138. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Энэхүү бүлгийн заалтуудыг биелүүлэхтэй холбоотой зардлыг замын барилгын ажлын гэрээ, зураг төсөлд хэрхэн тусгагдсанаас хамааруулан Захиалагчийн шийдвэрээр санхүүжилтийг хийнэ.

**БҮЛЭГ 200 – МАТЕРИАЛ, МАТЕРИАЛЫН
ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТ**

БҮЛЭГ 200 – МАТЕРИАЛ, МАТЕРИАЛЫН ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТ

201. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	18
202. ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	18
203. МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ СТАНДАРТ	19
204. ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД	19
205. ДАЛАНД ХЭРЭГЛЭГДЭХ ШОРООН МАТЕРИАЛ	20
206. ЧУЛУУ, ЧУЛУУН МАТЕРИАЛ, ЭЛС БА ДҮҮРГЭГЧ МАТЕРИАЛ.....	26
207. ПОРТЛАНДЦЕМЕНТ	32
208 АРМАТУР	35
209 БИТУМЭН БАРЬЦАЛДУУЛАГЧ	36
210. ЦЕМЕНТОБЕТОН ХОЛЫЦ.....	43
211. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТ, БАРИЛГЫН АРГАЧЛАЛ БА ТЕХНИКИЙН ШААРДЛАГЫГ БАТАЛГААЖУУЛАХ ТУРШИЛТУУД	48
212. ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ, ХУЧИЛТЫН ҮЕҮД БОЛОН УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙГ БАРИХ, АЖИЛД ТАВИХ ХЯНАЛТ	49
213. ХИЙМЭЛ БАЙГУУЛАМЖ	50
214. ЗАМЫН ТЭМДЭГ	50
215. ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭ	51
216. ЗАМЫН ТЭМДЭГ ХИЙХЭД ЗОРИУЛСАН ГЭРЭЛ ОЙЛГОГЧ МАТЕРИАЛ.....	51
217. ЗАМЫН ТЭМДГҮҮДИЙН ӨНГӨ.....	51
218. ХАШЛАГА	52
219. ГЭРЛИЙН ТУСГАЛААС ХАМГААЛАХ ТОНОГЛОЛ.....	52
220. ХУВАНЦАР ХӨДӨЛГӨӨН ТУСГААРЛАГЧ ХАШЛАГА	52
221. ХӨДӨЛГӨӨН ТУСГААРЛАГЧ ХУВАНЦАР ТОРХ	52
222. ШИЛЭН ГЭРЭЛ ОЙЛГОГЧ.....	53
223. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР	53

Ашигласан стандарт, норм, бусад хэвлэлүүдийн жагсаалт

Дор дурдсан стандартууд, норм болон бусад материалуудад хамгийн сүүлд оруулсан өөрчлөлт, шинэчилсэн хэвлэлүүд нь техникийн шаардлагын энэхүү хэсэгт дурдагдах ба эдгээртэй холбоотойгоор ашиглагдана. Үүнд:

Ашигласан стандарт, норм, бусад хэвлэлүүдийн жагсаалт

Стандартын нэр /Монгол хэл дээр/	Стандартын нэр /Англи хэл дээр/	Стандартын дугаар
Авто зам, нисэх онгоц хөөрөх, буух зурваст хэрэглэх органик барьцалдуулагч материал. Асфальтбетон болон полимерасфальтбетон хольц. Техникийн шаардлага.	Ashphaltic concrete and polimer ashphaltic concrete mixtures8 ashphaltic concrete for roads and aerodromes. Technical requirements	MNS GOST 9128 : 2019
Авто зам, нисэх онгоц хөөрөх, буух зурвасын барилгын ажилд хэрэглэх органик барьцалдуулагч материал. Турших арга	Materials on the basis of organic binders for road and airfield construction. Test methods	MNS GOST 12801 : 2019
Чулуун мастик асфальтбетон болон асфальтбетон хольц. Техникийн шаардлага	Ashphalt concrete mixtures stone mastic. Technical requirements.	MNS GOST 31015 : 2019
Газрын тос болон газрын тосон бүтээгдэхүүний хаяглалт, сав баглаа, тээвэрлэлт болон халгалалт	Petroleum and petroleum products. Marking8 packing8 transportation and storage	MNS GOST 1510: 2019
Төмөр бетон бүтээцийн арматурлалтын хөндийрүүлэгч болон зай баригчийн техникийн шаардлага. 1-р хэсэг: Бүтээгдэхүүний гүйцэтгэлийн шаардлага	Spacers and chairs for steel reinforcement and their specification. Part1: Product performance Requirements	MNS BS 7973 – 1 : 2017
Шүүрүүлж нягтруулаагүй холбоослог хөрсийг гурван тэнхлэгт шахалтаар турших арга	Standard Test Method for Unconsolidated-Undrained Triaxial Compression Test on Cohesive Soils	MNS ASTM D 2850 : 2017
Холбоослог хөрсийг гурван тэнхлэгт шахалтаар шүүрүүлэлтгүйгээр нягтруулж турших арга	Standard Test Method for Unconsolidated-Undrained Triaxial Compression Test on Cohesive Soils	MNS ASTM D 4767 : 2017
Туршилтын машины хүчний заалтыг баталгаажуулах хүч хэмжих багажийг тохируулах арга	Standard Practices for Calibration and Verification for Force-Measuring Instruments	MNS ASTM E 74 : 2016
Бетон ба бетон бүтээгдэхүүн. Бетоны гулзайлтын бат бэхийг тодорхойлох арга	Standard Test Method for Flexural Strength of Concrete (Using Simple Beam with Third-Point Loading)	MNS ASTM C 78/C 78 : 2016
Бетон бүтээцийг арматурчлах мяндас полимер (FRP) арматур. Техникийн ерөнхий шаардлага	Fiber-Reinforced Polymer Bar for Concrete Reinforcement. General Specifications	MNS GOST 31938 - 2015
Бетон ба төмөр бетон бүтээц. Арматурын хамгаалах бетон үеийн зузаан, арматурын хэмжээ, байрлал тодорхойлох радиацийн арга.	Concrete and Reinforced Concrete Structures. Radioactive Method for Determination of Concrete Protective Covering Thickness, Reinforcement Dimensions and Locations	MNS GOST 17625:2010
Бетон ба төмөр бетон бүтээц. Арматурыг хамгаалах бетон үеийн зузаан, арматурын байрлал тодорхойлох соронзон арга.	Concrete and Reinforced Concrete Structures. Magnetic Method for Determination of Concrete Protective Covering Thickness, Reinforcement Dimensions and Locations	MNS GOST 22904:2010

Стандартын нэр /Монгол хэл дээр/	Стандартын нэр /Англи хэл дээр/	Стандартын дугаар
Бетоны химийн нэмэлт. Техникийн шаардлага	Chemical Admixtures for Concrete. Standard Specifications	MNS ASTM C 494:2011
Бетон хольц. Турших арга	Concrete Mixtures. Methods of Testing	MNS 1170:2009
Хүнд бетон. Техникийн нөхцөл	Weighty Concrete. Standard Specifications	MNS1228:1987
Бетон зуурмаг техникийн шаардлага	Standard Specifications for Concrete Mortar	MNS 1185:1998
Бетон. Ангилал, ерөнхий техникийн шаардлага	Concrete Classification and General Specifications	MNS IEC3173:2002
Бетон болон төмөр бетон эдлэхүүн. Бетоны найрлагыг сонгох	Concrete and Reinforced Concrete Structures. Concrete Composition	MNS GOST 27006:2010
Лабораторийн нөхцөлд бетон сорьцыг бэлтгэх, аргачлал	Standard Test Method for Making and Curing Concrete Test Specimens in the Laboratory	MNS AASHTO T126:2005
Барилгын зуурмаг. Турших арга	Construction Mortar. Methods for Testing	MNS 2120:1999
Шинээр бэлтгэсэн бетон зуурмагийн агаарын агуулалтыг эзлэхүүний аргаар тодорхойлох арга	Standard Test Method for Air Content of Freshly Mixed Concrete by the Volumetric Method	MNS ASTM C173:2005
Шинээр бэлтгэсэн бетон зуурмагийн агаарын агуулалтыг даралтаар тодорхойлох арга	Standard Test Method for Air Content of Freshly Mixed Concrete by The Pressure Method	MNS ASTM C231:2005
Шинээр бэлтгэсэн портландцементэн бетоны температурыг тодорхойлох аргачлал	Standard Test Method for Temperature of Freshly Mixed Concrete	MNS ASTM C1064-2005
Бетон Үл эвдэх механик сорилын аргаар бетоны бат бэхийг тодорхойлох арга	Concrete Determination of Strength by Mechanical Methods of nondestructive testing.	MNS 5581:2005
Гидравлик цементэн бетоны конусын суултыг шалгах, турших арга	Standard Test Method for Slump of Hydraulic Cement Concrete	MNS ASTM C143-2005
Бетон зуурмагийн дундаж нягт, гарц ба агаар агуулалтыг (гравиметерик) тодорхойлох арга	Standard Test Method for Density (Unit Weight), Yield, and Air Content (Gravimetric) of Concrete	MNS ASTM C138:2005
Авто зам, хучилтын материалын туршилт-шинжилгээ, үзлэг хийх байгууллагад тавигдах шаардлага	Roadway and Pavement Material Testing and Sampling, Requirements for Inspection Authority dsf	MNS ASTM D666:2005
Бетон дахь шүлтэнд уусдаг цахиурын исэл агуулсан эрдсийг таних хурдавчилсан арга	Standard Method of Test for Rapid Identification of Alkali-Silica Reaction Products in Concrete	MNS AASHTO 299:2005
Бетон болон дүүргэгч материалын хлорын ион тодорхойлох арга	Standard Test Method for Sampling and Testing for Chloride Ion in Concrete and Concrete Raw Materials	MNS AASHTO T260:2004
Бетоны гадаргууг гадны нөлөөнөөс хамгаалах бүрхэвч үеийн материалын чийг хамгаалах чадварыг тодорхойлох	Standard Method of Test for Water Retention by Liquid Membrane-Forming Curing Compounds for	MNS AASHTO T155:2004

ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН-ӨМНӨДЭЛГЭР ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС БИНДЭР
ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТАЙ АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

Стандартын нэр /Монгол хэл дээр/	Стандартын нэр /Англи хэл дээр/	Стандартын дугаар
Бетоныг өрөмдөж дээж авах, бат бэхийг тодорхойлох	Standard Method of Obtaining Drilled Cores and Sawed Beams	MNS AASHTO 724:2003
Угсармал төмөр бетон бүтээц, эдлэхүүн. Ачаалж турших арга. Бат бэх, хөшүүншил, цав тэсвэршлийг үнэлэх ба турших арга	Precast Reinforced Concrete Structures and Elements. Loading Test Methods. Assessment of Strength, Rigidity and Crack.	MNS 2370:2003
Цутгамал бетон, төмөрбетон бүтээцийн хашмал. Ангилал ба техникийн ерөнхий шаардлага	Formworks for Concrete and Reinforced Concrete Structures, Its Classifications and General Specifications.	MNS IEC 3173:2002
Бетон болон бетонон бүтээгдэхүүн. Бетоны дүүргэгчид агуулагдах хүхэрлэг нэгдлийг тодорхойлох арга	Concrete and Concrete Structures. Sulfate Content in Concrete Aggregates. Testing Methods	MNS 4982:2000
Бетонд агаар оруулах нэмэлтэд тавигдах техникийн шаардлага	Standard Specifications for Air-Entraining Admixtures for Concrete	ASTM C260
Бетон болон бетонон бүтээгдэхүүн. Бетон. Сорьцоор бат бэхийг тодорхойлох арга.	Concrete and Concrete Structures. Concrete Strength Determination by its Composition	MNS 1272-99
Бетон ба төмөр бетон бүтээц. Төсөл хийх үндсэн журам	Concrete and Reinforced Concrete Structures. Project Basic Regulations.	MNS 3176 -1981
Бетоны эзлэхүүний жин, чийг, ус шингээлт, сүвэрхэгжилт, ус нэвтрүүлэлтийг тодорхойлох арга	Volume Mass of Concrete. Determination of Water Absorption and Transmission of Moisture and Porosity for Concrete	MNS 2122:1985
Бетоны хүйтэн тэсвэрлэлтийг тодорхойлох арга	Standard Test Method for Frosting Resistance of Concrete	MNS 1918:1985
Бетон болон бетон бүтээгдэхүүн. Бетоны бат бэхийг шалгаж үнэлэх зарчим	Concrete and Concrete Structures. Method Test for Concrete Strength	MNS 1920:1999
Хүнд, хөнгөн бетоны эзлэхүүний жинг тодорхойлох радиоизотопын арга	Radioisotopes Method for Determination of Volume Mass for Weighty and Lightweight Concrete	MNS 2791:1979
Хүнд бетон. Ойлт ба уян налархай чанараар нь бетоны бат бэхийг тодорхойлох арга	Weighty Concrete. Method for Determination of Strength by Reflection and Elasticity	MNS 3323:1991
Хүнд бетон Кашкаровын алхаар бат бэхийг тодорхойлох арга	Weighty Concrete. Method for Determination of Strength by Cashkirov's Hammer.	MNS 4113:1991
Хэт богино авиагаар бетоны бат бэхийг тодорхойлох арга	Method for Determination of Strength of Concrete by Ultrasonic Methods	MNS 4114:1991
Хүнд, хөнгөн бетоны бат бэхийг хэт богино дууны аргаар тодорхойлох	Method for Determination of Strength by Sound Short Proofing for The Weighty and Lightweight Concrete	MNS 2794:1979
Цемент 1-р хэсэг. Ердийн цементийн найрлага, техникийн шаардлага ба тохирлын шалгуур	Cement Part-1. Composition specifications and conformity criteria for common cements	MNS EN 197-1 : 2019
Цемент. Турших арга (1-р хэсэг Батбэх тодорхойлох)	Cement. Methods for Testing (Part-1 Strength Determination by its	MNS EN 196-1 : 2019

*ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН-ӨМНӨДЭЛГЭР ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС БИНДЭР
ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ТӨСӨЛ*

Стандартын нэр /Монгол хэл дээр/	Стандартын нэр /Англи хэл дээр/	Стандартын дугаар
Цемент. Турших арга (2-р хэсэг химийн шинжилгээний арга)	Cement. Methods for Testing (Part-2 Standard Method of Test, Chemical	MNS EN 196-2 : 2019
Цемент. Турших арга (3-р хэсэг цементийн барьцалдах хугацаа, эзэлхүүний өөрчлөлтийг тодорхойлох арга)	Cement. Methods for Testing (Part-3 Standard Method of Test for Time of Setting of Hydraulic Cement)	MNS EN 196-3 : 2019
Цемент. Турших арга (6-р хэсэг цементийн нунтаглалтыг тодорхойлох арга)	Cement. Methods for Testing (Part-6 Standard Method of Test for Fineness of Hydraulic Cement)	MNS EN196-6 : 2019
Цемент. Турших арга (7-р хэсэг цементийн дээж авах ба бэлтгэх арга)	Cement. Methods for Testing (Part-7 Standard Method of sampling and paking)	MNS EN 196-7 : 2019
Портланд цементийн техникийн шаардлага	Portland cement. General Specifications	MNS 0974: 2008
Цемент. Техникийн ерөнхий шаардлага	Cements. General Specifications	MNS 3091:2008
Цементэн зуурмагийг механик аргаар холих	Standard Method of Test for Mechanical Mixing of Hydraulic Cement Pastes and Mortars of Plastic Consistency	MNS AASHTO T162:2003
Гидравлик цементэд агааржуулах нэмэлт хэрэглэн хөлдөөлт, гэсгээлтийг үнэлэх арга	Standard Method of Test for Evaluation by Freezing and Thawing of Air-Entraining Additions to Hydraulic Cement	MNS AASHTO 188:2011
Цементийн нунтаглалтыг тодорхойлох арга	Standard Method of Test for Fineness of Hydraulic Cement	MNS AASHTO T128:2003
Гидравлик цементэн зуурмагийн шахалтын бат бэхийг тодорхойлох арга (50 мм-ийн шоо сорьц)	Standard Method of Test for Compressive Strength of Hydraulic Cement Mortar (Using 50-Mm Cube Specimens)	MNS AASHTO T106:2012
Викийн багажийг ашиглан цементийн бэхжих хугацааг тодорхойлох арга	Standard Method of Test for Time of Setting of Hydraulic Cement by Vicat Needle	MNS AASHTO T131:2003
Цемент Олон ширхэглэлтэй стандарт элс хэрэглэн турших арга	Cements. Method of Test Using Multiple Particles Standard Sand	MNS 976:2008
Цементийн туршилтад хэрэглэх стандарт элс. Техникийн шаардлага	Standard Method of Test for concrete samples. Standard Specifications	MNS 2930:2008
Гидравлик цементийн бэхжих хугацааг Гиллморийн зүүг ашиглан тодорхойлох	Standard Method of Test for Time of Setting of Hydraulic Cement Paste by Gillmore Needles	MNS AASHTO T154:2003
Цемент-Химийн шинжилгээний арга. Энэ стандартад заасан арга нь идэвхт эрдэс нэмэлттэй болон нэмэлтгүй портландцементэд хамаарах ба эдгээр цементийн түүхий эдийн зутан, чулуунцарт хэрэглэж болно.	Standard Method of Test, Chemical Analysis. This standard applies for Portland Cements with/without admixtures, and usage of these cements including, mortars and gravel mixing.	MNS 0975:2002
Барилга байгууламжийн ажилд хэрэглэх элс, дайрга. Ширхэглэлийн химийн найрлага	Crushid stone and sand for Construction. Chemical sieve analysis Specifications	MNS 6713:2018

ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН-ӨМНӨДЭЛГЭР ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС БИНДЭР
ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

Стандартын нэр /Монгол хэл дээр/	Стандартын нэр /Англи хэл дээр/	Стандартын дугаар
Том дүүргэгчийн нягт, харьцангуй нягт (хувийн жин) ба ус шингээлтийг тодорхойлох арга	Standard Test Method for Relative Density (Specific Gravity) and Absorption of Coarse Aggregate	MNS ASTM C 127 : 2017
Жижиг дүүргэгчийн нягт, харьцангуй нягт (хувийн жин) ба ус шингээлтийг тодорхойлох арга	Standard Test Method for Maximum Pore Diameter and Permeability of Rigid Porous Filters for Laboratory Use	MNS ASTM C 128 : 2017
Барилга байгууламжийн ажилд хэрэглэх элс. Техникийн шаардлага	Sand for Construction. General Specifications	MNS 0392:2014
Барилгын ажилд хэрэглэх элс. Турших арга	Sand for Construction. Test Methods	MNS 2916-2014
Элсний ширхэглэлийн модуль	Particle-Size Analysis and Determination of Soil Constants	MNS ASTM D421:02
Барилга байгууламжийн ажилд хэрэглэх буталсан чулуу, дайрга. Техникийн шаардлага	Standard Specifications for Constriction crushed stone and Aggregates	MNS 0346:2000
Уулын нягт чулуулаг, барилга-замын ажилд хэрэглэх хайрга, дайрга. Физик-механик шинж чанар тодорхойлох арга	Mountainous Stone, Aggregates for Road Construction. Methods for Testing.	MNS 2998:2009
Хүнд бетонд хэрэглэх дүүргэгч материал. Техникийн шаардлага	Standard Specifications for Binding Material of Weighty Concrete.	MNS 2803:2004
Барилгын ажилд хэрэглэх хайрга, буталсан хайрга. Техникийн ерөнхий шаардлага	Construction Aggregates (gravel and crushed stone). General Specifications.	MNS 0346:2000
Зам, гүүрийн барилгын ажилд хэрэглэх хайрга, чулууны ширхэглэлийн бүрэлдэхүүн. Техникийн шаардлага	Standard Specification for Sizes of Aggregate for Highway and Bridge Construction	MNS AASHTO M43:2002
Хайрга, дайрганы хүйтэн тэсвэрлэлтийг натрийн сульфат буюу магниийн сульфатын уусмал ашиглан түргэвчилсэн аргаар тодорхойлох	Standard Test Method for rapidly determining soundness of aggregates using sodium sulfate or magnesium sulfate.	MNS ASTM C88:2004
Том дүүргэгч материалын элэгдлийн хэмжээг Лос- Анжелесийн туршилтын төхөөрөмжөөр тодорхойлох	Standard Method of Test for Resistance to Degradation of Coarse Aggregate by Abrasion and Impact in the Los Angeles Machine	MNS ASTM C535:2003
Хайрга дайрганы асгаасан нягт ба ширхэг хоорондын зайг тодорхойлох	Standard Method of Test for Bulk Density ("Unit Weight") and Voids in Aggregate	MNS AASHTO T19:2003
Хайрга, дайрга дахь хөнгөн жинтэй хэсгийн агууламжийг тодорхойлох арга	Standard Method of Test to Determine Lightweight Particles in Aggregate	MNS AASHTO T113:2004
Хайрга, дайргын бүхэл шаврын хэмжээг тодорхойлох арга	Standard Method of Test to Determine Clay Particles in Aggregate	MNS AASHTO T112:2004
Хайрга, дайргын 0.075мм-ээс жижиг ширхэгийн агуулгыг угаах аргаар тодорхойлох	Standard Test Method by washing to Determine aggregate particles smaller than 0.075 mm.	MNS ASTM C117:2004
Том ба жижиг ширхэгтэй дүүргэгчийг шигших арга	Standard Method of Test for Sieve Analysis of Fine and Coarse Aggregates	MNS AASHTO T27:2003
Жижиг ширхэглэлтэй том дүүргэгчийн элэгдлийг Лос-Анжелесийн төхөөрөмжөөр тодорхойлох арга	Standard Test Method for Resistance to Degradation of Small-Size Coarse Aggregate by Abrasion and Impact in the Los Angeles Machine	MNS ASTM C131:2007

*ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН-ӨМНӨДЭЛГЭР ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС БИНДЭР
ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ТӨСӨЛ*

Стандартын нэр /Монгол хэл дээр/	Стандартын нэр /Англи хэл дээр/	Стандартын дугаар
Цохилтын аргаар дүүргэгчийн бутралтын хувийг тодорхойлох арга	Testing aggregates. Method for determination of aggregate impact value (AIV)	MNS BS 812-112:2008
Хайрга, дайргын урт, үзүүрлэг хэсгийн хэмжээг тодорхойлох арга	Testing aggregates. Methods for determination of particle shape. Elongation index of coarse aggregate	MNS BS 812 Хэсэг 105.2:2003
Хайрга, дайргын нимгэн, хавтгай хэсгийн хэмжээг тодорхойлох арга	Testing aggregates. Methods for determination of particle shape. Flakiness index	MNS BS 812 Хэсэг 105.1:2003
Барилга байгууламжийн ажилд хэрэглэх дайрга. Техникийн шаардлага	Standard Specifications for Constriction Gravel and Aggregates	MNS 390:1998
Бетонд орох жижиг чулуун материалын органик нэгдлийг тодорхойлох арга	Method to Determine Organic Matter in Fine Aggregates of Concrete	MNS AASHTO T21:2004
Бетон хольцод хэрэглэх ус. Техникийн шаардлага	Water to be used concrete. Standard Specifications	ГОСТ 23732-2011
Бетонд хэрэглэх усны чанарыг тодорхойлох туршилтын арга	Quality of Water to be used in Concrete	MNS AASHTO T26:2005
Усны чанар. Өнгө тодорхойлох ба шалгах	Water quality. Examination and determination of color	MNS ISO 7887:2000
Усны чанар. "рН"-ийг тодорхойлох.	Water quality. Determination of pH	MNS ISO 10523-2:2003
Усны чанар. Кальци ба магнийн нийт агуулгыг тодорхойлох – Трилон Б-гээр титрлэх арга	Water quality. Determination of the sum of calcium and magnesium - EDTA titrimetric method	MNS ISO 6059:2005
Усны чанар. Хлоридын агууламжийг тодорхойлох. Хромат илрүүлэгчийн оролцоотойгоор мөнгөний нитратаар титрлэх (Морын арга)	Water quality. Determination of chloride - Silver nitrate titration with chromate indicator (Mohr's method)	MNS ISO 9297:2005
Усны чанар. Нитрат тодорхойлох 3-р хэсэг: Сульфосалицилийн хүчил ашигласан спектрометрийн арга	Water quality. Determination of nitrate - Part 3: Spectrometric method using sulfosalicylic acid	MNS ISO 7890:2001
Ундны ус. Нитритын агуулгыг тодорхойлох арга	Drinking Water. Determination of nitric content	MNS ISO 4431:2005
Ундны ус. Төмрийн агуулгыг тодорхойлох арга	Drinking Water. Determination of iron content	MNS ISO 4430:2005
Байгаль орчин. Усны чанар. Аммоны молибдат ашиглан фосфор тодорхойлох спектрометрийн арга	Water quality. Determination of phosphorus - Ammonium molybdate spectrometric method	MNS ISO 6878:2001
Усны чанар. Ундны усанд сульфат ион тодорхойлох турбидиметрийн хурдавчилсан арга	Water quality. Rapid Determination of sulfate ion content	MNS ISO 6271:2010
Усны чанар. Ундны усанд фтор ион тодорхойлох арга	Water quality. Method to determine Fluorine Ion in drinking water	MNS ISO 6272:2001
Ундны ус. Хуурай үлдэгдлийг тодорхойлох арга	Drinking water. Method to Determine Dry Particles.	MNS ISO 4423:1997

ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН-ӨМНӨДЭЛГЭР ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС БИНДЭР
ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

Стандартын нэр /Монгол хэл дээр/	Стандартын нэр /Англи хэл дээр/	Стандартын дугаар
Авто Тээврийн зориулалттай цементийн үндэсний стандарт. Техникийн шаардлага	Cement for Transport Construction. Specifications	ГОСТ Р 55224-2012
Хайрга болон дайрга, элсний урвалжих чадварыг тодорхойлох стандарт арга.(Химийн арга)	standard Test Method for Potential Alkali-Silica Reactivity of Aggregates (Chemical Method)	ASTM C289
Хөрсний шугаман агшилтын үзүүлэлтийг тодорхойлох стандарт туршилтын арга	Standard Test Method for Shrinkage Factors of Soils by the Wax Method	ASTM D4943-08
Бетон Фрост багажаар бетоны хүйтэн гэсвэрлэлтийг хурдавчилсан аргаар тодорхойлох туршилтын арга	Methods for determination of frost resistance in concrete	ГОСТ 10060-2012
Шинэ бетоны туршилт ба үнэлгээ, тархалтыг тодорхойлох туршилт	Testing fresh concrete. Flow table test	BS EN 12350 Part 5
Шинэ бетоны нягтруулалтын зэргийг тодорхойлох	Testing concrete. Method for determination of compacting factor	BS 1881: Part 103
Бетон.Үл эвдэх, механик аргаар бат бэхийг тодорхойлох	Concrete. Determination of strength by mechanical methods of nondestructive testing	ГОСТ 22690-2015
Талбай дээр бетоны нягтыг цөмийн аргаар тодорхойлох	Standard Test Methods for In-Place Density of Unhardened and Hardened Concrete, Including Roller Compacted Concrete, By Nuclear Methods	ASTM C1040
Цементийн зуурмагийн шахалтын бат бэхийг тодорхойлох	Standard Test Method for Compressive Strength of Hydraulic Cement Mortars	ASTM C109
Шингэн цементийн зуурмагийн дээж авах, шинжилгээний хэмжээ	Standard Method of Test for Sampling and Amount of Testing of Hydraulic Cement	AASHTO T 127-04
Шингэн цементийн зуурмагийн агаарын хувь	Standard Method of Test for Air Content of Cement Mortar	AASHTO T 137-04
Шинээр зуурсан бетоноос дээж авах	Standard Method of Test for Sampling Freshly Mixed Concrete	AASHTO T 141-01
Цементийн эзэлхүүний өөрчлөлтийн жигд байдлыг тодорхойлох	Cements. Methods of Tests Consistency, Times of Settling and of Soundness	ГОСТ310.3-76
Цементийн идэвхи (хүйтэн гэсвэрлэлт)-ийг хурдавчилсан аргаар тодорхойлох	Rapid Determination Method of Cement Frost Resistance	МИ 2486
Цементийн лагшимын тэлэлтийг тодорхойлох	Methods of physical tests for hydraulic cement, Part 3: Determination of soundness	IS:4031 (Part 3):1988
Гидравлик цементийн тархалтыг тодорхойлох стандарт туршилтын арга	Standard Specification for Flow Table for Use in Tests of Hydraulic Cement	ASTM C230 / C230M - 14
Цементийн хувийн гадаргууг тодорхойлох	Standard Test Methods for Fineness of Hydraulic Cement by Air-Permeability Apparatus	ASTM C204
Гидравлик цементийн тэлэлтийг автоклавын аргаар турших арга	Standard Test Method for Autoclave Expansion of Hydraulic Cement	ASTM C151 / C151M - 15
Талбайн нягтрал болон жигд байдлыг газар дээр нь хатуурлыг хэмжих аргаар тодорхойлох	Standard Test Method for Measuring Stiffness and Apparent Modulus of Soil and Soil-Aggregate In-Place by Electro-Mechanical Method	ASTM D 6758:2008

*ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН-ӨМНӨДЭЛГЭР ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС БИНДЭР
ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ТӨСӨЛ*

Стандартын нэр /Монгол хэл дээр/	Стандартын нэр /Англи хэл дээр/	Стандартын дугаар
Замын гадаргуугийн тэгш бус байдлыг автомашин ашиглаж хэмжих арга	Standard Test Method for Measurement of vehicular to traveled surface roughness	MNS ASTM E1082 :2007
Авто замын хучлагын гадаргуугийн тэгш бус байдлыг хэмжих статик түвшингийн арга	Standard Test Method for Measuring Road Roughness by Static Level Method	MNS ASTM 1364 :2009
Авто зам, нисэх онгоцны талбай, хөөрөх буух зурвасын суурь болон дэд сууринд хэрэглэх ширхэглэлээр ангилсан дүүргэгч. Техникийн шаардлага.	Standard Specification for Graded Aggregate Material for Bases or Subbases for Highways or Airports	MNS ASTM 2940: 2009
Цемент. Техникийн ерөнхий шаардлага.	Cements. General specification	MNS 3091:2008
Бетоны шахалтын бат бэхийг цилиндр сорьцоор тодорхойлох арга.	Standard Test Method for Compressive Strength of Cylindrical Concrete Specimens	MNS ASTM C39/C39M :2007
Барилга, замын ажилд хэрэглэх уулын нягт чулуулаг-хайрга, дайрга. Физик-механик шинж чанарыг тодорхойлох арга.	Mountainous stone, gravel to be used for road construction. Methods to determine physical and mechanical characteristics	MNS 2998 :2009
Жижиг ширхэгтэй чулууны бутрагдалтын арван хувийг тодорхойлох арга.	Testing aggregates. Methods for determination of ten per cent fines value (TFV)	MNS BS 812-111 (2010)
Хөрс бэхжүүлэхэд хэрэглэх цемент, шохой, үнс болон бусад пуццалон нэмэлтүүд. Техникийн шаардлага	Standard Specification for Fly Ash and Other Pozzolans for Use with Lime for Soil Stabilization	MNS ASTM C 593 (2010)
Жижиг ширхэгтэй чулууны хувийн жин ба шингээх чадвар	Standard Method of Test for Specific Gravity and Absorption of Fine Aggregate	MNS AASHTO T84-00
Том ширхэгтэй чулууны хувийн жин ба шингээх чадвар	Standard Method of Test for Specific Gravity and Absorption of Coarse Aggregate	MNS AASHTO T85-91(2000)
Хөрсний ширхэглэлийг шинжлэх	Standard Method of Test for Particle Size Analysis of Soils	MNS AASHTO T88-00
Жижиг чулууг Лос Анжелес машин дээр үрэлт цохилтоор турших	Standard Method of Test for Resistance to Degradation of Fine Aggregate by Abrasion in the Los Angeles Machine	MNS AASHTO T96-02
Дээж авах, бэлтгэх, савлах, тээвэрлэх, хадгалах	Soil Sample, Packing, Transporting and Stockpile	MNS 2305-94
Эвдэрсэн бүтэцтэй хөрсний дээжийг нойтон аргаар бэлтгэх/	Standard Practice for Wet Preparation of Disturbed Soil Samples for Test	AASHTO T146-96 (2000)
Эвдэрсэн бүтэцтэй хөрс, хөрсний чулуулгийн дээжийг хуурайгаар бэлтгэх, шинжлэх	Standard Method of Test for Effect of Organic Impurities in Fine Aggregate on Strength of Mortar	AASHTO T87-2000
Замын суурийн доод үе, суурь болон өнгөн үеийн хөрс ба холимог материал. Техникийн шаардлага	Standard Specification for Materials for Soil-Aggregate Subbase, Base, and Surface Courses	MNS ASTM1241:2002
Хөрсний уян налархайн хязгаар ба уян налархайн индексийг тодорхойлох	Standard Test Methods for Liquid Limit, Plastic Limit and Plasticity Index of Soils	MNS ASTM D4318
Хөрсний хувийн жин	Standard Method of Test for Specific Gravity of Soils	MNS AASHTO T100-03

ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН-ӨМНӨДЭЛГЭР ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС БИНДЭР
ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТАЙ АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

Стандартын нэр /Монгол хэл дээр/	Стандартын нэр /Англи хэл дээр/	Стандартын дугаар
Чийгийн агуулгыг тодорхойлох (талбайд)	Standard Method of Test for Determination of Moisture in Soils by Means of a Calcium Carbide Gas Pressure Moisture Tester	AASHTO T217-02
Шингэн цементийн зуурмаг болон уян консистенци бүхий шохойг механикаар холих	Standard Method of Test for Mechanical Mixing of Hydraulic Cement Pastes and Mortars of Plastic Consistency Tester	MNS AASHTO T162-04
в. Замын тэмдгийн ойлгогч 45 градусын өнцгөөр, Улаанбаатараас баруун тийш харуулж, босоо байрлуулж хэрэглэхэд ямар нэг хагарал, цэврүү, хялгасан ан цав, хэмжээний хувьд өөрчлөлт гарахгүй байх ёстой.

с. Ойлгогч гадаргууг үндсэн суурь материал дээр тогтоох наалт нь 20 0С-ийн хэмд хүрэээр цохиход салахгүй, гараар зөөвөрлөхөд сэвтэж гэмтэхгүй, мөн хуурахгүй байх ёстой. 25°С-ийн хэмд усан дотор 8 цаг байлгахад ирмэг зах нь ямар нэг байдлаар хуйларч эргэхгүй байх ёстой. Цавуу нь ойлгогч материал дээр толбо үүсгэх ёсгүй. Цавуу нь ойлгогч материалыг нааснаас хойш -20°С хэмээс +93°С хэмд 48 цагийн хугацаанд түүнийг найдвартай тогтоон барьж байх шаардлагатай.

д. 20 орчим мм-ийн голчтой хүрээг тойруулан нугалахад 0.5 мм-ийн зузаантай хөнгөн цагаан дэвсгэр дээр наасан ойлгогч материалд ямар нэг хагарал үүсэхгүй байх ёстой.

217. ЗАМЫН ТЭМДГҮҮДИЙН ӨНГӨ

Замын тэмдэгний өнгөний код MNS FED ST 595C :2014 стандартыг мөрдөнө.

Замын тэмдэг, шон ба бусад тоноглолд хэрэглэх стандартын өнгө нь доорх Британийн стандартуудад заасны дагуу байна.

Улаан	BS 381 C No. 537
Цэнхэр	BS 4800 No. 18 E 53
Шар	BS 381 C No. 537
Ногоон	BS 4800 No. 14 C 39
Саарал	BS 4800 No. 10 A 11
Шаргал	BS 381 C No. 352
Хар	BS 873 хэсэг 1 – бүлэг 1-3.3

218. ХАШЛАГА

Хашлага болон түүний бүрдэл хэсгүүд нь AASHTO M180 – “Замын хашлаганы атираатай ган төмөр”-т заасан шаардлагыг хангасан, А ангиллын, 1 дүгээр төрлийн ган байна

219. ГЭРЛИЙН ТУСГАЛААС ХАМГААЛАХ ТОНОГЛОЛ

Гэрлийн тусгалаас хамгаалах тоноглол нь үйлдвэрлэгчийн сертификат, болон дараах 2 стандартын туршилтын дагуу туршигдсан шинжилгээний бичигтэй байна.

BS EN 12676-1: 2000 Замын гэрлийн тусгалаас хамгаалах систем- Хэсэг1: Шаардлага ба үзүүлэлтүүд

BS EN 12676-2: 2000 Замын гэрлийн тусгалаас хамгаалах систем- Хэсэг2: Туршилтын арга

220. ХУВАНЦАР ХӨДӨЛГӨӨН ТУСГААРЛАГЧ ХАШЛАГА

Хуванцар хөдөлгөөн тусгаарлагч хашлага нь дараах 2 стандартын туршилтын дагуу туршигдсан байх ёстой.

National Cooperative Highway Research Program /NCHRP 350/-ийн туршилт AASHTO MASH –т заагдсан туршилтын аргаар туршсан байна.

221. ХӨДӨЛГӨӨН ТУСГААРЛАГЧ ХУВАНЦАР ТОРХ

Хөдөлгөөн тусгаарлагч хуванцар торх нь дараах 2 стандартын туршилтын дагуу туршигдсан байх ёстой.

National Cooperative Highway Research Program /NCHRP 350/-ийн туршилт AASHTO MASH –т заагдсан туршилтын аргаар туршсан байна.

222. ШИЛЭН ГЭРЭЛ ОЙЛГОГЧ

Шилэн гэрэл ойлгогчийн геометр үзүүлэлт нь дараах техникийн шаардлагыг хангасан байна.

BS EN 1463-2:2000- Замын тэмдэглэгээний материалууд. Замын гэрэл ойлгогчтой тоноглолууд. Турших техникийн шаардлага

Хүснэгт 2-15 Замын тэмдэг, тэмдэглэгээний стандарт

Стандартын нэр /Монгол хэл дээр/	Стандартын нэр /Англи хэл дээр/	Стандартын дугаар
Замын тэмдэглэгийн материал. Физик шинж чанар	Road marking materials. Physical properties	MNS EN 1871:2018
Шон суурьтай замын тэмдэг.Замын гэрэлтдэг тэмдэг	Road vertical signs - Variable message traffic signs - Part 1:	MNS EN 12966 : 2016
Гэрэл ойлгогч материалын шинж чанар шалгагчийг сонгох шалгаруулах, үнэлэх, сургахад баримтлах стандарт заавар	Standard Guide for Selection, Evaluation, and Training of Observers	MNS ASTM E 1499 : 2016
Багажаар хэмжсэн өнгөний координатуудаас өнгөний хүлцэх хязгаар болон өнгөний ялгааг тооцох арга"	Standard Practice for Calculation of Color Tolerances and Color Differences from Instrumentally Measured Color Coordinates	MNS ASTM D 2244 : 2015
Авто замын хаалт. Техникийн ерөнхий шаардлага	Barrier closure for the auto roads. General technical requirements	MNS 6517 : 2015
"Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм"	Rules of application of traffic signs, road markings, traffic lights, quardrails and delineators	MNS 4596 : 2014
Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага	Traffic signs. Technical requirements	MNS 4597 : 2014
Авто замын тэмдэглэгээ. Техникийн ерөнхий шаардлага	Road markings. General technical requirements	MNS 4759 : 2014
Авто замын гэрлэн дохио. Техникийн ерөнхий шаардлага	Traffic lights. General technical requirements	MNS 4980 : 2014

223. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Материалын шинжилгээ, барилгын туршилт болон барилгын хяналтын шинжилгээнд зориулж тусдаа хэмжилт болон төлбөр хийгдэхгүй. Гүйцэтгэгч нь нэгж ажлын үнэлгээ болон нийт үнийн дүнд энэхүү техникийн шаардлагын бүлэг 200-ийн бүх шаардлагыг хангах зардлыг тусгасан гэж тооцно.

**БҮЛЭГ 300 – ЦЭГ, ТЭНХЛЭГ ТАВИХ БА
ХЭМЖИЛТИЙН ХҮЛЦЭХ АЛДАА**

БҮЛЭГ 300 – ЦЭГ, ТЭНХЛЭГ ТАВИХ БА ХЭМЖИЛТИЙН ХҮЛЦЭХ АЛДАА

301. ЦЭГ, ТЭНХЛЭГ ТАВИХ.....	2
(a) Нарийвчилсан хэмжилт, гадаслагааны ажил.....	3
302. ХҮЛЦЭХ АЛДААНУУД.....	4
a) Хэвтээ чиг	4
b) Хучилтын үеүдийн зузаан.....	4
c) Далан ба хучилтын үеүдийн гадаргуугийн төвшин	4
d) Хучилтын үеүдийн ба далангийн гадаргуугийн тэгш байдал	4
d) Далан ба ухмалын хажуу налуу.....	5
e) Далан ба ухмалын өргөн	5
f) Хажуугийн шуудууны гүн.....	5
g) Барилгын ажлын хяналт, шинжилгээ	5
303. ХҮЛЦЭХ АЛДААНААС ЗӨРҮҮТЭЙ АЖЛЫГ ЗАСАХ.....	5
(a) Газар шорооны ажил	6
(b) Суурь үе ба суурийн доод үе.....	6
304. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР.....	6

301. ЦЭГ, ТЭНХЛЭГ ТАВИХ

(а) Ерөнхий

Захиалагч нь барилгын цэг, тэнхлэгийг тавихад хангалттай хайгуулын мэдээллийг Гүйцэтгэгчид өгөх ба Гүйцэтгэгч бүх шаардлагатай хяналтын цэгүүдийн гадаслагааг хийж, тэдгээрийг арчилж хамгаалах хариуцлагыг хүлээнэ. Цэг, тэнхлэг тавих, гадаслагаа хийх нь үндсэн ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй дагалдан хийгдэх ажил гэж үзэх бөгөөд үүнийг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийх ба үүнд тусад нь төлбөр шаардагдахгүй. Гүйцэтгэгч хайгуулын үндсэн мэдээлэл, гадаслагааг хүлээн авмагцаа анхны хяналтын цэг, шугам, төвшин ба хэмжилтүүдийн нарийвчлалыг тодруулж, бодитоор шалгана.

Хэрэв Гүйцэтгэгч Захиалагчийн өгсөн хайгуулын мэдээлэлд ямар нэгэн алдаа буюу зөрүү байгааг илрүүлбэл Инженерт даруй мэдэгдэх ёстой. Хэрэв мэдээлсэн алдаа нь үнэн байвал засварласан зураг буюу алдааг залруулахтай холбогдсон зааврыг Инженер өгнө. Барилгын ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч нь анхан шатны хэмжилтийн цэгүүд болох, Монгол улсын геодезийн координатын (өндрийн) цэгүүдтэй холбогдсон, замын трассын дагууд байгаа репер болон хэвтээ хяналтын цэгүүдийн (өнцгийн орой, хэвтээ муруйн эхлэл, төгсгөл цэг г.м) байршил, бэхэлгээ зэргийг шалгаж, Захиалагчаас хүлээн авна. Үндсэн реперүүд нь замын ихэнх хэсэгт хоорондоо 2 км-ээс ихгүй зайд, гол төлөв замын зурвасын гадна, өнцгийн оройны ойролцоо байрлалтай байдаг.

Гүйцэтгэгч туслах реперүүдийг замын дагууд хооронд нь 200 м-ээс ихгүй зайд, замын тэнхлэгээс гадагш 50м-ээс багагүй зайд, аль болох өндөр газарт байрлуулж бэхэлнэ.

Бэхэлгээг дараах байдлаар хийнэ. 250x250x400 мм хэмжээтэй бетон гулдмай цутгаж, түүндээ 22 мм-ийн голчтой, 200 мм урт төмөр гадсыг гулдмайн дээд гадаргуугаас 20 мм дээш цухуйлган суулгаж бэхжүүлсний дараа уг хийцийг туслах репер байрлуулах цэгт ухаж суулган, эргэн тойрны газрыг сайтар чигжиж булна. Гулдмайн дээд ирмэг газрын төвшинтэй ижил байх ба дээд гадаргуу дээр тухайн реперийн дугаарыг арилдаггүй будгаар тод бичсэн байна.

Газарт суулгасан гулдмайгаас хааш хаашаа 0,5 м-т 200 мм гүнтэй шуудууг эргэн тойронд нь ухаж, гарсан шороог шуудууны гадна талаар овоолж орхино. Ухсан шуудууны аль нэг өнцөгт төмөр буюу модон гадсыг 400-500 мм ил цухуйж байхаар суулгана. Зарим түр реперийг Инженерийн зөвшөөрлөөр энд дурдсанаас өөрөөр өөрөөр бэхэлж болно. Зарим туслах реперийг байрлуулж, бэхэлсний дараа тэдгээрийг үндсэн реперийн байрлуулж болно. Энэхүү техникийн шаардлагын зүйл 107-д заасны дагуу бүх реперүүд, хэвтээ хяналтын цэгүүдийг “Барилга ашиглалтад хүлээлгэж өгсөн гэрчилгээ”-г олгох хүртэл, хамгаалах ажлыг Гүйцэтгэгч хариуцна. Гүйцэтгэгч нь бүх реперийн болон хэвтээ хяналтын цэгүүдийн өндөржилт, координат, байршлыг үзүүлсэн хүснэгтийг Инженерт гарган өгч байхын дээр хэмжилтийн ажлын шинэчлэгдсэн мэдээллээр байнга хангах үүргийг хүлээнэ. Гүйцэтгэгч нь улсын геодезийн сүлжээний өндрийн тэмдэгтүүд болон зургийн тэмдэгтийг эвдэх, гэмтээж, зайлуулж болохгүй.

Барилгын ажилд саад болох магадлалтай тэмдэгтүүдийн талаар Гүйцэтгэгч Инженерт мэдэгдэх ба тэдгээрийг зайлуулах буюу шилжүүлэн байршуулахад шаардагдах арга хэмжээний талаар холбогдох байгууллагатай харьцаж, шийдвэрлэх ажлыг Инженер хариуцна.

Хэрэв тэмдэгтүүдийг Инженерийн зөвшөөрөлгүйгээр зайлуулах болон хөндсөн тохиолдолд түүнийг дахин суурилуулах зардал болон үүнээс үүдэн гарах төлөвлөгөөний тасалдлын

хариуцлагыг Гүйцэтгэгч хүлээнэ. Гүйцэтгэгчийн талаас алдаатай хэмжилт хийснээс болж ажлын явцад ямар нэгэн хэмжилтийн ажлыг нэмж хийх шаардлага гарвал буруу хийгдсэн ажлыг Гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр засаж залруулна.

(b) Нарийвчилсан хэмжилт, гадаслагааны ажил

Репер болон хэвтээ хяналтын цэгүүдийг хүлээн авсны дараа Гүйцэтгэгч тэдгээрийн координат, өндөржилтийг нарийвчлан шалгаж, үр дүнг Инженерт танилцуулж зөвшөөрөл авна. Үүний дараа замын дагууд суулгаж бэхэлсэн туслах реперүүдийн өндөржилтийг үндсэн реперийн өндөржилттэй холбож тогтоон үр дүнг Инженер батлуулна. Гүйцэтгэгч нь энэхүү техникийн шаардлагын зүйл 301 /а/-д заасны дагуу замын тэнхлэгийн шугамыг зурагт үзүүлснээр Инженерийн зааварчилснаар тэдгээрийг дахин хянаж үзсэн аливаа зүйлийг харгалзан 25м-ээс ихгүй буюу түүнээс богино зайтайгаар гадаслах бөгөөд техникийн шаардлагын зүйл 302-т заасан хүлцэх алдааны дотор барилгын ажлыг гүйцэтгэхийн тулд дагуу налуугийн хугарлын цэгт болон зарим онцлог газарт гадаслагаа хийхэд эдгээр богино зайг ашиглах шаардлагатай болно. Гадаслагааг хийсний дараа Гүйцэтгэгч цэг, тэнхлэг тавьсан замын тэнхлэгийн дагууд, зуут /пикет/ болон нэмэх цэгүүдийн зай хэмжээ, газрын өндөржилтийг нарийвчлан шалгаж, газрын төвшний дагуу ба хөндлөн огтлолыг замын нийт өргөнд тодорхойлох хэмжилтийг гүйцэтгэнэ. Мөн үүнтэй адилаар замын тэнхлэгийн дагуух бүх төлөвлөгдсөн хоолой ба байгууламжуудын хөндлөн, дагуу хэмжилтийг гүйцэтгэнэ. Төлөвлөгдсөн болон засварлах хоолойны тэнхлэгийн дагууд газрын төвшинг тодорхойлохдоо замын тэнхлэгээс хоёр тийш Инженерийн зааварчилсан хязгаар хүртэл тодорхой зайнд хэмжилтийг гүйцэтгэнэ. Бүх холбогдох мэдээллийг (дугаар, байршил, төвшин г.м) угаагдаж арилдаггүй будгаар тодорхой тэмдэглэж бичсэн лавлагааны гадас, самбарыг ухмал ба далангийн налуу, хучилтын үеүдийн төвшинг ямар ч үед шууд тодорхойлох боломжтойгоор, замын тэнхлэгтэй перпендикуляраар, замаас тодорхой зайд байрлуулна. Эдгээр нь Гүйцэтгэгчид барилгын ажлыг шалгах, хянах зориулалтаар ашиглагдана.

Талбайн цэвэрлэгээг хийж дуусмагц Гүйцэтгэгч нь лавлагааны 50x50x1200 мм хэмжээтэй модон гадсыг хөрсийг нь хуулсан талбайн хоёр захаас гадагш 0,5-0,8 м зайнд, 400 мм гүн суулгана. Тэнхлэгийн дагууд байрлах лавлагааны гадаснуудын хоорондын зай 20 м-ээс ихгүй байна. Гадасны газраас дээш ил гарсан хэсгийг цагаанаар будсан байна. 25-45 мм-ийн урттай хадаасыг гадсан дээр үе тус бүрийн өндрөөр зоох ба хадаасны толгой нь хэмжилт хийх цэг ба замын тэнхлэгийг зааж өгнө. Гадсан дээр зуутын дугаар болон тэнхлэгээс хуулсан хөрсний зах хүртэлх цэвэр зайг Инженерийн шаардлагад нийцүүлэн тод, арилахааргүй тэмдэглэсэн байна. Замын дагууд хийгдсэн бүх гадаслагааг Гүйцэтгэгч нь шаардлагатай хугацааны туршид арчлан хамгаалж, эвдрэл гэмтэл гарсан бол нэн даруй засварлаж, тэмдэглэгээг тогтмол сэргээж байна. Хэмжилтийн ажлыг хэмжилтийн нарийвчлалын шаардлага хангах багажийн тусламжтайгаар гүйцэтгэх ба өгөгдлийг Инженерийн зөвшөөрсөн формат ба нарийвчлалын стандартын дагуу нэгтгэн боловсруулна. Зам барилгын үе шат бүрт замын хөндлөн огтлолын зургийг 1:200 масштабтайгаар хэвлэж, үе шатын ажил хүлээлцэх бүрт Инженерт танилцуулна. Дагуу огтлолын зургийг хэвтээ чиглэлд 1:2000 масштабтай, босоод чиглэлд 1:200-гийн масштабтайгаар боловсруулна. Гүйцэтгэгчээс ажлын явцын зургуудыг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор зам, хоолой, бусад байгууламжуудын байрлал ба төвшинг баталгаажуулна. Гүйцэтгэгч нь нэг удаад 10 км-ээс багагүй урттай замын ажил гүйцэтгэх зургийг танилцуулна. Инженерийн зааварласан зам, хоолой ус зайлуулах байгууламжуудын эцсийн төвшин нь зурагт үзүүлснээс өөр байж болно. Мөн тухайн ажлыг гүйцэтгэсний дараа гүйцэтгэлийн зургийг Гүйцэтгэгч боловсруулж Инженерээр хянуулна. Энэ нь тухайн ажлыг санхүүжүүлэх нэг зайлшгүй нөхцөл болно.

Далангийн дүүргэлтийн газар шорооны ажлыг дуусангуут, гэхдээ далангийн дээд үе болон хучилтын үеүдийн ажлыг эхлэхээс өмнө Гүйцэтгэгч нь модон эсвэл төмөр гадаснуудыг өндөрлөсөн далангийн хоёр талын ирмэгт, замын тэнхлэгээс ижил хэмжээтэй тогтмол зайд, аль болох бөх суулгана. Ухмал ба өндөрлөгөөтэй хэсэгт талбайн нөхцөлөөс шалтгаалан тэнхлэгээс гадас хүртэлх зай өөрчлөгдөж болох ба ийм тохиолдолд Инженерийн зөвшөөрсөн зайд суулгана. Далангийн гадаргуугаас дээш ил байх гадасны өндөр нь 1м-ээс багагүй байна. Гадсан дээр зорчих хэсгийн хөндлөнгийн аль ч цэгт замын тэнхлэг болон төвшинг нарийн утас ашиглан шууд тодорхойлоход шаардлагатай бүх холбогдох мэдээллийг арилахгүйгээр тэмдэглэсэн байх ёстой. Гадаснуудын хоорондох зай нь 20 м-ээс ихгүй байх ажил гүйцэтгэх хугацааны туршид Гүйцэтгэгч тэдгээрийг засварлан сэргээж байна. Инженерийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр аль нэг гадсыг хөдөлгөж болохгүй.

302. ХҮЛЦЭХ АЛДААНУУД

а) Хэвтээ чиг

Замын хэвтээ чиг нь зурагт үзүүлсэн буюу зургаас тооцож гаргасан замын хучилтын тэнхлэгээр тодорхойлогдоно. Дэвссэн хучлагын тэнхлэг ба түүнтэй зэрэгцээ орших бусад чигийн нарийвчлал ± 10 мм-ийн дотор байвал зохино.

б) Хучилтын үеүдийн зузаан

Дурын 1000 метрийн дотор 5 цэгт хэмжсэн хучилтын аль ч үеийн дундаж зузаан нь Инженерийн зааварласан буюу тогтоосон зузаанаас 99%-иас багагүй, 120%-иас ихгүй байна. Үүний дээр, хучилтын аль ч үеийг дурын цэгт хэмжсэн зузаан нь Инженерийн зааварласан, эсвэл техникийн шаардлагад зааснаас 99%-иас бага, 120%-иас их байх ёсгүй.

в) Далан ба хучилтын үеүдийн гадаргуугийн төвшин

Хучилтын үеүдийн болон далангийн дээд үеийн гадаргуугийн аливаа цэгт хэмжсэн төвшин ба зургаас тооцсон зохих төвшингийн хоорондох зөрүү нь (хүснэгт 3-1)-д үзүүлсэн хүлцэх алдаанаас илүү байх ёсгүй. (Хүснэгт 3-1)-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд Инженерийн сонгосон цэгүүдэд, замын тэнхлэгийн дагууд 20 м тутамд, тухайн үеийн голд болон хоёр захад гадаргуугийн төвшнийг хэмжихээс гадна гол замын суурь үеийн болон хучлагын гадаргуу дээр тэнхлэгээс хоёр тийш 1.75 м-т, салаа замын суурь үеийн болон хучлагын гадаргуу дээр тэнхлэгээс хоёр тийш 1.5м-т тус тус нэмэлт хэмжилт хийнэ. Уулзвар дээр төвшинг торон хэмжилтийн аргаар хийх бөгөөд цэгүүдийн байршлыг Инженер тодорхойлно.

г) Хучилтын үеүдийн ба далангийн гадаргуугийн тэгш байдал

Инженерийн сонгосон газарт 3м-ийн төмөр рейкийг замын тэнхлэгт паралель буюу перпендикуляраар байрлуулж хучилтын үеүдийн болон далангийн дээд үеийн гадаргуугийн жигд байдлыг шалгана. Рейкийн доор гарах хөндий зайн зөвшөөрөгдөх хамгийн их хэмжээг (хүснэгт 3-1)-д үзүүлэв. Хөндлөнгийн хэвгий нь зураг төслийн хэмжээнээс (хүснэгт 3.1)-д зааснаас хэтэрч болохгүй.

Хүснэгт 3-1: Хучилтын үеүдийн болон далангийн дээд үеийн гадаргуугийн хүлцэх алдаа

Үе / Layers	Гадаргуугийн төвшингийн хамгийн их зөрүү	3м-ийн рейкийн доогуурх хөндий зайн хамгийн их хэмжээ	Хөндлөн хэвгийн хүлцэх алдаа
Асфальтобетон хучлага	± 5 мм	3 мм	±0.15%
Суурь үе	- 10 мм	8 мм	±0.30%
Суурийн доод үе	± 15 мм	12 мм	±0.40%
Далангийн гадаргуу	- 25 мм	20 мм	±0.50%
Хөвөө	± 10 мм	8 мм	±0.25%

е) Далан ба ухмалын хажуу налуу

Засаж тэгшилсэн ба нягтарсан ухмал ба далангийн хажуу налууугийн огцмын хүлцэх хэмжээ зураг төсөлд тусгагдсанаас +0,20 байхыг зөвшөөрнө.

ф) Далан ба ухмалын өргөн

Замын тэнхлэгээс ухмалын хажуу налууугийн доод зах хүртэл хэмжсэн хэвтээ зай нь ±200 мм байх ба энэ нь ухмалын ёроолын өргөний зөвшөөрөгдөх хүлцэх алдаа болно. Замын тэнхлэгээс далангийн ирмэг хүртэл хэмжсэн далангийн өргөн нь зурагт үзүүлснээс багагүй, эсвэл зурагт үзүүлснээс +300 мм-ээс ихгүй байна.

г) Хажуугийн шуудууны гүн

Газрын гадаргуу болон хажуугийн шуудууны ёроолын төвшингийн зөрүүгээр хэмжигдсэн шуудууны гүн нь зурагт үзүүлсэн гүнээс багагүй, эсвэл мөн хэмжээнээс 100 мм-ээс ихгүй байна. Хэрэв хажуугийн шуудууны гүн зурагт заасан хэмжээнээс бага хийгдсэн бол зохих хэмжээнд хүртэл засна.

г) Барилгын ажлын хяналт шинжилгээ

Хэрэв өөрөөр заагаагүй бол, энэхүү техникийн шаардлагад тодорхойлсон хэмжээ нь хамгийн бага буюу хязгаарлагдмал хэмжээ бөгөөд төслийн чанарын хяналтын төлөвлөгөөнд тусгагдсанаар, эсвэл техникийн шаардлагын бүлэг 200-д тогтоосон давтамжаар хийгдсэн бүх туршилт, шинжилгээ нь тухайн хэсгүүдэд тодорхойлсон хэмжээний алдаа дээр дурдсантай тэнцүү буюу бага байх нөхцөлд ажлыг овор хэмжээний хувьд болсон гэж үзнэ.

303. ХҮЛЦЭХ АЛДААНААС ЗӨРҮҮТЭЙ АЖЛЫГ ЗАСАХ

Ямар нэг ажлын хэмжээ техникийн шаардлагын зүйл 302-т зааснаас зөрсөн тохиолдолд Гүйцэтгэгч зөрүүтэй хийгдсэн ажлыг бүрэн хэмжээгээр тодорхойлж, дор дурдсан байдлаар дахин засварлана. Дахин засварлах талбайн хамгийн бага хэмжээ нь өнгөн хучлагаас бусад үеүдэд 3 м өргөн, 30 м урттай байна. Харин асфальтбетонбетон хучлагын засварыг хийхдээ хучлагыг нийт өргөнөөр сольж, 50метрээс бага урттай байж болохгүй.

(а) Газар шорооны ажил

Ухмал болон далангийн овор хэмжээний аливаа алдааг Гүйцэтгэгч энэхүү техникийн шаардлагын бүлэг 500-д нийцүүлэн засварлана. Дахин засварлах талбай нь хамгийн багадаа 50 м-ийн уртад, уг хэсгийн нийт өргөнийг хамаарна.

Хэрэв ухмалын налуу нь зурагт заагдсан хэмжээнээс илүү огцом, эсвэл илүү бол зурагт заагдсан хэмжээнд заагдсан хэмжээнд хүртэл засаж тэгшилнэ. Харин далангийн хажуу налуу нь заагдсан хэмжээнээс илүү огцом байвал шатлан ухаж гарсан материалыг зайлуулаад, оронд ижил төрлийн дүүргэгч материалыг дэвсэж нягтруулан налууг тэгшлэх ажлыг бүлэг 500-д нийцүүлэн гүйцэтгэнэ. Ухмал, далангийн хажуу налууг илүү ухах болон гүйцэтгэгч өөрийн буруугаас үүдэн гарсан газар шорооны ажилд нэмэлт төлбөр тооцогдохгүй. Далангийн өндөрлөгөө, хиймэл байгууламжийн ойролцоох буцаан дүүргэлтийн ажил материалын чанар техникийн шаардлагад заасан хэмжээнд хүрэхгүй байгаа хэсэгт гүйцэтгэгч үеийн нийт зузаанд дахин боловсруулалт хийнэ. Дахин засварлах талбайн зөвшөөрөл авахаар танилцуулсан нийт хэсэг бүхлээрээ байх юмуу эсвэл шинжилгээгээр муу гэж нотлогдсон талбайгаас хоёр тийш тус бүр 30м уртад, уг хэсгийн тогтоосон хэмжээтэй байх ба талбайн хэмжээг Инженер тогтооно. Далангийн дээд үе бусад тусгай зорилалтын үеийн төвшин хүлцэх алдаанаас хэтэрсэн бол техникийн шаардлагад нийцүүлэн тэдгээрийг нийт өргөн ба гүнд дахин засна.

(б) Суурь үе ба суурийн доод үе

Хэрэв суурь үеийн төвшин ба өргөн, түүнчлэн гадаргуугийн тэгш байдал нь хүлцэх алдаанаас хэтэрсэн, суурийн доод үеийн төвшин ба өргөн нь хүлцэх алдаанаас хасах тал руу зөрүүтэй байвал эдгээрийг нийт гүнд нь хуулан авч, дахин шинээр дэвсэх ажлыг техникийн шаардлагад нийцүүлэн хийнэ. Харин суурийн доод үеийн төвшин ба өргөн нь хүлцэх алдаанаас нэмэх тал руу хэтэрсэн, гэхдээ энэ нь 50 мм-ээс их бол техникийн шаардлагад заасан хэмжээнд хүртэл хусаж, тэгшилж болох боловч Инженер зөвшөөрөөгүй тохиолдолд үеийг нийт гүнд нь хуулан авч, дахин шинээр дэвсэнэ. Дахин хийх хэсэг нь хамгийн багадаа 30м урт, 3 м-ийн өргөнтэй байх, эсвэл Инженерийн тодорхойлсон талбай байна. Хэрэв суурь болон суурийн доод үеийн барилгын ажлын чанарын шинжилгээний дүн нь Техникийн шаардлагад заасан хэмжээнд хүрэхгүй байгаа хэсэгт Гүйцэтгэгч үеийн нийт зузаанд дахин боловсруулалт хийнэ. Дахин засварлах талбай нь зөвшөөрөл авахаар танилцуулсан нийт хэсэг бүхлээрээ байх, эсвэл шинжилгээний үр дүн муу гарсан байршлаас Инженерийн саналаар хоёр тийш хамгийн багадаа 50 м-ийн уртад, уг хэсгийн нийт өргөнөөр тогтоогдсон хэсэг байна.

304. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Техникийн шаардлагын зүйл 301, 302, 303-т тавигдсан шаардлагуудыг хангахтай холбогдсон зардлыг гүйцэтгэгч ажлын нэгж үнэ ба өртөгтөө оруулан тооцсон гэж үзнэ. Энэхүү техникийн шаардлагын зүйл 302, 303-т заасныг үл харгалзан, газар шорооны ажил, хучилтын үеүдийн хэмжилт ба төлбөрийг хэмжилтийн хөндлөн огтлолын зурагт үндэслэн хийх ба зөвшөөрөгдсөн хүлцэх алдааны дотор байх зөрүүгийн хувьд ямар нэг нэмэгдэл төлбөр хийгдэхгүй. Хэдийгээр эдгээр хүлцэх алдааны дотор байлаа ч гэсэн далангийн дээд үе, хөвөө болон хучилтын бүх үеүдийн баригдсан дундаж зузаан нь зөвшөөрөгдсөн хэмжээнээс бага байж болохгүй.

**БҮЛЭГ 400 – ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ, ӨНГӨН
ХӨРС ХУУЛАЛТ**

БҮЛЭГ 400 – ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ, ӨНГӨН ХӨРС ХУУЛАЛТ

401. ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ	2
(a) Ерөнхий	2
(b) Модноос бусад цэвэрлэгээ	2
(c) Модыг зайлуулах	2
402. ӨНГӨН ХӨРСИЙГ ХУУЛАХ	3
403. ХААЛТ, ХАШЛАГА БА БАЙГУУЛАМЖИЙГ ЗАЙЛУУЛАХ	3
404. ХУУЧИН ГҮҮРИЙГ НУРААХ ЗАЙЛУУЛАХ	3
405. ХАШАА, МОД, ХАШИЛТЫГ ХАМГААЛАХ	3
406. ИНЖЕНЕРИЙН ШУГАМ, СҮЛЖЭЭГ ХАМГААЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ	4
407. ХУДАГ ГАРГАХ	4
408. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР	4

401. ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ

(а) Ерөнхий

Талбайн цэвэрлэгээ гэдэг нь хаалт, саад, өвс, ургамал, хог, шороо, материалын үлдэгдлийг цэвэрлэж зайлуулах, өнгөн хөрс хуулах, бут, сөөг, үндэс, хожуул, зулзаган мод, бул чулуу зэргийг булгалах, сугалах, цэвэрлэж, зайлуулах, тэдгээрийг булгалж сугалахад үүссэн нүхнүүдийг буцаан дүүргэж, засах зэрэг ажлууд юм. Талбайн цэвэрлэгээний бүхий л ажил нь энэхүү техникийн шаардлага, Монгол улсын хууль тогтоомж болон Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний дагуу хийгдэнэ.

Талбайн цэвэрлэгээ хийх ба хог хаягдлыг зайлуулах явцад Гүйцэтгэгч нь нийтийн болон хувийн өмчийг гэмтээхгүй ба замын хөдөлгөөнд саад учруулахгүй байхаар анхааралтай ажиллана. Зурагт үзүүлсэн эсвэл Инженерийн зааварласан газруудад талбайн цэвэрлэгээг хийнэ.

Гүйцэтгэгч өөрсдийн түр суурин, шороон ба чулууны орд газар, материал нөөцлөх талбай ба хаягдал зайлуулах газар болон бусад ажлын талбайд Инженерийн заавраар талбайн цэвэрлэгээг хийнэ. Дээр дурдсан газрууд нь төлбөрт хамаарагдахгүй.

Инженер талбайн цэвэрлэгээний явцад буулгаж, зайлуулж болохгүй тусгай мод, хожуул эсвэл объектуудын талаар зааварлана. Гүйцэтгэгч талбайн цэвэрлэгээний явцад нийтийн болон хувийн өмчийг гэмтээхгүй байх шаардлагатай бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах ба хэрэв өмч хөрөнгө, инженерийн шугам сүлжээнд ямар нэгэн гэмтэл учруулбал Гүйцэтгэгч нь гарсан хохирлыг бүрэн засах хариуцлагыг хүлээнэ.

Өнгөн хөрсийг зурагт заасан ба Инженерийн зааварчилсан гүнд хуулж, зайлуулах ажил талбайн цэвэрлэгээнд багтана.

(а) Модноос бусад талбайн цэвэрлэгээ

Инженерийн заавраар талбай дахь цэвэрлэгээг хийсэн бол цэвэрлэж зайлуулсан бүх зүйлс болон материал нь модноос бусад цэвэрлэгээнд хамаарна. Нийтийн болон хувийн өмчид хохирол учруулах буюу хүрээлэн буй орчинд хамаарах шаардлагыг зөрчихгүйгээр гүйцэтгэгч нь хаягдал материалыг зайлуулах буюу хаяна. Техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу хаягдал зайлуулах цэгийг тогтооно. Хэрэв Гүйцэтгэгч урьдчилан талбайг цэвэрлэх ажлыг хийсний дараа гол ажил эхлэхээс өмнө зүлэг дахин ургавал нэмэлтээр талбайн цэвэрлэгээг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

(b) Модыг зайлуулах

Талбайн цэвэрлэгээгээр зайлуулан цэвэрлэх модыг хаяж болохгүй, Инженерийн заасан газар шилжүүлэн суулгана.

Гүйцэтгэгч Инженерийн зааврын дагуу талбайн цэвэрлэгээг хийхдээ аль болох газрын төвшинтэй ойролцоогоор модыг тайрч авах ба энэ Техникийн шаардлагын дэд зүйл 401(2)-ийн заалтуудын дагуу хаягдал зайлуулах цэгт хаяна. Мөн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний зааврын дагуу модны гол, том хэмжээний салаа мөчир зэргийг тайрч болно.

Гүйцэтгэгч хожуул болон модны үндсийг булгалан сугалж авч зайлуулна. Хожуул болон үндсийг сугалж булгалахад үүссэн бүх нүхийг зөвшөөрөгдөх материалаар буцаан дүүргэж газрын төвшинд хүртэл эсвэл ухмал хэсэгт бол шороон далангийн төвшинд хүртэл 95% (AASHTO T180) байхаар нягтруулна.

402. ӨНГӨН ХӨРСИЙГ ХУУЛАХ

Талбайн цэвэрлэгээ хийгдэх хэсгүүдэд өнгөн хөрсийг зурагт заасан буюу Инженерийн зааварчилсан гүнд Гүйцэтгэгч хуулж зайлуулна. Хэрэв Гүйцэтгэгч заагдсан гүнээс илүү гүн хөрсийг хуулбал өөрийн өртгөөр заагдсан хэмжээнд хүртэл дүүргэж нягтруулна.

403. ХААЛТ, ХАШЛАГА БА БАЙГУУЛАМЖИЙГ ЗАЙЛУУЛАХ

Гүйцэтгэгч зураг болон Инженерийн зааварчилгааны дагуу барилга, байшин, суурь, хуучин төмөрбетон хоолой, хашаа болон хиймэл байгууламж болон хөшөө, овоо болон бусад байгууламжуудыг бүхэлд нь болон хэсэгчлэн буулгах, нураан зайлуулах ажлыг хийнэ. Инженерийн шийдвэрийн дагуу дахин ашиглах боломжгүй бүх төрлийн материалыг Гүйцэтгэгч талбайгаас зайлуулан энэхүү Техникийн шаардлагын 401(b)-д заасны дагуу хаягдал зайлуулах цэгт аваачиж буулгана. Хэрэглэж болох буулгагдсан бүх материал нь Захиалагчийн өмч байх бөгөөд захиалагч тэдгээрийг ачиж явах хүртэл эсвэл баталгаат засварын хугацаа дуусах хүртэл Гүйцэтгэгч хадгалан хамгаална.

Барилга, байгууламж, хуучин суурь, хоолой, хашаанууд болон ямар нэгэн хиймэл байгууламжуудыг буулган зайлуулснаас үүсэх хоосон зайг энэхүү Техникийн шаардлагын зүйл 507-д заасан шаардлагуудын дагуу буцаан дүүргэж нягтруулна.

404. ХУУЧИН ГҮҮРИЙГ НУРААХ ЗАЙЛУУЛАХ

Инженерийн зааварласан үед Гүйцэтгэгч янз бүрийн байршилд байгаа хуучин төмөрбетон гүүрүүдийг нураах бол нураагдсан гүүрээс гарсан дахин ашиглах боломжтой гэж үзсэн материалыг Инженерийн зааварчлагын дагуу Захиалагчид хүлээлгэн өгнө. Үлдсэн материалыг энэ Техникийн шаардлагын дэд зүйл 401 (b)-д заасны дагуу Гүйцэтгэгч талбайгаас зайлуулан заагдсан газар аваачиж хаяна. Гүүрийг нураах ажилд хайс, тавцан, завсрын тулгуур, дам нуруу болон усны доод төвшингөөс дээших байгууламжуудыг зайлуулах ажил орно.

Гүйцэтгэгч гүүрийг нураасны дараа гүүрийн талбайд эрэг хөвөөг сайтар хийж өгөх ёстой. Гүйцэтгэгч, орлуулах түр гүүр болон зөвшөөрөгдсөн түр ажлуудыг гүйцэтгэж дуусан тээврийн хөдөлгөөнийг нээх хүртэл гүүрийг нурааж болохгүй. Гүүрийг нураах үед гарах материал нь устай холилдож бохирдохоос сэргийлсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг гүйцэтгэгч авна. Хэрэв гүүрийг нураах үед ямар нэг материал ус руу унавал Гүйцэтгэгч нэн даруйд нь уснаас гаргах ёстой.

405. ХАШАА, МОД, ХАШИЛТЫГ ХАМГААЛАХ

Инженерийн эвдлэлгүй орхихыг зааварласан ямар нэгэн жим зөрөг, хашаа, хана, хашилт, мод, бут, зүлэг ба бусад зүйл зэргийг ажил гүйцэтгэж байх явцад эвдэрч гэмтэхээс хамгаалсан шаардлагатай бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг Гүйцэтгэгч авна. Хангалттай урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүйгээс болж ямар нэг хохирол учирвал сэргээн засварлах ажлыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

406. ИНЖЕНЕРИЙН ШУГАМ, СҮЛЖЭЭГ ХАМГААЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ

Инженерийн шугам сүлжээг хамгаалах, шилжүүлэх ажлыг тухайн шугам сүлжээний ашиглагчийн заавар болон Инженерийн зөвшөөрлийн дагуу гүйцэтгэнэ. Гарах зардлыг гүйцэтгэлээр нь Гүйцэтгэгчид олгоно.

407. ХУДАГ ГАРГАХ

Инженерийн зааварчилснаар худгийг гаргаж болно. Худаг гаргахтай холбогдон гарах зардлыг төсөвт заасан болон захиалагчийн санал гүйцэтгэлээр нь Гүйцэтгэгчид олгоно.

408. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

(a) Зүйл: Талбайн цэвэрлэгээ

Нэгж : Га

Замын чулуун ба шороон ордын талбай болон замын уртад хийх талбайн цэвэрлэгээний ажлыг (байгууламжаас бусад) гектараар хэмжинэ. Түр суурин, чулуун ба шороон орд, нөөц материал, хаягдал материалын цэг, тэдгээрт хүрэх туслах замууд,суваг, шуудууны талбайн цэвэрлэгээний зардлыг Гүйцэтгэгч өртөг зардалдаа багтаасан гэж тооцно. Талбайн цэвэрлэгээний ажлын зардалд дараах зүйлүүд багтана. Үүнд:

- Өвс, ногоо, хог шороо, бут ширэг болон бүх төрлийн бартаа саадыг цэвэрлэх, булгалж сугалах, хаях;
- Өнгөн хөрсийг хуулж зайлуулах;
- Бул чулуу, хожуул болон үндсийг зайлуулах гэх мэт мод тайрах ажил;
- Шаардлагатай тээвэрлэлт;
- Ажлыг бүрэн дуусгахад шаардагдах ажилчид, материал, багаж, техник дагалдах материалуудын нөхөн төлбөр;
- Энэ техникийн шаардлагын зүйл **401, 402** болон **405**-ын шаардлагыг хангах.

(b) Зүйл: Төмөрбетон хоолойнуудыг зайлуулах

Нэгж : Метр

Төмөрбетон хоолойг зайлуулах ажлыг шугаман метрээр хэмжинэ. Уртын хэмжээс нь хуучин хоолойны тэнхлэгийн дагуу хэмжигдэнэ. Төмөрбетон хоолойнуудыг зайлуулах ажлын үнэлгээнд дараах ажлууд орно:

- Төмөрбетон хоолойн орох гарах амсрын байгууламжуудыг ухаж аван зайлуулах;
- Бетон ба чулуун өрлөг, толгой, хана, далавч, рисбермыг буулгаж, зайлуулах;
- Буцаан дүүргэх;
- Бүх төрлийн тээвэрлэлт;
- Нурааж зайлуулах ажлыг Техникийн шаардлагын зүйл **403**-т заасны дагуу гүйцэтгэх;
- Шаардлагатай бүх нураан буулгах ажил;

- Нураасан зүйлсийг хаяж зайлуулах.

(с) Зүйл: Төмөрбетон гүүрийг нураан буулгах

Нэгж : Бүхэлд нь төлөх мөнгө

Бетон гүүрийг нураан буулгах үнэлгээний тогтолцоо нь бүхэлд нь төлөх мөнгө байна. Гүүрийг нураах үнэлгээнд дараах өртгүүд орно:

- Нураах;
- Хайс, тавцан, завсрын тулгуур, дам нуруу болон усны доод төвшингөөс дээших бусад байгууламжууд гэх мэт дахин ашиглах боломжтой материал;
- Шаардлагатай бүх тээвэрлэлтүүд;
- Ажлыг бүрэн дуусгахад шаардагдах ажилчид, материал, багаж, техник дагалдах материалуудын нөхөн төлбөр;
- Энэхүү техникийн шаардлагын зүйл **404-г** заасан шаардлагуудыг мөрдөх.

(d) Зүйл: Хөшөө, овоо болон бусад байгууламжийг шилжүүлэх буюу зайлуулах

Нэгж: Гүйцэтгэлээр төлөгдөх төлбөр

Инженерийн зааварчилснаар хийгдэнэ гэж заасан 408(b), 408(c), 408(d)- ээс бусад хөшөө, овоо болон бусад байгууламжуудыг зайлуулах буюу шилжүүлэх ажлын төлбөрийг гүйцэтгэлээр хийнэ.

(e) Зүйл: Худаг гаргах

Нэгж: метр

Худаг болгон цахилгаан шахуургатай хоолойд таарсан тагтай байна.

Өрөмдөх	Гүн	Нэгж
Эхний 30 м	0-30 м	м/м
Нэмэлт гүн	30-40 м	м/м
Нэмэлт гүн	40-50м	м/м
Нэмэлт гүн	50-60м	м/м
Нэмэлт гүн	60 -ээс дээш	м/м

f) Зүйл: Холбоо ба цахилгааны шугамыг өргөх, шилжүүлэх

Нэгж: Захиалагчийн санал, Гүйцэтгэлээр төлөгдөх төлбөр

БҮЛЭГ 500 - ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ

БҮЛЭГ 500 - ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ / SECTION 500 – EARTHWORK

501. БҮЛГИЙН АГУУЛГА	2
502. ЕРӨНХИЙ.....	2
503. УХМАЛ МАТЕРИАЛЫН АНГИЛАЛ	3
504. ДАЛАНГИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ.....	4
505. ДАЛАН БАРИХ.....	4
506. НАМАГТАЙ БОЛОН БАМБАЛЗУУР ХӨРСИЙГ ЧУЛУУГААР ДҮҮРГЭХ.....	7
507. ХУУЧИН АСФАЛЬТОБЕТОН ХУЧЛАГЫГ ХУУЛАХ.....	7
508. ДАЛАНГ НЯГТРУУЛАХ.....	8
509. ХАЯГДАЛ МАТЕРИАЛ.....	9
510. ТУРШИЛТЫН НЯГТРУУЛАЛТ	10
511. ХАЖУУ НАЛУУГ ТЭГШИЛЖ ЗАСАХ.....	10
512. ЗҮЛЭГЖҮҮЛЭЛТ ХИЙХ.....	10
513. ДАЛАНГИЙН ОГЦОМ ХАЖУУ НАЛУУГ ГЕОТОРООР БЭХЛЭХ.....	10
514. ХАЖУУГИЙН ШУУДУУ	11
515. УХМАЛЫН ХАЖУУ НАЛУУ ДАХЬ ТОГТВОРГУЙ МАТЕРИАЛ.....	11
516. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР.....	11

501. БҮЛГИЙН АГУУЛГА

Энэ бүлэгт далан барих болон ухмалын ухалтын ажил багтах ба эдгээр нь хажуугийн шуудуу, шатлал, даланд дүүргэгч материалыг асгах, тэгшлэх, нягтруулах, суурийн доод үеийн үеийн материалыг асгах, тэгшлэх, нягтруулах, намгархаг газрыг ухах, хатуу чулуун дүүргэлт хийх, зүлэгжүүлэх ажлууд багтана.

502. ЕРӨНХИЙ

Газар шорооны ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч Инженерийн зааврын дагуу талбайн цэвэрлэгээ, мод, хожуулыг булгалах, сугалах, намаг болон шаварлаг хөрсийг зайлуулах, өнгөн хөрсийг хуулах зэрэг ажлыг хийнэ. Гүйцэтгэгч нь газар шорооны ажлыг Инженерийн зааварчилснаар буюу зургийн дагуу гүйцэтгэнэ.

Газар шорооны ажлыг энэхүү шаардлагын дагуу хийж гүйцэтгээгүй тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн зардлаар дахиж гүйцэтгэнэ. Ухмалаас гарсан тохиромжтой материалыг даланд хэрэглэж болно. Техникийн үзүүлэлтийн хувьд тохирохгүй материалыг далангийн дүүргэлтэд хэрэглэхгүй.

Инженерийн санал болгосон лабораторийн шинжилгээгээр шаардлага хангахгүй гэдэг нь нотлогдсон материалыг далангийн дүүргэлт болон далангийн дээд үе ашиглахгүй

Тохиромжгүй материалд дараах зүйлс багтах бөгөөд зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. (Далан ба ухмалд хамаарна)

Үүнд:

- ✓ Өнгөн хөрс, намгархаг хөрс, хүлэртэй хөрс, хожуул, органик бодис 2%-иас их агуулсан шороо, амархан мууддаг материал холилдсон хөрс шороо;
- ✓ Шигшүүрийн 0.075мм-ийн нүхээр өнгөрөх хэсгүүдийн жин нь хуурай үеийн жингийн 15 %-иас их;
- ✓ Хөөлт нь 2 %-иас их;
- ✓ Уян налархайн индекс 9 %-иас их;
- ✓ Бул чулуу, хад болон 75 мм-ээс том хэмжээтэй чулуу,
- ✓ Нягтрах боломжгүй, тогтворгүй элсэн болон бусад шаардлага хангахгүй шаварлаг материал (MNS 2487:2004 стандартаар ангилагдсан элсэн материал).

Хөрс нь “Тохиромжгүй материал”-д заасан дээрхи үзүүлэлтүүдийн аль нэг шаардлагыг хангахгүй нь шинжилгээгээр нотлогдсон бол тухайн материалыг солих ба тохиромжгүй материалыг дүүргэлтэнд ашиглахгүй. Тохирохгүй буюу эсвэл илүү гарсан үл тохирох материалыг Гүйцэтгэгч ашиглагдахгүй материалын талбай руу зөөж зайлуулна. Гүйцэтгэгч нь дүүргэлтэд тохирох зохист ширхэглэл бүхий ердийн хайрган материалыг Инженер зөвшөөрсөн ухмал ба тусгайлан олборлох талбай буюу шороон ордоос зөөвөрлөн ашиглана.

Инженер өөрөөр заагаагүй тохиолдолд хуучин асфальтобетон хучлага болон суурийг өөрөө явдаг, буталж жижиглэх төхөөрөмжийг ашиглан 0,2 м хүртэл гүнд ухаж, шаардлага хангасан материал гэдэг нь шинжилгээгээр тогтоогдсон тохиолдолд суурийн доод үед холих зорилгоор урьдчилан бэлдсэн талбайд овоолго хийн ашиглаж болно.

Тохирохгүй буюу эсвэл илүү гарсан үл тохирох материалыг Гүйцэтгэгч ашиглагдахгүй материалын талбай руу зөөж зайлуулна. Гүйцэтгэгч нь дүүргэлтэд тохирох материалыг зөвхөн

ухмал ба тусгайлан олборлох талбайгаас ашиглаж болно.

Даланд шаардлагатай материалын хэмжээ нь ухмалаас гарсан тохиромжтой материалаас илүү байвал Гүйцэтгэгч Инженерийн заавраар (трассын дагуу 50м-т) ухмалыг өргөтгөх эсвэл шинээр шороон орд болгон нээж болно.

Гүйцэтгэгч нь ухмалын болон дүүргэгч материал дэвссэн гадаргууг цаг агаарын нөлөөлөл, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас гэмтэж эвдрэхээс байнга сэргийлж, хамгаалах үүрэгтэй. Хэрэв ямар нэг эвдрэл гарсан тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн зардлаар тухайн ажлыг засаж хийнэ. Гүйцэтгэгч далангийн дүүргэлтэд тохиромжтой материалыг ашигласан эсэхийг баталгаажуулах үүднээс нэмэлт хяналт хийнэ. Хэрэв ямар нэг тохиромжгүй материал ашигласан бол түүнийг зайлуулан оронд нь тохиромжтой материал дэвсэх ажлыг Гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх болно. Ухмал, далан, хажуугийн шуудуу, хөвөө зэргийг тогтоосон налууд хүртэл тэгшилж засах ажлуудыг газар шорооны ажил явагдаж буй байршил, төвшинд нэг зэрэг хийнэ. Гүйцэтгэгч нь газар шорооны ажлыг хийж гүйцэтгэхдээ Инженерийн зааварчилгааг биелүүлэх үүрэгтэй.

503. УХМАЛ МАТЕРИАЛЫН АНГИЛАЛ

Замын ухмалаас гарсан материалыг дараах байдлаар ангилна:

(a) Ердийн ухалт

- Ердийн ухалтын ажилд хадан хөрсийг ухах болон хучилт хуулахаас бусад бүх ухалтын ажлууд орно.
- Ердийн ухалтад намагжсан, намгаас гарсан материал, тогтворгүй элс мөн багтана.

(b) Хадан хөрсийг ухах

Хадан хөрсний ухмал гэдэгт тэсэлж суллан улмаар шингэн ба хийн шахуургат бутлагч төхөөрөмж ашиглан боловсруулах материалыг хэлнэ. Хадан хөрсний үнэлгээнд тухайн нөхцөл байдалд шаардагдах бүх аргаар хийх ухалтын ажлууд орсон гэж тооцно.

0.3 м³ -ээс том чулууг ухаж зайлуулах ажил нь хатуу хадан материалыг зайлуулах ажлын төрөлд хамаарна. 0.3 м³ -ээс бага эзлэхүүнтэй бат бөх хатуу чулууг ухах ажил нь ердийн ухалтад хамаарна. Ухмалын ангиллыг Инженер тогтоох ба түүний шийдвэр эцсийнх бөгөөд Гүйцэтгэгч энэ шийдвэрийг мөрдөж ажиллана. Инженерийн зүгээс хадан хөрсийг ухах ажилд тэсэлгээг зайлшгүй шаардлагатай гэж үзэх хүртэл ухалт тэсэлгээг хийхгүй. Материалын ангиллын талаар маргаан гарах тохиолдолд Инженерийн шийдвэр эцсийн бөгөөд дагаж мөрдөх шийдвэр энэ байна.

Ухмалаас гарсан хатуу материалыг MNS 2998:2009 стандарт заасны дагуу цилиндр шахалтын бат бэхийн туршилтаар чулууны маркыг тодорхойлох ба үр дүнг Инженер баталгаажуулсан байна.

Хатуу материалыг ухаж зайлуулсаны дараа ухмалыг буцааж дүүргэхдээ зурагт заасан хэмжээгээр Инженерийн зөвшөөрсөн, шинжилгээгээр баталгаажсан зохист ширхэглэл бүхий хайрган материалыг дэвсэнэ. Ухмалын ул хөрс шинжилгээр тохирохгүй гэдэг нь нотлогдсон тохиолдолд зурагт заасан гүнд буюу Инженерийн зааварчилсан гүн (30см хүртэл) ухаж, материалын өөр эх үүсвэрээс тохирсон материалаар солино. Лабораторийн шинжилгээр шавар

болон элсний агууламж стандартад зааснаас их болох нь тогтоогдсон материалыг дүүргэлтэнд ашиглахгүй бөгөөд Инженерийн шийдвэрийг баримтлана.

Ухмалын материалд тавигдах шаардлагыг хангаж байгаа боловч үеийн зузаан нь 30 см-ээс бага байвал далангийн дээд үед хийх материалыг заавал зөөвөрлөн авчирч дэвсэнэ.

504. ДАЛАНГИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ

Далан барих газрын хэвгий 1 : 4 - аас их байвал Гүйцэтгэгч хөрсний өнгөн үеийг хуулсны дараа даланг барих ажлыг эхлэхээс өмнө газрыг шатлан ухна. Дэвсэх ба нягтруулах тоног төхөөрөмжийг ажиллах боломж олгох үүднээс далангийн доорх эхний шатлалыг хангалттай өргөн зай гаргаж ухна. Дүүргэлт хийж нягтруулсны дараа дараагийн шатлалыг ухна. Газрыг шаталж ухах үед гарсан материал нь үл тохирох материал бол ашиглагдахгүй материалын талбай руу зайлуулж, зөөвөрлөх ба тохирох материал бол даланд ашиглана. Шаталж ухах өндөр нь 200-250 мм эсвэл Инженерийн зааварчилсны дагуу байна. Гүйцэтгэгч нь далангийн доорх ул хөрсийг нийт өргөнийх нь дагууд 150 мм гүнд хуурай үеийн хамгийн их нягтын 95%-иас багагүй байхаар нягтруулна.

Далангийн доорх ул хөрс болон шаталсан талбайн нягт нь дээр зааснаас бага байвал Инженерийн зааварласны дагуу баригдаж буй нийт өргөнд 150 мм буюу түүнээс илүү гүнд дахин сэндийлж, ХҮХИН-ын 98%-иас багагүй (AASHTO T180) нягтралтай болтол индүүднэ.

Нягтруулалт хийх үед хөрсний чийгийн хэмжээ тохиромжтой чийгээс (AASHTO T180) 1%-иас бага, 2%-иас их байж болохгүй. Чийгийн хэмжээ тохиромжтой агуулгаас их бол хөрсийг хатаах ба бага бол дахин чийг өгнө. Далангийн ажилд зарцуулах төлбөрөөс тусдаа ямар нэг төлбөр шатлалын ажилд зориулан хийгдэхгүй.

Далангийн доорх ул хөрсийг дүүргэлт хийхэд тохиромжгүй гэдэг нь шинжилгээгээр нотлогдож, Инженер зөвшөөрсөн тохиолдолд Гүйцэтгэгч ул хөрсийг Инженерийн заасан гүнд хүртэл ухан, ашиглагдахгүй материалын талбайд зөөж зайлуулан, оронд нь зохист ширхэглэл бүхий хайрган (тохиромжтой) материалыг дэвсэж, зохих шаардлагын хэмжээнд хүртэл нягтруулна. Инженерийн зааварчилгаагаар солих материалд хатуу материал орсон байж болно. Энэхүү тохиромжгүй хөрсийг солих нэмэлт ажилд төлбөр хийгдэх эсэхийг гэрээ, захиалагчийн санал болон ажлын даалгаварын хүрээнд Инженер шийдвэрлэнэ.

505. ДАЛАН БАРИХ

Далангийн барилгын ажил

- Тохиромжгүй гэж үзэхээс бусад тохиолдолд замын ухмалаас гарсан материалыг даланд хэрэглэж болно. Нөөц газраас авах материалыг зөвхөн ухмалаас гарах материал хангалтгүй гэж Гүйцэтгэгчийн нотолж, Инженерийн зөвшөөрсөн газарт хэрэглэнэ.
- Материалыг зөвхөн чийгтэйгээс болоод тохиромжгүй материал гэж үзэхгүй. Чийгтэй материалыг урсалтын хязгаар нь техникийн шаардлагад заасан чийгийн хэмжээнд нийцэх хүртэл нь борнойдож хатаана.

“Далангийн дүүргэгч” материал гэдэгт дараах шаардлагыг хангасан материал хамаарна.

Үүнд:

- Өнгөн хөрс, намгархаг хөрс, хүлэртэй хөрс, хожуул, органик бодисыг 2 %-иас бага агуулсан шороо;

- Хөрсний ачаа даацын үзүүлэлт (CBR) нь 30 %-иас их буюу тэнцүү;
- Шигшүүрийн 0.075 мм-ийн нүхээр өнгөрөх хэсгүүдийн жин нь хуурай үеийн жингийн 15 %-иас бага;
- Хөөлт нь 2 %-иас бага;
- Уян налархайн индекс 7-оос бага.

“Далангийн дүүргэлт” гэдэг нь сонгосон зохист ширхэглэл бүхий шороон ордоос байгалийн материалыг ашиглан, хучилтын үндсэн буюу суурийн доод үеийн доор байрлах тусгайлан үечлэн дэвсэж нягтруулсан хайрган материалыг хэлнэ.

Тухайн орон нутгийн онцлог материалын шинж чанараас хамаарч туршилтын үр дүнгээр тогтоогдсон (газар дээрхи судлагаа, холбогдох норм дүрэм стандартад үндэслэн) шаардлагатай гэж үзсэн тохиолдолд далангийн дүүргэлтийн материалын шинж чанарыг MNS AASHTO M57-2004, MNS AASHTO M 145-2004, MNS ASTM D 1241-2002 стандартанд нийцүүлэн Инженер өөрчилж болно.

“Далангийн дээд үе” гэдэг нь сонгосон зохист ширхэглэл бүхий материалыг ашиглан, хучилтын үндсэн буюу суурийн доод үеийн доор байрлах тусгайлан дэвсэж нягтруулсан хайрган үеийг хэлнэ.

Далангийн дээд үеийн материалыг шууд байгалиас олборлож авах буюу эсвэл буталж, шигшин тодорхой харьцаагаар дахин хольж бэлтгэх замаар чанарын үзүүлэлтийг хангуулах ба сайжруулалтанд нэмэлт төлбөр тооцогдохгүй.

Гүйцэтгэгч нь өөрийн зам барилгын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан материалын давтан шинжилгээг аль болох шуурхай явуулах ба талбайд нягт шалгахаас өмнө шинжилгээ батлагдсан байна. Инженер зөвшөөрөөгүй материалыг талбайгаас зайлуулах. Мөн материал буулгасан талбайгаас дээж аваад 3-7 хоногт шинжилгээнд хамруулсан байх.

Зураг төсөлд өөрөөр үзүүлээгүй, эсвэл Инженер өөрөөр зааварчлаагүй бол Инженерийн зөвшөөрсөн шороон орд, эсвэл ухмалаас гарсан тохиромжтой дүүргэгч материалыг далан барихад ашиглана. Өөрөөр тогтоогоогүй бол Гүйцэтгэгч нь газар шорооны ажилд шаардлагатай материал олборлох талбай, ашиглагдахгүй материалын талбайг сонгож, Инженерээс урьдчилан зөвшөөрөл авч, орон нутгийн Засаг захиргааны байгууллагуудтай зөвшилцөнө. Гүйцэтгэгч нь материал олборлох талбай ба замын ухмалаас гарсан материалын тохирох эсэхийг шалгах бөгөөд газрыг ашиглалтын асуудлыг Инженерийн зөвшөөрлийг авсаны дараа баталгаажуулна. Материал олборлох талбай, ашиглагдахгүй материалын талбайг эзэмших болон дүүргэгч материал болон шороог тээвэрлэхтэй холбоотой төлбөрүүд тусгайлан хийгдэхгүй.

Далангийн дээд талын 0.25м зузаантай хэсгийг далангийн дээд хэсэг гэж тодорхойлно. Инженерийн зааварчилснаас өөрөөр заагаагүй буюу зурагт үзүүлээгүй бол далангийн дээд хэсэгт дээр дурдсан үзүүлэлт бүхий материалыг Инженерийн зөвшөөрлийн дагуу хэрэглэнэ.

Ухмалын ул хөрс нь далангийн дээд үед хэрэглэх материалын шаардлагыг хангахгүй нөхцөлд (Ухмал нь $CBR < 30\%$, 0.075мм -ээр өнгөрсөн хэсэг $> 15\%$ үед) далан, замын зорчих хэсэг ба хөвөөний доорх үеийн шаардлага хангасан материалаар хөрс солилт хийх шаардлагатай ба холбоотой төлбөрүүд тусгайлан хийгдэхгүй бөгөөд гэрээний дагуу Инженер эцсийн шийдвэрийг гаргана.

Ухмалын ул хөрс нь далангийн дээд хэсэгт хэрэглэх материалын шаардлагыг хангахгүй нөхцөлд замын зорчих хэсэг ба хөвөөний доорх үеийн шаардлага хангасан материалаар хийх ёстой. Далангийн дээд үеийн материалыг шууд байгалиас олборлож авах буюу эсвэл буталж, шигшин тодорхой харьцаагаар дахин хольж бэлтгэх замаар чанарын үзүүлэлтийг хангуулах ба сайжруулалтанд нэмэлт төлбөр тооцогдохгүй.

“Ухмал”-ын ул хөрсний материал дараах шаардлагыг хангасан байх шаардлагатай. Үүнд:

- Өнгөн хөрс, намгархаг хөрс, хүлэртэй хөрс, хожуул, органик бодисыг 2 %-иас бага агуулсан шороо;
- Ачаа даацын үзүүлэлт 30 %-иас их буюу тэнцүү; ($CBR \geq 30 \%$)
- Шигшүүрийн 0.075 мм-ийн нүхээр өнгөрөх хэсгүүдийн жин нь хуурай үеийн жингийн 15 %-иас бага;
- Хөөлт нь 2 %-иас бага;
- Урсгалын хязгаар ≤ 30
- Уян налархайн индекс ≤ 7

Ухмалын материалд тавигдах шаардлагыг хангаж байгаа боловч үеийн зузаан нь 30 см-ээс бага байвал далангийн дээд үед хийх зохист ширхэглэл бүхий материалыг зөөвөрлөн авчирч дэвсэнэ. Ухмал дахь далангийн дээд үеийн дор байгаа шороо нь шаардлага хангахгүй тохиолдолд Гүйцэтгэгч нь тохирохгүй материалыг Инженерийн заасан гүнд хүртэл ухан авч, ашиглагдахгүй материалын талбайд зөөж зайлуулан тохирох материалаар сольж, нягтралын зэрэг нь далангийн дээд үетэй ижил болтол нягтруулна. Солих үеийн зузаан нь зурагт зааснаас багагүй буюу Инженерийн заасан гүнийг баримтлана.

Гүйцэтгэгч нь газар шорооны ажлыг дарааллын дагуу тасралтгүй аргаар хийж гүйцэтгэх бөгөөд үе тус бүрийг барьж дуусах бүртээ баталгаа авах хүсэлтээ бичгээр үйлдэнэ. Баталгаа авсны дараа дараагийн үе шатны ажлыг хийнэ.

Зөвшөөрөл авсан талбайг 48 цагаас дээш хугацаагаар хамгаалалтгүйгээр орхисон тохиолдолд Гүйцэтгэгч нь талбайн хяналтын баталгааг дахин авна. Энэ үеийн дээр шинээр үе дэвсэхийн өмнө Инженер шаардлагатай гэж үзвэл урьд нь дэвссэн үеийг дахин сэргээн засварлана.

Нягтруулагч тоног төхөөрөмж болон ажлын горим, нягтруулалтыг чанартай жигд хийх технологи аргачлалаа боловсруулан талбайн туршилтын үр дүнгийн хамт Инженерт танилцуулж батлуулна. Гүйцэтгэгч нь цаашид далангийн ажил хийхдээ уг аргачлалын дагуу технологийн горимыг баримталж ажиллана.

Хэрэв далангийн ажлыг эхлэхэд түүнд хэрэглэх шороон материал, тоног төхөөрөмж болон ажлын горим нь талбайн туршилтын үед үзүүлж байснаас өөр байвал Инженер болон түүний төлөөлөгч ажлыг урьдчилсан мэдэгдэлгүйгээр зогсоох эрхтэй. Ийм тохиолдолд Гүйцэтгэгч нь шинээр талбайн туршилтыг хийж Инженерээс зөвшөөрөл авна. Нягтруулж байгаа үеийн зузаан нь 250 мм-ээс буюу инженерийн зөвшөөрсөн хэмжээнээс хэтрэх ёсгүй. Үе бүр зохистой ширхэглэл бүхий чулуунаас бүрдэх бөгөөд жижиг ширхэглэлтэй чулуунууд хайргатай жигд холилдсон байна. Үе бүрийг далангийн нийт өргөний хэмжээнд 507-д заасны дагуу нягтруулна.

Өндөр далан барих тохиолдолд хэрэв Инженер зөвшөөрвөл далангийн дээд үеэс 1.5

метрээс доош орших төвшинд 250 мм-ийн хүртэл хэмжээтэй дүүргэгч хатуу материалыг далангийн үед ашиглаж болно. Өндөрлөгөөнд хэрэглэх хатуу материал (чулуун дүүргэлт) нь далангийн нийт өргөнд тараагдахад нягтруулаагүй үеийн зузаан нь 500мм-ээс хэтрэхгүй байвал зохино. Далангийн шороог бульдозер эсвэл автогрейдерээр тарааж тэгшилнэ.

Инженер нь ажлын аргачлал, талбайн туршилтыг хянаж шалгаад өөрийн санал зөвлөмжийг уг аргачлалд оруулж болно.

Далангийн хажуу налууд материал нэмж дэвсэхээс бусад тохиолдолд даланг барихдаа Гүйцэтгэгч нь далангийн нягтруулалт, суулт, агшилтын зөвшөөрөгдөх хэмжээг бодолцох ёстой. Даланг барих явцад материал нягтарч суух, доод үе рүүгээ шигдэх тохиолдол гарвал Гүйцэтгэгч өөрийн зардлаар үе бүрийн тогтоосон төвшин ба өргөнд хүртэл зөвшөөрөгдсөн дүүргэгч материалыг дахин дэвсэж нягтруулах ёстой. Гүйцэтгэгч нь далан барих ажлын үед нягтруулсан шороон үеийн хамгаалалтгүй гадаргуу дээгүүр ямар нэгэн тээврийн хэрэгслийг явуулахгүй байх арга хэмжээг авна.

Хэрэв нягтруулсан шороон үе нь хэв гажилтад орох эсвэл тээврийн хэрэгсэл дээгүүр нь явж мөр үүсэх эсвэл эвдсэн бол дараагийн үе шатны ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч нь тухайн үеийг дахин засварлаж нягтруулна.

Барьж байгаа буюу дууссан далан дээр дүүргэгч материалыг овоолж болохгүй, ийм хэлбэрээр зам хаах, хөдөлгөөн хязгаарлахыг хориглоно.

Талбайд буулгасан дүүргэлтийн материалыг овоолго хэлбэрээр 24 цагаас дээш хугацаагаар орхиж болохгүй бөгөөд хамхуул өвс зэрэг органик хольц холилдсон, бөөгнөрсөн хэсгийг талбайгаас зайлуулж, тохирох материалыг дахин дэвсэнэ.

506. НАМАГТАЙ БОЛОН БАМБАЛЗУУР ХӨРСИЙГ ЧУЛУУГААР ДҮҮРГЭХ

Намагтай болон бамбалзуур хөрстэй, чийг ихээр хуримталсан газрыг ухан Инженерийн зааварласан хаягдал зайлуулах газарт хаяж дараах байдлаар чулуун дүүргэлтийг дүүргэнэ.

- Инженерийн заавраар намагтай газарт Гүйцэтгэгч зөвшөөрөгдсөн чулууг дэвсэнэ. Чулуун дүүргэлтийг зааварласан газарт нийтэд нь сайтар суух хүртэл жигд үеэр дэвсэж, индүүдэн хөдөлгөөн явуулна. Тогтворгүй ул суурь дээр чулуун дүүргэлтийг хийх бол материалыг ажлын талбайд ойрхон газарт буулгаж далангийн өндөр нь барилгын ажлын хүнд машин механизмын ачааллыг даах боломжтой болох хүртэл нь бульдозероор түрж тараах замаар хийнэ. Хөвөөн дээр дүүргэлт хийхээс өмнө далангийн доорх хэсэгт чулуун дүүргэлтийг хийнэ. Далангийн хажуу налууд чулуун материал буулгахыг үл зөвшөөрнө. Хажуу налууг зурагт зааснаар хийнэ.
- Чулуун дүүргэлтийн 10 мм-ээс жижиг ширхэгтэй чулууны хэмжээ нь 5%-иас хэтрэхгүй, хамгийн том нь 250мм-ийн хэмжээтэй байна. Нягтарсан үеийн зузаан 500 мм буюу үүнээс бага байх ба чулуун дүүргэлтийг хийж байх явцад Инженер тавигдах шаардлагуудыг өөрчилж болно. Дараагийн үеийг дэвсэхээс өмнө урьд дэвссэн үед жижиг ширхэгтэй чулууг хийн, нүх сүвийг чигжиж нягт болгоно. Техникийн шаардлагын зүйл 507-г зааснаар нэмэлт үеүдийг дэвсэх буюу газар шорооны ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч чулуун үе бүрийг боломжийн хязгаарт нягтруулсан байна.

507. ХУУЧИН АСФАЛЬТОБЕТОН ХУЧЛАГЫГ ХУУЛАХ, СОЛИХ

Энэ төсөлд хэрэглэгдэхгүй

Хуучин хучилтыг хүйтнээр нь дахин боловсруулахдаа талбайд холих ба тусгайлан бэлтгэсэн талбайд хольц бэлтгэх гэсэн 2 үндсэн аргаар боловсруулна.

Хуучин асфальтобетон хучлагын материалын шинж чанарыг урьдчилсан байдлаар нарийвчлан судлахад материалын үзүүлэлтүүд нь чанарын шаардлага хангасан нь тогтоогдвол газар дээр нь холигч төхөөрөмжийг ашиглан хучлагын төвшингөөс доош 20 см хүртэл гүнд хуулна. Энэхүү хольсон материалыг туршилт шинжилгээнд хамруулж үр дүн нь энэхүү техникийн шаардлагын Бүлэг-800-д тусгагдсан шаардлагуудыг хангаж байгаа тохиолдолд урьдчилан бэлтгэсэн талбай руу зөөж нөөцөлж болох эсвэл шаардлагатай хэсгүүдэд газар дээр тээвэрлэхгүйгээр шууд боловсруулна. Нөөцөлсөн шороо болон хуучин асфальтобетоны хольцыг Инженерийн зөвшөөрөлтэйгээр далангийн дүүргэлт, суурийн доод үед хэрэглэж болно.

Ажил эхлэхээс өмнө талбайд далангийн даацыг DCP-ээр тодорхойлж, шинжилгээний үр дүнгээр шаардлага хангахгүй гэдэг нь нотлогдвол тохиромжгүй хэсгүүдийг Инженерийн заасан гүнд ухаж зайлуулан, тохиромжтой материалаар солино.

Гүйцэтгэгч нь техникийн шаардлагад заасан ширхэглэлийн бүрэлдэхүүнийг хангахын тулд зөвшөөрөгдсөн эх үүсвэрээс өөр материал авч нэмэлтээр хольж ашиглаж болно. Энэ үед дараах нөхцөлүүдийг хангана. Үүнд:

- Материал бэлдэх, олборлох, холихтой холбоотой бүх зардлыг Гүйцэтгэгч хариуцна.
- Суурийн тогтвортой байдлыг хангах үүднээс /нягтралтыг сайжруулах/ уян налархайгүй, органик нэгдэл агуулаагүй элс эсвэл буталсан чулууг хольцод нэмж болно.
- Нэмэх материалын хувь хэмжээг лабораторийн туршилтын дүгнэлт болон тогтоосон орцыг үндэслэн Инженертэй зөвшилцөж тогтоох ба нэмэх материалын хэмжээ нь хольцын жингийн 15%-иас илүүгүй байна.

Талбайд холих үйл ажиллагааны нэг оролтын өргөн холигч машины (ресайклер) ажлын өргөнөөр тодорхойлогдох бөгөөд дагуу залгаас гаргахгүйн тулд нэг удаагийн оролтын урт 100-120 метрээс ихгүй байна.

Дахин боловсруулсан материалыг ямар үед ашиглаж байгаагаас хамаарч Бүлэг 508-ын шаардлагад хүртэл нягтруулна.

508. ДАЛАНГ НЯГТРУУЛАХ

Гүйцэтгэгч нь нягтруулах ажлыг эхлүүлэхийн өмнө дүүргэгч материалын чийгийн хэмжээг тодорхойлох ёстой. Материалыг услах буюу хатаах замаар нягтруулах үеийн чийгийн хэмжээ нь (AASHTO T180) тохиромжтой чийгийн хэмжээнээс -1 +2%-ийн хооронд хэлбэлзэж байхаар тохируулна. Гүйцэтгэгч нь далангийн дээд хэсгийн 250 мм зузаантай үеийн хөрсний чийгийн хэмжээг материалыг услах буюу хатаах замаар (AASHTO T180) тохиромжтой чийгийн хэмжээнээс -1,+2%-ийн хооронд хэлбэлзэж байхаар тохируулна. Дүүргэгч материалыг тодорхой зузаантайгаар жигд тараагаад материалын үе бүрийн чийгийн хэмжээ нь дээр дурдсан хязгаарт байхаар буюу хуурай үеийн нягт нь дор зааснаас багагүй байхаар нягтруулна.

Үүнд:

- А. Далангийн дээд үеийн дүүргэгч материалаас бусад бүх үеүдийн дүүргэгч материалыг хуурай үеийн хамгийн их нягтын 98%-иас багагүй байхаар нягтруулах ёстой.
- В. Далангийн дээд үеийг хуурай үеийн хамгийн их нягтын 98%-иас багагүй байхаар

нягтруулах ёстой.

С. Зорчих хэсэг ба хөвөөний доорхи далангийн дээд хэсгийг бүрдүүлж буй материалыг хуурай үеийн хамгийн их нягтын 99 % -иас дээш байхаар нягтруулах ёстой.

Далан ба далангийн дээд хэсгийн нягтруулалтыг Инженерийн зөвшөөрлөөр Гүйцэтгэгчийн санал болгосон горимын дагуу хийж гүйцэтгэнэ. Ухмал ба өндөрлөх хэсгийн 250мм-ээс зузаантай далангийн дээд хэсгийг 150мм-ийн зузаантайгаар хоёр үечлэн дэвсэж нягтруулна.

Нягтруулах явцад Гүйцэтгэгч нь шаардлагатай гэж үзвэл холимог материалын хөндий зайг чигжиж өгөх үүднээс гадаргууг засварлаж усална. Гүйцэтгэгч нь талбайд нягтруулалтын туршилтыг лабораторийн шинжилгээний хамт хийж гүйцэтгэх бөгөөд нягтруулалттай холбоотой бүх шаардлагыг хангасан байх ёстой. Гүйцэтгэгч Инженерийн санал болгосон нягтруулалтын горимын бусад туршилтыг хийж гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь нягтруулалтад зайлшгүй хэрэглэх усаа нөөцлөх ёстой. Нягтруулалтад зөвхөн давсгүй, элдэв хольцгүй цэвэр ус хэрэглэх ба Инженерийн зөвшөөрсөн эх булгаас авна. Хэрвээ Инженер шаардсан бол Гүйцэтгэгч нь усанд шинжилгээ хийлгэж, шаардлага хангаж байгаа эсэхийг шалгана. Гүйцэтгэгч нь ус зөөвөрлөх болон тараах шаардлагатай бүхий л тоног төхөөрөмжөөр хангана. Шүршигч хошуу эсвэл ижил төстэй тоноглолтой усны нөөц сав ашиглан усыг далангийн үеүдийн гадаргуу дээр тогтмол хэмжээгээр жигд шүршинэ. Инженерээс зөвшөөрөгдсөн автогрейдер, анжис эсвэл ижил төрлийн холигч машин ашиглан нягтруулах гэж байгаа шороог устай жигд хольсон байх ёстой. Инженер далангийн тухайн үеийг хангалттай нягтруулсан гэж үзсэн тохиолдолд дараагийн шинэ үеийг дэвсэнэ.

509. ХАЯГДАЛ МАТЕРИАЛ

Замын ухмалаас гарсан далангийн дүүргэлтэд ашиглахад тохиромжгүй буюу дүүргэлтийн болон суурийн доод үед хэрэглэх шаардлагагүй гэж Инженер тодорхойлсон бөгөөд хаягдал зайлуулах талбайд зөөж буулгах заавар өгсөн материалыг хаягдал материал гэж тодорхойлно. Инженер тусгай зөвшөөрөл өгөхөөс бусад тохиолдолд ухмалын материалыг хаягдал зайлуулах талбайд зайлуулахгүй.

Эхлээд хаягдал материал гэж ангилагдсан боловч дараа нь Инженерийн зөвшөөрлөөр Гүйцэтгэгч дүүргэлт, хөлдөлтөөс хамгаалах үе, суурийн доод үе буюу зам барилгын нэг хэсэг болгож ямар нэгэн байдлаар хэрэглэсэн ухмалын материалыг хаягдал материал гэсэн ангиллыг нь өөрчилж, хаягдал материалын хэмжилтэд зохих өөрчлөлтийг хийж болно.

Гүйцэтгэгч байршлыг нь тогтоож, Инженер урьдчилан баталж, орон нутгийн захиргааны зөвшөөрсөн хаягдал материал зайлуулах талбайд Гүйцэтгэгч хаягдал материалыг зөөвөрлөж хаяна. Энэ техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу Гүйцэтгэгч хаягдал материалын талбайг олж тогтооно. Гүйцэтгэгч хаягдал материалыг зайлуулах үйл ажиллагааг эхлэх тухай мэдэгдлийг хамгийн багадаа 24 цагийн өмнө Инженерт өгнө. Техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу шороон ордыг тогтоох бөгөөд материалыг зөвхөн Инженерийн зөвшөөрсөн шороон ордоос авна. Шороон ордын материал шинж чанараараа нэг төрлийн, ижилхэн байх шаардлагыг хангахын тулд шороон орд болон түүнд ойрхон газарт материалыг сайтар холих буюу овоолго хийж, дараа нь хэрэглэхээр бэлтгэнэ.

Гүйцэтгэгч нь шороон ордод очих туслах замыг заавал байгуулж, өвс ургамал, хад чулуу, овор хэмжээ ихтэй үл тохирох материал, том чулууг зайлуулна. Техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу шороон ордыг нөхөн сэргээх үед ашиглах зорилгоор өнгөн хөрсийг хуулж, овоолон хадгална.

Гүйцэтгэгч нь шороон ордод буй тохиромжтой материал нь үл тохирох материалтай холилдохгүй байх арга хэмжээг авна. Үл тохирох материалыг техникийн шаардлагын зүйл 508-д заасны дагуу зайлуулах, эсвэл техникийн шаардлагын зүйл 509-д заасны дагуу ухмалыг нөхөн сэргээхэд ашиглаж болно.

Шороон ордыг тогтоосон өргөн ба хэлбэрээр ухах ажил дууссаны дараа цэвэрлэж, нөхөн сэргээнэ. Нөхөн сэргээсэн шороон ордын хажуу налуу нь хамгийн ихдээ хэвтээ байдлаар 6, босоо байдлаар 1 гэсэн харьцаатай байна. Техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу ордын хажуу налуу ба ойр орчим нь цэвэрхэн үзэмжтэй засагдсан байна. Шороон ордыг тойруулж, хашаа хийж, аюулгүй ажиллагааг хангана. Шороон ордыг ашиглахдаа техникийн шаардлагын холбогдох заалтуудын зэрэгцээ Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний зааврыг баримтална.

510. ТУРШИЛТЫН НЯГТРУУЛАЛТ

Далангийн доорх ул хөрс, ухмалын ёроол, чулуун дүүргэлтийн үеүдийг доргиулагч индүү ба гөлгөр бултай индүүгээр нягтруулна. Инженерийн оролцоотойгоор Гүйцэтгэгч туршилтын нягтруулалтыг хийнэ. Нягтруулалтыг хангалттай гүйцэтгэсний дараа л тухайн үеийг зузаан болон нягтруулалт хийх арга технологийг баталгаажуулна. Туршилтын нягтруулалтын зардлыг Гүйцэтгэгч хариуцна. Хэрэв туршилтын нягтруулалтын дараа ямар нэг засвар хийх шаардлагатай бол холбогдох зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

511. ХАЖУУ НАЛУУГ ТЭГШИЛЖ ЗАСАХ

Гүйцэтгэгч нь далангийн болон ухмалын хажуу налууг зурагт зааснаар буюу Инженерийн зааврын дагуу гараар болон зөвшөөрөгдсөн техник ашиглан тэгшилж янзлах ёстой. Далангийн хажуу налууг зохих ёсоор нягтруулах бөгөөд нягтруулаагүй, дутуу нягтруулсан болон илүүдэл хэмжээтэй материалыг тэгшлэн хусаж, далангийн хажуу налуугаас зайлуулна. Илүүдэл материалыг хаягдал материал зайлуулах талбай руу зөөх эсвэл Инженер зөвшөөрлөөр тарааж тэгшилнэ. Ухмалын хажуу налууд ил гарсан том чулуу, хадыг зайлуулан, үүссэн зайд нь Инженерийн зөвшөөрсний дагуу тохиромжтой материалаар дүүргэлт хийн нягтруулна. Далан ба ухмалын хажуу налууг тэгшилж засах нь ухмал болон далангийн ажлын нэг хэсэг гэж тооцогдох ба Гүйцэтгэгчид тусдаа төлбөр хийгдэхгүй.

512. ЗҮЛЭГЖҮҮЛЭЛТ ХИЙХ

Зураг төсөлд заагдсан буюу Инженер зааварласан тохиолдолд Гүйцэтгэгч далангийн хажуу налуу, ухмалын хажуу энгэрийн бэхэлгээ болон хөдөлгөөн тусгаарлах зурвас, арлын өнгөлгөөг Монгол орны нөхцөлд тэсвэртэй олон наст ургамлаар зүлэгжүүлнэ. Гүйцэтгэгч сонгож, Инженер баталсан зохих эх үүсвэрээс зүлэгжүүлэлтэд хэрэглэх олон наст ургамлыг авч ашиглана. Инженер өөрөөр зааварлаагүй бол зүлэгжүүлэлтийг хажуу налууд зөвхөн 4, 5, 6 саруудад хийнэ. Зүлэгжүүлэлт хийсний дараа Гүйцэтгэгч олон наст ургамлыг ургаж, бэхжих хүртэл нь усалж арчилна. Зүлэгжүүлэлт хийхийн өмнө далангийн элэгдэл, эвдрэлийг Гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр засна.

513. ДАЛАНГИЙН ОГЦОМ ХАЖУУ НАЛУУГ ГЕОТОРООР БЭХЛЭХ

Ажлын зурагт заасан байрлалуудад далангийн огцом хажуу налууг геотороор бэхэлнэ. Геоторт тавигдах техникийн шаардлагыг Техникийн шаардлагын бүлэг 1800-д тусгайлан

оруулсан болно.

Хажуу налуу 1:0,5 хүргэхээр төлөвлөгдсөн хэсгүүдэд (ИНЗТ-д заасан байршлуудад) далангийн хажууг геотороор бэхэлнэ. Геотор нь хөрсөнд орших байгалийн ямар ч химийн бодист тэсвэртэй байх бөгөөд орчны температурт өөрчлөлтгүй байна.

Мөн гидролизэд өртөмтгий биш, давс, хүчил, шүлт (рН-ийн 12.5 2.0) -ийн усан уусмалд тэсвэртэй, биологийн задрал явагдахгүй байх ёстой.

514. ХАЖУУГИЙН ШУУДУУ

Хажуугийн шуудууг барих ажлыг Техникийн шаардлагын зүйл 501, 502, 503-т заасны дагуу ухмалын нэг адил авч үзэх ба газар шорооны ажлын ангилалд хамаарна. Инженер барилгын ажлын явцад хажуугийн шуудууны гүн, налуу хэмжээнд өөрчлөлт оруулж болох ба энэхүү өөрчлөлтийн дагуу барина.

515. УХМАЛЫН ХАЖУУ НАЛУУ ДАХЬ ТОГТВОРГҮЙ МАТЕРИАЛ

Ухмал болон түүний хажуу налууд нурамтгай, тогтворгүй материал гарвал Гүйцэтгэгч Инженерт мэдэгдэх ба Инженерийн заавраар нурамтгай материалыг ухан зайлуулж оронд нь тохирох материалаар дүүргэнэ. Тохиромжгүй хөрсийг ухааж зайлуулах ажил нь ухмалын нэг хэсэг гэж тооцогдох ба тохирох материалаар дүүргэх ажил нь далангийн ажлын нэг хэсэг гэж тооцогдож холбогдох зааврыг баримтална.

516. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Техникийн шаардлагын бүлэг 300-д заасны дагуу 20м тутамд хэмжсэн хэмжилтийг ашиглан замын хөндлөн огтлолыг зурж, газар шорооны ажлын хэмжээг тодорхойлно. Инженерийн зааварчилгааны дагуу хөрсний нөхцөл өөрчлөгддөг газарт болон огцом эргэлттэй газарт хөндлөн огтлолын хэмжил болон зургийг илүү ойрхон зайтайгаар хийж болно. Мөн Инженер зөвшөөрсөн тохиолдолд газрын гадаргын байдлыг харгалзан хөндлөн огтлол хийх зайг 50м хүртэл уртасгаж болно. Газар шорооны дүүргэлтийн ажлыг бүрэн дууссан далайд нягтруулсан материалыг шоо. метрээр хэмжинэ. Далангийн дүүргэлтэд хэрэглэх шороог авах зорилгоор ухсан ухмалын ажилд ямар нэгэн тусдаа хэмжилт буюу төлбөр хийгдэхгүй.

Инженер шороон ордыг шинээр нээх заавар өгсөн тохиолдолд дор дурдсан зүйлд тусдаа хэмжилт буюу төлбөр хийгдэхгүй.

- Газрын зөвшөөрөл;
- Туслах замын зөвшөөрөл;
- Эзэмшигчид болон засаг захиргаатай хийх гэрээ хэлцэл;
- Олборлосон дүүргэгчийн татвар, хураамж;
- Техникийн шаардлагын бүлэг 400-д заасны дагуу шороон ордын талбайн цэвэрлэгээ;
- Техникийн шаардлагын бүлэг 400-д заасны дагуу шороон ордын өнгөн хөрсийг хуулан өөр газарт хэрэглэх;
- Тээвэрлэлт;
- Техникийн шаардлагад нийцүүлэх зорилгоор овор ихтэй материал, жижиг ширхэгтэй болон бусад фракцын чулууг зайлуулахын тулд материалыг бутлах буюу шигших;
- Шороон ордын тохиромжтой материалыг дахин шилжүүлэн зөөвөрлөх буюу түр зуурын овоолго хийх, Техникийн шаардлагын бүлэг 500-д заасны дагуу өнгөн хөрсийг хуулж, түр зуур овоолон хадгалж, шороон ордыг сэргээн засварлахад хэрэглэх.

Инженер заавар өгсөн тохиолдолд Гүйцэтгэгч ухмал хийх явцад байгалийн хөрсний үе давхаргын өндрийг аль болохоор нарийн тодорхой үзүүлэх боломжийг олгох тийм хэлбэр, хэмжээ, байрлалд гүнийг заагч тэмдгийг тавьж байна. Гүйцэтгэгч гүн заагчийг сүүлчийн хэмжилт хийх хүртэл хэвээр байлгана. Техникийн шаардлагын зүйл 508, 515-д заасны дагуу тохиромжгүй болон тогтворгүй материалыг ухан зайлуулах ажлын хэмжээг ухмалын эзлэхүүнээр хэмжин гаргана.

Ухаж зайлуулах материалын хэмжээг зохих нарийвчлалтай хэмжилтийн багаж болон хөндлөн ба дагуу зүсэлтийн зураг ашиглан гаргана. Техникийн шаардлагын зүйл 503-т заасны дагуу материал нь ердийн ухмалын, хучилтын ухалтын, хадан хөрсний ухалтын гэж ангилагдана.

(а) Зүйл: Ухмал болон шороон ордоос авсан материалыг даланд хэрэглэх

Нэгж: м³

Далангийн ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана. Үүнд:

- Замын зурвасын ухмал, шатлал гаргах ухмал болон шороон ордоос материал ухаж авах;
- Материалыг ачих, тээвэрлэх, далан болон дүүргэлт шаардлагатай бусад газарт дэвсэх;
- Бүх төрлийн тээвэрлэлт;
- Материалыг тараах, тэгшлэх, услах болон нягтруулах;
- Энэ техникийн шаардлагын бүлэг 100, 200, 300 болон 600-д заасныг мөрдөх;
- Энэхүү техникийн шаардлагын зүйл 515-д заасныг мөрдөх.

Инженерийн зааврын дагуу барилгын ажил эхлэхээс өмнө, мөн хойш 20 м-ийн зайтайгаар хэмжсэн, эсвэл нугачаатай болон уулархаг газарт илүү бага зайтайгаар хэмжсэн хөндлөн огтлолыг үндэслэн далангийн ажлын эзлэхүүнийг гаргана.

(b) Зүйл: Материалыг ухаж, зайлуулах

Нэгж: м³

Ердийн ухмалын ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана. Үүнд:

- Материалыг ухах;
- Материалыг ачих, тээвэрлэх ба тогтоосон хаягдал материал зайлуулах цэгт хаях;
- Бүх төрлийн тээвэрлэлт;
- Өнгөн хөрсийг бэлдэх;
- Хаягдал материалын цэгт өнгөн хөрсийг зайлуулах;
- Энэхүү техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу хаягдал материалын талбайг бэлдэх, хэлбэрт оруулах, засах сэргээх;
- Энэ техникийн шаардлагын зүйл 502, 503, 504, 505, 506, 508, 509, 511 болон 515-д заасан шаардлагыг хангах
- Техникийн шаардлагын зүйл 506-д заасны дагуу далангийн доорх намагтай хөрсний ухалтад ямар нэгэн тусдаа болон нэмэлт төлбөр хийгдэхгүй.

(c) Зүйл: Хуучин асфальтобетон хучилтыг дахин боловсруулах

Нэгж: м³

Дахин боловсруулалт хийх ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана.

Үүнд:

- Хучилтыг суурийн хамт 0,2 м хүртэл гүнд буталж холих,
- Буталж хольсон материалыг ачих, тээвэрлэх ба тогтоосон материалын талбайд нөөцлөх,
- Бүх төрлийн тээвэрлэлт,
- Материалыг нөөцлөх талбайн өнгөн хөрсийг зайлуулах,
- Энэ техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу нөөцлөх материалын талбайг бэлдэх, хэлбэрт оруулах, засах сэргээх, суурийн доод үеийн материалтай холих, шинжлэх,
- Энэ техникийн шаардлагын зүйл 515-д заасан шаардлагыг хангах.

(d) Зүйл: Хадан хөрсийг тэсэлж, ухаж зайлуулах

Нэгж: м³

Хадан хөрсийг ухаж, тэслэх ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана.

Үүнд:

- Хадан хөрсний зэрэглэлээс хамаарч хадыг өрөмдөж тэслэх, доргиулагчтай алхаар хадыг бутлах
- Материалыг ухах,
- Материалыг ачих, тээвэрлэх ба тогтоосон хаягдал материалын цэгт хаях,
- Бүх төрлийн тээвэрлэлт,
- Өнгөн хөрсийг бэлдэх,
- Хаягдал материалын цэгт өнгөн хөрсийг зайлуулах,
- Энэхүү техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу хаягдал материалын талбайг бэлдэх, хэлбэрт оруулах, засах сэргээх
- Энэхүү техникийн шаардлагын зүйл 502, 503, 504, 505, 506, 508, 509, 511, болон 515-д заасан шаардлагыг хангах.

Төлбөр хийх зорилгоор ухмалаас гарч буй эзлэхүүнээрээ 0.5 м³-аас том хэмжээтэй чулууны эзлэхүүнийг тээвэрлэж буй машины тэвшин дэх тэдгээрийн сул эзлэхүүний 50%-иар тооцож авна.

(e) Зүйл: Ул хөрсийг нягтруулах

Нэгж: м³

Ул хөрсийг ХҮХИН-ийн 95% хүртэл нягтруулах (AASHTO T180) ажлын хэмжилтийн нэгж нь куб метр байна. Нягтруулсан ул хөрсний эзлэхүүнийг нягтруулсан талбай ба тогтоосон, нягтруулсан зузааны үржвэрээр хэмжинэ.

Нягтруулалтын ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана.

Үүнд:

- Ул хөрсийг сийрэгжүүлэх;
- Овор ихтэй материалыг шигших, зайлуулах;
- Чийгийн агуулгыг нь тохируулахын тулд материалыг хатаах болон чийглэх;
- шаардлагатай хөндлөн хэвгийг гаргаж тэгшлэх;
- 150 мм зузаантай хоёр үеэр тэгшлэх болон нягтруулах;
- Энэхүү техникийн шаардлагын зүйл 505, 507, 510, 511 ба 515-д заасан шаардлагуудыг хангах.

(f) Зүйл: Намагтай газрыг чулуугаар дүүргэх

Нэгж: м³

Намгийг чулуугаар дүүргэх ажлын хэмжих нэгж нь шоо метр байна. Ажлын хэмжээг чулуугаар дүүргэх талбайг чулуун дүүргэлтийн зузаанаар үржүүлж гаргана.

Намган хөрсийг чулуугаар дүүргэх ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана. Үүнд:

- Чулууг бэлдэх;
- Намагтай хөрсийг зөөж, зайлуулах;
- Бүх төрлийн тээвэр;
- Чулуун дүүргэлтийг хийх;
- Энэ нь техникийн шаардлагын зүйл 505, 506, 508, 510 ба 515-ын шаардлагыг хангах.

(g) Зүйл: Зүлэгжүүлэлт хийх

Нэгж: м²

Зүлэгжүүлэх ажлыг хавтгай дөрвөлжин метрээр хэмжинэ. Зүлэгжүүлэх талбайг байршлын төрөл бүр дээр, өөрөөр хэлбэл далангийн хажуу налуу, ухмалын налуу, хажуугийн шуудуу, ус цуглуулах шуудуу зэргийн хувьд Инженерийн зааварлаж, хажуу налууд дэвссэн цэвэр талбайгаар тооцож гаргана.

Зүлэгжүүлэх ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана.

Үүнд:

- Үрслэгээг бэлдэх, хадгалах;
- Үрслэгээг тээвэрлэж, авчрах;
- Талбайг зүлэгжүүлэх;
- Шаардлагатай үед нь усалж арчлах;
- Энэхүү техникийн шаардлагын зүйл 511-д тавигдсан шаардлагыг хангах.

(h) Зүйл: Хажуу налууг засах (далангийн, ухмалын)

Нэгж: м²

Хажуу налууг засах ажлын хэмжих нэгж нь квадрат метр байна. Төлбөрийг зурагт өгсөн хэмжээ эсвэл зассан талбайн хэмжээгээр тооцно.

Хажуу налууг засах ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана.

Үүнд:

- Материалыг ухаж авах;
- Материалыг ачих, тээвэрлэх, хадгалах;
- Шигших, том хэмжээст материалыг зайлуулах;
- Ажил гүйцэтгэхэд шаардлагатай ажиллах хүч, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж ба эдгээртэй холбогдох жижиг зардлуудын бүрэн төлбөр;
- Хөндлөн огтлолын хэмжээнд хүртэл налууг засах;
- Тэгшилж нягтруулах;
- Энэ техникийн шаардлагын зүйл 501, 502, 503, 510, 511, 513 болон 514, 515-ын шаардлагыг хангах.

(i) Зүйл: Хажуугийн болон өөрийн шуудуу ухах Нэгж: м³

Хажуугийн болон өөрийн шуудууг ухах ажлын хэмжих нэгж нь куб метр байна. Хэмжээг Инженерийн зааварласан эсвэл зурагт өгсөн хэмжээсүүдээр тооцно.

Хажуугийн болон өөрийн шуудууг ухах ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана. Үүнд:

- Ажлын зурагт өгсөн гүн, суурийн өргөнөөр ухах;
- Шуудууны хажуу, суурийг засах хэлбэржүүлэх;
- Ухсан материалыг зайлуулах;
- Тэгшилгээ хийж нягтруулах;
- Энэ техникийн шаардлагын зүйл 501, 502, 503, 504, 510, 511, 514, болон 515 -ын шаардлагуудыг хангах.

БҮЛЭГ 600 - ЧУЛУУН БА ШОРООН ОРД

БҮЛЭГ 600 - ЧУЛУУН БА ШОРООН ОРД

601. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
602. ТОДОРХОЙЛОЛТУУД.....	2
603. ГАЗАР ОЛГОХ.....	3
604. ГАЗАР ДЭЭР АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ.....	4
605. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОЛОН ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГУУД.....	4
606. ТУСЛАХ ШОРООН ЗАМУУД.....	5
607. ТАЛБАЙГ ЦЭВЭРЛЭХ, ӨНГӨН ХӨРС ХУУЛАХ БА ХӨРСНИЙ ДЭЭД ҮЕИЙГ УХАЖ ЗАЙЛУУЛАХ	5
608. МАТЕРИАЛЫГ СОНГОХ, ХОЛИХ, НӨӨЦЛӨХ	6
609. МАТЕРИАЛЫГ АШИГЛАХ	6
610. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР.....	7

601. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Асфальтбетон, цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь, чулуун өрлөг, чулуун асгаас, намаг, шавартай газрыг чулуугаар дүүргэх зэрэгт ашиглах чулуун материалуудын эх үүсвэрийг Гүйцэтгэгч сонгоно. Энэхүү техникийн шаардлагын бүлэг 602 (а) -д заасан аргаар ордыг ашиглахад бэлдэнэ.

Замын далан барихад дүүргэлтэд ашиглах шороо болон суурийн доод үе, хөвөөнд ашиглах хайрган материалын эх үүсвэрийг Гүйцэтгэгч сонгоно. Энэхүү техникийн шаардлагын бүлэг 602 - д зааснаар эдгээрийг авах шороон ордыг тогтооно.

Чулууны болон шороон ордуудын байршлаас хэд хэдэн дээжүүдийг экскаватор, геологийн өрмийн машин зэргийг ашиглан авна. Тэсэлгээний ажил эхлэхээс өмнө Инженерийн оролцоотойгоор дээжүүдийг авч битүүмжлэн Итгэмжлэгдсэн лабораторид илгээж, үр дүнг нь баталгаажуулна. Шинжилгээний үр дүнгээс хамааран тухайн чулууг ямар зориулалтаар хэрэглэхийг шийднэ. Хэрэв шинжилгээний үр дүн бүлэг 200-ийн шаардлагуудыг хангаж байвал тохирсон хийцэд (цементобетон хучлага, цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь, далан, суурийн доод үе г.м) тухайн ордоос хэрэглэж болно.

Зураг төслийн материалын тайланд дурдсан ямар ч чулуун орд, шороон ордын аль ч материалын чанар болон тэдгээрийн тохиромжтой эсэх талаар Захиалагч ямар нэгэн хариуцлага хүлээхгүй. Тендерийн хугацаанд Захиалагч нь эдгээр бичиг баримтыг тендерт оролцогчдод чөлөөтэй үзэж танилцах боломж олгох бөгөөд тэдгээр нь тендерийн бичиг баримтын хэсэг болохгүй.

602. ТОДОРХОЙЛОЛТУУД

- *Чулуун орд гэдэг* нь зам барилгын ажилд ашиглах чулууг уулнаас өрөмдөж тэслэх буюу бусад арга хэрэгслүүдийг ашиглан олборлох газрыг хэлнэ.

- *Шороон орд гэдэг* нь зам барихад ашиглах чулуунаас бусад материалуудыг авч буй талбай юм.

- *Материал нөөцлөх газар гэдэг* нь дүүргэлтийн материал, хайрга, дайрга өнгөн хөрс зэргийг зам барилгын ажилд ашиглахын өмнө түр хугацаагаар нөөцлөн овоолох талбайг хэлнэ.

- *Хаягдал материал зайлуулах газар гэдэг* нь зам барилгын ажлаас гарсан илүүдэл болон шаардлага хангахгүй материалуудыг тараан асгадаг талбайг хэлнэ. Инженерийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр илүүдэл болон шаардлага хангахгүй материалыг замын зурвас газарт асгаж болохгүй.

- *Хайрган (сайрга-чулуун) материал гэж гэдэг* нь 75мм-ийн шигшүүрээр өнгөрч 4.75мм-ийн шигшүүр дээр үлдсэн хатуу хэсгийг хэлнэ.

- *Элсэн материал гэдэг* нь 4.75мм-ийн шигшүүрээр өнгөрч 0.075мм-ийн шигшүүр дээр үлдсэн хэсгийг хэлнэ.

- *Шавар гэдэг* нь 0.075мм-ийн шигшүүрээр өнгөрсөн тодорхой чийгийн үед налархай шинж чанар үзүүлэх ба хатахад хэлбэрээ хадгалж үлдэнэ. Уян налархай тоогоороо 4-өөс их байгаа хөрс юм.

- *Тоос гэдэг* нь 0.075мм-ийн шигшүүрээр өнгөрсөн хөрс нь налархай шинж чанар үзүүлэхгүй буюу маш бага үзүүлдэг ба агаарт хуурай нөхцөлд хэлбэрээ маш бага хадгалдаг ба эсвэл хадгалж

чадахгүй. Уян налархайн тоогоороо 4-өөс бага байх хөрс гэж MNS ASTM D 2487:2004 ангилдаг.

603. ГАЗАР ОЛГОХ

Захиалагч нь энэхүү техникийн шаардлагын бүлэг 100-д заасны дагуу барилгын ажилд шаардагдах замын зурвас болон бусад зориулалтын газрыг үнэ төлбөргүй ашиглах боломжийг гүйцэтгэгчид бүрдүүлж өгнө. Үүнд:

- Чулуун ба шороон орд
- Материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газар,
- Тэдгээрт хүрэх туслах замууд,
- Замын зурвасын гаднах түр замууд,
- Талбайн лаборатори байгуулах газар,
- Инженерийн орон сууц болон ажлын байрны газар,
- Гүйцэтгэгчийн түр суурин, контор, агуулахууд, засвар үйлчилгээний болон амьдрах байрны газар,
- Түр барилгын ажилд шаардлагатай газар.

Бусад зорилгоор ашиглахад шаардлагатай газар авах асуудлыг Гүйцэтгэгч хариуцна. Чулуун болон шороон ордын газрыг тогтоох, ашиглахдаа гүйцэтгэгч нь Улсын болон орон нутгийн холбогдох хууль журмуудыг баримтлан ажиллана. Гүйцэтгэгчийн сонгож тогтоосон чулуун орд, шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газруудын байршил болон хэмжээг Инженер хянаж батална. Чулуун болон шороон орд, материал нөөцлөх, хаягдал зайлуулах газруудын болон тэдгээр рүү хүрэх туслах замуудын байршил нь дор дурдсан нөхцөлтэй байвал Инженер зөвшөөрөл олгохгүй байж болно. Үүнд:

- Хүрээлэн буй орчинд хор нөлөө учруулахаар бол,
- Хот суурины дотор буюу түүнтэй хэтэрхий ойрхон байх,
- Хэтэрхий урт туслах зам шаардахаар бол,
- Дэндүү өргөн талбайг хамарсан байвал,
- Олон нийтийн аюулгүй байдалд эрсдэл учруулахаар бол,
- Ашиглаж болохуйц тохиромжтой материал болон газруудаас илүү хол байвал,
- Усны эх үүсвэр болон усан хангамжийг таслах, түүнд саад тотгор учруулахаар байвал.

Гүйцэтгэгч нь тухайн чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах талбайд ямар нэгэн ажил эхлэхээс хамгийн багадаа 28 хоногийн өмнө энэ талаар Инженерт бичгээр мэдэгдэнэ.

Дээрх мэдэгдлийг хийхээс өмнө шинжилгээ, судалгааны ажил хийгдсэн байх ёстой бөгөөд Гүйцэтгэгч нь хайгуулын ажил эхлэхээс 7 хоногийн өмнө орон нутгийн холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж тэдний зөвшөөрлийг авсан байх ёстой. Гүйцэтгэгч нь чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газруудыг сонгохын тулд тухайн орон нутагтай гэрээ хэлцэл хийж, холбогдох хууль журмын дагуу газар ашиглалтын ба түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр болон бусад шаардлагатай төлбөрийг хийсэн байх ёстой.

Гүйцэтгэгч нь газар ашигласны болон ус хэрэглэх, барилгын материал олборлохтой

холбогдсон бүхий л татвар, хураамжийг хуульд заасны дагуу төлж барагдуулах хариуцлага хүлээнэ.

Инженерт бичгээр мэдэгдэл өгөхийн өмнө Гүйцэтгэгч чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газар тус бүрд тэмдгүүд тавьж, ажил явагдах, материал нөөцлөх талбай, тэсэлгээний ажлын аюулгүй бүс, туслах зам г.м-ээр тэдгээрийн хил хязгаарыг зааглан тогтоож тэмдэглэсэн байна. Дээрх газруудын талаар Гүйцэтгэгчээс ирүүлэх мэдэгдэл нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- a. Төлөвлөж буй туслах замын чиглэлийг харуулсан дэлгэрэнгүй зураг,
- b. Доорх зүйлсийг тусгасан 1:500 масштабтай дэвсгэр зураг:
 - тухайн газрын зах, хил, урт өргөн, нийт талбайн хэмжээ
 - газар эзэмшигчийн нэр, хаяг,
 - тухайн газарт буй барилга, хашаа, булш, тариалангийн талбай, бусад зүйлсийн талаар газар эзэмшигчтэй зөвшөөрөлцсөн тухай дэлгэрэнгүй мэдээлэл
 - ажлын талбай, материал нөөцлөх талбай, тэсэлгээний ажлын аюулгүй бүс зэргийг зурж тэмдэглэсэн байна.
- c. Газар эзэмших, ашиглах Улсын ба орон нутгийн эрх бүхий байгууллага буюу үндсэн эзэмшигчийн албан ёсны зөвшөөрөл

Хэрвээ сонгосон газарт шаардлагатай материалын нөөц хүрэлцээгүй байх буюу эсвэл талбай нь бага байвал Гүйцэтгэгч нь одоогийн ашиглаж байгаа чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газрыг өргөтгөх буюу эсвэл тэдгээрийг шинээр олж тогтоох, ашиглах хүсэлтээ бичгээр өгнө. Өргөтгөх буюу шинээр нээх газрын зөвшөөрлийг энэхүү техникийн шаардлагын 603-р бүлэгт заасны дагуу авна.

604. ГАЗАР ДЭЭР АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ

Захиалагчаас зохион байгуулж, улмаар тухайн орон нутгаас газрын зөвшөөрөл олгосон даруйд ямар нэгэн ажил эхлэхийн өмнө Гүйцэтгэгч нь тухайн газарт хүрээлэн буй орчныг хамгаалахаас эхлүүлээд бусад бүх ажлыг эхлэх хууль эрх зүйн бүхий л нөхцөл бүрэлдсэн эсэхийг хянаж баталгаажуулсан байх ёстой. Инженерээс бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр Гүйцэтгэгч ямар ч газарт ажил эхэлж болохгүй.

605. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОЛОН ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГУУД

Гүйцэтгэгч нь чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газарт үйл ажиллагаа явуулахдаа эрүүл мэнд, ахуйн болон аюулгүй байдлын талаарх орон нутгийн засаг захиргааны дүрэм журмыг мөрдөж ажиллана. Тийм дүрэм, журам байхгүй тохиолдолд, эсвэл тэдгээр дүрэм журмаас гадна дараах нөхцөлийг хангаж ажиллана:

- a. Ажил явагдаж байгаа бүх газрын усыг байнга зайлуулж хуурай байлгана. Хэрэв чулуун ба шороон ордын ухагдсан газарт ус гарч тэр нь өөрөө хатахааргүй байгаа бол ажил явагдаж байх хугацаанд усыг байнга соруулж зайлуулж байна. Тиймэрхүү хонхор газрыг ажил дууссаны дараа Инженерийн заавраар мал услах усан сан болгон үлдээж болно. Энэ тохиолдолд эргийн налууг 1:6-аас алгуур болгон засаж, мал ороход тохиромжтой болгоно.
- b. Зам барилгын ажилд шаардагдах дээрх газрууд нь усны эх бүхий газар, хот, суурины дотор буюу тэдэнтэй ойр зэргэлдээ оршиж болохгүй.
- c. Газрууд нь доор дурдсан хил хязгаарын дотор байж болохгүй. Үүнд:

- Тусгай хамгаалалттай газар,
- Дархан цаазтай газар,
- Хилийн бүс,
- Байгалийн нөөц газар
- Дурсгалт газар,
- Хамгаалалттай ойн бүс,
- Усны эх, усан хангамжийн бүс,

Хаягдал зайлуулах газар нь гол горхи, суваг шуудуу, усны урсац, усны эх, нуур зэрэг усны нөөцийг боож, бохирдуулахгүй байх ёстой.

Гүйцэтгэгч нь олгосон газарт ажлын талбарынхаа хил хязгаарыг тогтоож, Инженерийн зааврын дагуу хашаа хамгаалалт барьж тусгаарлан, үйл ажиллагаагаа зөвхөн тэр хил хязгаарын дотор бие даан явуулна.

d. Мөргөцгийн өндөр 1м-ээс илүү болсон газарт, мөргөцөг рүү хүн, мөн мал орохоос хамгаалсан түр зуурын хайс, хашааг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж тавина.

e. Ажил дуусахад бүх мөргөцгүүдийг нурааж, 1:6-аас багагүй налуу болгож сайтар тэгшлэн засна.

f. Ажил дуусахад бүх хайс, хашаа болон түр хугацааны бусад байгууламжуудыг буулгаж, зөөн, жорлонгийн нүхийг булж, өнгөн хөрсийг тарааж тэгшлэн усалж, талбайг цэвэрхэн болгож үлдээнэ.

g. Гүйцэтгэгч нь байгаль орчныг бохирдуулахгүй байх бүхий л арга хэмжээг авч ажиллана. Үүнд хөрсний болон гадаргын усанд тос, эрдэсжсэн ус оруулахгүй байх ба гэхдээ энэ чиглэлийн арга хэмжээ нь зөвхөн эдгээрээр хязгаарлагдах ёсгүй бөгөөд байгаль орчны нарийвчилсан үнэлгээг дагаж мөрдөнө.

h. Ажил дуусахад бүх чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газруудыг нөхөн сэргээж хүрээлэн буй орчны харагдах байдлыг сайжруулаад зогсохгүй хүн, малд саад болохооргүй байдлаар хуучин төрхийг сэргээнэ. Налуу жигд байх бөгөөд түүнийг өнгөн хөрсөөр хучиж, ургамалжилтыг тэтгэх зорилгоор байнга усалж байна. Газрыг нөхөн сэргээхэд шаардлагатай бүхий л зүйлийг хийж гүйцэтгэнэ.

606. ТУСЛАХ ШОРООН ЗАМУУД

Чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газруудад хүрэх туслах замууд болон барилгын явцад нийтийн хөдөлгөөнийг саадгүй явуулах замыг Гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр барьж, засварлана. Нийтийн хөдөлгөөнд зориулагдсан түр замыг тэмдэгжүүлэх аюулгүй нөхцөлийг хангах зэрэгт холбогдох төлбөрийг Захиалагчаас олгож болно.

607. ТАЛБАЙГ ЦЭВЭРЛЭХ, ӨНГӨН ХӨРС ХУУЛАХ БА ХӨРСНИЙ ДЭЭД ҮЕИЙГ УХАЖ ЗАЙЛУУЛАХ

Инженер өөрөөр зааварчлаагүй бол Гүйцэтгэгч энэхүү техникийн шаардлагын бүлэг 400-д заасны дагуу одоогийн байгаа чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газрууд болон тэдэнд хүрэх туслах замуудыг цэвэрлэнэ.

Инженер заавраар зайлуулж буюу хөдөлгөж үл болох хашилт, мод, малын хашаа болон бусад

зүйлсийг энэхүү техникийн шаардлагын бүлэг 400-д заасан нөхцөлийн дагуу хамгаална. Инженер) өөрөөр зааварчлаагүй бол Гүйцэтгэгч чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газруудын болон тэдэнд хүрэх туслах замуудын өнгөн хөрсийг хуулах ба шаардлагатай үед чулуун болон шороон ордод тохиромжтой материалын үе гарч ирэх хүртэл хөрсний дээд хэсгийг ухааж авч зайлуулна. Өнгөн хөрсийг дангаар нь хуулж зайлуулах, эсвэл тохиромжтой материалын үе хүртэлх давхаргатай хамт хуулах эсэхийг Инженер зааварчилна. Түүнчлэн Инженер өнгөн хөрснөөс доош тохиромжтой материалын үе хүртэлх давхарга нь шаардлага хангана гэж үзсэн бол зам барилгын ажилд ашиглах талаар зөвлөж болно.

Хуулсан өнгөн хөрсийг 1 м-ээс илүүгүй өндөртэйгээр товлосон талбайд буулгана. Борооны усыг шингээн барих, гадаргын ус урсахаас хамгаалах зорилгоор өнгөн хөрсийг шатлан овоолно. Гүйцэтгэгч, салхинд өнгөн хөрсийг хийсгэж алдахгүйн тулд, мөн ургамалжилтыг сэргээх зорилгоор өнгөн хөрсний овоолгыг шаардлагатай бол усалж байна. Чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газар тус бүрт ажил дууссаны дараа ашиглагдаагүй үлдсэн өнгөн хөрс ба тохиромжтой материалын үе хүртэлх давхарга үеийг тухайн газруудад нь тарааж хаялгүй, ойролцоох хонхор хотгор газруудад зөөж аваачин тэгшилнэ. Өнгөн хөрсийг дангаар нь овоолсон тохиолдолд түүнийг нөөцөлж байгаад газраа зассаныхаа дараа тараана.

608. МАТЕРИАЛЫГ СОНГОХ, ХОЛИХ, НӨӨЦЛӨХ

Инженер нь олборлох материалын төрөл, талбай, гүн зэргийг Гүйцэтгэгчид зааварчилна. Зохистой ширхэглэлийг хангахын тулд Гүйцэтгэгч байгалиас олборлосон материалуудыг бульдозер, автогрейдер, ачигч ба экскаватор зэрэг тохиромжтой машин техникийг ашиглан холих шаардлага гарч болно. Эдгээр материалыг сайн хольж нэгэн жигд хольц болгоод ажилд ашиглахаас хамгийн багадаа 7 хоногийн өмнө нөөц материал хадгалах талбайд овоолон хадгална.

Гүйцэтгэгч нь том хэмжээтэй буюу шавар, хар шороон хөрс болон бусад чанар муутай, барилгын ажилд хор нөлөөтэй, тохиромжгүй материалуудыг ажилд ашиглах тохиромжтой материалуудаас тусгаарласан байх ёстой. Дээрх тохиромжгүй материалуудыг хаягдал зайлуулах газар руу зөөж буулгана. Шороон орд бүрт материалыг төрөл, ширхэглэл тус бүрээр нь ялгаж нөөцөлнө.

Материал нөөцлөх газраас материалыг авахдаа уланд нь байгаа материалтай хольж болохгүй бөгөөд ёроолын үеийг 100мм орчим зузаантай үлдээнэ.

Хэрэв нөөц материал нь шаардлагатай хэмжээнээс илүү гарсан бол Инженер өөрөөр зааварчлаагүй тохиолдолд Гүйцэтгэгч түүнийг чулуун болон шороон ордын дотор талбайд тараана. Бутлах ба шигших ажил нь энэхүү техникийн шаардлагын бүлэг 500 ба дэд бүлэг 503 (с)-д заасны дагуу хийгдэнэ.

609. МАТЕРИАЛЫГ АШИГЛАХ

Зам барилгын байнгын ажилд хэрэглэгдэх, шороон ордоос олборлосон материалд тавигдах шаардлага нь Гүйцэтгэгчийн бусад ажлуудад хамааралтай шаардлагаас давуу байдлаар ашиглагдана. Шороон ордоос олборлосон материалыг туслах зам, түр зам, бусад түр барилга г.м үндсэн ажлаас бусад ямар нэг ажилд Инженерийн зөвшөөрөлгүйгээр ашиглаж болохгүй.

- Ухмалыг ухах буюу өргөтгөхөд гарсан материал дээр нэмж шаардагдах дүүргэлтийн

материалыг шороон ордоос авна. Техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу шороон ордыг тогтооно. Шороон ордын байршлыг Гүйцэтгэгч тогтоож, Инженер батална.

- Инженер барилгын аль нэг онцлог хэсэгт ашиглахаар шороон ордоос тодорхой материалыг сонгох зааврыг өгч болно. Ийм сонголт хийхээр зааварласан тохиолдолд шороон ордын тодорхой хэсэгт материалыг ухах, дахин шилжүүлэн зөөвөрлөх, овоолох ажил хийгдэж болох юм.

- Гүйцэтгэгч нь шороон ордод хүрэх туслах замыг барьж, шороон ордоос овор хэмжээ ихтэй том чулуу, үл тохирох материал, бүх төрлийн ургамлыг цэвэрлэж зайлуулна.

- Өнгөн хөрсийг хуулж, Техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу шороон ордыг нөхөн сэргээх үед ашиглах зорилгоор овоолон хадгална.

- Гүйцэтгэгч нь шороон ордод буй тохиромжтой материал нь үл тохирох материалтай холилдохгүй байх арга хэмжээг авна. Тохиромжгүй материалыг техникийн шаардлагын зүйл 508-д заасны дагуу зайлуулна.

- Шороон ордыг тогтоосон өргөн ба хэлбэрээр ухах ба ажил дууссаны дараа цэвэрлэж, нөхөн сэргээнэ. Нөхөн сэргээсэн газрын хажуу налуу нь хамгийн ихдээ хэвтээд 6, босоод 1 гэсэн харьцаатай байна. Техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу ойр орчмын газрыг цэвэрхэн үзэмжтэй зассан байна.

- Шороон ордыг нөхөн сэргээсний дараа Инженерээс баталгаа зөвшөөрөл авах ёстой.

610. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Техникийн шаардлагын бүлэг 600-д хамааруулан ямар нэгэн хэмжилт ба төлбөр хийгдэхгүй. Гүйцэтгэгч нь техникийн шаардлагын бүлэг 600-д заасан шаардлагуудыг хангахтай холбогдсон зардлыг бусад ажлын нэгж үнэ ба өртөгт тооцсон гэж үзнэ. Хэрэв Инженер чулуун ба шороон ордоос тохиромжтой материалын үе хүртэл ухаж гаргасан давхарга үеийг зам барилгын үндсэн ажилд ашиглахаар зааварчилсан тохиолдолд хэмжилт ба төлбөрийг Техникийн шаардлагын тохирох бүлэгт заасны дагуу хийнэ.

БҮЛЭГ 700 – ХӨДӨЛГӨӨН НЭВТРҮҮЛЭХ

БҮЛЭГ 700 – ХӨДӨЛГӨӨН НЭВТРҮҮЛЭХ

701. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
702. ХУУЧИН ШОРООН ЗАМУУДЫГ ЗАСАЖ АРЧЛАХ	2
703. ТҮР ЗАМ БАРИХ БА ТҮҮНИЙ ЗАСВАР, АРЧЛАЛТ	3
704. АЖЛЫН ТАЛБАРААР ХӨДӨЛГӨӨНИЙГ НЭВТРҮҮЛЭХ	5
705. ЗАМЫН ТЭМДЭГ, ХААЛТ, ГЭРЭЛТҮҮЛЭГ	5
706. ТУСЛАХ ЗАМ	6
707. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТЕХНОЛОГИЙН МАШИН МЕХАНИЗМУУД	6
708. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР	7

701. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Шинээр баригдаж байгаа замын барилгын ажлын үеэр нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлж, зорчигчдыг ая тухтай зорчих нөхцөлийг хангах арга хэмжээг тухайн барилгын ажлын Гүйцэтгэгч авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Ая тухтай, аюулгүй нөхцөл гэдэгт дараах арга хэмжээг ойлгоно. *Түр зам нь:*

- Хөдөлгөөний аюулгүй байдалд хүргэхээр тоос босгохгүй болгох арга хэмжээг тогтмол авагдсан байна. Жишээ нь. Өдөрт 2-оос багагүй удаа байнгын усалгаа болон чийгшүүлэлт хийх
- Бороо орж хөрсний гадаргуу чийглэгдсэн үед тэгшилгээ болон шаардлагатай үед нягтруулалт хийх
- Шавар багатай байгалийн хайрга элсэн хольцоор баригдсан байх
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн зохицуулж чадахуйц түр тэмдгүүдээр тэмдэгжүүлэгдэх
- Хүн болон тээврийн хэрэгсэлд аюул учрахуйц том чулуу үсрэхээс сэргийлэх арга хэмжээ авах

Нийт тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэвтрүүлэлтийг дараах байдлаар шийднэ.

- 1) Шинээр баригдах зурвасын барилгын ажлыг хийхэд саад болохооргүй хэсгүүдэд одоо байгаа асфальтобетон хучилттай замын зурвасыг нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэвтрүүлэхэд ашиглана.
- 2) Одоо байгаа замыг ашиглах боломжгүй хэсгүүдэд түр замыг шинээр барих эсвэл хуучин хөрсөн замыг сэргээн засварлана. Түр замаар тээврийн хэрэгслүүд тэгш тал газарт хамгийн багадаа 50 км/цаг, харин уулархаг газарт хамгийн багадаа 30 км/цаг хурдтай явах бололцоогоор хангаж, нийт барилгын ажлын үргэлжлэх явцад (барилгын ажил хүйтний улиралд зогсох үед ч) байнга засварлаж арчлах ажлыг Гүйцэтгэгч хариуцна.
- 3) Зам барилгын ажлын явцад тухайн газар орны онцлог, (өндөр уул, усаар хашигдсан, барилга байгууламж ойрхон гэх мэт) зам барилгын ажлын нөхцөлөөс шалтгаалан хөдөлгөөнийг түр замаар өнгөрүүлэх боломжгүй тохиолдолд зайлшгүй байдлыг харгалзан, ажилд эвдрэл, хохирол учруулахгүй байх нөхцөлийг хангасан тохиолдолд барилгын ажил явагдаж зурвасаар нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэвтрүүлэн өнгөрүүлэхийг Инженерээс Гүйцэтгэгчид зөвшөөрч болно.

Инженерийн зөвшөөрлөөр одоо мөрдөж буй стандартад нийцсэн тоосгүйжүүлэх бодисыг түр замд хэрэглэнэ.

- 4) Гэрээний хугацаанд Гүйцэтгэгч барилгын ажил явагдаж буй газруудтай ойр байгаа замуудын дагуу түр тэмдэг, хаалт байрлуулан, засвар арчлалт хийж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллана.

702. ХУУЧИН ШОРООН ЗАМУУДЫГ ЗАСАЖ АРЧЛАХ

Гүйцэтгэгч нь, шинэ барилгын ажлыг явуулахад ямар нэгэн байдлаар нөлөөлөх, талбайд ойрхон буюу зэрэгцээ оршиж байгаа шороон замуудыг гэрээ хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн барилга ашиглалтад орох хүртэл, гэрээнд хүлээсэн үүргийнхээ дагуу хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх, аюулгүй байх нөхцөлийг хангахуйц байдлаар засаж арчилна. Энэ нь шинэ замын ажлыг хамгаалах давхар ач холбогдолтой юм. Засвар арчлалтад дараах ажлууд багтах

бөгөөд зөвхөн тэдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- Шороон замын хонхрыг дүүргэж тэгшлэх, дэргжигнүүртэй хэсгийг зохих өргөнөөр хусах,
- Шаардлагатай үед услах, замаас тоос босохгүй нөхцөлийг хангах
- Төслийн замтай огтлолцох тохиолдолд гарц хийх
- Шаардлагатай хэсэгт ус зайлуулах хажуугийн болон жишүү шуудууг татаж төслийн замаас гадаргуугийн усыг холдуулах, зарим үед шуудууг гүнзгийлэх,
- Ус зайлуулах шуудуу, сувгаар ус чөлөөтэй урсах нөхцөлийг хангах,
- Замын түр тэмдэг, хаалт тавих засаж арчлах,
- Хөдөлгөөнийг нэвтрүүлэхэд шаардлагатай туслалцаа үзүүлэх.
- Гүйцэтгэгч нь засвар арчлалтыг хийх эрх зүйн баримт бичигт “Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын зохион байгуулалтын техникийн дүрэм” ЗЗБХБД 41-011-2015 –ийг ашиглана.

703. ТҮР ЗАМ БАРИХ БА ТҮҮНИЙ ЗАСВАР, АРЧЛАЛТ

а) Ерөнхий зүйл

Гүйцэтгэгч нь нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг одоо байгаа замаар зохицуулан явуулах боломжгүй бүхий л тохиолдолд түр зам барина. Түр замыг газрын хэвгий, саадыг харгалзан хамгийн боломжит богино чиглэлд сонгон барих бөгөөд сонгосон чигийг Инженерээр батлуулна. Зам барилгын ажил дууссан хэсгийн түр замыг түрж тараан, тэгшилж, ургамал тарих (ургамлын үндэс бүхий хар шороогоор хучих, ургамал тарих) замаар нөхөн сэргээнэ. Гүйцэтгэгч нь барилгын ажлын үеэр талбай дундуур болон хажуугаар нь тээврийн хэрэгслийг хэрхэн өнгөрүүлэх ба түр замыг барих төлөвлөгөө бүхий зургийг Инженерт танилцуулж, зөвшөөрөл авна.

Энэхүү зурагт дараах мэдээлэл багтах ба гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй:

- Түр замын урт ба чиг,
- Барьж байгаа замыг хөндлөн огтлох, эсэх
- Хоёр урсгалтай хөдөлгөөн,
- Замын өргөний хязгаар,
- Ус зайлуулах шуудуу,
- Элс, цасны хунгарлалтаас хамгаалах,
- Хоолой,
- Дагуу налуу
- Газар шорооны ажил,
- Хучилт,
- Тоос багасгах болон хөрсний элэгдлийн эсрэг арга хэмжээнүүд,
- Тэмдэг, хаалт хашилт,

Инженерээс бичгээр зөвшөөрөл авсны дараа Гүйцэтгэгч түр зам барих ажлыг эхлүүлнэ. Түр зам барих ажилтай холбогдон Гүйцэтгэгч нь дараах хариуцлагыг хүлээх ба холбогдож гарах зардлыг хариуцна. Үүнд:

- Замын зурвасаас гадагш ашиглах газрын (хэрвээ шаардлагатай бол) зөвшөөрлийг авах, төлбөрийг хийх.
- Холбооны болон цахилгааны шугам, ус дамжуулах хоолой болон бусад и инженерийн шугам сүлжээг шилжүүлэх, хамгаалах

Гүйцэтгэгч нь түр зам барихад хөндөгдөж болзошгүй инженерийн шугам сүлжээ, шон зэргийг хамгаалах үүрэгтэй. Гүйцэтгэгч кабель утас, шонгууд болон бусад шаардлагатай зүйлсийг хамгаалах хэлбэр, шилжүүлэх, солих арга зэрэг асуудлыг энэхүү техникийн шаардлагын зүйл 701-ын заалтууд ба холбогдох эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлага, мөрдөгдөж байгаа стандартыг баримтална. Эдгээр шугам сүлжээ нь түр замыг хөндлөн огтолж буй тохиолдолд техникийн шаардлагын зүйл 703(а)-ын заасан шаардлагуудад нийцүүлэн, эрх бүхий байгууллагын зөвлөсний дагуу хамгаалах арга хэлбэрийг сонгоно. Тэдгээрийг шилжүүлэх шаардлагатай бол техникийн шаардлагын зүйл 703-т зааснаар хийж гүйцэтгэнэ.

b) Геометр хэмжээ

Түр замыг зурагт үзүүлсний дагуу буюу Инженерийн зааварчилсан хөндлөн огтлолоор барина. Инженер өөрөөр зааварлаагүй бол түр замын зорчих хэсгийн өргөн нь 8-12м, хоёр урсгалтай байна.

Түр замын дагуугийн хамгийн их налуу 9%-иас хэтрэхгүй байвал зохино.

c) Барилгын ажил

Талбайг цэвэрлэх болон шаардлагатай бусад газар шорооны ажлыг энэхүү техникийн шаардлагын бүлэг 400 ба бүлэг 500-д заасны дагуу хийнэ. Ерөнхийдөө түр зам нь газар шорооны ажил багатай, тэгшилсэн шороон зам байх бөгөөд Инженерээс зааварчилсан тохиолдолд асфальтобетон эсвэл хайрган хучилт хийнэ. Замын түр тэмдэг, хаалт хашилт, зэргийг суурилуулна.

d) Ус зайлуулах байгууламж

Гүйцэтгэгч түр зам барих явцдаа түүнийг хөндлөн дайрч өнгөрөх усны гольдрол нь ус зайлуулах байгууламжаар ус чөлөөтэй урсаж байх нөхцөлийг хангасан байна.

Инженерийн зүгээс шаардлагатай гэж үзсэн газруудад зохих хэмжээ, нэвтрүүлэх хүчин чадал бүхий ус зайлуулах түр суваг шуудуу, хоолой, уулын шуудуу болон гүүр зэргийг барина.

Уулын шуудууны уртын хэмжээг Инженер-тэй зөвшилцсөний үндсэн дээр тухайн үед нь тогтоох ба гэхдээ шуудуугаар гадагшилсан ус шинэ болон түр замын аль нэг хэсгийг гэмтээхгүйгээр алсад зайлуулагдахаар барих хэрэгтэй. Уулын шуудууны гүн нь 0,6 м-ээс багагүй байх ба шуудуунаас гарсан шороог зам талын ирмэгт овоолж өгнө. Хэрэв ашиглалтын явцад үерийн буюу уулын ус овоолго шорооноос давж байвал шуудууг гүнзгийлж, овоолгын өндрийг нэмэгдүүлнэ.

e) Түр зам барьсан газруудыг нөхөн сэргээх

Гүйцэтгэгч түр зам барихад ашигласан газрыг, барилгын ажил эхлэхээс өмнө байсан байдалтай нь адил хэмжээнд хүртэл нөхөн сэргээнэ.

f) Түр замын засвар, арчлалт

Гүйцэтгэгч нь баригдсан түр замын засвар арчлалтыг “Авто замын, замын байгууламжийн засвар, арчлалтын арга технологи” БНБД 13-03-00-ийн заалтуудыг мөрдлөг болгон замын хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх нөхцөлийг хангахуйц хэмжээнд хийнэ. Түр замыг ашиглалтад өгсөн цагаас эхлэн баригдаж байгаа шинэ зам ашиглалтад орох хүртэл хугацаанд засвар арчлалтыг хийж гүйцэтгэнэ. Түр замын засварт дараах ажлууд хамрагдах ба гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- Замыг услах, тоосжилт дарах
- Замыг нийт өргөнөөр нь хусаж тэгшлэх,
- Хонхор хотгорыг дүүргэж, дахин хэлбэржүүлэх ба нягтруулах,
- Ус зайлуулах шуудуу, усны гольдрол ба хоолойгоор усны урсгал чөлөөтэй нэвтрэх боломжийг хангах, уулын шуудууг сэргээх, овоолгыг өндөрлөх
- Хоолой болон гүүрний жижиг засвар,
- Замын тэмдэг, хаалт хашилт,
- Замын хөдөлгөөнийг нэвтрүүлэхэд туслалцаа үзүүлэх.

704. АЖЛЫН ТАЛБАРААР ХӨДӨЛГӨӨНИЙГ НЭВТРҮҮЛЭХ

Ердийн нөхцөлд ажлын талбар дундуур хяналтын ажилтнуудын машин Гүйцэтгэгчийн технологийн машин техникээс бусад нийтийн тээврийн хэрэгсэл явуулахыг зөвшөөрөхгүй.

Барилгын ажлын талбар дундуур, өөрөөр хэлбэл, аль нэг хийгдэж байгаа үе дээгүүр болон түүний хөндлөн чиглэлд нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэвтрүүлэх асуудлыг зөвхөн Инженерийн зөвшөөрлөөр шийднэ. Ийм газруудад хөдөлгөөнийг аюулгүй байдлыг хангахын тулд Гүйцэтгэгч ажлаа замын өргөний хагаст буюу тодорхой хэмжээний богино зайд хийж гүйцэтгэнэ. Ажлын талбар дундуур нэвтрэх хөдөлгөөнийг саатуулах давтамж ба үргэлжлэх хугацааг аль болох бага байлгахаар Гүйцэтгэгч ажлаа зохион байгуулна. Барилгын ажлын талбар дундуур нийтийн тээврийн хэрэгсэл нэвтэрч буй газруудад Гүйцэтгэгч ухсан нүх болон бусад аюултай саадыг хаалт хашилтаар хамгаалж, шөнийн цагт тод гэрэлтүүлсэн байна. Барилгын ажлын талбар дундуур нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэвтрүүлэхтэй холбогдон ажилд учирсан аливаа эвдрэл гэмтлийг Гүйцэтгэгч өөрийн зардлаар, чанарын зохих хэмжээнд засварлана.

705. ЗАМЫН ТЭМДЭГ, ХААЛТ, ГЭРЭЛТҮҮЛЭГ

Гүйцэтгэгч нь Инженерийн зааварчилснаар шороон замаар болон баригдаж байгаа замаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэвтрүүлэхдээ энэхүү техникийн шаардлагын зүйл 705-т зааснаар түр тэмдэг, хаалт хашилтыг тавина.

Түр тэмдэгжүүлэхэд ашиглах замын бүх тэмдгүүд нь Монгол улсын MNS 4597-98 стандартын шаардлагад нийцсэн, хаалт хашилт нь Гүйцэтгэгчээс санал болгож, Инженер баталсан хэлбэр, хэмжээтэй байна. Байрлуулах замын түр тэмдгүүдийн төрлийг Инженер батална. Тэмдгүүдийг цэвэр, бүрэн бүтэн байлгана. Хаалт, хашилтуудыг цэвэр, бүрэн бүтэн байлгах ёстой. Хаалтуудыг зохих өнгийн гэрэл ойлгодог будгаар будах буюу эсвэл гэрэл ойлгогч наана.

706. ТУСЛАХ ЗАМ

а) Талбайд хүрэх зам

Гүйцэтгэгч нь өөр зам байхгүй газарт өөрийн тоног төхөөрөмж, ажиллах хүчин, материалыг тээвэрлэх болон нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулан ажлын талбайн бүх хэсэгт хүрэх туслах зам барих, засварлаж арчлах ажлуудыг өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэнэ. Шинэ замд хүрэх болон түүний дагуу ямар нэг туслах зам байхгүй тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн хэрэгцээнд зориулан материал тээвэрлэх замуудыг өөрийн зардлаар барьж арчилна. Тэдгээр замуудыг Захиалагч болон Инженер ашиглах боломжтой байна.

б) Шинэ туслах замууд

Материал нөөцлөх газар, чулуун ба шороон орд, хаягдал материал зайлуулах газрууд руу хүрэх туслах замуудыг тэдгээрийн хоорондох хамгийн боломжтой богино чиглэлээр, шинээр барьж байгаа зам руу тээвэр хийхэд хамгийн ойр цэгийг дайрч өнгөрөхөөр сонгоно. Туслах замуудыг байнга арчилж, материал тээвэрлэлтээс шалтгаалан барилгын ажил саатахгүй байх нөхцөлийг хангасан байна.

в) Туслах зам барьсан газруудыг нөхөн сэргээх

Гүйцэтгэгч энэхүү техникийн шаардлагын зүйл 703(д)-д түр замуудыг нөхөн сэргээх талаар заасантай адил байдлаар бүх туслах замуудыг нөхөн сэргээнэ.

д) Зардал

Гүйцэтгэгч туслах замуудыг барихтай холбоотой санхүүгийн бүх хариуцлагыг хүлээх бөгөөд тэдгээрээс үүдэн гарч байгаа дараах зардлуудыг төлөх ба гэхдээ зөвхөн тэдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- Газар авахтай холбоотой бүх арга хэмжээ,
- Газрын төлбөр,
- Газар эзэмшигч, тэнд оршин суугчид болон холбогдох байгууллагуудтай хийх хэлэлцээр,
- Холбооны болон цахилгааны шугам, ус дамжуулах хоолой болон бусад шугам сүлжээний бүх ажлууд,
- Нөхөн олговор,
- Байгалиас ашигласан хайрга, бусад материалын төлбөр.

707. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТЕХНОЛОГИЙН МАШИН МЕХАНИЗМУУД

(а) Баригдаж буй шинэ замыг ашиглах

Гүйцэтгэгчийн барилгын материал тээвэрлэж буй тоног төхөөрөмж, хүнд даацын ачааны машинууд нь баригдаж буй хучилтын үеүд дээгүүр явах ёсгүй. Энэ зорилгоор хучилтын үеүд болон цементобетон хучлагыг хангалттай бэхжих хүртэл сайтар хамгаалах ёстой.

Хучилт нь бүрэн дууссан хэсэг дээгүүр Гүйцэтгэгчийн технологийн машин механизмууд болон тэнхлэг дээрээ 10 тонноос илүү ачаалал бүхий машинуудыг явуулахгүй. Инженерээс

хиймэл байгууламж, далангийн үе, хучилтын үеүд буюу гадаргууд эвдрэл үүсэж болзошгүй гэж үзсэн тохиолдолд замын дууссан хэсгүүдийг буюу дууссан хучилтын үеүдийг Гүйцэтгэгч тээвэрлэлтийн ажилд гүйцэтгэхдээ ашиглахыг хориглоно.

Бүрэн дууссан далангийн үе, хучилтын үеүд буюу хучлага дээр, машины тэнхлэгийн ачааллаас үл хамааран, Гүйцэтгэгчийн машинуудын аль нэгний буруутай үйлдлээс шалтгаалж ямар нэг эвдрэл үүссэн тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн зардлаар Инженерийн зааврын дагуу засварлана.

Нийтийн замаар зорчиж буй Гүйцэтгэгчийн машинууд энэ талаарх Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийг дагаж мөрдөнө.

708. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Энэхүү техникийн шаардлагын зүйл 701, 702, 704, 705, 706, 707-ийн шаардлагуудыг хангах үүднээс зарцуулах аливаа зардалд тусад нь хэмжилт, төлбөр хийгдэхгүй бөгөөд Гүйцэтгэгчийг аль нэг ажлынхаа өртөг зардалд оруулан тооцсон гэж үзнэ.

(а) Зүйл: түр замыг барих, засаж арчлах

Нэгж: км

Энэхүү зүйлийн төлбөрийн нэгж нь километр байна. Инженерийн зааварчилж, түүний шаардлагыг хангах хэмжээнд баригдаж, засвар арчлалт нь хийгдсэн замын хэсгүүдэд хэмжилт, төлбөр хийгдэнэ.

Энэхүү зүйлийн өртөг нь техникийн шаардлагын зүйл 703 ба бүлэг 100-ийн шаардлагуудыг хангахад зориулагдан, барилгын ажлын явцад бүхэлд нь гаргах зардлуудыг хамрах ба үүнд энэхүү техникийн шаардлагын бүлэг 100-ын дагуу тусдаа хэмжилт ба төлбөр нь хийгдэх түр замын хайрган хучилтын ажил орохгүй.

Гэрээнд тусгагдсан бол дараах нөхцөлүүдийн дагуу түр замын засвар арчлалтын ажлын төлбөрийг хийнэ. Үүнд: Дэд-зүйл 708 (а)-д заасан нийт үнийн дүнгийн 60%-ийг Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажил хэрэгжиж дуусах хүртэлх хугацаагаар тооцож, сар бүр адил хэмжээгээр төлнө. Гэхдээ гэрээний нөхцөл ба барилгын дуусах хугацааг сунгагдах нөхцөлийг харгалзан үзнэ.

Зүйл 701-ээс 703-ын шаардлагын дагуу хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх үүднээс хийгдэх ёстой ажлууд нь Гүйцэтгэгчийн буруугаас хийгдээгүй хэмээн Инженер тодорхойлсон бол сар бүрийн төлбөрийн зохих хэсгүүдийг саатуулан барина. Үүнтэй холбогдуулан, Гүйцэтгэгчийн гаргасан зөрчлийг арилгах үүднээс Инженер түр замын шаардлагатай засвар арчлалтыг өөр байгууллагаар хийлгэх эрхтэй бөгөөд үүнд зарцуулсан зардлыг Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс нөхөн олгоно.

Гүйцэтгэгч нь нийт барилгын ажлын явцад зүйл 701-ээс 703-д заасан шаардлагын дагуу хуучин шороон зам, түр замыг засаж арчилсан гэж Инженер шийдвэрлэсэн бол энэ ажлын нийт үнийн дүнгийн үлдсэн 40%-ийг барилгыг хүлээн авсан гэрчилгээг олгосны дараа Гүйцэтгэгчид төлөх боломжтой бөгөөд захиалагчийн шийдвэрийг мөрдлөгө болгоно.

БҮЛЭГ 800 – СУУРИЙН ДООД ҮЕ

БҮЛЭГ 800 – СУУРИЙН ДООД ҮЕ

801. ЕРӨНХИЙ.....	2
a) Тодорхойлолт.....	2
b) Материалын эх үүсвэр.....	2
c) Ажлын талбайг үзэж судлах.....	3
d) Шороон орд газруудыг ашиглах журам.....	3
802. МАТЕРИАЛЫН АНГИЛАЛ.....	3
803. МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	4
a) Ерөнхий.....	4
b) Суурийн доод үе.....	4
804. МАТЕРИАЛЫГ БУТЛАХ, ШИГШИХ БА ХОЛИХ.....	7
805. ДЭВСЭХ БА НЯГТРУУЛАХ.....	7
806. СОРИЛТЫН НЯГТРУУЛАЛТ.....	8
807. ХЭМЖИЛТ БА ХҮЛЦЭХ АЛДАА.....	8
808. СУУРИЙН ДООД ҮЕ БА СУУРИЙН ГАДАРГУУГААС УСЫГ ЗАЙЛУУЛАХ.....	8
809. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР.....	8

801. ЕРӨНХИЙ

а) Тодорхойлолт

Энэ бүлэгт буталсан чулуу суурь болон суурийн доод үеийг хэрхэн дэвсэх талаар зааварчилсан болно.

“**Зохист ширхэглэл бүхийн байгалийн материал**” гэдэг нь хайрга, элс хайрганы хольц, уулын чулуулаг, элс, элсэрхэг хөрс, эдгээрийн холимог зэрэг (гэвч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй) байгалиас шууд олборлосон, бутлалгүйгээр хэрэглэх материалыг хэлнэ. Байгалийн хайрган материалыг “хайрга” гэсэн ерөнхий нэр томъёогоор нэрлэнэ. Суурийн доод үеийн материалыг шууд байгалаас авах буюу эсвэл буталж, шигшин тодорхой харьцаагаар дахин хольж гаргаж авна.

“**Зохист ширхэглэлтэй буталсан чулуун чулуун хольц**” гэдэг нь байгалийн том чулууг буталж, тодорхой харьцаагаар хольсон, ширхэглэлийн тогтоосон хязгаар дотор орших алгуур муруйгаар илэрхийлэгдсэн, ширхэглэл бүхий хольцыг хэлнэ.

“**Буталсан чулуу**” гэдэг нь байгалийн том чулууг бутлах төхөөрөмжөөр буталж, ширхэглэлийн бүрэлдэхүүнээр нь ангилж ялгасан материал.

Суурийн доод үед зохистой ширхэглэл бүхий хайрган материал,

Буталсан чулуун сууринд буталж, шигшиж ангилсан дүүргэгч материалыг тус тус ашиглана

б) Материалын эх үүсвэр

Буталсан чулуун суурь болон Суурийн доод үе буюу зохист ширхэглэлтэй хайрган материалыг дараах эх үүсвэрээс гаргаж авч болно. Үүнд:

- 1) Шороон орд газар
- 2) Чулууны карьер
- 3) Хуучин асфальтобетон хучлагыг бутлан хайрга, элстэй тохиромжтой харьцаагаар хольж бэлдсэн материал
- 4) Ухмал

Материалын эх үүсвэрийг сонгож тогтоох ажлыг Гүйцэтгэгч хариуцаж, өөрийн зардлаар гүйцэтгэнэ. Аль ч тохиолдолд хэрэглэгдэх материалын эх үүсвэрийг Инженерээр батлуулна.

Суурь болон Суурийн доод үеийн материалын чанар, ширхэглэлийг сайжруулахаар хийгдсэн нэмэлт ажлууд нь нэгж үнэлгээнд багтсан бөгөөд төлбөрийг нэмж тооцохгүй.

с) Ажлын талбайг үзэж судлах

Тендерийн явцад Гүйцэтгэгч нь ажлын талбайтай танилцах үедээ хуучин асфальтбетон хучилтын материал болон байгалиас олборлон ашиглаж болох материалуудын талаар сайтар судалж, олдоцтой бөгөөд зохих нөөцтэй болохыг магадлан шалгана. Ажлын явцад Гүйцэтгэгч нь дараах зүйлүүдийг тодорхойлж, Инженерт танилцуулна. Үүнд:

- Одоо байгаа замын асфальтбетон хучлагыг 0.2 м хүртэл зузаантай үеийн материалын буталж хуулан, шинжилгээнд хамааруулах
- Уг хольцын шаардлага хангах хэсгийг нөөцлөх талбайг бэлдэх,
- Хольцыг суурийн доод үед хэрэглэх шороон материалтай тохиромжтой харьцаагаар холих лабораторийн туршилтыг Гүйцэтгэгчийн лабораторид хийх, ачаа даацын шинжилгээ хийх
- Суурийн доод үед хэрэглэх шороон ордыг нээх, Гүйцэтгэгчийн лабораторид урьдчилсан байдлаар далан суурийн иж бүрэн шинжилгээг хийсэн байх
- Шороон ордуудын нөөцийг тогтоосон байх
- Уг шороон ордын иж бүрэн шинжилгээг хийх,
- Зайлуулах хөрс хуулалтын хэмжээ
- Том материалын харьцаа,
- Суурийн доод үеийн материалын эх үүсвэрт хүрэх түр замыг барих, арчлах

d) Шороон орд газруудыг ашиглах журам

Гүйцэтгэгч нь шороон орд, мөн материалыг зайлуулж хаях буюу нөөцөлж овоолох газар зэргийг нээх, ашиглах, буцааж дарах, нөхөн сэргээх болон тэдгээр рүү хүрэх түр замтай холбоотой ажлыг гүйцэтгэхдээ Монгол улсын холбогдох хууль тогтоомж болон энэхүү Техникийн шаардлагын 600-р бүлэгт заасан шаардлагыг дагаж мөрдөнө.

802. МАТЕРИАЛЫН АНГИЛАЛ

Зохист ширхэглэл бүхий хайрган буюу суурийн доод үе болон суурь үед хэрэглэх материалын ангилал:

1. Шороон орд газрын материал
2. Чулууны карьерын материал
3. Хуучин асфальтбетон хучлагыг бутлан шороон ордын материалтай тохиромжтой харьцаагаар хольж бэлдсэн материал
4. Ухмалаас олборлосон зохист ширхэглэл бүхий шороон материал

803. МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

а) Ерөнхий

Суурийн доод үеийн материал нь доор дурдсан зүйлсийг агуулаагүй байна. Үүнд:

- Өгөршсөн буюу хэврэгшсэн материал,
- Хоёрдогч (шавар) эрдэс бодис,
- Хавтгай буюу хайрслалт материал (миканит),
- Зөөлөн чулуу,
- Тэлэх чадвартай эрдэс бодис,
- Химийн нөлөөнд хялбар өртдөг материал,
- Уусдаг давс

б) Суурийн доод үе

Суурийн доод үеийн материалын дэвсэж нягтруулсны дараах ширхэглэлийн харьцаа нь (Хүснэгт 8-1)-д үзүүлсэн ширхэглэлийн хязгаарт ойролцоо буюу зэрэгцэн явах аажим муруйн өөрчлөлтийн хэлбэртэй байна.

Хүснэгт 8-1. Суурийн доод үеийн материалд тавигдах ширхэглэлийн шаардлага

Шигшүүрийн хэмжээ Sieve size, мм/мм	Шигшүүрээр өнгөрсөн материалын жингийн эзлэх хувь/ Aggregate percent passing		
	ЖТШ	MNS ASTM D 1241:2002	
63	100	A	B
37.5	90 – 100		100
25.0	80 – 100		75-95
19.0	60 – 90		-
9.5	30 – 65	30-65	40-75
4.75	25 – 55	25-55	30-60
2.36	15 – 40	15-40	20-45
0.425	8 – 20	8-20	15-30
0.075	0 – 5	2 - 8	5-15

***Тухайн орон нутгийн материалын шинж чанараас хамаарч туршилтын үр дүнгээр тогтоогдсон, хэрэв инженерийн зөвшөөрснөөр шаардлагатай тохиолдолд хольцын төрөл, ширхэглэлийн хязгаарыг тухайн материалд тохируулан өөрчилж болно*

Суурийн доод үеийн материалын физик шинж чанар нь дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- ✓ Жигд байдлын коэффициент < 50
- ✓ Уян налархайн модуль $\leq 60\%$,
- ✓ Урсалтын хязгаар $\leq 25\%$,
- ✓ Уян налархайн индекс $\leq 6\%$,
- ✓ (AASHTO T180-93)-аар тодорхойлсон MDD - 98 % байх үеийн усанд 4 хоног сойсны дараах ачаа даац буюу CBR $\geq 50\%$
- ✓ ХҮХИН (AASHTO T1810-10) 1,85 т/м³-аас багагүй

Хүснэгт 8-2. Суурийн доод үеийн гадаргууд тавигдах шаардлага

№	Шалгах үзүүлэлт		Тогтоосон утга буюу хүлцэх алдаа		Шалгах арга ба давтамж
			Суурийн дээд үед	Суурийн доод үед	
1	Нягтралын зэрэг, % (хэмжилтийн утга)		98	98	200м тутамд багадаа 2 хэсгийг шалгана
2	Тэгш байдал (мм)		12	-	3м рейк: 200м тутамд чиглэл тус бүрд 10 удаа хэмжинэ
3	Босоо төлөвлөлтийн өндөржилт (мм)		±15 мм	±15 мм	Нивлер: 200м тутамд 4 багагүй огтлолыг түүвэрлэж хэмжинэ
4	Өргөн (мм)		Зурагт зааснаас багагүй		Хуваарьт уртын хэмжүүр: 200м тутамд 4 огтлолыг хэмжинэ
5	Зузаан (мм)	Хэмжилтийн утга	-10	±12	Хөдөлгөөний зурвас бүрийн 1000-2000 м ² тутамд 1 хэсгийг шалгана
		Хүлцэх алдаа	-20	±30	
6	Хөндлөн хэвгий (%)		±0.30	-	Налуу хэмжигч: 200м тутамд 4 огтлолыг хэмжинэ

Суурийн доод үед хэрэглэх байгалийн материалд зохих шаардлагыг хангахгүй тохиолдолд төрөл бүрийн хэмжээтэй, өөр өөр эх үүсвэрээс авсан материалыг материал хураан нөөцөлдөг талбайд механик ажиллагаатай төхөөрөмжийг ашиглан Гүйцэтгэгчийн туршиж, Инженерийн хүлээн зөвшөөрсөн аргачлалын дагуу холино. Материал ялгарахаас сэргийлж буталсан чулууг боловсруулах, тээвэрлэх явцад чийглэж байх ба өндрөөрөө 5м-ээс илүүгүй овоолго хийж хураана.

Мөн тухайн орон нутгийн материалаас хамаарч хөлдөлтийн улмаас эвдрэлд орохгүй (овойхгүй) байхын тулд 0.075мм-ээр өнгөрсөн хувь 8-1-т хүснэгтэд заасан шаардлагаас бага байх шаардлагатай.

с) Буталсан чулуун суурь үе

Буталсан чулуун материалын дүүргэгч нь өгөршсөн, хавтгай буюу хайрслалттай материал (миканит), шавар, шавранцар, органик материал болон бусад хортой бодис агуулаагүй буталсан чулуу байна. Газар дээрээ амархан бутарч буюу хагарч байгаа мөн хагарахдаа хавтгай хайрс мэт

салдаг эсвэл хагарсан судлын дагуудаа гөлгөр гадаргуутай зэрэг чулууг буталсан чулуун материалд ашиглаж болохгүй. Материалын физик шинж чанар нь дараах шаардлагыг хангасан байна. Буталсан чулуун суурийн ширхэглэлийн харьцаа нь Хүснэгт:11-3 үзүүлсэн ширхэглэлийн хязгаарт ойролцоо буюу зэрэгцэн явах аажим муруйн хэлбэртэй байна

Хүснэгт 8-3. Буталсан чулуун суурийн материалын ширхэглэлийн хязгаар

Шигшүүрийн хэмжээ	Шигшүүрээр өнгөрсөн материалын жингийн эзлэх хувь, %	
	А	Б
50 мм	100	
37.5 мм	90 - 100	-
25.0 мм	-	100
19.0 мм	73 - 88	85 - 100
9.5 мм	49 - 69	52 - 74
4.75 мм	29 - 54	29 - 54
2.36 мм	17 - 37	17 - 37
0.600 мм	8 - 20	8 - 20
0.075 мм	0 - 7*	0 - 7*

***Тухайн орон нутгийн материалын шинж чанараас хамаарч туршилтын үр дүнгээр тогтоогдсон, хэрэв инженерийн зөвшөөрснөөр шаардлагатай тохиолдолд хольцын төрөл, ширхэглэлийн хязгаарыг тухайн материалд тохируулан өөрчилж болно*

**Уян харимхай индекс 0 үед шигшүүрээр өнгөрөх материалын жингийн хувийг их байхаар авна.*

Хэрэв чулууг бутлах явцад нарийн ширхэглэлтэй хэсгийн хэмжээ хүрэлцэхээргүй эсвэл шаварлагын хэмжээ хэт их байвал Инженерийн баталсан орд газраас шавар агуулаагүй, элс авчирч хольж сайжруулж болно.

Буталсан чулуун суурийн материалын физик шинж чанар нь MNS 390-98 стандарт болон дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- ✓ Ширхэгийн дундаж нягт > 2.4г/см³
- ✓ Содын сульфатыг ашиглан тодорхойлсон буталсан чулууны бат бэх (AASHTO T104) < 12%,
- ✓ Лос Анжелесын машинаар тодорхойлсон чулууны элэгдлийн бат бэх (MNS ASTM C535:2003) < 30,
- ✓ Үзүүрлэг шовх ба хавтгай хэсгийн хэмжээ (BS 812) < 25
- ✓ Цохилтой бутрагдалт (BS 812) < 25
- ✓ Ус шингээлт < 2%.
- ✓ Бутрагдалтын харьцаа 100%-аас багагүй
- ✓ (MNS ASTM D1557:2002 ба MNS ASTM D1556:2002) -аар тодорхойлсон MDD -100 % байх үеийн усанд 4 хоног сойсны дараах CBR > 80 байна.
- ✓ Бутрагдалтын харьцаа буюу бутлагдсан хэсгийн хэмжээ 80%-аас багагүй
- ✓ Уян налархайн индекс нь 0 буюу холбоосгүй байна.
- ✓ (AASHTO T180-93)-аар тодорхойлсон MDD - 98 % байх үеийн усанд 4 хоног сойсны дараах ачаа даац буюу CBR ≥ 80%
- ✓ ХҮХИН (AASHTO T 1810-10) 1.95 т/м³-аас багагүй

Материалыг бутлах, шигших болон тогтоосон орц хэмжээгээр тэдгээрийг холихдоо эцсийн бүтээгдэхүүний чанарыг хангахуйц ажлын аргачлалын дагуу, сайн тохиргоотой, механик

ажиллагаатай төхөөрөмжийг ашиглан гүйцэтгэнэ. Төрөл бүрийн хэмжээтэй, өөр өөр эх үүсвэрүүдээс авсан материалыг материал хураан нөөцөлдөг талбайд механик ажиллагаатай төхөөрөмжийг ашиглан Гүйцэтгэгчийн түршиж, Инженерийн хүлээн зөвшөөрсөн аргачлалын дагуу холино. Материал ялгарахаас сэргийлж буталсан чулууг боловсруулах, тээвэрлэх явцад чийглэж байх ба өндөрөөрөө 5м-ээс илүүгүй овоолго хийж хураана.

Хүснэгт 8-4. Суурь үеийн гадаргууд тавигдах шаардлага

№	Шалгах үзүүлэлт		Тогтоосон утга буюу хүлцэх алдаа		Шалгах арга ба давтамж
			Суурийн дээд үед	Суурийн доод үед	
1	Нягтралын зэрэг, % (хэмжилтийн утга)		99	98	200м тутамд багадаа 2 хэсгийг шалгана
2	Тэгш байдал (мм)		8	-	3м рейк: 200м тутамд чиглэл тус бүрд 10 удаа хэмжинэ
3	Босоо төлөвлөлтийн өндөржилт (мм)		-10 мм	-10 мм	Нивлер: 200м тутамд 4 багагүй огтлолыг хэмжинэ
4	Өргөн (мм)		Зурагт зааснаас багагүй		Хуваарьт уртын хэмжүүр: 200м тутамд 4 огтлолыг хэмжинэ
5	Зузаан (мм)	Хэмжилтийн утга	-10	±12	Хөдөлгөөний зурвас бүрийн 1000-2000 м ² тутамд 1 хэсгийг шалгана
		Хүлцэх алдаа	-20	±30	
6	Хөндлөн хэвгий (%)		±0.30	-	Налуу хэмжигч: 200м тутамд 4 огтлолыг хэмжинэ

804. МАТЕРИАЛЫГ БУТЛАХ, ШИГШИХ БА ХОЛИХ

Материалыг бутлах, шигших болон тогтоосон орц хэмжээгээр тэдгээрийг холихдоо эцсийн бүтээгдэхүүний чанарыг хангахуйц ажлын аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

805. ДЭВСЭХ БА НЯГТРУУЛАХ

Материалыг зурагт заасан буюу Инженерийн тогтоосон нийт өргөнд, хангалттай хэмжээгээр жигд тарааж нягтруулсны дараах зузаан нь зурагт заасан буюу Инженерийн зааварчилснаас багагүй байхаар дэвсэнэ.

Тухайн (суурь болон суурийн доод үе) үеийн нягтарсан зузаан 250мм-ээс их байх тохиолдолд дэвсэлтийг 2 үеэр үелүүлэн хийнэ. Ямар ч тохиолдолд, суурийн доод үеийн нягтарсан зузаан нь хэрэглэж байгаа материалын хамгийн том хэмжээнээс 2 дахин их байх ёстой.

Гүйцэтгэгч материалыг дэвсэхээс өмнө тохиромжтой чийгийн агуулгыг тогтоох ба материалыг дэвсэж нягтруулах үед чийгийн агуулгыг шаардлагатай хэмжээнд байлгах зорилгоор чийгийн хэмжээг тохируулна. Хэрэв Инженерээс өөрөөр зааварчлаагүй бол нягтруулалтын үед материалын чийг нь тохиромжтой чийгийн агууламжаас (AASHTO T180-93) 2%-иар ихгүй буюу 1%-иас бага байна. Талбайд материалыг дэвссэний дараа дурандлага хийж төвшинг эцсийн байдлаар тааруулах ба 3м-ийн рейк, эсвэл бусад зөвшөөрөгдсөн багажийг ашиглан гадаргуугийн

тэгш байдлыг дээд үеүүдэд шалгаж, шаардлагатай газруудыг тэгшилж засах ёстой. Гүйцэтгэгч үе тус бүрийг дэвссэн даруйдаа шууд нягтруулна. Эргэц бүхий тойруугаас бусад бүх хэсэгт нягтруулалтыг хучлагын гадаад ирмэгээс төв рүү чиглэсэн байдлаар, тэнхлэгийн дагуу явж нягтруулна. Эргэцтэй хэсэгт мөн тэнхлэгийн дагуу, гэхдээ нам ирмэгээс өргөгдсөн ирмэг рүү чиглэсэн байдлаар гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч материалыг тараах, тэгшлэх, нягтруулах үедээ гадаргуу болон материалыг хатахаас сэргийлж ус шүрших буюу бусад зөвшөөрөгдсөн аргыг хэрэглэн тогтоосон чийгшлийн агууламжийг зохих хэмжээнд барина. Эцсийн хэлбэржүүлэлт хийж хуссаны дараа суурь болон суурийн доод үеийг MDD (хуурай үеийн хамгийн их нягтшил) нь хүснэгт 8-2, 8-4-т зааснаас багагүй MNS ASTM D1557:2002 ба MNS ASTM D1556:2002) байхаар нягтруулна

Нягтруулалт хийж дууссаны дараа гадаргуу нь сайн нягтарсан, элдэв ан цав, хагаралгүй, индүүдлэгийн улмаас гулсалт, долгион үүсээгүй, чулууны ялгарал гараагүй байх ёстой. Хэрвээ гадаргуу нь энд дурдсан шаардлагыг хангахгүй байвал Гүйцэтгэгч энэхүү Техникийн шаардлагыг 300-р бүлэгт заасан арга хэмжээг авах буюу дахин шинээр хийх зэргээр Инженерийн шаардсан аливаа бусад арга хэмжээг авна. Засварын болон дахин хийх ажлын зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

806. СОРИЛТЫН НЯГТРУУЛАЛТ

Гүйцэтгэгч тухайн үеийг Инженерийн зөвшөөрсөн даац, техникийн үзүүлэлт бүхий индүүгээр индүүдэж сорино. Сорилтын нягтруулалт хангалттай болсон гэж үзвэл ажил эхлэх зөвшөөрлийг олгоно. Сорилтын нягтруулалт хийх болон сорилтын дараа гарсан шаардлагатай аливаа засварыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

807. ХЭМЖИЛТ БА ХҮЛЦЭХ АЛДАА

Суурь үе болон Суурийн доод үеийн хэмжилт ба барилгын ажлыг энэхүү Техникийн шаардлагын 300-р бүлэгт заасан хүлцэх алдааг харгалзан гүйцэтгэнэ.

Хэрэв материалын аль 1 үзүүлэлт дээр дурдсан шаардлага хангаж чадаагүй бол тухайн өдрийн эх үүсвэрээс авч хийсэн (талбайн хэмжээг тогтоож) хэсгийг шаардлага хангаагүйд тооцож, Инженерийн зааварчилгаагаар хуулах, талбайгаас зайлуулах болон бусад сайжруулах арга хэмжээг нэн даруй авна (БНБД 32-02-00 2010-07). Энэ үед гүйцэтгэгч нэн даруй Инженерийн зөвшөөрөлтэйгөөр суурийн орцын нормыг өөрчлөх арга хэмжээ авч, техникийн шаардлагын зүйл 803-д нийцүүлнэ.

808. СУУРИЙН ДООД ҮЕ БА СУУРИЙН ГАДАРГУУГААС УСЫГ ЗАЙЛУУЛАХ

Гүйцэтгэгч далангийн дээд үе, суурийн доод үе ба буталсан чулуун суурийн гадаргуугаас усыг байнга зайлуулж, хамгаалах арга хэмжээ авах бөгөөд гадаргуу дээр ус тогтсон буюу урссанаас гарсан аливаа эвдрэл гэмтлийг өөрийн зардлаар засварлана. Тухайлбал, энэ техникийн шаардлагын 100 ба 800, 900-р бүлгүүдэд заасан ус зайлуулах шаардлагыг мөрдөнө. Хэрэв далангийн дээд үе, суурийн доод үе ба суурийн үеийн аливаа хэсэгт ус тогтсоноос болж материал усанд нэвчсэн буюу үүний улмаас материал нь шаардлагатай нягтыг авч чадахгүй болсон бол Гүйцэтгэгч өөрийн зардлаар эдгээр материалыг зайлуулан хаяж, энэхүү Техникийн шаардлагад нийцсэн материалаар солино.

809. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

(а) Зүйл: Суурийн доод үе

Нэгж: м³

Суурийн доод үеийн ажлыг зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсны дагуу замын далан дээр дэвсэж нягтруулсан шоо метрээр хэмжинэ. Ажлын тоо хэмжээг тооцохдоо нягтруулсан үеийн хөндлөн огтлолын талбайг заасан уртаар үржүүлж гаргана.

Засварын ажилд тусад нь хэмжилт буюу төлбөр хийхгүй. Суурийн доод үеийн нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- Шороон орд, материал хураах талбай, боловсруулалт хийх талбай болон тэдгээрт хүрэх түр замын цэвэрлэгээ,
- Дээрх газрууд болон түр замаас хуулсан өнгөн хөрс, бусад хаягдлыг зайлуулах ба хэрэв шаардлагатай бол тусад нь овоолох,
- Дээрх газрууд болон түр замаас ус зайлуулах, ажил дууссаны дараа тэдгээрийг буцааж булах, зүлэгжүүлэх, нөхөн сэргээх,
- Орд газрыг тойруулж хамгаалалт хийх, хайс барих,
- Түр зам барих ба тэдгээрийг арчлах, түр замаар хөдөлгөөн явах нөхцөлийг бүрдүүлэх,
- Тээврийн хөдөлгөөний хяналт, аюулгүй байдал ба олон нийтийн эрүүл ахуйн шаардлагыг хангах,
- Материалыг сонгох, ухаж авах,
- Том ширхэглэлтэй материал байвал тэдгээрийг зайлуулах,
- Хуучин хучилтын үеүдийг холигч машинаар буталж холих, тэдгээрийг түр хураах,
- Материалыг дахин боловсруулах ба хураах,
- Материалыг ачих, тээвэрлэх, буулгах,
- Бүхий л шаардлагатай тээвэрлэлт,
- Ус авчирч материалыг услах, хатаах,
- Материалыг холих, боловсруулах, тараах, нягтруулах,
- Шаардлагатай гэж үзвэл нарийн ширхэглэлтэй материал авчирч нэмж холих,
- Шүүрдэх, доголдолтой хэсгүүдийг засаж сайжруулах, гадаргууг арчлах,
- Энэхүү Техникийн шаардлагын 100, 200, 300, 600 ба 800-р бүлгүүдийн заалтуудтай нийцүүлэх.

Зүйл : Буталсан чулуун суурь

Хэмжих нэгж : м³

Буталсан чулуун суурийн үеийн ажлыг Зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсны дагуу замын далан дээр дэвсэж нягтруулсан эзэлхүүнээр хэмжинэ. Ажлын тоо хэмжээг тооцохдоо нягтруулсан үеийн хөндлөн огтлолын талбай, урт, зузааны үржвэрээр гаргана. Засварын ажилд тусад нь хэмжилт буюу төлбөр хийхгүй. Буталсан чулуун суурийн нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- ✓ Материалын орд газар, материал хураах талбай, боловсруулалт хийх талбай болон тэдгээрт хүрэх түр замын талбайн цэвэрлэгээ,
- ✓ Дээрх газрууд болон түр замаас хуулсан өнгө хөрс бусад хаягдлыг зайлуулах ба хэрэв шаардлагатай бол тусад нь хураах,
- ✓ Дээрх газрууд болон түр замаас ус зайлуулах, ажил дууссаны дараа тэдгээрийг буцааж

- булах, зүдэгжүүлэх, нөхөн сэргээх,
- ✓ Чулууны карьерыг тойруулан хамгаалалт хийх, хайс барих,
 - ✓ Тэсэлгээний ажлын аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бүхий л арга хэмжээ авах,
 - ✓ Түр зам барих ба тэдгээрийг арчлах, түр замаар хөдөлгөөн явах нөхцөлийг бүрдүүлэх,
 - ✓ Тээврийн хөдөлгөөний хяналт, аюулгүй байдал ба олон нийтийн эрүүл ахуйн шаардлагыг хангах,
 - ✓ Материалыг сонгох, ухаж авах,
 - ✓ Материалыг хоёроос доошгүй үе шаттайгаар бутлах, шигших, угаах,
 - ✓ Хэрэв шаардлагатай бол нарийн ширхэглэлтэй материалыг нэмж холих, тэдгээрийг туслах орд газраас гаргаж авах, тээвэрлэлт, орд газар ашигласны төлбөр, нөхөн сэргээлт
 - ✓ Уян налархай чанарыг өөрчлөх нэмэлтүүдийг авчрах, боловсруулах,
 - ✓ Заасан хэмжээнээс том ширхэглэлтэй материалыг зайлуулж заасан газарт хаях,
 - ✓ Материалыг давхар боловсруулах ба 5м-с дээшгүй өндөртэйгээр овоолон хураах,
 - ✓ Материалыг ачих, тээвэрлэх, буулгах,
 - ✓ Бүхий л шаардлагатай тээвэрлэлт,
 - ✓ Ус авчирч материалыг услах буюу хатаах,
 - ✓ Материалыг тараах, нягтруулах,
 - ✓ Шүүрдэх, доголдолтой хэсгүүдийг засч сайжруулах, гадаргууг арчлах,
- Энэхүү Техникийн шаардлагын 200, 300 ба 1100-р Бүлгүүдийн заалтуудтай нийцүүлэх.

**БҮЛЭГ 900 – ЦЕМЕНТЭЭР БЭХЖҮҮЛСЭН
ХӨРСӨН СУУРЬ**

БҮЛЭГ 900 – ЦЕМЕНТЭЭР БЭХЖҮҮЛСЭН ХӨРСӨН СУУРЬ

901. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
902. МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА	2
903. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	5
904. БАРИЛГЫН АЖИЛ	8
905. ЧАНАРЫН ХЯНАЛТ	11
906. БАРИЛГЫН АЖЛЫН ДАРААЛАЛ	12
907. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР	13

901. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэ бүлэгт зохист ширхэглэл бүхий байгалийн хөрс материалыг цементээр бэхжүүлсэн суурь 4-6% байх үеийн барилгын ажилд тавигдах шаардлагыг оруулсан болно.

ЦББЧ болон ЦБХ суурийн дээр Асфалтбетон хучлагын дэвсэнэ..

Бүлэг дотроо гурван дэд бүлэгт хуваагдана.

Дэд бүлэг “А” Ерөнхий зүйл

Дэд бүлэг “В” Цементээр бэхжүүлсэн хөрсөн суурийн доод үе 4-6% (дээд үе 6-8%)

“В” ДЭД БҮЛГИЙН АГУУЛГА

Цементээр бэхжүүлсэн суурин дээр асфальбетон хучлагыг хийнэ. ЦБХ (4-6%) суурийг зураг төсөлд заагдсаны дагуу суурийн доод үе болон буталсан чулуун суурь үе дээр дэвсэнэ. ЦБХ суурь гэдэг нь шаардлага хангасан байгалийн хайрга, шороон материал, цемент болон усыг зохих харьцаагаар хольсон хольцыг хэлнэ. Хольцыг технологийн онцлог, ажлын хэмжээ зэргийг харгалзан холигчийн үйлдвэр эсвэл газар дээр нь холигч төхөөрөмж ашиглан холино.

902. МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА

(а) Цемент

Цементээр бэхжүүлсэн хөрсөн суурь үед ашиглах цемент нь ердийн болон портландцемент байх бөгөөд AASHTO M85-07, MNS 974:99, MNS EN 197-1:2018 болон бусад олон улсын стандартуудын шаардлагад нийцсэн байна. Цемент нь удаан бэхжилттэй 32.5МПа бат бэхтэй портландцемент байна. Талбайд татан авалт хийхийн өмнө физик-механик, химийн шинжилгээ нь туршилтаар нотлогдож баталгаажуулсан байх шаардлагатай. Инженерийн зөвшөөрсөн бусад маркийн цементийг ашиглаж болно. 200тн тутамд цементийн давтан шинжилгээ хийнэ.

Хүснэгт 9-1: Цементийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Х/н	Техникийн шаардлага
1	Хувийн гадаргуун талбай	м ² /кг	270-350
2	Цементийн барьцалдах эхний хугацаа	цаг	< 2
3	Эзлэхүүний өөрчлөлт	мм	< 10
4	Суурийн оксид (цементийн жингийн)	%	< 0.8
5	Цементийн ус ялгаруулалт	%	< 28
6	3 кальцид алюминат C ₃ A	%	< 7

Хүснэгт 9-2: Цементийн чулуунцарын үзүүлэлт

Чулуунцрын төрөл	Чулуунцрын агууламж, %	Тайлбар
C ₃ A	< 7	3 кальцит алюминатийг цементбетоны ажлын онцлогтой холбоотойгоор богино хугацаанд барьцалдалт болон бэхжилт явагдахаас сэргийлж 7% хязгаарласан

$C_3A + C_4AF$	< 24	3 кальцат алюминат болон 4 кальцит алюмоферритийн нийлбэрийг хязгаарлах нь зүйтэй. $4CaO \cdot Al_2O_3 \cdot Fe_2O_3$ нь чулуунцарын хэмжээ 5-15% байдаг. Энэхүү эрдэс нь цементийн бат бэхийн өсөлтөнд нөлөөлдөг.
C_3S	> 55	3 кальцит силикат буюу алит нь портланд цементийн бат бэхийн өсөлт болон бэхжих хурдыг тодорхойлдог чулуунцарын үндсэн материалын доод хязгаарыг тавьсан.

(б) Хайрган материал

ЦБХС-д ашиглах материал нь байгалийн элс-хайрганы хольц болон хөрс, шаардлагатай бол буталсан чулуу байх ба хүснэгтэд үзүүлсэн ширхэглэл, физик механик шинж чанарыг хангасан байна. Байгалийн материалыг суурь үед зөвхөн шигшиж хэрэглэнэ, шууд хэрэглэхийг хориглоно.

Хүснэгт 9-3: ЦБХ суурийн ширхэглэлийн бүрэлдэхүүний хязгаар

Шигшүүрээр өнгөрсөн хэсэг, %		
Шигшүүрийн хэмжээ, мм	Ширхэглэлийн төрөл ба техникийн шаардлага	
	Тасралтгүй ПА, ПВ*	Тасралттай ПА, ПВ*
63.0	100	-
53.0	95 - 100	100
37.5	85 - 95	80 - 100
19.0	60 - 90	55 - 90
9.50	30 - 65	30 - 65
4.75	20 - 45	-
2.36	10 - 30	20 - 50
0.425	5 - 15	10 - 20
0.075	2 - 8	3 - 15
Хамгийн том ширхэглэл, мм	37.5	31.5
Үеийн нэр	доод	дээд

***Тухайн орон нутгийн материалын шинж чанараас хамаарч туршилтын үр дүнгээр тогтоогдсон, хэрэв инженерийн зөвшөөрснөөр шаардлагатай тохиолдолд хольцын төрөл, ширхэглэлийн хязгаарыг тухайн материалд тохируулан өөрчилж болно.*

Хүснэгт 9-4: ЦБХ суурийн материалын үзүүлэлтүүд

№	Шинжилгээний төрөл	х/н	ЦБХС	
			доод үе	дээд үе
1	Цементийн агууламж	%	4-6	6-8
2	Чулууны элэгдэл	%	≤ 50	≤ 35
3	0,075 мм-ийн шигшүүрээр өнгөрсөн хэсгийн хувь	%	≤ 15	≤ 15

№	Шинжилгээний төрөл	х/н	ЦБХС	
			доод үе	дээд үе
4	Урсалтын хязгаар LL, (MNS ASTM D4318:2006)	%	≤ 25	≤ 30
5	Уян налархайн индекс PI, (MNS ASTM D4318:2006)	-	< 5	< 6
6	Хөрсний шугаман агшилтын хүчин зүйлийг тодорхойлох арга (ASTM D4943 – 08)	%	< 3	< 3
7	Хөрсний ачаа даацын үзүүлэлт	%	> 30	> 50
8	10% Нарийн ширхэглэлийн хамгийн бага тоог тодорхойлох MNS BS 812-111(2010)	%	> 110	> 110
9	Ус шингээлт (MNS 2998-2001)	%	< 2	< 2
10	Бутрагдалтын хувь	%	< 15	< 15
11	Хүйтэн тэсвэрлэлт	%	< 12	< 12
12	Хувийн жин, асгамал эзэлхүүн	г/см ³	≥ 2.4	≥ 2.4

*Ус шингээлт 2.0%-иас их байвал хүйтэнд тэсвэрлэх чанарын туршилтыг хийх шаардлагатай. Чулуун материалын шинж чанар MNS 0346:2000 стандартын шаардлага хангасан байх ба стандартад заасан шинжилгээг хийх.

(в) Ус

Цементээр бэхжүүлсэн хөрсөн суурийн бэхжилтэнд муугаар нөлөөлж болохуйц хүчил шүлт, тос, давс, органик болон бусад хорт бодис агуулаагүй, цэвэр ундны ус хэрэглэвэл зохино. Хольцыг зуурах, суурь үеийн арчилгаа хийх усны шүлтийн агууламж (рН) нь MNS AASHTO T26-ийн дагуу 4-12.5 хооронд хэлбэлзэнэ. Усны чанарыг “ЦБХ суурийн техникийн шаардлага” барилгын дүрмэнд заасан шаардлагаар тодорхойлно.

Хүснэгт 9-5: Усны шинж чанар, үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Техникийн шаардлага
1	Усны өнгөний ялгарал	°C	≤70
2	Усны шүлтийн агууламж	рН	4 - 12.5
3	Усны исэлдэлт	мг/л	< 15
4	Усан дахь уусдаг хог хаягдлын агууламж	%	< 4
5	Усны үнэр	балл	< 2

Лабораторийн туршилтад ашиглах усны дээж 5 литрээс багагүй байна. Усны дээж нь төвлөрсөн усны эх үүсвэрийг төлөөлөх ба улирлын болон байгаль цаг уурын өөрчлөлт, усны нөөц, материалын эх үүсвэр өөрчлөгдөх бүрд лабораторийн шинжилгээ хийх шаардлагатай.

(г) Хамгаалах бүрхэвч

Хамгаалалтын бүрхэвчинд хэрэглэх материал нь энэхүү техникийн шаардлагын 903-р бүлэгт заасан шаардлагыг хангасан байна.

(д) Элс

Шинээр дэвссэн ЦБХС-ийг арчлах зориулалтаар ашиглах элс нь аливаа химийн хортой бодис агуулаагүй байна.

(е) Холих харьцаа

Орцын нормыг бат бэхийн үзүүлэлтүүдийг хангахаар тогтоох ба ус ба цементийн орцыг лабораторид тогтооно. Өмнө дурдагдсан шаардлагууд холилт хийгдэх хэсгүүдэд ижил байна. Орцын нормын бат бэхийн үзүүлэлтүүдийг 7, 28 хоногийн UCS (unconfined compressive strength) туршилтаар лабораторид тогтооно.

ЦБХ суурийн (дээд үе) 28 хоногийн бат бэх нь М60-аас их, ЦБХ суурь (доод үе) М40-өөс их (талбайн нөхцөлд) маркийн бат бэхтэй байна. Цементийн агууламж суурийн дээд үе 6-8%, суурийн доод үе 4-6 %-ийн байвал зохино. Тухайн орон нутгийн материалын шинж чанараас хамаарч туршилтын үр дүнгээр тогтоогдсон, инженерийн зөвшөөрснөөр эцсийн хувь тодорхойлогдоно.

Хүснэгт 9-6: Шахалтын бат бэх болон гулзайлтын үеийн суналтын үзүүлэлтүүд (лабораторид)

ЦБХ суурийн бат бэхийн марк	Бат бэхийн хязгаар, МПа (кгс/см ²), багагүй	
	Гулзайлтын үеийн суналтын бат бэх, 28 хоног (R _{гул})	Шахалтын бат бэх, 28 хоног (R _{шах})
М 20	> 0.4	> 2.0
М 40	> 0.8	> 4.0
М 60	> 1.2	> 6.0
М 75	> 1.5	> 7.5

Тайлбар: *AASHTO T-180-д заасан цилиндрийн шоо

Хүснэгт 9-7: Суурийн орц шахалтын бат бэх (7хоног)

ЦБХ суурийн бат бэхийн марк	Бат бэхийн хязгаар, МПа (кгс/см ²), багагүй	
	Шахалтын бат бэх, 7 хоног (R _{шах})	Шахалтын бат бэх, 28 хоног (R _{шах})
М 20	> 1.2	> 2.0
М 40	> 2.4	> 4.0
М 60	> 4.0	> 6.0
М 75	> 5.25	> 7.5

ЦБХСуурийн үед ашиглах хөрс ба хайрган материал нь шороон болон хайрганы орд газар, чулуун ордоос тэслэлт хийхгүйгээр экскаватороор ухаж авсан ба ширхэглэл тохируулж холилт хийсэн материал байна.

Инженерийг зааварчилсан тохиолдолд гулзайлтын үеийн суналтын бат бэхийг шалгана

903. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

(1) Холигч төхөөрөмж (Үйлдвэр)

Чулуун материалыг бутлах, шигших, холихдоо эцсийн бүтээгдэхүүний чанарыг хангахуйц ажлын аргачлалын дагуу, сайн тохиргоотой, механик ажиллагаатай чулуу бутлуурын болон холигчийн үйлдвэрүүдийг ашиглан гүйцэтгэнэ. Барьж буй замын уртаас хамаарч бутлуурын үйлдвэрийн хүчин чадал 1 цагт 25-100 тонн-д хэлбэлзэх бөгөөд буталсан чулууг гол төлөв 4 фракцаар бутлан ангилах тоноглолоор хангагдсан байх.

Төрөл бүрийн хэмжээтэй, өөр өөр эх үүсвэрүүдээс авсан материалыг материал хураан нөөцөлдөг талбайд механик ажиллагаатай төхөөрөмжийг ашиглан Гүйцэтгэгчийн туршиж баталсан, Инженерийн хүлээн зөвшөөрсөн аргачлалын дагуу холино. Материал ялгарахаас сэргийлж буталсан чулууг хольж боловсруулах, тээвэрлэх явцад чийглэж байх ба өндрөөрөө 5м-ээс илүүгүй байхаар 25 см-ээс ихгүйгээр үелж, овоолго хийж хураана. Тодорхойлсон ширхэглэлийн хэмжээнд хүрэхийн тулд Гүйцэтгэгч зөвшөөрөгдсөн эх үүсвэрээс өөр материал авч холихоор бол дараах нөхцөлүүдийг хангана. Үүнд:

- Материал бэлдэх олборлох, холихтой холбоотой бүх зардлыг Гүйцэтгэгч хариуцна.
- Суурийн тогтвортой байдлыг хангах үүднээс /нягтралтыг сайжруулахаар/ уян налархайгүй, органик нэгдэл агуулаагүй элсийг хольцонд нэмж болно.
- Нэмэлт элсний хувь хэмжээг лабораторийн дүгнэлтийг үндэслэн Инженертэй зөвшилцөж тогтоох ба хольцын жингийн 15%-иас илүүгүй байна.

Дайрган материал, ус, цементийг үргэлжилсэн циклээр буюу багцлан хольж цагт 180 тн-оос багагүй хольц гаргах хүчин чадалтай холигчийн суурин үйлдвэр эсвэл бетон зуурмагийн үйлдвэрийг ашиглан холино. Хольц үйлдвэрлэхэд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Багцлан хольдог үйлдвэрт хуурай материалыг жингээр хэмжинэ.

Үргэлжилсэн циклээр холих төхөөрөмж нь бүх материалыг автоматаар жинлэх тохиргоотой байх тул туузан дамжуулагчаар урсаж байгаа чулуун материал болон шурган дамжуулгаар урсаж байгаа цементийн урсалтын хурдыг байнга хянаж байх шаардлагатай.

Цементийг үндсэн дамжлагаас хэмжигч жин рүү өгөх ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор цемент дамжуулагч цорго ашиглана. Цементийн цоргыг барихдаа цементийн туршилтын хугацааг хянаж болохоор барина.

Багцлан хольдог үйлдвэрт цементийг хэмжих жин нь дайрган материалыг хэмжих жингээс тусдаа байна. Хэрвээ цементийн бункер нь дайрганы бункерээс тусдаа байдаг ба дайргыг жинлэхээс өмнө цементийг жинлэдэг бол цемент дайрга хоёрыг нэг жин дээр жинлэж болно.

Цементийг дайргатай жигд холихын тулд дайрган материалтай холигч руу цементийг хийж холино.

Үргэлжилсэн циклтэй үйлдвэрт холих бол цемент, ус, хайргыг батлагдсан тоног төхөөрөмжөөр дамжуулах ба жинлэнэ. Үүний тулд дамжуулагч болон жин нь хоорондоо харилцан уялдсан

байж, нийт холих үйл ажиллагааны явцад цемент ба хайрганы зөв харьцааг барьж чадна. Үргэлжилсэн циклтэй үйлдвэрт холигчийн хүчин чадал хэтрэх болон хамгийн доод хэмжээг заасан дохиоллын системтэй байх шаардлагатай

Багцлан хольдог үйлдвэрийн нэг удаагийн багцын хэмжээ болон үргэлжилсэн циклтэй үйлдвэрийн дамжуулах нэгж хэмжээ нь хольцын жигд байдлыг хангах хэмжээнээс хэтэрч болохгүй. Холигч доторх материал хүрдэггүй буюу холигддоггүй хэсэг байвал дамжуулах хэмжээг тохируулж дутагдлыг арилгана.

Усыг жин буюу эзлэхүүнээр хэмжиж болно. Хольцод хийх усны хэмжээ болон хугацааг Инженер тодорхойлно. Цемент, ус ба дайрга нь жигд холигдох ёстой бөгөөд нэг багцыг холих хугацаа 30 секундээс бага байж болохгүй

(2) Талбайд холигч төхөөрөмж (холигч машин)

Дэвсэлтийг газар дээр нь холигч машин ашиглан хольсоны дараа автогрейдерээр нарийн тэгшилгээг хийнэ.

Аль ч аргаар хольж боловсруулсан суурийн нягтруулсан нэг үеийн зузаан 150мм-ээс багагүй, 225мм-ээс ихгүй байх шаардлагатай. Суурийн нягтарсан зузаан 225мм-ээс их байх тохиолдолд дэвсэлтийг 2 үеэр үелүүлэн хийнэ. Материалыг газар дээр нь холихдоо талбайд хайрган (хөрс) материалыг дэвссэний дараа цементийг жигд тарааж, аливаа чулуун материал болон цементийн ялгарал буюу бөөгнөрөл үүсэхээс сэргийлэх замаар барилгын ажлаа явуулна. Нягт ба чийг нь нийт зузааны хэмжээгээр жигд тархсан байна. Материалын суулт, үеийн нягтруулалт, нягт болон чийгийн хангамж, гадаргуун тэгш байдлыг тодорхойлох зорилгоор 200м-ээс багагүй урттай хэсэгт эхлээд туршилтын үе дэвсэнэ. Туршилтын үе батлагдсаны дараа үндсэн ажлыг эхэлнэ. Туршилтаар баталгаажуулсан, инженерийн хүлээн зөвшөөрсөн аргачлалын дагуу суурийн үндсэн ажлыг хийж гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч нь техникийн шаардлагад заасан ширхэглэлийн бүрэлдэхүүнийг хангахын тулд зөвшөөрөгдсөн эх үүсвэрээс өөр материал авч нэмэлтээр холих шаардлагатай бол дараах нөхцөлүүдийг хангана. Үүнд:

- Материал бэлдэх, олборлох, холихтой холбоотой бүх зардлыг Гүйцэтгэгч хариуцна.
- Суурийн тогтвортой байдлыг хангах үүднээс /нягтралтыг сайжруулах/ уян налархайгүй, органик нэгдэл агуулаагүй элс эсвэл буталсан чулууг хольцод нэмж болно.
- Нэмэх материалын хувь хэмжээг лабораторийн туршилтын дүгнэлт болон тогтоосон орцыг үндэслэн Инженертэй зөвшилцөж тогтоох ба нэмэх материалын хэмжээ нь хольцын жингийн 15%-иас илүүгүй байна.

Хэрэглэх материалын шинж чанарыг урьдчилсан байдлаар нарийвчлан судлахад үзүүлэлтүүд нь чанарын шаардлага хангасан нь тогтоогдсон байх шаардлагатай. Ус болон цементийг уян хоолойгоор холигч машинд дамжуулах, эсвэл газар дээр нь тараагч төхөөрөмжөөр урьдчилан тарааж бэлтгэсэн байна.

Усны машинтай холбогдсон холигч (рейсаклинг) машин 1 мөрөөр холилт хийн явмагц 6-10т жинтэй хөнгөн индүүний нэг мөрөөр явж нягтруулна. Холигч машин зэргэлдээх мөрөөр холилт хийн, индүүгээр нэг удаа явж нягтруулсны дараа автогрейдерээр нарийн тэгшилгээг эхэлнэ.

Холих үйл ажиллагааны нэг оролтын өргөн холигч машины (ресайклинг) ажлын өргөнөөр тодорхойлогдох бөгөөд дагуу залгаас гаргахгүйн тулд нэг удаагийн оролтын урт 100-120 метрээс ихгүй байна. Эхний явалтын дараа хажуугийн эгнээний эхний байрлалд буцан ирж холилтыг үргэлжлүүлнэ. Энэ үйл ажиллагаа замын суурийн нийт өргөнд хийгдэнэ. Холигч машины роторын эргэлтийн хурд 180 эрг/мин, хөдлөх ажлын хурд 5-12 м/мин байна.

Мөн цементийг дараахь 2 аргаар тарааж болно. Үүнд:

- Хуурай аргаар тараах
- Цементийг усанд ууссан хэлбэрээр тараах арга

Хуурай аргаар тараах: Цементийг зориулалтын тараагч машинаар тараах бол тохируулсан хурд болон орцын дагуу тараана. Цементийг салхигүй болон бороогүй нөхцөлд тараах ёстой. Тарааж буй цементийн зузаан 25 мм-ээс бага байх бөгөөд түүний зузаан нэгэн жигд байхад сайтар анхаарах хэрэгтэй. Цементийг хуурай аргаар тараах тохиолдолд зориулалтын цемент тараагч машин нь холигч машины урд байрлана.

Цементийг усанд уусгаж хэрэглэх: Энэ аргыг цементийн ямар ч агууламжтай тохиолдолд хэрэглэж болно. Цементийн уусмал дахь цемент болон усны харьцаа 1:1 байвал зохино. Энэ аргын давуу тал нь байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр цементийн зүй бус хаягдал гарахаас сэргийлж, орцын нормыг чанд мөрдөх боломжийг олгодог.

Цементийг усанд уусгаж хэрэглэх тохиолдолд холигч машины урд цементийн уусмалыг тээвэрлэж буй машин байрлах бөгөөд холигч машинтай уян хоолойгоор холбогдсон байна. Холигч машин нь ус болон цементийн уусмалыг хэмжих автомат тохируулагчтай байна.

Цементээр бэхжүүлсэн хөрсөн суурь дэвсэх технологи аргачлалыг схемчилвэл:

Дүүргэгч материалыг автосамовалаар зөөж буулгана → Нэмэлт материал хийх бол талбайд буулгана → Автогрейдерээр нарийн тэгшилгээ хийнэ → Цементийг тараагч машинаар жигд тараана → Холигч машинаар эхний боловсруулалтыг хийнэ → Гадаргууг усална → Индүүдэж нягтруулна → Арчилгааг хийнэ.

Усыг автоцистернд тээвэрлэх ба ихэвчлэн холигч машин урд байрлана. Холилтын давтамжийн тоо нь холигчийн төрөл болон материалын онцлог шинж, чийгийн агууламж, холигчийн хурдаас хамаарна.

Усыг жин буюу эзэлхүүнээр хэмжиж болно. Хольцонд хийх усны хэмжээ болон хугацааг Инженер тодорхойлно. Цемент, ус ба хайрга нь жигд холигдох ёстой бөгөөд нэг багцыг холих хугацаа 30 секундээс бага байж болохгүй.

(3) Тээвэрлэх төхөөрөмж

Хольцыг тээвэрлэж буй өөрөө буулгагч машинуудын тэвшийг Инженерийн зааварчилсны дагуу сайтар хучсан байх ёстой. Хольцыг 20 км дотор тээвэрлэнэ.

(4) Автогрейдэр

Автогрейдерүүд нь сийрүүлэх төхөөрөмжөөр тоноглогдсон, нэг явалтаар замыг нийт өргөнд нь хэлбэржүүлэхэд хангалттай урт хутга, дугуйны суурь, нийт жинтэй байх ёстой. Автогрейдерүүд нь хутга болон хэвгий тохируулдаг автомат удирдлагатай байх ёстой.

Газар дээр нь холих аргаар боловсруулалт хийж хольцыг тарааж тэгшлэхдээ автомат мэдрэгч бүхий автогрейдерийг ашиглана.

Суурийн нарийн тэгшилгээг автогрейдерээр гүйцэтгэхдээ дараах ажилбаруудыг хийнэ. Үүнд :

- i) Суурийг автогрейдерийн тусламжтайгаар жигдхэн тэгшилнэ.
- ii) Замын хүндрэлтэй хэсэгт болон налууд тэгшилгээ хийхээс өмнө мэдэгдэхүйц үзэгдэх хотгор гүдгэрийг хольцын материалаар дүүргэж буюу хусаж тэгшилнэ.

iii) 3 метрийн рейкээр хучилтын гадаргуугийн тэгш байдлыг шалгана.

iv) Засварлах газрын хонхор хэсэгт жигд дүүргэлт хийж, хавтгай, тэгш болгох бөгөөд үүний дараа доргиурт индүүгээр индүүднэ.

(5) Суурь дэвсэгч - Грейдэр болон дэвсэгчийг хослуулан ажиллуулж болно.

1. ЦБХС-ийг талбайд холигч машин (ресайклер) ашиглан дэвсэж болно. Энэ төрлийн сууринд ашиглах төхөөрөмж нь материалыг зохих гүнд холих хүчин чадалтай, ажиллагаа хэвийн байх ба ухах гүний хэмжээ нь наад зах нь 20 мм-ээс багагүй байна.

Холигч төхөөрөмж нь жигд хөдөлгөөнийг хадгалж, хурд нь 5-12 м/мин хооронд хэлбэлзэнэ. Хольцыг нэгэн жигд, тэгш дэвсэх зорилгоор тэгшлэгч хавтантай байна. Мөн хөрсийг ухах, зорж авах шүднүүд нь элэгдээгүй, жигд өндөртэй байна.

2. Мөн суурь үеийг нэг зурвасын өргөнөөс багагүй өргөнтэй дэвсэх хүчин чадалтай, илүү өргөнөөр дэвсэх нэмэлт төхөөрөмж залгах боломжтой дэвсэгчээр дэвсэнэ. Дэвсэгч нь дараах тоноглолоор тоноглогдсон байна. Үүнд:

- Ачигч бункер ба тараах механизмтай байх;
- Хольцыг жигд үеэр тэгш дэвсэх зорилгоор доргиулагч бүхий тэгшлэгч хавтантай байх;
- Дэвсэгч нь хэвгий болон налуу мэдрэгчтэй байх;
- Дэвсэгч нь гадаргуугийн аливаа доголдуудыг шалгах хяналтын механизмаар тоноглогдсон байх ёстой.

(6) Нягтруулах тоног төхөөрөмж

Төмөр бултай буюу хийн дугуйт индүүгээр нягтруулна. Доргиурт индүүний жин 9 – 12т-оос багагүй байна. Бичил хагарал үүсэх үе шатанд 12тн жинтэй ган дугуйт индүү шаардлагатай. Хийн дугуйт индүү нь 20 –30тн жинтэй, дугуйны даралт 0.7 МПа байна.

Холигч машины араас нарийн тэгшилгээний ажлыг автогрейдерээр гүйцэтгэж, дууссан даруй нь нягтруулалтын ажлыг эхлүүлнэ. Нягтруулалтыг ихэвчлэн ган булт доргиурт болон энгийн горимоор ажилладаг индүү явж эхний, урьдчилсан нягтруулалтыг хийнэ. Суурийг бүрэн нягтруулахын тулд өөр олон төрлийн нягтруулах тоног төхөөрөмжийг сонгон ашиглах боломжтой юм. Нягтруулах төхөөрөмжөөр суурийн ирмэгийг гэмтээх эсвэл замын хөдөлгөөн болон цаг агаарын байдлаас болж гэмтэхээс болгоомжлох хэрэгтэй.

(7) Арчлах

• *Усаар арчлах:* Даралт хуваарилагчийг машинд суурилуулсан байх ба замын гадаргууд шууд нөлөө үзүүлэлгүйгээр усан манан үүсгэж гадаргууг арчилна.

• *Хамгаалалтын битумэн хальсаар арчлах* тохиолдолд Инженерийн зөвшөөрсөн техникийн үзүүлэлт бүхий өөрөө явагч битум цацагч ашиглана.

• *Нийлэг гялгар цаас бүхий тааран материал* ашиглаж болно. Нийлэг хальсан бүрхүүл нь цагаан, гэрэл нэвтрүүлдэггүй хальс бүхий 0.10 мм-ээс багагүй зузаантай байх ба тааран материалын нэг тал дээр бэхлэгдсэн ус тогтоох чадвар бүхий материал байна.

Ус нэвтрүүлдэггүй нийлэг гялгар цаасыг Инженерийн зөвшөөрөлтэйгөөр ашиглана. Нарийн шүршүүрээр шүршиж, чийглэсэн гадаргууг ус нэвтрүүлдэггүй гялгар цаасан хучлага эсвэл нийлэг бүрхүүлтэй тааран материалаар хучна. Бэхжүүлсэн суурийн гадаргууг хучихын өмнө гадаргууг сайтар норгоно. Ус нэвтрүүлдэггүй нийлэг гялгар цаасан хучлага эсвэл нийлэг

бүрхүүлтэй тааран материалын цайвар өнгөтэй талыг дээш харуулан хучна. Хучлагыг сунгах байдлаар суурийн гадаргуун ирмэгийг давуулан бүрхэх ба арчилгааны явцад хучлагыг сайтар хамгаална. Хучлагуудын хажуугийн зах өөр хоорондоо дор хаяж 300 мм-ээр давхцаж хучигдах ёстой ба давхацсан хучлагын хэсгийг цемент эсвэл скотчоор нааж бэхжүүлж хамгаална. Хучлагын цоорсон хэсгийг тэр даруй нөхөж засна

(8) Хатуулаг шалгах багаж

ЦБХС-ийг барьж дууссаны дараа тусгай багаж ашиглан үеийн хатуулгийг шалгана. Humboldt Stiffness Gauge (HSG) гэсэн багаж байдаг. Энэхүү багаж нь ЦБХС үед гажилт өгөхийн тулд хэр зэрэг хүч шаардагдахыг заадаг.

904. БАРИЛГЫН АЖИЛ

(1) Ерөнхий

ЦБХС-ийг дэвсэхдээ цементийн хольц жигд тарж, аливаа ялгарал буюу бөөгнөрөл үүсэхээс сэргийлэх замаар барилгын ажлаа явуулна. Үеүдийн нягт ба чийг нь нийт зузааны хэмжээгээр жигд тархсан байна. Үеийн нягтруулалт, нягт болон чийгийн хангамж, гадаргуун өнгөлгөөг турших зорилгоор 200м урт хэсэгт туршилтын үеийг дэвсэнэ. Туршилтын үе батлагдсаны дараа үндсэн ажлаа эхэлнэ.

(2) Гадаргууг бэлтгэх

Суурийн доод үе: ЦБХС-ийг дэвсэхээс өмнө далангийн дээд хэсгийн гадаргууг сайтар нягтруулж, талбайн нягтыг шалгахад ХҮХИНягт 98-аас доошгүй хувийг хангасан байх ёстой. Гадаргуугийн тэгш байдал дагуу болон хөндлөн чиглэлд 3м-ийн рейкийн доогуурх хөндий зай 8 мм-ээс хэтрэх ёсгүй. ЦБХС-ийг дэвсэхээс өмнө гадаргууг чийгтэй (нойтон бус) байлгана.

Суурийн үе: ЦБХС дэвсэх доод үеийн гадаргууг хог хаягдал, илүүдэл материалаас сайтар цэвэрлэж суурь үе авахаас өмнө чийглэж өгнө.

Талбайн төвшинг хянах зорилгоор гадаслагаа хийнэ. Гадаслагааг замын захын цэгүүдийн дагуу параллель байдлаар байрлуулах ба утас татах эсвэл бусад хяналтын аргуудаас сонгож хэрэглэнэ. Хэрэв суурь огцом эргэлттэй хэсэгт дэвсэгдэх бол тэрхүү уулзварт хангалттай урт бүхий шилжилтийн хэсгийг байгуулах ба суурийн гадаргууд тухайн замын ангиллын шаардлагыг зөрчихөөр гэнэтийн эсвэл мэдэгдэхүйц өөрчлөлт оруулахаас сэргийлнэ.

(3) Цаг агаарын нөхцөл

1. Агаарын температур: агаарын температур буурч 5°C хүрсэн бол ЦБХС-ийн ажлыг эхлүүлж болохгүй бөгөөд өсч буй агаарын температур 5°C хүртэл бол ЦБХС-ийн ажлыг эхлүүлж болохгүй.
2. *Цас/бороо:* Бороо буюу цас орж байгаа тохиолдолд ЦБХС-ийн ажлыг гүйцэтгэж болохгүй. Нэгэнт тавьсан ЦБХС-ийн үе дээр бороо, эсвэл цас орвол гадаргуу хангалттай бэхжсэн тохиолдолд гадаргууг хур тунадасаас хамгаалах арга хэмжээ авна.

(4) Хугацаа

Хайрган материал буюу хөрсийг цементтэй хольсноос хойш 45 минутын дотор хольцыг урьдчилан бэлтгэсэн гадаргуу дээр дэвсэх ёстой. Үүнээс гадна холигч руу ус хийснээс хойш 2 цагийн дотор хольцыг дэвсэх, тэгшлэх, нягтруулах бүхий л ажиллагаа дууссан байх ёстой. Нэг зурваст хольцыг дэвссэний дараа 30 минутын дотор зэрэгцээ зурваст хольцыг дэвсэх шаардлагатай.

(5) Дэвсэлт ба нягтруулалт

1. Цементээр бэхжүүлсэн хөрсөн суурийн хольцыг дэвсэхээс өмнөхөн даланг чийглэсэн байх ёстой бөгөөд чийгийг хольц дэвсэх хүртэл хадгална. Шаардлагатай чийгээс их ус нэмж, суурийн материалыг хэт зөөлрүүлэхээс болгоомжлох хэрэгтэй. Ус илүүдэж, тогтоол үүсгэхийг хатуу хориглоно. Хольцыг дэвсэгч эсвэл ямар нэг төрлийн тараагч төхөөрөмжөөр тараах ба суурийн нягтруулалт дууссаны дараа түүний хөндлөн огтлолын хэлбэр, хэвгий болон төвшин нь ажлын зурагтай нийцэж байх ёстой. Цементийн агууламж нь орцоор батлагдсаны дагуу байвал зохино.

Хольцыг зэрэгцээ байдлаар дэвсэх тохиолдолд дэвсэх өргөнөөс хамааруулан 2 ба түүнээс дээш дэвсэгчийг ашиглана. Нэг дэвсэгч 2 эгнээгээр явж тараах үед барилгын заадас үүсгэхээргүй хугацаанд тохируулан дэвсэх оролтын уртыг тодорхойлно. Хоёр зэрэгцээ эгнээгээр тараах хоорондын хугацаа 30 минутаас бага байвал заадас хийхгүй. Эсрэг тохиолдолд барилгын заадас хийх шаардлагатай. Хольцыг дэвсэж дууссаны дараа, нэмэлт эгнээг дэвсэх шаардлагатай болсон тохиолдолд дэвссэн суурийн дагуу чиглэлд зэрэгцээ байдлаар суурийн захыг зүсэж авна. Суурийн хольцыг тараахдаа хэт их хуурайших эсвэл чийг алдалт явагдахаас сэргийлн

2. Нягтруулсан ЦБХС-ийн хуурай үеийн нягт AASHTO T-180 стандартын дагуу хамгийн их хуурай нягт 99%-аас багагүй. Нягтруулалтын үеийн чийгийн агууламж зохист чийгийн агууламжаас $\pm 2\%$ -ийн хэлбэлзэлтэй байж болно

Тэгшилгээ болон нягтруулалтыг тогтмол хэмжиж, ажлын зурагт заасан төвшинд хүргэх ба нягтруулсны дараа нягтыг талбайн туршилтаар баталгаажуулахдаа үеийн зузааныг дахин нягтлан тодорхойлно. Нягтарсан нэг үеийн зузаан нь зурагт зааснаас багагүй байна.

Суурийн нягтарсан үеийн зузаан 225мм-ээс их байх үед дэвсэлтийг 2 үеэр хийнэ. Суурийн хольцыг дэвссэний дараа тэр даруй нягтруулах шаардлагатай бөгөөд нягтруулж дууссан суурь нь шаардлагатай төвшин, хөндлөн огтлолын хэлбэр болон жигд зузаантай байна. Суурийг төлөвлөсөн хугацаанд шаардлагатай нягттай болтол нь нэгэн жигд нягтруулсан байх ёстой. Нягтруулах төхөөрөмжөөр суурийн ирмэгийг гэмтээх эсвэл замын хөдөлгөөн болон цаг агаарын байдлаас шалтгаалж гэмтээхээс болгоомжлох хэрэгтэй. Нягтруулж дууссан гадаргуу нь нэгэн жигд ба бүрэн гүйцэд нягтруулагдсан байх шаардлагатай.

Суурийн гадаргууд үүсэх сул чулууг цаг тухайд нь зайлуулна. Нягтруулах үеийн чийгийн агууламж зохист чийгийн агууламжаас $\pm 2\%$ -ийн хэлбэлзэлтэй байж болно. Индүүгээр нягтруулахад тохиромжгүй тохиолдолд гар индүүгээр нягтруулна. Өндөрдсөн цэгүүдийг сууринд аль болох гэмтэл бага учруулах байдлаар автогрейдер болон өөр ижил төстэй төхөөрөмжийн тусламжтайгаар хусна. Инженерийн зааварчилсны дагуу илүүдэл материалыг хөвөө эсвэл зэргэлдээ талын далан руу шилжүүлнэ. Суурийн гадаргуу дээр аливаа сул материалыг үлдээхгүй байх ёстой. Төлөвлөсөн төвшинд хүргэхийн тулд нягтарсан суурь дээр нэмж хольц дэвсэхийг хориглоно. Нягтруулалт хийсний дараа төвшин намдсан нь тодорхой болсон тохиолдолд заавал дахин сэндийлсний дараа материал нэмнэ

Индүүдэх явцад засварлаж байгаа гадаргуу нь үргэлж чийглэг байх хэрэгтэй. Хэрэв хэтэрхий их ууршилттай байвал чийгийн уурших хугацааг тооцох шаардлагатай. Индүүдэх явцад гадаргууд хуйлрал, том ширхэглэлт материалын ялгарал, сулралт, ховхролт болон бусад гэмтлийн үзэгдлүүд үүсвэл талбайд дахин холилт хийнэ. Дахин холилтыг 10 м-ээс багагүй урттай газарт хийнэ. Дахин холилт хийсэн урт биш хольцын гадаргууг малтуур, гаануу мэтийн зохих гар багажийн тусламжтайгаар гараар тэгшилж болно. Нягтруулалтыг дуусгахын өмнө дахин нэг удаа сүүлийн тэгшилгээг хийнэ. Баригдаж буй суурийн үеийн зузаан, өндөр зэрэг

үзүүлэлтүүд нь ажлын зурагт заасан шаардлагыг хангаж байх шаардлагатай

(6) Технологийн үйлдэл хийх урт ба засвар

Хольцыг талбайд хамгийн багадаа 20-30м урт хэсэгт дэвссэний дараа нягтруулалтыг эхлүүлэх бөгөөд технологийн нэг үйлдлийн урт 100-300 метрээс багагүй байна.

Нэг удаагийн технологийн үйлдлийн уртын хэмжээг оролтын урт гэж нэрлэж болно.

Ажлын хэсэг буюу оролтын урт. Хэт богино оролт нь дагуудаа олон залгаас гаргах бөгөөд, улмаар залгаас бүрд зузааны хэмжээ өөрчлөгдөх магадлал их байна. Харин хэтэрхий урт оролт хийвэл дараагийн зэрэгцээ 2 дахь явалтын үед хольсон материалын чийг алдагдах, улмаар зэрэгцээ зурвасын нягтруулалт харилцан адилгүй болох магадлалтай. Нягтруулалтыг хамгийн багадаа 20-30м урт хэсэгт хольцыг дэвссэний дараа эхлүүлнэ.

Өндөрдсөн цэгүүдийг сууринд аль болох гэмтэл бага учруулах байдлаар автогрейдер болон өөр ижил төстэй төхөөрөмжийн тусламжтайгаар хусаж авна. Инженерийн зааварчилсны дагуу илүүдэл материалыг хөвөө эсвэл зэргэлдээ талын далан руу шилжүүлнэ. Суурийн гадаргуу дээр аливаа сул материалыг үлдээхгүй байх ёстой. Суурийн төлөвлөсөн төвшинд хүргэхийн тулд нягтарсан суурь дээр нэмж хольц дэвсэхийг хориглоно. Нягтруулсны дараа төвшин намссан нь тодорхой болсон тохиолдолд заавал дахин сэндийлсний дараа материал нэмж засварлана. Хамгийн сүүлд гадаргуугаас суларсан материалыг зайлуулж, шаардлагатай бол гадаргууг бага зэрэг чийглэн хийн дугуйт индүүгээр индүүднэ.

(7) Барилгын заадас

Дагуу: Дэвсээд 30 минутаас илүү хугацаа өнгөрсөн нягтруулсан зурвастай залгуулан зэрэгцээ зурваст дараагийн хольцыг дэвсэх тохиолдолд нягтруулсан үеийн ирмэгийг нийт зузаанаар зүсч босоо гадаргуу үүсгэнэ. Зүсэлтийг тухайн өдрийн ажил дуусахаас өмнө хийнэ.

Хөндлөн: Хэрэв дэвсэх ажиллагаа түр зогсож, дараагийн өдөр үргэлжлэхээр бол тухайн өдөр дэвсэж буй хольцын зузааныг аажмаар нимгэрүүлж (тэнхлэгийн дагуу бм-ийн зайнд) хольцын зузааны талд хүргэнэ. Дараагийн өдөр ажил эхлэхдээ нимгэн хэсэг дээр шинэ хольц дэвсэж шаардлагатай зузаан хүртэл дүүргэнэ.

Суурийн гадаргуу дээр асфальтбетон хучлага дэвсэх үед хучлага болон суурийн заадсуудыг давхцуулж болохгүй. Заадас хоорондох зай 30 см-ээс багагүй байна.

(8) Гадаргууг тэгшилж, засах, эцсийн нягтруулалт хийх

Гадаргууд шаардлагатай налуу болон хэвгий гаргахын тулд дагуу налуу болон хөндлөн хэвгийг хянах хяналтын системтэй, автомат удирдлагатай зүсэх төхөөрөмж бүхий дэвсэгч ашиглана. Дэвсэгчийн араас доргиурт болон энгийн горимоор ажилладаг индүү явж эхний урьдчилсан нягтруулалтыг хийнэ.

1. Хучилтын гадаргууг шалгах

Эхний нягтруулалт хийгдсэний дараа 3м урт рейк ашиглан хучилтын гадаргуугийн дагуу налуу болон хөндлөн хэвгий гарсан эсэхийг шалгана.

2. Гадаргууг дуусгах, эцсийн нягтруулалт

Хийн дугуйтай индүүгээр индүүдэх ба шаардлагатай тохиолдолд индүүдэх явцад бага зэрэг чийглэн индүүдэж сул материалыг зайлуулсны дараа заслын индүүдлэг хийнэ.

Хамгийн сүүлд гадаргуугаас суларсан материалыг зайлуулж, шаардлагатай бол гадаргууг бага зэрэг чийглэн хийн дугуйт индүүгээр индүүднэ. Хийн дугуйтай индүүгээр индүүдэх ба шаардлагатай тохиолдолд индүүдэх явцад бага зэрэг чийглэн индүүдэж сул материалыг

зайлуулсны дараа заслын индүүдлэг хийнэ. Эхний нягтруулалт дууссаны дараа гадаргуугийн дагуу болон хөндлөн хэвгийг хэмжилтийн багаж эсвэл 3 м-ийн рейк ашиглан хэмжилт хийнэ. Рейкийг замын аль ч хэсэгт тавьсан рэйк болон гадаргуугийн хоорондын бүлэг 300-д зааснаас хэтрэх ёсгүй.

(9) Эхний арчлалт

Гадаргуугийн заслын ажлыг хийж байх явцад чийгийн хэмжээ орцын нормд заасан чийгийн агууламжаас багагүй байхаар гадаргууг нарийн ширхэгтэй шүршүүрээр эсвэл усан манангаар чийглэж өгнө. Гадаргууг хэзээ ч өндөр даралттай усаар шүршиж болохгүй. Эхний арчлалтыг нягтруулалт хийж дууссанаас хойш 24 цагийн туршид тогтмол хийнэ.

(10) Бичил хагарлууд

Гадаргууг 24 цагийн турш чийгтэй байлгаж, арчлалт хийсний дараа ЦБХС-ийн хатуулгийг тусгай багаж (тухайлбал, Humboldt Stiffness Gauge (HSG) буюу түүнтэй адил багаж) ашиглан шалгана. Хэрэв багажны заалт 50–60 мН/м буюу кН/мм хооронд байвал бичил хагарлын нягтруулалтыг эхлэх шаардлагатай. Хэрэв багажны заалт үүнээс бага бол усаар чийглэх арчлалтыг дахиад 24 цаг үргэлжлүүлэн гадаргуун хатуулаг нь 50 – 60 мН/м хүртэл хийнэ. Хатуулгийн туршилтыг замын тэнхлэгийн дагуу 30-50м тутамд хийх бөгөөд дараа нь бичил хагарлын нягтруулалт хийх зорилгоор туршилт хийсэн газруудад тэмдэг тавина.

Дууссан ЦБХС-ийн бичил хагарлын нягтруулалтыг хийхдээ доргиурыг хамгийн дээд хүчин чадал хүртэл ажиллуулсан 12 тонны доргиурт индүүгээр цагт 3 км-ийн хурдтайгаар индүүдэн хийж болно. Инжене зөвшөөрвөл бичил хагарал хийх бусад аргуудаас сонгож болох бөгөөд аргачлал батлагдсан байх шаардлагатай. Нягтруулалтыг замын ирмэгийн 0.3м-ийг эс тооцвол замын нийт өргөнөөр гүйцэтгэнэ. Дээрхи аргыг ашигласан тохиолдолд тэмдэг тавьсан хэсгүүдэд индүүний 1-2 явалтын дараа хатуулгийн хэмжээ өмнөх хэмжилтээс 40%-иар буусан тохиолдолд бичил хагарлын нягтруулалтыг дууссан гэж үзнэ. Индүүний явалт бүрийн дараа хатуулгийг хэмжих ба хатуулгийн хэмжээ өмнөхөөс 40%-иар буурмагц индүүдлэгийг зогсооно. Ийнхүү хатуулгийн хэмжээг 40%-иар бууруулахын тулд индүүний хэдэн явалт шаардагдахыг тогтооно. Инженерийн зөвшөөрлөөр батлагдсан аргачлалын дагуу бичил хагарал үүсгэх бусад аргуудаас сонгон хэрэглэх боломжтой.

(11) Эцсийн арчлалт

Бичил хагарлын нягтруулалтыг хийж дууссаны дараа тухайн хэсгийг 48 цагийн хугацаанд чийг өгч арчлалт хийнэ. Үүний дараа асфальт дэвсэхээс өмнө хийдэг битумэн цацлагын нэгэн адил МС-30 битумээр цацлага хийж хамгаалалтын хальс үүсгэнэ. Битумыг 0.8-1.2 кг/м² -аар бодож цацна. Хэрэв битумэн цацлага хийсний дараа томоохон хагарал үүсвэл зохих маркийн битумэн материалаар хагарлыг бөглөнө. Битумэн цацлага хийсний дараа 3 хоногийн турш битумэн хальсыг чийг өгч арчилна.

(12) Хөдөлгөөний хязгаарлалт

ЦБХС дэвссэнээс хойш 7 хоногийн дотор буюу арчлалт дуусахаас нааш аливаа тээврийн хөдөлгөөн явуулахыг хориглоно.

Арчилгааны явцад гэмтэл учруулахгүйгээр нягтруулж дууссан суурийн зарим хэсэгт суурийн нягтруулалт дууссанаас хойших 48 цагийн дараа хөнгөн тэрэг хөдөлгөөнд орж болох ба тоног төхөөрөмж эсвэл замын хөдөлгөөний улмаас гэмтэл үүсэхээс сэргийлж, арчилгаа хийгдэж

дуусаж, хангалттай хатуулаг чанартай болсны дараа бусад тээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөнд оруулна. Суурийг дэвссэнээс хойш 7 хоногийн дотор аливаа хүнд даацын тоног төхөөрөмжийг замын хөдөлгөөнд оролцуулж болохгүй бөгөөд хучлагын ажлыг эхлүүлж болно. Инженерийн зөвшөөрөлтэйгөөр суурийн дээгүүр цемент болон усыг тээвэрлэж болно. Ажлын заадастай залгаж шинэ суурь барих явцад хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн хөдөлгөөнөөс шалтгаалж гүйцэтгэж дууссан суурийн гадаргууд гэмтэл үүсэхээс урьдчилан сэргийлнэ.

(13) Хөвөө

ЦБХС-ийг дэвсэж нягтруулалт ба хамгаалалтын хальс үүсгэж арчлалт хийсний дараа нэн даруй хөвөөний ажил эхэлнэ. ЦБХ суурь дээр хөвөөний материал тарсан тохиолдолд Инженерийн зааварчилсан аргаар суурийн гадаргууг гэмтээлгүйгээр цэвэрлэнэ. ЦБХ суурийн арчлалтыг хөдөлгөөний хязгаарлалтын хамт 7 хоног хийсний дараагийн ажлыг эхлүүлж болно.

905. ЧАНАРЫН ХЯНАЛТ

(a) Шахалтын бат бэх

Хольц наалдахаас сэргийлж индүүнүүд дүүрэн ус бүхий усны зориулалтын савтай байх бөгөөд булыг усаар бага зэрэг норгох тохиргоотой байна. Харин полимер битум хэрэглэж буй тохиолдолд усанд савангийн уусмалыг Инженерийн зөвшөөрсөн хэмжээгээр хийж болно. Ямар ч нөхцөлд дизель түлш, бензин хэрэглэхийг хориглоно. Индүү ажиллах боломжгүй хэт бага талбайд доргилтот нягтруулагч ашиглаж болно.

1028 ӨНГӨЛГӨӨ, ИРМЭГ БА ЗААДАС

Аливаа хольц хагарах, хог шороотой холилдож суларч гарах тохиолдолд түүнийг ухан авч шинэ халуун хольцоор дүүргэн эргэн тойрны гадаргуутай ижил хэмжээнд нягтруулна.

Өмнө нь хийгдсэн хучилттай залгаж дараагийн хэсгийг дэвсэхдээ урьд дэвссэн үеийг нийт өргөн ба гүнд нь шулуун шугамаар зүсэгч машин ашиглан хөндлөн зүснэ. Гар багаж (лоом, сүх г.м) ашиглаж болохгүй. Зүсэлт хийсэн босоо нүүрийг хийн халаагуураар халааж 130/200 маркийн халуун битум түрхэх ба үүний дараа нэн даруй шинэ хольцоо залгаж дэвсэнэ. Дэвсэлтийг эхлэхдээ дэвсэгчийн өнгөлөх хавтан нь зүсэлтийн шугамнаас хойш 20-30см илүү гарсан байхаар дэвсэгчийг байрлуулна.

Дэвсэгчийг явуулж эхлэхээс өмнө шнекээр татагдаж ирсэн халуун хольцыг залгаасны хэсгийн хуучин хучилт дээр 5-10 минут орчим байлгаад үүний дараа дэвсэгчийг ажиллуулна. Залгаасны хэсэгт дэвсэгч явж өнгөрмөгц овон товон дэвсэгдсэн хольцыг малтуураар жигд хусч аваад залгаасан дээрээ нарийн ширхэглэлтэй хольц цацаж гараа маш нямбай тэгшлэнэ. Тэгшилгээ сайн болсон гэж үзвэл индүүдлэгийг шууд эхлэнэ.

Залгаасны өнгөлгөөг гадаргууд тавигдах шаардлагын дагуу хучилтын бусад хэсэг дэх нягтрал, бүтэц, өнгөлгөө зэрэгтэй ижил байхаар хийж гүйцэтгэнэ.

Хэрэв дэвсэлтийн явцад гадаргууд чулууны ялгарал үүсч барзгар болсон бол халуун хольцноос авч нарийн нүхтэй шүүрээр тухайн хэсэг дээр шигшээд дараа нь модон малтуураар хөнгөн гүйлгэж сайтар тэгшлээд индүүднэ.

1029. АСФАЛЬТОБЕТОНООС ДЭЭЖ АВАХ БА ШИНЖЛЭХ

Гүйцэтгэгч нь MNS AASHTO T168:2003 (Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн асфальтобетон хольцоос дээж авах) стандарт, бүлэг 209(Д)-д заасан давтамжаар дээж авч, туршилтыг явуулна.

1030. ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ШИНЖИЛГЭЭНҮҮД

Битумэн хольцыг холих ба дэвсэх үед Гүйцэтгэгч түүний Төслийн чанарын хяналтын төлөвлөгөө болон Техникийн шаардлагын Хэсэг 200, Зүйл 1229-ын дагуу хольц болон түүний бүрэлдэхүүн материалуудаас дээж авч шинжилж байх ёстой. Хэрвээ шинжилгээний үр дүн материалын шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд Гүйцэтгэгч материал болон ажлын журамд оруулах шаардлагатай өөрчлөлтийг хийхээс өмнө Инженерийн зөвшөөрлийг авсан байх ёстой.

Хэрвээ хольц болон материалын 10 амжилттай шинжилгээ тутамд хоёроос дээш тооны шинжилгээний хариу нь Шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд Гүйцэтгэгч шалтгааныг нь олж тогтоож залруултал хольц дэвсэхийг даруй зогсооно. Гүйцэтгэгч шаардлага хангахгүй байгаа бүх материалыг өөрийн зардлаар буцаан авч шаардлага хангах материалаар хучилтын нийт өргөнөөр солино.

1031. ХҮЛЦЭХ АЛДАА

Гүйцэтгэгч хучилтыг Техникийн шаардлагын 300-р бүлэгт заасан геометр хүлцэх алдааны хүрээнд барина. Гүйцэтгэгч хольцын найрлагыг жишиг орцын норм болон талбайн туршилтуудаар тодорхойлсоны дагуу Хүснэгт 10-5-д үзүүлсэн хүлцэх алдааны хүрээнд байлгана.

Хүснэгт 10-5: Асфальтобетон хольцны хүлцэх алдаа

Бүрэлдэхүүн хэсэг	Хүлцэх алдаа
Битумын агуулга	Хольцны нийт жингийн $\pm 0.3\%$
4.75 мм ба түүнээс том шигшүүрээр өнгөрөх хувь	Эрдэс нунтгийг оролцуулан хуурай чулуулаг материалын нийт жингийн $\pm 6\%$
2.36 - 0.15 мм-ийн шигшүүрээр өнгөрөх хувь	Эрдэс нунтгийг оролцуулан хуурай чулуулаг материалын нийт жингийн $\pm 4\%$
0,075 мм-ийн шигшүүрээр өнгөрөх хувь	Эрдэс нунтгийг оролцуулан хуурай чулуулаг материалын нийт жингийн $\pm 2\%$
Хольцны температур	$\pm 10\text{ }^\circ\text{C}$

Нэг удаагийн шинжилгээгээр гарсан битумын агууламжийг хольцийн нийт жингээр үржүүлж тооцсон, аливаа үеийн нийт уртад орох битумын дундаж хэмжээ нь заасан хэмжээнээс багагүй байх ёстой. Хольцын жинг шалгаж тодорхойлсон өдөр тутам үйлдвэрлэсэн хольцын битумын дундаж хэмжээ нь заасан хэмжээнээс багагүй байх ёстой.

1000 м урт хэсэгт хоорондоо ижил зайтай 6 цэгт хэмжсэн асфальтобетон хучилтын өргөн зурагт заасан өргөнөөс бага байж болохгүй. Аль ч цэгт замын тэнхлэгээс хучилтын гадаргуугийн ирмэг хүртэл зай заасан зайнаас 10 мм-ээс илүү нарийссан байж болохгүй

1032. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР – ДЭД БҮЛЭГ “В”

(а) Ажлын нэр: Асфальтобетон хучилт

Хэмжих нэгж: м³

Асфальт бетон хучилтыг нягтруулсан үеийн хэмжих нэгж м³ байна. Асфальт бетон хучилтын ажлын эзэлхүүнийг Зурагт заасан буюу Инженерийн зааварчилсаны дагуу нягтруулсан үеийн хөндлөн огтлолын талбайг замын тэнхлэгийн дагуу Инженерийн зааварчилсаны дагуу хэмжсэн уртаар үржүүлж гаргана. Асфальтобетон хучилтын ажлын нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана.

Үүнд:

- Барьцалдуулагч болон буталсан чулууг бэлдэх, халаах, холих,
- Эрдэс нунтаг бэлдэх, холих,
- Шаардлагатай бол нэмэлт бодис бэлдэх, холих,
- Чулуу болон эрдэс нунтагийн хэмжээг өөрчлөх,
- Нэмэлт бодисын хэмжээг өөрчлөх,

- Гадаргууг бэлдэх,
- Эгц налуу газар ажиллах,
- Тээвэрлэх,
- Халаасан хольцыг нягтруулсан үеийн зузааныг хангахаар дэвсэх,
- Индүүдэх,
- Гадаргууг шаардагдах хэмжээнд хүртэл засах,
- Энэхүү техникийн шаардлагын 1200-р бүлгийн “А”, “В” дэд бүлгийн шаардлагад нийцүүлэх.
- Асфальтобетон хучилтын ажлын нэгж үнэлгээнд мөн дараах ажлууд багтана. Үүнд:
- Чулуу бутлах ба шигших тоног төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулах,
- нөөц газрыг ашиглах,
- газрын зөвшөөрөл авах, холбогдох татвар төлбөрийг хийх,
- ажил дууссаны дараа нөхөн сэргээлт хийх,
- энэхүү Техникийн шаардлагын 100, 200, 300 ба бүлгүүдийн шаардлагад нийцүүлэх,

БҮЛЭГ 1100 – ХӨВӨӨ

БҮЛЭГ 1100 – ХӨВӨӨ

1101. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
1102. ХӨВӨӨНИЙ МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА	2
1103. ХӨВӨӨГ БАРИХ	Error! Bookmark not defined.
1104. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР.....	4
1105. ТУРШИЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ДАВТАМЖ	4

1101. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хөвөөг дараахь 2 төрлөөр хийнэ. Үүнд :

- **Хайрган хөвөө**

Хайрган хөвөөг зохист ширхэглэлтэй материал буюу ердийн хайрга, эсвэл буталсан чулуугаар баяжуулан хийнэ.

Хайрган хөвөө гэдэг нь дээрх материалыг дангаар нь буюу тэдгээрийн хольцыг хэрэглэн, зөвшөөрөгдсөн суурийн доод үе дээр суурийн хоёр захыг хамгаалах зориулалтаар, зурагт үзүүлсэний дагуу хийсэн зохист ширхэглэлтэй өнгөн үе юм.

Энэ бүлэгт хайрган хөвөөний материалын шаардлага, барих, нягтруулах, хэмжилтийн ажлууд багтана.

1102. ХӨВӨӨНИЙ МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА

Хөвөөнд хэрэглэх материал нь дараах шаардлагуудыг хангаж байх ёстой. Үүнд:

- Материалын хуурай үеийн хамгийн их нягтшил (MDD) 98%-аас багагүй байх ба 4 хоног усанд сойсны дараах CBR үзүүлэлт 20%-с багагүй
- Хөөлт (CBR-ийн туршилтын сойлтын үед) 1 %-иас ихгүй
- Уян налархайн индекс 6%-аас ихгүй
- Урсалтын хязгаар нь 25%-иас ихгүй
- Уян харимхайн үзүүлэлт нь 90-ээс ихгүй
- Хайрга болон дайрган хөвөөний материал нь дараах 3 төрлийн хөвөөний материалын аль нэгийг хангаж байна. Хайрган хөвөөний материалын ширхэглэлийн шаардлагыг (Хүснэгт 11-1)-т үзүүлэв

Хүснэгт 11-1 Хайрга дайрган хөвөөний чулуун материалд тавигдах
техникийн шаардлага

Шигшүүрийн хэмжээ, мм	Бүрэн өнгөрөлт, жингийн хувиар		
	Зэрэглэл		
	А/А	Б/В	В/С
37,5	100	-	100
19,0	95-100	100	75-95
9,5	60-90	80-100	40-75
4,75	40-70	60-75	30-60
2,36	25-50	35-55	20-45
0,425	15-35	18-27	15-30
0,075	5-20	10-15	5-12

***Тухайн орон нутгийн материалын шинж чанараас хамаарч туршилтын үр дүнгээр тогтоогдсон тохиолдолд хольцын төрөл, ширхэглэлийн хязгаарыг тухайн материалд тохируулан хэрэглэнэ*

Хүснэгт 11-2 Хайрган хөвөөнд тавигдах үндсэн шаардлага

ХЭНГИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН-ӨМНӨДЭЛГЭР ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС БИНДЭР
ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

№	Шалгах үзүүлэлт		Тогтоосон утга буюу хүлцэх алдаа	Шалгах арга ба давтамж
1	Нягтралын зэрэг (%)		98-аас их	200м тутамд 2-оос багагүй хэсгийг шалгана
2	Тэгш байдал (мм)	хучлагагүй	20	3м рейк : 200м тутамд 4 шугамаар 2 хэсгийг хэмжинэ
		хучлагтай	12	
3	Хөндлөн хэвгий (%)		±0.40	Налуу хэмжигч: 200м тутамд 2 цэг авч хэмжинэ
4	Гадаргуугийн түвшин (мм)		±15	Нивлер: 20м тутамд хэмжинэ
5	Өргөн (мм)		Зурагт зааснаас багагүй ба +300 мм-ээс ихгүй	Хуваарьт уртын хэмжүүр: 200м тутамд 4 цэг авч хэмжинэ

Хайрган хөвөөний ажилд ашиглах тоног төхөөрөмж, тэдгээрийн ажлын аргачлалыг Инженерийн зааварчилсны дагуу талбайд туршилт хийж сонгох ба тогтооно. Гүйцэтгэгч нь хайрган хөвөөг хийхдээ аливаа үеийн гадаргуугийн усыг байнга гадагшлуулж байх нөхцөлийг хангасан аргачлалыг сонгож ажиллана.

Хайрган материалыг хөвөөний нийт өргөнөөр, хангалттай хэмжээгээр жигд тарааж, нягтруулсны дараах зузаан нь Инженерийн зааварчилсан хэмжээтэй байхаар дэвсэнэ.

Дэвссэн материалд том чулуу болон хар шороо орсон байвал зайлуулах ба хэрэв тэр нь их хэмжээтэй байх буюу шаардлага хангахгүй материал ихээр холилдсон бол хайрган материалыг нийтэд нь талбайгаас гаргаж зайлуулна. Хайрган материалыг ачих, тээвэрлэх, буулгах, тарааж дэвсэх, нягтруулах явцад хайрга ширхэглэлээрээ ялгарахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай.

Нэг удаагийн ажиллагаагаар дэвсэж, нягтруулсан аливаа үеийн зузаан нь 200мм-ээс илүүгүй байна. Нягтруулсан үеийн зузаан үүнээс их байх шаардлагатай хэсэгт материалыг хоёр буюу түүнээс дээш үеэр дэвсэж боловсруулна. Нягтруулсан үеийн хамгийн бага зузаан нь 100 мм байна. Хайрганы чийгийн агууламж нь тохиромжтой чийгийн агууламжаас (MNS AASHTO T180-93) 1%-иар их буюу 2%-иар бага байж болно. Үүний тулд материалыг нэгэн жигд усалж холих буюу эсвэл хатаах замаар чийгийг тохируулах хэрэгтэй. Хайрган материалыг заасан өргөнд хүргэж, хөндлөнгийн налууг гаргаж тэгшилнэ. Орчны температур 0° С-оос доош орсон үед хөвөөг ямар нэг хэмжээгээр усалж, чийглэхийг хориглоно.

Эцсийн хэлбэржүүлэлт хийж тэгшилсний дараа хөвөөг ХҮХИ нягтын 98%-с доошгүй байхаар нягтруулна. Гүйцэтгэгч материалыг тараах, тэгшлэх, нягтруулах үед шаардлагатай чийгшилтэй байлгах үүднээс ус шүрших буюу бусад зөвшөөрөгдсөн аргаар тогтоосон чийгшлийн агууламжийг хангалттай хэмжээнд барина. Нягтруулалт хийж дууссаны дараа гадаргуу нь сайн нягтарсан, элдэв ан цав, хагаралгүй, индүүдлэгийн улмаас гулсалт, долгион үүсээгүй, чулууны ялгарал гараагүй байх ёстой.

1104. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Зүйл: Хайрган хөвөө

Хэмжих нэгж: мЗ

Хайрган хөвөөний ажлыг суурийн доод үе дээр дэвсэж нягтруулсан шоо метрээр хэмжинэ. Ажлын тоо хэмжээг гаргахдаа хөвөөний өргөнийг нягтруулсан зузаан ба уртаар үржүүлнэ. Хайрган хөвөөний нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- Материалын сонголт хийж, орд газрыг тогтоох, хөрс хуулах
- Орд газар, хуулсан өнгөн хөрс, бусад хаягдлыг зайлуулах
- Хэрэглэхэд тохиромжтой материалыг орд газраас ухаж гаргах, бутлах, шигших, угаах ба холих, том хэмжээтэй материалыг зайлуулах,
- Материалыг ачих, тээвэрлэж буулгах, тараах
- Овор хэмжээ томтой материалыг шигшиж, зайлуулах,
- Материалыг хатаах, услах замаар чийгшлийг тохируулах,
- Зохих хөндлөн хэвгийг аргах,
- Хөвөөний материалыг 150 мм-ийн зузаан үеэр нягтруулах
- Барилгын ажил дууссаны дараа орд газрыг буцааж булаах, нөхөн сэргээх

**БҮЛЭГ 1200 – ХООЛОЙ БА УС ЗАЙЛУУЛАХ
БАЙГУУЛАМЖ**

БҮЛЭГ 1200 – ХООЛОЙ БА УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖ

1201. БҮЛГИЙН АГУУЛГА.....	2
1202. АЖЛЫН ДЭС ДАРААЛАЛ.....	2
1203. НҮХ УХАХ АЖЛЫН АНГИЛАЛ.....	3
1204. ХООЛОЙН БА УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН НҮХ УХАХ.....	3
1205. ХАТУУ МАТЕРИАЛД НҮХ УХАХ.....	4
1206. УХСАН НҮХИЙГ ХУУРАЙ БАЙЛГАХ.....	4
1207. ДӨРВӨЛЖИН ТӨМӨР БЕТОН ХООЛОЙ.....	4
1208. ХООЛОЙН СУУРЬ ЦУТГАХ.....	4
1209. БЕТОН ХООЛОЙН ЦАГИРГУУДЫГ УГСРАХ БА ХОЛБОХ.....	5
1210. БЕТОН БӨГЖ БА ЗУЗААЛАХ ХЭСЭГ.....	6
1211. БУЦААН ДҮҮРГЭХ.....	6
1212. ШҮҮРҮҮЛЭХ ҮЕ.....	7
1213. ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛАМЖУУД.....	7
1214. УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН ЖИЖИГ ХИЙЦҮҮД.....	7
1215. ШУУДУУ, ЧУЛУУН БЭХЭЛГЭЭ БА РИСБЕРМ.....	7
1216. ЧУЛУУН БЭХЭЛГЭЭ /ЗУУРМАГТАЙ ЧУЛУУН ДОТОРЛОГОО/.....	8
1217. УС ТУСГААРЛАГЧ ҮЕ.....	9
1218. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР.....	10

1201. БҮЛГИЙН АГУУЛГА

Энэ бүлэг дор дурдсан зүйлсийг хамаарна. Үүнд:

Дугуй болон дөрвөлжин төмөр бетон хоолойнуудыг угсрах;

Хоолойны орох, гарах амсрын хийцүүд, ус цуглуулах худаг, усны урсгалын хурд сааруулах болон эдгээртэй төстэй байгууламжуудыг барих; Угаagdлаас хамгаалах тулц ханыг хийх;

Дор дурдсан байгууламжийн ухмал, өндөрлөгөө ба бусад ажлууд:

1. Дугуй хоолой байрлуулах суурийн нүх
2. Орох амсрын шуудуу
3. Гарах амсрын шуудуу
4. Уулын шуудуу
5. Замын хажуугийн шуудуу
6. Хөрсний ус шүүрүүлэх
7. Ус цуглуулах худаг
8. Тулц хана
9. Жижиг байгууламжууд

Хажуугийн шуудууны барилгын ажилд тавигдах шаардлагыг энэ техникийн шаардлагын бүлэг 1215-д оруулсан болно. Ус зайлуулах байгууламжийн барилгын ажил, чулуун бэхлэгээтэй хажуу налуугийн хамгаалалтын ажлуудад тавигдах шаардлагыг энэ техникийн шаардлагын бүлэг 1215-д оруулсан. Төмөр бетон дугуй хоолойны барилгын ажилд тавих шаардлагыг энэ техникийн шаардлагын бүлэг 1207 ба 1209 –д оруулсан.

1202. АЖЛЫН ДЭС ДАРААЛАЛ

Ажлын зургуудад хоолой бүрийн байршил, хэмжээний талаар заасан байдаг. Хоолойн налуу, орох гарах амсар, толгойны өндрийн төвшингийн ажлын зургийг Гүйцэтгэгч гаргаж, Инженер-т ирүүлж баталгаажуулна. Энэхүү техникийн шаардлагын бүлэг 300-д нийцүүлэн дагуу огтлол, хөндлөн огтлол болон бусад мэдээллийг ирүүлэхээс өмнө, байгаа бүх хоолойг цэвэрлэж, тэдгээрийн орох ба гарах амсрыг сэргээж, ус чөлөөтэй нэвтрэх боломжтой болгоно. Гүйцэтгэгч нь гэрээний заалтын дагуу танилцуулах ажлын хөтөлбөртөө дээр дурдсан мэдээллийг ирүүлэх ба хоолойн нарийвчилсан мэдээллийг бэлтгэх ажлын хугацааг тооцсон байна. Бүх хоолой ба ус зайлуулах байгууламжийн барилгын ажлыг сайтар төлөвлөсөн байна. Гүйцэтгэгч нь Инженер өөрөөр заагаагүй бол гэрээний заалтын дагуу эдгээр байгууламжийн дээр буюу хоёр талд далан барихаас өмнө бүх хоолой ба ус зайлуулах байгууламжийн ажлыг дуусгахаар ажлынхаа хөтөлбөрт тусгасан байх ёстой. Хэрэв Гүйцэтгэгч далан, дугуй хоолой ба ус залах байгууламжийг далангийн ажил эхлэхээс өмнө барьж дуусгах шаардлагагүй гэж үзвэл ажлын ердийн дарааллыг өөрчлөх хүсэлтийг бичгээр Инженерт гаргана.

Дор дурдсан нөхцөлд Инженер энэ хүсэлтийг зөвшөөрч болно. Үүнд:

- Гүйцэтгэгч нь хоолой болон даланд эвдрэл гарах эсвэл эдгээрийг барих ажил хойшлогдвол хариуцлага хүлээнэ.
- Гүйцэтгэгч далангийн ажил дуусангуут хоолойн барилгын ажлыг яаралтай эхэлнэ.

Ухмалтай хэсгийн замын далан доор хоолой барих газарт ухмал ба буцаан дүүргэлтийн газар шорооны ажлын ихэнх хэсэг дууссаны дараа, гэхдээ ухмал дахь далангийн гадаргуугаас доош 300 мм үеийг хийхийн өмнө гүйцэтгэнэ. Хэрвээ гүйцэтгэгч ажлын энэ дарааллыг өөрчлөхийг хүсвэл Инженер-т энэ тухай хүсэлтийг бичгээр гаргана. Хоолойн ухмалын

төлбөрийг далангийн түвшнээс доош ухсан хэмжээгээр хийх нөхцөлд газар шорооны ажлыг дуусахаас өмнө эдгээр хоолойн ухмалын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийн хүсэлтийг Инженер зөвшөөрч болно.

1203. НҮХ УХАХ АЖЛЫН АНГИЛАЛ

Хоолой ба ус зайлуулах байгууламжийн нүх ухах ажлыг дараах ангилалд хуваана. Үүнд:

a/ Хатуу материалын ухмал гэдэгт зөвхөн тэсэлгээний аргаар, эсвэл чулуу бутлагч хошуу бүхий механик бутлагч тоног төхөөрөмж ашиглан ухаж, боловсруулах ажил багтана. Том чулууны хэмжээ нь 0.20 м³-ээс их байвал хатуу материалын ухмалд багтана.

b/ Хатуу материалын ухмалаас бусад дахин ашиглагдах ба ашиглагдахгүй материалын ухмалыг ердийн ухмалд хамааруулна.

1204. ХООЛОЙН БА УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН НҮХ УХАХ

Гүйцэтгэгч нь хоолой ба ус зайлуулах байгууламжийн нүхийг зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварласан байрлал, төвшин, налуу хэмжээг баримтлан хийж гүйцэтгэнэ. Хэрэв Гүйцэтгэгч тодорхойлсон хэмжээнээс илүү гүн ба өргөнд ухсан бол өөрийн зардлаар зөвшөөрөгдсөн материалыг ашиглан зохих төвшин болон хэмжээнд хүргэж дүүргэх ба Инженерийн баталсны дагуу зэргэлдээ хөрсний нягтралын хэмжээнд хүртэл нягтруулна.

Гүйцэтгэгч нь ухаж гаргасан шорооноос ашиглах боломжтойг нь ялгаж, дүүргэх материалд нөөцөлж хадгална. Хэрэв Гүйцэтгэгчийн ухсан нүхний шороо нь дахин ашиглахад тохиромжгүй гэж үзвэл Инженерийн зөвшөөрлийн дагуу ашиглагдахгүй материалын талбайд шилжүүлнэ. Гүйцэтгэгч ухсан нүхийг цэвэр байлгах ба ус орохоос хамгаалж ус зайлуулах суваг ухах, усны хаалт барих, насосоор соруулах эсвэл нүхийг усгүйжүүлэх ажлыг хийнэ.

Инженер нь Гүйцэтгэгчийн ажлын арга барилаас шалтгаалан ухмалын ёроолын гадаргуу нь сул, зөөлөн буюу тохиромжгүй болсон гэж үзвэл Гүйцэтгэгчийн зардлаар тохирохгүй материалыг зайлуулж, Инженерийн зааврын дагуу зөвшөөрөгдсөн ширхэглэлтэй материалаар, эсвэл бүтээцийн бус бетоноор солино.

Гүйцэтгэгч нь бэлэн болсон нүхний ёроолыг AASHTO T99 стандартын дагуу хуурай үеийн хамгийн их нягтын 95%-иас багагүй байхаар нягтруулсны дараа 150 мм-ийн зузаантай дэвсгэр материалыг дэвсэнэ.

Өндөржилтийн хувьд ойролцоогоор, одоо байгаа газрын хөрсөн дээр баригдах хоолойн тухайд бол Гүйцэтгэгч нь өнгөн хөрсийг хуулсны дараа газрын хөрсийг үечилж ухах буюу өндөрлөж тэгшилнэ. Ул суурийг сайн тэгшлэх ба хоолойн нийт уртад жигд нягтралтай байна. Дэвсгэр материалын доорх ул суурийг 150 мм-т AASHTO T99-94 стандартын дагуу хуурай үеийн хамгийн их нягтын 95%-иас багагүй байхаар нягтруулна.

Дэвсгэр материалыг дэвсэхээс өмнө Инженерээс ул хөрсний талаарх зөвшөөрлийг авсан байх ёстой.

Хоолой ба бусад байгууламжийг барих нүхийг бэхэлгээтэй ухах ёстой бөгөөд хоолойг угсрах, суурь бетон цутгах нүхийг буцааж дүүргэх болон нягтруулах ажлыг хийж гүйцэтгэхэд боломжийн хэмжээтэй байхаар ухна. Инженерийн зааварласан газарт нүхний бэхэлгээний шон ба хашилтыг үлдээж орхино. Хангалттай хэмжээнд хүртэл боловсруулах боломжгүй нөхцөл бүхий хөрсийг Инженерийн зааврын дагуу тохирох материал гарч иртэл нь буюу Инженерийн зааварласан гүн, өргөний хэмжээгээр ухаж, тохирохгүй материалыг зайлуулна. Үүний үр дүнд гарах ухмалыг Гүйцэтгэгч нь зөвшөөрөгдсөн материалаар буцааж дүүргэн, AASHTO T180 стандартын дагуу хуурай үеийн хамгийн их нягтын 95%-иас багагүй байхаар нягтруулна. Зөвшөөрөгдсөн материал нь дээр дурдсан 1203-т тодорхойлсон хатуу дүүргэгч материал ба

зохист ширхэглэлтэй дүүргэгч материал, эсвэл 1211-ийн дагуу сонголт хийсэн буцааж дүүргэх материал байж болно.

1205. ХАТУУ МАТЕРИАЛД НҮХ УХАХ

Дугуй бетон хоолой

Бетон дугуй хоолой барих газарт хатуу материал тааралдвал ул хөрсний 50 мм-т ямар ч хатуу материал ил байлгахгүйгээр нүхийг тэгшилж янзална. Гүйцэтгэгч нь нүхний ёроолд 50 мм бүхий зузаантай бүтээцийн бус бетоноор тэгшилгээний үеийг дэвсэж хоолойн суурийн ёроолтой нэг төвшинд байхаар тэгшилж нягтруулна. Тэгшилгээний үеийн хамгийн их зузаан нь 50 мм байна. Сул хөрс ба тохиромжгүй материал тааралдвал тэдгээрийг 300 мм буюу Инженерийн заасан гүнд хүртэл хусаж зайлуулаад, оронд нь зөвшөөрөгдсөн материалаар буцааж дүүргэн хуурай үеийн хамгийн их нягтын 95%-иас багагүй байхаар /AASHTO T99/ нягтруулна.

1206. УХСАН НҮХИЙГ ХУУРАЙ БАЙЛГАХ

Гүйцэтгэгч нь суурийн нүхэнд ус орохоос сэргийлэх ба ус орохоос хамгаалж, ус зайлуулах шуудуу ухах, усны хаалт барих, насосоор усыг соруулах эсвэл нүхийг усгүйжүүлэх ажлыг хийнэ.

а. Гүйцэтгэгч нь суурийн нүхэнд ус орохоос сэргийлэх ба ус орохоос хамгаалж, ус зайлуулах шуудуу ухах, усны хаалт барих, насосоор усыг соруулах эсвэл нүхийг усгүйжүүлэх ажлыг хийнэ.

б. Хайрган суурь

Хоолойн бетон суурийг цутгахаас өмнө хайрган суурийг зурагт үзүүлсэн хэмжээг баримтлан, зохистой ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй материалаар хайрган суурийг тохиромжтой материалаар хийнэ. Суурийн материалыг авчирч буулгахаас өмнө хоолойн суурь болон бусад хэсгийн нүхийг энэхүү ТШ-ын 1204-ын дагуу бэлэн болгосон байна.

Хоолойн хайрган суурийн материал нь дараах шаардлагыг хангасан байна.

Хөрсний даацын үзүүлэлт (CBR) нь 4 өдөр сойсны дараа ХҮХИН нь 98% (MNS ASTM D2217:2002/AASHTO T1810-10) хүртэлх нягтруулалтанд шалгаж үзэхэд 20%-иас их байвал зохистой.

- ХҮХИН (AASHTO T1810-10) 1,85 т/м³-аас багагүй
- 0,075мм шигшүүрээр өнгөрсөн хэсгийн хувь 15-аас бага,
- Ширхэглэлийн хамгийн том хэмжээ нь 60мм-ээс бага байна.

Хоолойн хайрган суурийг ХҮХИН нь хамгийн багадаа 95% (MNS ASTM D 2217:2002/AASHTO T180-10) хүртэл нягтруулах ба тохиромжтой чийгийн агууламжийг 1-2%-ийн хэлбэлзлээс хэтрэхгүй байхаар тохируулна.

Бетон суурийн ажил эхлэхээс өмнө хайрган суурийн геометр хэмжээ, нягт, төвшинг шалгаж, Инженерээс зөвшөөрөл авсан байна. (Дөрвөлжин хоолойн хувьд зурагт заасан тэгшилгээний бетоныг цутгаж холбогдох зөвшөөрлийг авсан байх).

1207. ДӨРВӨЛЖИН ТӨМӨР БЕТОН ХООЛОЙ

Дөрвөлжин төмөр бетон хоолойг ИНЗ-д заасны дагуу хийнэ. Хоолойн бетон нь энэхүү техникийн шаардлагын 1300-р бүлэгт нийцэж байна.

1208. ХООЛОЙН СУУРЬ ЦУТГАХ

Гүйцэтгэгч нь хоолойн нийт уртын дагууд (хүчитгээгүй) 150 мм зузаантай эсвэл ажлын зурагт заасан зузааны дагуу бетон суурь цутгана. Бетоны анги нь ажлын зурагт зааснаар байх

ёстой. Бэлтгэл ажил нь бүрэн дуусч зөвшөөрөгдсөн хайрган суурь/ тэгшилгээний бетон дээр бетон суурийн 2 захын болон тулц хана, толгой, далавчны арматур зэрэг холбогдолтой бүхий ажлыг энэхүү техникийн 208-д заасныг баримтлан гүйцэтгэнэ.

Бэлэн болсон арматурчлалын хэмжээг Инженер шалгаж зөвшөөрсөний дараа бетон суурийн хэвийг ажлын зургийн дагуу угсарч зөвшөөрөл авна. Хэв хашмалыг төсөллөх, барих, ажилд бэлтгэх, буулгахад энэхүү техникийн зүйл 1318-д заасаныг тус тус мөрдөнө.

1209. БЕТОН ХООЛОЙН ЦАГИРГУУДЫГ УГСРАХ БА ХОЛБОХ

Хоолойн бетон цагиргуудыг холбох ажлыг дараах аргуудаар хийж болно.

Үүнд:

a/ Хоолойн цагиргуудыг угсрах ба холбох

Хоолойн цагиргуудыг угсрахын өмнө Гүйцэтгэгч нь цагиргуудын амсрыг шавар, шороо, тоосноос цэвэрлэх ёстой. Зурагт үзүүлснээр цутгамал хоолой нь тэгш амсартай байна. Тэгш амсартай цагиргуудын уулзварыг гадна ба дотор талаас нь цементэн зуурмагаар жигд дүүргэж чигжинэ. Гүйцэтгэгч хоолойн цагиргийг угсарсны дараа уулзваруудын дотор талыг нь хусаж тэгшлээд, усаар норгож цемент-элсний 1:2 харьцаатай зуурмагаар чигжинэ.

Гүйцэтгэгч хоолойн цагиргуудыг угсарч хоорондох зайг цемент-элсний зуурмагаар чигжиж, цул болгосны дараа хоолойн их бие ба бетон суурьтай нийлэх хэсгийн хоёр хажуугийн зайг B15 ангийн бетоноор чигжиж нягтруулна. Гүйцэтгэгч нь Инженерийн зөвшөөрсөн бүрээс, халхавчаар бүх уулзварыг бүтээж, салхи, нар, ус борооноос хамгийн багадаа 3 хоногийн турш хамгаалж, чийгийг нь хадгална. Хоолойн цагиргуудыг холбосны дараа 48 цагийн дотор хоолойг хөдөлгөөнгүй байлгахад Гүйцэтгэгч анхаарах ёстой.

b/ Хөшүүн холбоос

Хөшүүн холбоосоор холбосон, үл салах хоног бүхий бетон хоолойг суулгахдаа Гүйцэтгэгч нь хоолойн углуургыг хоногт нь оруулахын өмнө углуурга ба хоногийг шавар, тос болон бусад хорт бодисоос цэвэрлэнэ. Хоолойн хамгийн дээд хэсэг дээр холбоос үүсгэхэд тохиромжтой уртаар тайрсан давирхайтай олсон жийргийг углуургыг тойруулан ороож, дараа нь углуургыг хоногт гүйцэд оруулан суулгах ба холбоосыг жийргээр битүү бөглөнө. Үүний дараа 1:2-ийн харьцаатай цемент-элсний зуурмагаар холбоосыг битүү дүүргэж, 45⁰-ийн өнцгөөр зуурмагаар шавна. Хоёр углуургыг холбоход ашигласан хөшүүн холбоосоор холбосон бугуйвчуудыг үл салах хоногийг холбосонтой ижил байдлаар холбоно. Хэрвээ S хэлбэрийн хоногоор холбогдсон хоолойнуудыг зуурмагаар холбохоор зурагт заагдсан бол Гүйцэтгэгч нь тэдгээрийг суулгах үедээ гүйцэтгэнэ. 1:2-ийн харьцаатай цемент-элсний зуурмагийг хоногийн доод талын хагас тойрог дээр, углуургын дээд хагас тойрог дээр шавж, хоолойг хоногт сайн суулгана. Холбоосын эргэн тойрон 75 мм-ийн өргөн, 25 мм-ийн зузаантай нэг ижил зуурмагаар шавна. Хоолойнуудыг холбохын өмнө хоолойг хусаж цэвэрлээд усаар норгож, 1:2-ийн цемент-элсний зуурмагаар холбоосыг шавна. Бүх холбоосыг Инженерийн баталсан халхавч бүрээсээр хучиж, салхи, нар болон хүйтнээс хамгаалах ба доод тал нь 3 хоногийн туршид чийгийг хадгална.

Холбосны дараа хоолойнуудыг дор хаяж 48 цагийн туршид хөдөлгөхгүй байлгах ёстой.

c/ Уян холбоос

Үл салах хоног бүхий бетон хоолойнуудын уян холбоосыг хоног дотор суулгасан резинэн жийрэг болон хоолойн углуурга дээр байрлуулсан дугуй жийргийн тусламжтайгаар гүйцэтгэнэ. Уян холбоосын энэ төрлийг Инженер баталгаажуулах ёстой.

Аливаа холбоосыг хийхийн өмнө холбоосын бүх хэсгийг шавар, тос болон бусад хорт бодисоос цэвэрлэсэн байх шаардлагатай.

Гүйцэтгэгч нь суулгасан жийргүүдийг үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу нарийн, нягт нямбай тослох шаардлагатай. Өөр өөр үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн уян холбоосын эд ангиудыг хамт хэрэглэж болохгүй.

Суулгах хоолойны углуургыг өмнөх хоолойны хоногт оруулж, хоёр хоолойг нэг шугамд байрлуулна. Суулгаж буй хоолойны төгсгөл дээр тогтмол даралт ирж байх ёстой. Шаардлагатай тохиолдолд өмнөх хоолойны бүслүүрийг тойруулж бэхэлсэн өргөгч хэрэгслийг ашиглан дараагийн хоолойг татан оруулна. Углуургыг хоногт нь сайн шахаж оруулан суулгах ба дараа нь холбоосын уян налархай байдлыг хангахын тулд үйлдвэрлэгчийн зөвлөсөн зай хэмжээгээр буцаан суллана.

Холбоосыг хийсний дараа Гүйцэтгэгч дугуй жийргүүдийг зөв байрласан эсэхийг мэдрэгч багажаар туршина. Хэрвээ дугуй жийргүүд нь хоолойн тойргийн дагуух шугамаас нэлээд их зайнд холдсон байвал холбоосыг задалж, шинэ дугуй жийргээр дахин хийнэ. Гөлгөр хоолойнуудыг уян холбоосыг агуулсан бугуйвчаар холбох үед холбоос нь үл салах хоногтой хоолойныхтой адил байдлаар хийгдэнэ. Эхний хоолой ба бугуйвч хоёрын хоорондох холбоосыг хоёрдох хоолойг бугуйвчинд суулгахын өмнө хийж дуусгана.

Гүйцэтгэгч хоолойн хоног буюу бугуйвч бүрийн доторх зай болон жийргийн гадна талыг чулуу орохоос сэргийлж шавар, олс болон Инженерийн баталсан бусад тохиромжтой материалаар дүүргэнэ.

d/ Хоолойны төгсгөл

Өөрөөр заагаагүй бол хоолойны төгсгөлийг тэгш босоо байдлаар үлдээнэ.

1210. БЕТОН БӨГЖ БА ЗУЗААЛАХ ХЭСЭГ

Бетоны ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч нь бетон чигжээс тавих, зузаалах хэсгийн гадаргууг Инженерийн шаардлагад хүртэл цэвэрлэж бэлдэх ёстой. Зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварласан хэсэгт Гүйцэтгэгч нь бетон хоолойнуудын уулзварын хэсгүүдэд 150 мм-ийн зузаантай бетон хийнэ. Бетон зузаалах хэсэгт B15 ангийн бетоныг ашиглах боломжтой ба зурагт буюу Инженерийн заасан хэмжээгээр хийнэ.

Хоолойны шороотой нийлэх бүх гадаргууд битумэн ус тусгаарлагчийг түрхэнэ. Битум түрхэхийн өмнө хоолойн бүх гадаргууг төмөр сойзоор сайтар үрж, цэвэр усаар шүршиж цэвэрлэнэ. Битумэн ус тусгаарлагч нь асбест ширхэглэл ба эрдэс нэмэлтүүдийг агуулсан буюу эсвэл Инженерийн зөвшөөрсөн ижил төстэй материал байх ёстой бөгөөд түүнийг цацах буюу түрхэнэ.

1211. БУЦААН ДҮҮРГЭХ

Гүйцэтгэгч нь бетон хоолойг эргүүлж булахад хэрэглэх материалыг нүхнээс гарсан материалаас сонгож авна. Хүрэлцээтэй хэмжээний материал байхгүй тохиолдолд, эсвэл хоолой газрын төвшинд их ойр буюу газар дээр байрлахаар бол Гүйцэтгэгч нь материал олборлох талбайгаас хоолойг булах материалыг олборлоно. Буцааж булах материал нь нүхнээс ухаж гаргасан материал, эсвэл олборлох талбайгаас авсан алин боловч дүүргэгч материалын шаардлагыг хангасан байх ёстой. Сонгож авсан дүүргэгч материалыг 150-200мм-ээс илүүгүй зузаантайгаар үечлэн дэвсэнэ. Дүүргэх материалын чийг нь зохистой хэмжээнээс MNS AASHTO T180 стандартын дагуу +2%-иас их хэлбэлзэж болохгүй. Гүйцэтгэгч бүх дүүргэх материалыг MNS AASHTO T180 стандартын дагуу хуурай үеийн хамгийн их нягтын 95%-иас багагүй байхаар нягтруулна.

Гүйцэтгэгч хоолойг эргүүлж булах үед шорооны даралт хоолойд жигд бус үйлчлэхээс сэргийлж, дүүргэх материалыг хоолойн хоёр тал руу нэг зэрэг хийнэ. Гүйцэтгэгч хоолойн ойр

орчимд тодорхой заасан нягтралыг бий болгохын тулд тохиромжтой нягтруулагч тоног төхөөрөмжийг бэлдсэн байх ёстой. Хоолойнд эвдрэл учруулалгүйгээр ойр орчмыг нь Инженерийн хяналттайгаар нягтруулагч тоног төхөөрөмж ашиглан нягтруулна. Хэрэв хоолойд ямар нэгэн эвдрэл учруулбал Гүйцэтгэгч өөрийн зардлаар засна.

Инженер өөрөөр зааварчлаагүй бол нүхний ханыг бэхэлсэн шон ба хашилтыг салган авч, тэдгээрийн доорх ба ар талын зайд дүүргэх материалыг хийж нягтруулах ёстой.

Газар дээр буюу газрын төвшинтэй ойрхон баригдсан, эсвэл газраас дээш ил гарсан хоолойн хоёр хажууд болон хоолой дээгүүр дүүргэх материалыг 150 мм-ээс ихгүй зузаантайгаар үечилж дэвсээд нягт нь зэргэлдээх үеийн дүүргэх материалын нягтаас багагүй байхаар нягтруулна. Хоолойн дагууд буцааж хийсэн дүүргэх материалын өргөн нь 2м-ээс багагүй байх ёстой. Энэ дүүргэх материалын дор байх ул хөрсийг AASHTO T99 стандартын дагуу хуурай үеийн хамгийн их нягтын 95%-иас багагүй байхаар нягтруулах ёстой. Газар дээр баригдсан хоолойн дагууд хийсэн дүүргэх материал нь зэргэлдээх дүүргэх материалтай ижил төстэй байх ёстой бөгөөд бүлэг 500-д зааснаас өөр нэмэлт төлбөр хийгдэхгүй болно. Гүйцэтгэгч нь баригдаж байгаа хоолой дээгүүр ямар ч машин, тоног төхөөрөмжийг явуулж болохгүй бөгөөд гарцаагүй шаардлага гарсан тохиолдолд л Инженерээс зөвшөөрөл авч, хамгаалалтын арга хэмжээг урьдчилан авах ёстой.

1212. ШҮҮРҮҮЛЭХ ҮЕ

Энэхүү техникийн шаардлагын үүднээс, шүүрүүлэх үе нь дороос ундрах, эсвэл дээрх гадаргуугаас шүүрэх усыг цуглуулах зорилгоор төлөвлөгдсөн ямар ч төрлийн ус зайлуулах байгууламж байж болох бөгөөд энэ нь хоолойг багтаасан буюу багтаагаагүй байж болно. Ухсан нүхэн дэх газар шорооны ажлын ихэнх хувийг хийж дуусах хүртэл тэрхүү нүхэнд шүүрүүлэх үеийг байгуулах зааврыг өгөхгүй. Зааварласан аливаа шүүрүүлэх үеийг барих ажлыг залгаа орших далангийн дээд талын 300 мм үед хийгдэх ажлыг эхлэхээс өмнө дуусгана.

Шүүрүүлэх үед ашиглах том ширхэглэлтэй материал нь цэвэр, хатуу, буталсан чулуу байна. Шүүрүүлэх үед хамгийн том нь 37.5 мм. Инженерийн зааварласан хязгаарын хооронд ширхэглэлтэй материалыг ашиглана.

Шүүрүүлэх үеийн жижиг ширхэглэлтэй материал нь хажуугийн нөөцөөс авсан цэвэр, хатуу элс байна.

1213. ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛАМЖУУД

Зурагт үзүүлсэн буюу Инженер зааварласан тохиолдолд Гүйцэтгэгч хамгаалалтын байгууламжуудыг барина. Ус зайлуулах суваг, хоолойн орох ба гарах амсар ба голын урсгалыг зайлуулахтай холбогдсон хамгаалалтын байгууламжуудад ерөнхийдөө энэхүү техникийн шаардлагын бүлэг 1215-ийн дагуу чулуу дүүргэсэн торон бэхэлгээ, чулуун асгаас зэрэг багтана. Инженер өөрөөр заагаагүй бол голын ёроол дахь бул чулуунуудыг зайлуулахгүй.

1214. УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН ЖИЖИГ ХИЙЦҮҮД

Ус зайлуулах байгууламжийн жижиг хийцэд хоолойн орох ба гарах амсрын бүтээцүүд, ус цуглуулах худаг, урсгал сааруулагч, ус хаялгын байгууламж болон тэдгээртэй ижил төстэй байгууламжууд орно. Нэг маягийн зургуудад үзүүлсэн боловч гэрээт ажлын явцад Инженер ажлын нарийвчлалыг Гүйцэтгэгчид үе үе гаргаж өгч байна. Зурагт өөрөөр заагаагүй бол ус зайлуулах байгууламжийн жижиг хийцүүдэд B15 ангийн бетоныг ашиглана.

1215. ШУУДУУ, ЧУЛУУН БЭХЭЛГЭЭ БА РИСБЕРМ

а. Шуудуу, чулуун бэхэлгээ болон рисберм зэргийг зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсан байршил, чиг, түвшин, налуутай хийнэ.

b. Зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсан газарт Гүйцэтгэгч нь ус зайлуулах байгууламж руу усны урсгалыг чиглүүлэх зорилгоор уулын шуудуу, жишүү шуудуу, ус зайлуулах шуудуу болон гаргах шуудууг байгуулна. Энэ ажилд бүх материалыг ухах, зайлуулах ажил багтана. Талбайг цэвэрлэсний дараа ухмалын хязгаарыг зурагт үзүүлсэн болон Инженерийн зааварласан чиг, налуу, түвшин болон огтлолын дагуу тэмдэглэж гадаслана. Налуугаас гадагшаа буюу тогтоосон түвшнээс доош ухах ёсгүй бөгөөд ухмалын хязгаараас гадагш аливаа материалыг суллахгүй. Тогтоосон түвшнээс доош илүү гүнд ухсан тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн зардлаар буцааж дүүргэнэ. Тогтоосон хэмжээ, түвшин ба хажуу налууд хүргэх зорилгоор ухсан шуудууны ёроол болон хажуу талыг тэгшилж, сайтар нягтруулна.

c. Зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсан чиг, түвшин, хажуу налуу, хэмжээ ба огтлолын дагуу уулын шуудууг ухаж, гарсан материалыг шуудууны доод талаар далагнаж асгана.

d. Зааварчилгаа өгсөн тохиолдолд шуудуунуудын ёроол ба хажуу налууг чулуу буюу бетоноор бэхэлж, ширэг суулгана.

e. Зурагт үзүүлсэн буюу Инженер зааварчилсан тохиолдолд Гүйцэтгэгч энэ техникийн шаардлагын зүйл 1216-ийн дагуу тогтоосон зузаан ба хэлбэртэй чулуун бэхэлгээг хийнэ.

f. Гүйцэтгэгч нь зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсан чиг, түвшин ба хэмжээний дагуу рисбермийг байгуулна.

Чулуу нь хатуу, бат бэх, хэмжээгээр ижил байх ёстой. Ус болон цаг агаарын нөлөөгөөр өгөршсөн чулуулгийг ашиглахгүй. Чулууны хувийн жин нь хамгийн багадаа 2.40 байх ёстой. Рисберм хийх чулууны хэмжээ нь аль болох том байна. Чулууны аль ч ширхэг нь 40 кг-аас бага байх ёсгүй. Чулууг 600 мм гүнзгий нүхэнд 1 м-ийн зузаантай эмх цэгцтэй өрж байрлуулна. Рисберм хийх нүхний ёроолыг зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсан урт ба өргөнтэй тэгшилж, нягтруулна.

1216. ЧУЛУУН БЭХЭЛГЭЭ /ЗУУРМАГТАЙ ЧУЛУУН ДОТОРЛОГОО/

Гүйцэтгэгч нь зургийн дагуу болон Инженерийн зааварчилгааны дагуу шуудуунд 200 мм-ийн зузаан зуурмагтай чулуун доторлогоог хийнэ. Зуурмагтай чулуун доторлогоо нь элс-цементийн зуурмагаар тогтоож, шуудууны хажуу тал болон ёроолд тавьсан чулуунаас бүрдэнэ.

Зуурмагтай чулуун доторлогоонд ашиглах чулуу нь хатуу, бат бэх, элэгдээгүй байх ёстой бөгөөд ан цав, хагарал, нүх сүв, үе давхраа болон ямар нэг эвдрэл гэмтэлгүй байх ёстой. Чулууны ширхэг бүр нь параллелолипед хэлбэртэй, 180 мм-220 мм зузаан, 220 мм-280 мм өргөн, 300 мм-450 мм урт байх ёстой. Бөөрөнхий болон гурвалжин гадаргуутай буюу үелэлтэй чулуунууд ашиглагдах ёсгүй. Ил гарсан гадаргуу дээр бага зэргийн /барзгардуу/ боловсруулалттай чулууг тавих ба эдгээр нь хажуу бэхлэгээний шугамаас 12 мм-ээс илүү гарах ёсгүй. Бусад бүх гадаргуу дээр нарийн боловсруулсан чулууг тавих ба эдгээр нь хажуу бэхлэгээний шугамаас 6 мм-ээс хэтрэхгүй байна. Чулууг ажлын талбайд авчрахын өмнө Гүйцэтгэгч ашиглах чулууны 5 (таван) дээжийг баталгаажуулахаар Инженер-т ирүүлэх ба үүний хамтаар чулууг гарган авах орд газрын геологийн болон байршлын нарийвчилсан мэдээллийг ирүүлнэ. Зөвхөн Инженерийн баталсан чанар ба гарал үүсэлтэй чулууг ажилд ашиглана. Чулууг тавихын өмнө хэмжээгээр нь бүрэн ангилж, засаж өөлөх ба зуурмагийг хөдөлгөхгүй байлгах зорилгоор тавьж байх явцад хэмжээгээр нь ангилах ажлыг хийхгүй.

Чулууг өрөхөд ашиглах зуурмаг нь дараах найрлагатай байх ёстой.

Үүнд:

- Портландцемент ба Ус
- Нойтон шохой

- Элсэн чулуу

Зуурмагт хэрэглэх цементэн барьцалдуулагч нь нэг хувийн портландцемент, ¼-½-ийн нойтон шохойноос бүрэлдэнэ. Элс-цементэн барьцалдуулагчийн харьцааг чийгтэй, сул байдалд байгаа элсний хэмжээ цементэн барьцалдуулагчийн хэмжээнээс 3 дахин их байхаар тогтооно. Эдгээр харьцааг хангаж байгаа, урьдчилан хольсон материалыг ашиглана. Зуурмагт орох ус нь хольцыг ашиглах боломжтой хэмжээнд байх ёстой ба бэлтгэсэн зуурмагаас ус дуслах ёсгүй. Устай хольсны дараа зуурмагийг 1.5 цагийн дотор ашиглах бөгөөд ашиглаагүй тохиолдолд зуурмагийг хаяна. Зуурмагаас гарсан усыг нэвчүүлэхгүй байх зорилгоор чулуунуудыг тавихын өмнө хангалттай чийглэж, гадаргууг нь хатаасан байна. Чулууг тавих суурийг цэвэрлэж, чийглэн, шинэ бэлдсэн зуурмагаар шавна. Хэрвээ суурийн хөрс сул байвал зуурмаг тавихын өмнө чийглэж, нягтруулна. Хэрвээ суурь хөрсөнд сул, зууралдамтгай бус материал байвал нягтруулж, зууралдамтгай болгосон хайргархаг хөрсөөр солино.

Чулууг суурь дээр зуурмагаар бэхлэн тавих ба тавьсны дараа даруйхан резинэн эсвэл модон алхаар болгоомжтой цохин зуурмагийг бэхжихээс өмнө сайтар суулгана. Чулуун бэхэлгээнд хуурай болон хоосон зай гарах ёсгүй ба суулгасан чулууны завсар зайг зуурмагаар шавна. Завсар зайг дүүргэсэн илүүдэл зуурмагийг цэвэрлэн арилгаж заадсыг мэдэгдэхүйц болгоно. Чулууны заадсуудын хоорондох зай нь хамгийн багадаа 150 мм байх ба чулууг нэг шугамд тавьж бага зэрэг тэгшилнэ.

Агаарын болон хөрсний температур 5⁰C-ээс бага үед чулуун бэхэлгээг хийхгүй. Чулуун бэхэлгээг тавьсны дараа зуурмагийг бэхжүүлэхийн тулд 2 /хоёр/ өдрийн турш усаар хөнгөн шүршиж, чийгтэй байлгана. Дээр заагдсан материал болон ажлын технологийг үл баримтлан барьсан чулуун бэхэлгээг хүлээн авахгүй бөгөөд Инженерийн зааварчилгааны дагуу дахин барина.

1217. УС ТУСГААРЛАГЧ ҮЕ

Ус тусгаарлагчийн зорилго нь төмөр бетон хоолойг ус, эрдэс болон давснаас үүсгэгдэх зэвэнд идэгдэхээс хамгаалахад оршино. Төмөр бетон дугуй болон дөрвөлжин хоолойн толгой ба суурийн хэсэгт ажлын зурагт үзүүлсэн болон Инженерийн заасны дагуу ус тусгаарлагчийг хийх шаардлагатай. БНД 90/130 маркийн битум буюу барилгын шингэн битумыг ус тусгаарлагчид хэрэглэгдэнэ.

Гүйцэтгэгч нь техникийн шаардлагад нийцсэн, үйлдвэрлэгчийн гэрчилгээтэй, шинжилгээ хийгдсэнийг нотолсон баримт бичигтэй битумыг Инженерт танилцуулж зөвшөөрөл авна. Түрхлэг хийх үед замын тоноглол, хоолойн толгой, далавч, мод, бут зэрэг бохирдож болох зүйлсийг хамгаалах ба санамсаргүй байдлаар битум цацарч тэдгээрийг бохирдуулсан бол Инженерээс зөвшөөрсөн тохиромжтой аргаар сайтар цэвэрлэнэ. Гадаргууг энэхүү Техникийн шаардлагад заасны дагуу Инженерийн зөвшөөрөх хэмжээнд бэлтгэсний дараа битумыг түрхэнэ. Хэрэглэх битумыг энэхүү техникийн шаардлагад нийцүүлэн хамгийн багаар 500 литрийн багтаамжтай саванд жигд халааж бэлтгэнэ. Бэлтгэсэн талбайд битумыг 4 цагийн дотор түрхэж гүйцэтгэнэ. Битумыг гараар эсвэл зориулалтын машин ашиглаж түрхэнэ. Цацах буюу шүршихийг хориглоно.

Агаарын температур +10 C° –аас дээш, салхигүй, тогтуун нөхцөлд хийж гүйцэтгэнэ. Битумыг бороотой, цастай, манантай үед хийхийг хориглоно. Битумыг зурагт үзүүлсний дагуу хоолойн гадаргууд, суурийн дээд болон хажуу хэсэгт, хоолойн толгойн арын хэсэгт түрхэх ба далангийн материалаар буцаан дүүргэлт хийж өгнө. Түрхлэгийг хоёроос багагүй удаа давтан хийж гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч нь түрхлэг жигд хийгдэж буй эсэхийг шалгаж, бүх гадаргуу дээр түрхлэгийг жигд хийж гүйцэтгэнэ. Талбайн туршилтыг нэг хоолой дээр хийж туршиж үзнэ. Түрхлэгт ашиглагдах битумын хэмжээг Инженерийн зөвшөөрсөн хэмжээгээр хийж гүйцэтгэнэ.

1218. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

а) Зүйл: Хоолойн суурь цутгах нүх болон ус зайлуулах байгууламжийн жижиг хийцүүд, орох гарах амсрын нүх, жишүү шуудуу болон ус зайлуулах шуудууны сул хөрсний ухмал

Нэгж: м³

Хоолойн суурь цутгах нүх болон ус зайлуулах байгууламжийн жижиг хийцүүд, орох гарах амсрын нүх, жишүү шуудуу болон ус зайлуулах шуудууны сул хөрсний ухмалын хэмжих нэгж нь шоо метр байна.

Хоолой байрлуулах нүхний эзлэхүүнийг нүхний гүн ба өргөнөөр тооцсон хөндлөн огтлолын талбайг уртаар нь үржүүлж тодорхойлно. Бетон бөгж ба зузаалах хэсэгт ашиглах В15 ангийн бетоныг хэмжих нэгж нь шоо метр байна.

Бетоны эзлэхүүнийг бөгжний хөндлөн огтлолын талбайг бетон бөгж ба ус зайлуулах байгууламжийн жижиг хийцүүдийг барих нүхний эзлэхүүнийг тэдгээр байгууламжийн талбай болон нүхний дундаж гүний үржвэрээр тодорхойлно.

Хоолойн орох ба гарах амсар, жишүү шуудууны эзлэхүүнийг шуудууны тэнхлэгийн дагуу 10 м-ээс хэтрэхгүй зайд хэмжсэн хөндлөн огтлолын талбайг шуудууны уртаар үржүүлсэн үржвэрээр тодорхойлно. Ус зайлуулах шуудууны эзлэхүүнийг шуудууны тэнхлэгийн дагуу 10 м-ээс хэтрэхгүй зайд хэмжсэн хөндлөн огтлолын талбайг шуудууны уртаар үржсэн үржвэрээр тодорхойлно.

Ажлын талбайг эдгээр хязгаараас илүү гарган тооцох ёсгүй. Сул хөрсний ухмалын ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлыг тооцож оруулна. Үүнд:

- Тодорхой гүн хүртэл нүх ухах;
- Орох ба гарах амсар, жишүү шуудууны ёроол ба ханыг нэг шугам ба түвшинд тэгшлэх;
- Нүхний ёроол ба ханыг нягтруулах;
- Нүхнээс гарсан илүүдэл болон шаардлага хангахгүй материалыг зайлуулж, ашиглагдахгүй материалын талбайд зөөж овоолох;
- Уулын шуудууны доод талд нь шуудуунаас гарсан шороог далагнах;
- Бүх шаардлагатай тээвэрлэлт;
- Энэ техникийн шаардлагын бүлэг 1201, 1202, 1203, 1204, 1206, 1208, 1211, 1212, 1214, 1215 -д нийцэх зардлууд;

б) Зүйл: Шуудууны сул хөрсний ухмал

Нэгж: м³

Шуудууны орох ба гарах амсар буюу жишүү шуудууны суурийн зааварласан өргөн нь 2.5 м-ээс илүү байвал үүнийг шуудууны ухмал гэж ангилах ба энэ бүлгийн 1203-д заасантай адилаар тооцож, шоо метрээр хэмжинэ. Шуудууны сул материалын ухмалд дор дурдсан ажлын зардлууд орно. Үүнд:

- Тодорхой гүн хүртэл ухсан ухмал;
- Суурь ба ханыг нэг шугам ба түвшинд тэгшлэх;
- Ухмалын суурь ба ханыг нягтруулах;
- Ухмалаас гарсан илүүдэл материалыг зайлуулж ашиглагдахгүй материалын талбайд зөөж овоолох;
- Бүх шаардлагатай тээвэрлэлт;
- Энэ техникийн шаардлагын бүлэг 1201, 1202, 1203, 1204, 1206, 1215 -д нийцэх зардлууд

в) Зүйл: Хатуу материалд нүх ухах дэд зүйл 1217-(а), (б)-ийн нэмэлт

Нэгж: м³

Дэд зүйл 1205(в)-д дурдсан суурийн нүх ухахад тохиолдох хатуу материалыг шоо метрээр хэмжих ба эзлэхүүнийг нүхний тэнхлэгийн дагуу Инженертэй зөвшилцөж, тохиролцсон зайд хэмжсэн нүхний хөндлөн огтлолын талбайг хатуу материал ухсан хэсгийн уртаар үржүүлсэн үржвэрээр тодорхойлно. Хөндлөн огтлолын талбайг нүх ухахаас өмнөх хатуу материалын гадаргуугийн төвшин, ухсаны дараах нүхний ёроолын төвшингийн зөрүүг уртаар нь үржүүлж олно. Төлбөр хийх үүднээс 0.5 м³ –ээс том хэмжээний хатуу материалын эзлэхүүнийг машины тэвшний сул эзлэхүүний 50%-иар авна.

Хатуу материалын ухмалын дэд зүйлүүдийн үнэлгээг сул хөрсний ухмалын үнэлгээнд нэмэлт болгон оруулах ба аливаа гүний ухмал ба энэ техникийн шаардлагын бүлэг 1201, 1202, 1203, 1204, 1205, 1206, 1215 -тэй холбоотой зардлуудыг тооцож оруулна.

d) Зүйл: Уулын шуудуу

Нэгж: м

Уулын шуудууг барихад ашиглах хэмжилтийн нэгж нь урт метр байна. Уулын шуудууны уртыг зурагт үзүүлсний дагуу буюу шуудууны тэнхлэгийн дагуу хэмжсэн уртаар тооцно. Уулын шуудууг барих үнэлгээнд дор дурдсан ажлуудын зардал орно. Үүнд:

- Тодорхой гүн хүртэл ухсан нүх;
 - Шуудууны ёроол ба ханыг нэг шугам ба төвшинд тэгшлэх;
 - Шуудууны ёроол ба ханыг нягтруулах;
 - Зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварласны дагуу шуудуунаас гарсан шороог доод талд нь далагнах;
-
- Бүх шаардлагатай тээвэрлэлт;
 - Энэ техникийн шаардлагын бүлэг 1201, 1202, 1203, 1204, 1206, 1211, 1215 -д нийцэх зардлууд

e) Зүйл: Зохистой ширхэглэл бүхий дүүргэгч материал

Нэгж: м³

Буцаан дүүргэлтэд ашиглах зохистой ширхэглэл бүхий дүүргэгч материалын хэмжих нэгж нь шоо метр байна. Хоолойг буцааж дүүргэх эзлэхүүнийг хөндлөн огтлолын дундаж талбайг буцааж дүүргэх хэсгийн уртаар үржүүлсэн үржвэрээс хоолой ба бетон суурь, хийцүүдийн эзлэх эзлэхүүнийг хасаж тодорхойлно.

Буцааж дүүргэхэд ашиглах зохистой ширхэглэл бүхий дүүргэгч материалын үнэлгээнд дор дурдсан зардлууд багтана.

Үүнд:

- Материалын хангалт
- Тодорхой гүнд буцааж дүүргэх

f) Зүйл: Шүүрүүлэх үед ашиглах том ширхэглэлтэй материал

Нэгж: м³

Шүүрүүлэх үед ашиглах том ширхэглэлтэй материалын хэмжих нэгж нь шоо метр байна. Эзлэхүүнийг шүүрүүлэх үеийн хөндлөн огтлолын дундаж талбайг шүүрүүлэх үеийн уртаар үржүүлсэн үржвэрээр тодорхойлно. Хөндлөн огтлолын талбай нь том ширхэглэлтэй материалын өндрийг энэ стандартын дагуу тооцоолсон ухмалын өргөнөөр үржүүлж, хоолойн хөндлөн огтлолын талбайг хассантай тэнцүү байна.

Шүүрүүлэх үеийн том ширхэглэлтэй материалын үнэлгээнд дор дурдсан зардлуудыг тооцож оруулна.

Үүнд:

- Материалын хангалт;
- Тодорхой гүнд буцааж дүүргэх;
- Бүх шаардлагатай тээвэрлэлт;
- Энэ техникийн шаардлагын бүлэг 1201, 1202, 1204, 1206, 1211, 1212 -д нийцэх зардлууд.

г) Зүйл: 1.0 м-ийн голчтой төмөр бетон хоолойгоор хангах, суулгах ба холбох

Нэгж: м

1.0м-ийн голчтой төмөр бетон хоолойг нийлүүлэх, суулгах ба холбох хэмжилтийн нэгж нь урт метр байна. Хоолойн урт нь зурагт үзүүлсний дагуу буюу хоолойн тэнхлэгийн дагуу хэмжсэн уртаар тооцоологдоно.

1.0 м-ийн голчтой төмөр бетон хоолойг хангах, суулгах ба холбох үнэлгээнд хоолойг хангах болон энэхүү техникийн шаардлагын бүлэг 1201, 1207, 1208, 1209-д нийцэх зардлууд багтана.

h) Зүйл: 1.5 м-ийн голчтой төмөр бетон хоолойгоор хангах, суулгах ба холбох

Нэгж: м

1.5 м-ийн голчтой төмөр бетон хоолойг нийлүүлэх, суулгах ба холбох хэмжилтийн нэгж нь урт метр байна. Хоолойн урт нь зурагт үзүүлсний дагуу буюу хоолойн тэнхлэгийн дагуу хэмжсэн уртаар тооцоологдоно. 1.5м-ийн голчтой төмөр бетон хоолойгоор хангах, суулгах ба холбох үнэлгээнд хоолойгоор хангах болон энэхүү техникийн шаардлагын бүлэг 1201, 1207, 1208, 1209-д нийцэх зардлууд багтана.

и) Зүйл: 2 х 2 м-ийн дөрвөлжин төмөр бетон хоолой

Хэмжих нэгж: м³

- Төмөр бетон хоолойн их биений хэсэглэл суурин дээр цутгах В30
- Төмөр бетон хоолойн толгойны хэсэглэл цутгах В30
- Төмөр бетон хоолойн далбааны хэсэглэл цутгах В30
- Энэ техникийн шаардлагын бүлэг 1201, 1202, 1204, 1205, 1206, 1208, 1211, 1214, 1217-д нийцэх зардлууд

j) Зүйл: 2.5 х 2 м-ийн дөрвөлжин төмөр бетон хоолой

Хэмжих нэгж: м³

- Хоолойн суурийн ажил
- Хоолойн ул суурь нягтруулах
- Зохист ширхэглэл бүхийн элс хайрган хольцоор суурь байгуулах
- Бетон суурь байгуулах В15
- Төмөр бетон хоолойн хэсэглэл суурин дээр цутгах В30
- Төмөр бетон хоолойн толгойны хэсэглэл цутгах В30
- Төмөр бетон хоолойн далбааны хэсэглэл цутгах В30
- Энэ техникийн шаардлагын бүлэг 1201, 1202, 1204, 1205, 1206, 1208, 1211,1214,1217 -д нийцэх зардлууд

к) Зүйл: Бетон бөгж ба зузаалах хэсэгт ашиглах В15 ангийн бетон

Нэгж: м³

Зузаалах хэсгийн уртаар үржүүлсэн үржвэрээр тодорхойлно. Хөндлөн огтлолын талбайг зураг төсөлд үзүүлсэн буюу Инженерийн зааварласан хэмжээгээр авна.

Бетон бөгж ба зузаалах хэсэгт ашиглах В15 ангийн бетоны үнэлгээнд дор дурдсан зардлуудыг багтаана.

Үүнд:

- Бетон бөгжний үнэ;
- Зузаалах бетоны үнэ;
- Хэв хашмал ба тулгуур;
- Гадаргууг ердийн байдлаар засах.
- Энэ техникийн шаардлагын бүлэг 1201, 1202, 1204, 1205, 1206, 1208, 1210 -д

нийцэх зардлууд

Бетон цутгах ухмалын гадаргууг бэлдэж засахтай холбоотой ухмалын үнэлгээнээс давсан зардлуудад нэмэлт төлбөр хийгдэхгүй.

l) Зүйл: Ус зайлуулах байгууламжийн жижиг хийцүүдэд ашиглах В20 ангийн бетон

Нэгж: м³

Ус зайлуулах байгууламжийн жижиг хийцүүдэд ашиглах бетоныг хэмжих нэгж нь шоо метр байна. Бетоны эзлэхүүнийг зураг төсөлд үзүүлсэн буюу Инженерийн зааварласан хэмжээгээр тооцно.

Ус зайлуулах байгууламжийн жижиг хийцүүдэд ашиглах В20 ангийн бетоны үнэлгээнд дор дурдсан зардлуудыг багтаана.

Үүнд:

- Арматур
- Хэв хашлага ба тулгуур
- Гадаргууг ердийн байдлаар засах
- Энэ техникийн шаардлагын бүлэг 1201, 1202, 1204, 1205, 1206, 1214 -д нийцэх

зардлууд

Бетон цутгамал хийх ухмалын гадаргууг бэлдэж засахтай холбоотой ухмалын үнэлгээнээс давсан зардлуудад нэмэлт төлбөр хийгдэхгүй.

m) Зүйл: Чулуун бэхэлгээ

Нэгж: м²

Чулуун бэхэлгээний хэмжих нэгж нь хавтгай дөрвөлжин метр байна. Талбайг бэхэлгээ хийхээр Инженерийн зааварласан налуу дээр хэмжсэн цэвэр талбайгаар тодорхойлно. Чулуун бэхэлгээний үнэлгээнд дор дурдсан ажлууд орно.

Үүнд:

- Бэхэлгээ хийх гадаргууг бэлдэх;
- Ухмалын материалыг тогтоосон талбайд зайлуулах;
- Нэг шугам, түвшинд тэгшлэх;
- Ухмалын суурийг нягтруулах;
- Бэхэлгээний чулууг бэлтгэх, ачих, буулгах;
- Бүх шаардлагатай тээвэрлэлт;
- Энэ техникийн шаардлагын бүлэг 1201, 1202, 1204, 1205, 1206, 1214 -д нийцэх

зардлууд

п) Зүйл: Рисберм

Нэгж: м3

Рисбермийн хэмжих нэгж нь шоо метр байна. Рисбермийн эзлэхүүнийг зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсан хэмжээгээр тооцоолж гаргана. Рисберм хийх ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана.

Үүнд:

- Шуудууг ухах;
- Чулууг бэлтгэх, ачих;
- Шуудуунаас гарсан шороог тогтоосон хаягдал материалын талбайд зайлуулах;
- Шуудууны ёроолыг тэгшлэх;
- Рисбермийн чулууг өрөх;
- Бүх шаардлагатай тээвэрлэлт.

о) Зүйл: Шуудуунд зуурмагтай чулуун бэхэлгээ хийх

Нэгж: м²

Шуудуунд хийх зуурмагтай чулуун бэхэлгээний хэмжих нэгж нь хавтгай дөрвөлжин метр байна. Талбайг зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварласан хэмжээнээс тооцоолно.

Шуудуунд хийх зуурмагтай чулуун бэхэлгээний үнэлгээнд дор дурдсан ажлын зардал орно. Үүнд:

- Чулууг бэлтгэх ба ачих;
- Ажлыг хийхэд шаардлагатай ажиллах хүч, материал, багаж, тоног төхөөрөмж ба жижиг зардлуудын бүрэн төлбөр;
- Чулууг шуудууны ёроол ба хананд суулгах;
- Чулууны хоорондох завсар зайг зуурмагаар бөглөх;
- Бүх шаардлагатай тээвэрлэлт.
- Энэ техникийн шаардлагын бүлэг 1201, 1216-д нийцэх зардлууд багтана.

р) Зүйл: Ус тусгаарлагч үе хийх

Нэгж: м2

Ус тусгаарлагчийн хэмжих нэгж нь техникийн шаардлагад заасны дагуу метр квадрат байна. Ажлын хэмжээг бодохдоо ус тусгаарлагч хийгдсэн цэвэр өргөнийг тэнхлэгийн дагуу заагдсан уртаар үржүүлж гаргана.

Заагдсан хэмжээнээс илүү гарсан талбайд төлбөр хийгдэхгүй. Битумэн ус тусгаарлагчийн нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана.

Үүнд:

- Хэрэглэх материалыг бэлтгэх, тээвэрлэх ба тогтоосон хэмжээгээр хэрэглэх /цацах, шүрших/;
- Ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг тээвэрлэх;
- Огцом налуу газар ажиллах;
- Техникийн шаардлагын 1216-а болон бусад шаардлагад нийцүүлэх

қ) Зүйл: Бетон бэхэлгээ /шуудуу болон далангийн хажуу налуу/

Нэгж: м²

Бетон бэхэлгээг квадрат метрээр хэмжинэ. Бетон бэхэлгээ хийх газрын хэмжээг инженерийн зааварласнаар буюу ажлын зурагт өгөгдсөн хэмжээгээр тооцоолж бетон бэхэлгээг

хийнэ.

Бетон бэхэлгээнд дор дурдсан ажлуудын зардлыг оруулан тооцно. Үүнд:

- Ажиллах хүч, материал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж болон ажлыг бүрэн гүйцэд дуусгахад шаардагдах бусад зардлууд;
- Зөөж тээвэрлэхэд шаардлагатай зардлууд болон бусад;
- Зөвлөх болон гүйцэтгэгчтэй хамтран хэлэлцэж тохиролцсоны дараа эцсийн шийдвэрийг гаргах.

**БҮЛЭГ 1300 – ХИЙМЭЛ БАЙГУУЛАМЖИЙН
БЕТОНЫ АЖИЛ**

БҮЛЭГ 1300 –ХИЙМЭЛ БАЙГУУЛАМЖИЙН БЕТОНЫ АЖИЛ

1301. БҮЛГИЙН АГУУЛГА	13-4
1302.ТОДОРХОЙЛОЛТ	13-4
1303. МАТЕРИАЛ.....	13-13
1304. БЕТОН ХОЛЫЦЫН ОРЦЫН НОРМЫГ ТОГТООХ	13-17
1305. ТАЛБАЙН ТУРШИЛТ	13-18
1306. БЕТОНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ	13-22
1307. БЕТОНЫГ ХОЛИХ.....	13-26
1308. БЕТОН ХОЛЫЦЫГ ТЭЭВЭРЛЭХ.....	13-27
1309. БЕТОН ХОЛЫЦЫГ ЦУТГАХ.....	13-34
1310. БЕТОНЫГ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛӨӨС ХАМГААЛАХ	13-39
1311. БЕТОНЫГ НЯГТРУУЛАХ	13-22
1312. БЕТОНЫГ АРЧЛАХ.....	13-47
1313. АЖЛЫН ЗАЛГААС.....	13-27
1314. ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС	13-51
1315. УС ТОГТООГЧ	13-52
1316. ХЭВЛЭМЭЛ БУС ГАДАРГУУН ӨНГӨЛГӨӨ	13-56
1317. ХЭВЛЭМЭЛ ГАДАРГУУН ӨНГӨЛГӨӨ.....	13-58
1318. ТУЛАХ ТҮР БАЙГУУЛАМЖ БА ХЭВ ХАШМАЛ	13-68
1319. ӨТГӨН БА ШИНГЭН ЗУУРМАГ (ЦЕМЕНТИЙН УУСМАЛ БА ЗУУРМАГ).....	13-70
1320. БЕТОН ЦУТГАЛТЫН АЖЛЫН БҮРТГЭЛ.....	13-71
1321. СОГОГТОЙ БЕТОНЫГ ЗАСАХ	13-72
1322. БЕТОНД ХИЙХ АРМАТУР	13-78
1323. ӨӨР ХЭМЖЭЭНИЙ АРМАТУРААР ОРЛУУЛАХ	13-78
1324. УГСАРМАЛ ТӨМӨР БЕТОН.....	13-44
1325. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР	13-45

1301. БҮЛГИЙН АГУУЛГА

Энэ бүлэгт хиймэл байгууламжийн зориулалттай бетоны ажилд шаардагдах материал, орцын норм, холилт, тээвэрлэлт, дэвсэлт, нягтруулалт болон арчлалтын тухай заасан болно. Мөн бетоны хэв хашмал, арматурчлал болон угсармал хийцийн тухай заалтууд орсон байгаа.

1302. ТОДОРХОЙЛОЛТ

Хийцийн бетон гэж аль ч ангиллын, урьдчилан хүчитгэсэн болон хүчитгээгүй даацын бетоныг хэлнэ.

Хийцийн бус бетон гэдэг нь энэхүү техникийн шаардлагад нийцэх материалаас бүтсэн, зөвхөн нүх, зай завсрыг бөглөх, ул бетон болон бусад ачаалал ирдэггүй эд ангиудад хэрэглэх даацын бус бетоныг хэлнэ.

Хэвлэмэл гадаргуу гэдэг нь цутгамал бетоны хэвтэй харьцсан гадаргууг хэлнэ. Хэвлэмэл бус гадаргуу гэдэг нь хэвтээ буюу бараг хэвтээ байрлалтай, тараах тэгшлэх аргаар үүссэн гадаргууг хэлнэ. Ийм гадаргууд өнгөлгөө хийх шаардлагатай.

Цутгалт гэдэг нь аливаа хэв хашмал, тэвш гэх мэт эзлэхүүнд бетоныг шаардлагатай хэмжээнд хүртэл дүүргэхийг хэлнэ. Тулах түр байгууламж гэдэг нь хэв хашмал болон цутгасан бетоныг бэхжиж дуустал нь тулах даацын элементүүдээс бүтсэн байгууламж юм.

Хэв хашмал гэдэг бол цутгасан бетоныг бэхэжтэл нь шаардлагатай хэлбэрт барих түр буюу байнгын бүтэц юм.

Тогтворжилт буюу суулт гэдэг нь бетон хольцын урсах эсэргүүцлийг буюу өтгөрөлтийг хэлэх бөгөөд ихэнхдээ конусын суултын аргаар тодорхойлогддог. Тогтворжилтыг хэмжих өөр аргуудад нягтралын хүчин зүйл ба Вебе тогтворжилт хэмжигч ордог.

1303. МАТЕРИАЛ

(a) Ерөнхий

Гүйцэтгэгч нь бетонд ашиглахаар төлөвлөж байгаа материалын тухай бүрэн мэдээллийг Инженерт танилцуулна. Инженер бүх материалыг зөвшөөрөх хүртэл бетон дэвсэж болохгүй. Инженерийн зөвшөөрсөн материалыг солих буюу өөр материалаар орлуулж болохгүй.

(b) Цемент

Цемент нь MNS 974:2008, MNS 3091:2008, MNS EN 197:2018 стандартын техникийн шаардлага хангасан PC 42.5-62,5 болон CEM 42.5-62.5 ангиллын поргландцемент байна. Т хэлбэрийн дам нуруу болон хавтан дам нуруунд хэрэглэх бетон зөвхөн PC ангиллын цементийг хэрэглэнэ.

Цемент нь хялбар урсдаг, бөөгнөрөлгүй байх ба үйлдвэрлэгчээс хагарч урагдаагүй уутанд савласан буюу задгай байдлаар нийлүүлэгдэх ёстой. Ууттай цементийг тээврийн хэрэгслээр тээвэрлэхдээ цаг агаарын нөлөөнөөс сайтар хамгаалж тээвэрлэнэ.

Задгай цементийг тусгай зориулалтаар тоноглогдсон тээврийн хэрэгсэл эсвэл контейнерт хийж тээвэрлэнэ.

Ууттай цементийг цаг агаарын нөлөөнөөс хамгаалагдсан хуурай, байнгын агааржуулалттай байр саванд хадгална. Шал нь чийг орохоос хамгаалагдсан ба орчин тойрны газрын түвшнээс өндөр байна.

Ууттай цементийг авчрах бүрт нэг газарт хооронд нь нийлүүлж хурааж тавина. Ууттай цементийг агаарын солилцоо явагдах боломжийг нь багасгах зорилгоор нийлүүлж хураах ба харин гадна хананд ойр хурааж болохгүй. Хэрвээ тавиур дээр хурааж байгаа бол ууттай цементийг хураах, зөөх үед уутнуудыг урж гэмтээхгүйгээр тавиурыг бэлдсэн байх ёстой. Ууттай цементийг 1.8 метрээс өндөргүйгээр, өөр, өөр маркийн цементийг тус тусад нь хураана. Урагдсан ууттай цементийг ажилд хэрэглэхгүй. Ууттай цементийг тээвэрлэж, авчирсан дарааллаар нь хэрэглэнэ.

Задгай цементийг цаг агаарын нөлөөнөөс хамгаалагдсан агуулах, силост хадгалах бөгөөд цементийн төрлийг зааж тэмдэглэсэн байна. Өөр, өөр төрлийн цементийг өөр, өөр агуулах силост хадгална.

Гүйцэтгэгч нь барилгын ажилд цемент дутагдсанаас шалтгаалан зогсохоос сэргийлэн тээвэрлэлт, цаг агаарын нөхцөл, баяр амралтын өдрүүд зэрэг хүчин зүйлүүдийг тооцон талбай дээр хүрэлцэхүйц хэмжээгээр хадгалсан байна.

Гүйцэтгэгч нь хатуурсан, бөөгнөрсөн, эсвэл энэ техникийн шаардлагыг хангаагүй цементийг талбайгаас зайлуулна. Нэг бүтээцэд ашиглах цементийг нэг газраас авчирсан байна. Үйлдвэрлэгч буюу Гүйцэтгэгч ажилд хэрэглэх бүх цементийг Инженерийн зөвшөөрсөн лабораторид шинжилсэн байна. Шинжилгээг техникийн шаардлагын бүлэг 200-д заасны дагуу хийнэ. Гүйцэтгэгч шинжилгээ хийсэн гэрчилгээг 2 хувь үйлдэж Инженерт ирүүлнэ. Инженер шинжилгээний дүнг батлахаас нааш Гүйцэтгэгч нь талбайд цемент авчирч болохгүй.

Үйлдвэрлэгч буюу Гүйцэтгэгч нь үйлдвэр тус бүрээс үйлдвэрлэгдэж гараад нэгээс олон хоноогүй, шууд талбайд ирсэн цементийн дээжид шинжилгээ хийнэ. Мөн дээжийг Инженерийн зөвшөөрсний дагуу үйлдвэр тус бүрээс талбайд ирсэн цементийн 200 тн бүрээс авч шинжилгээ хийнэ. Цементийг талбайд татан авалт хийхээс өмнө физик, механик болон химийн шинж чанарын туршилтыг хийж, баталгаажуулсан байх шаардлагатай. Гүйцэтгэгч ажилд хэрэглэхээр талбайд хүргэгдсэн цементийн үйлдвэрлэгч, ирсэн өдөр, шинжилгээ болон юунд хэрэглэсэн тухай мэдээллийг байнга бүртгэж Инженерт 2 хувь ирүүлнэ.

Талбайд 42 хоногоос удаан хадгалсан цементийг Инженерийн заавраар зөвшөөрөгдсөн лабораторид дахин шинжилгээнд оруулна.

Энэхүү техникийн шаардлагад нийцээгүй цементийг ажилд хэрэглэж болохгүй ба ийм цементийг Гүйцэтгэгч талбайгаас зайлуулна.

(с) Чулуун материалд тавигдах ерөнхий шаардлага

Материалын эх үүсвэрийг Инженерээр батлуулсан байна.

Инженерийн ажилд хэрэглэж болохгүй гэж үзсэн чулуун материалыг Гүйцэтгэгч талбайгаас нэн даруй зайлуулна. Чулуун материалыг талбайд цэвэр бөгөөд тохиромжтой машинаар тээвэрлэж авчирна. Өөр хэмжээ буюу ширхэглэлтэй материалыг нэг машинаар авчирч болохгүй.

Чулуун материалыг Инженерийн зөвшөөрсөн эх үүсвэрээс авсан усаар угааж цэвэрлэнэ. Усны хангалт, хадгалалтыг Гүйцэтгэгч хариуцна. Чулуу угаасан усыг гол ба гадаргуугийн усны бусад эх үүсвэр лүү шууд хийж болохгүй. Ашигласан шавартай усыг Инженерийн зөвшөөрсний дагуу дараах аргаар зайлуулна. Үүнд:

- хээр газар руу шахаж тараах;
- нүх ухаж шахах;
- бохирын хоолой руу хийх;
- тогтонги ус руу шахах;
- шүүлтүүрээр шүүх.

Чулууг хэмжээ болон ширхэглэл бүрээр ангилан бага зэрэг налуу бетон шалтай тасалгаануудад тус тусад нь хадгална. Тасалгаануудын хоорондох тусгаарлагч хана нь чулуу хоорондоо холилдохгүй байхаар үргэлжилсэн, хангалттай хэмжээтэй байна. Овоолсон чулуу ширхэглэлээр ялгарахгүй байх талаар Гүйцэтгэгч арга хэмжээ авна. Чулууг хэвтээ үеэр хураах ба овоолгын өндөр 1.5 м-ээс өндөргүй байна. Холих үед чийгийн агуулга нь гэнэт өөрчлөгдөхөөс сэргийлэхийн тулд чулуун овоолго нь ус тогтдоггүй, амархан урсдаг байхаар байна. Нойтон чулуун материалыг Инженер сайн хатсан гэж тодорхойлохоос нааш Гүйцэтгэгч ажилд хэрэглэж болохгүй. Гүйцэтгэгч чулуун материалын чийгийн агууламжийг тогтмол хэмжиж, холилт бүрт чулуун материал болон усны хэмжээг чулуун материалын чийгийн агууламжийг харгалзан тохируулна. Гүйцэтгэгч чулуун материалыг цаг агаарын нөлөөнөөс хамгаална.

(d) Жижиг ширхэглэлт чулуун материал

Жижиг ширхэглэлтэй чулуун материалд цэвэр, хатуу ба бөх, байгалийн гаралтай элс, буталсан хайрган элс эсвэл AASHTO M6 стандартад тохирох буталсан чулуун элс орно. Бүх чулуулаг материал нь 9,5 мм-ийн шигшүүрээр өнгөрөх ёстой бөгөөд (хүснэгт 13-1)-т үзүүлсэн ширхэглэлийн найрлагатай тохирсон байна. Материалын шаардлагатай ширхэглэлийг гаргаж авахын тулд материалыг нэгээс дээш эх үүсвэрээс хольж авч болно.

Жижиг ширхэглэлтэй чулуун материал нь төмрийн хольцгүй эсвэл төмрийн исэлд ороогүй байна. Мөн шаврын гялтгануур, нарийн ширхэглэлт чулуу, нүүрс бусад ялтаслаг бодис, зөөлөн эсвэл сийрэг ба органик материалуудыг агуулаагүй байна.

Аливаа 2 шигшүүрийн дунд үлдсэн жижиг ширхэглэлийн чулууны хэмжээ 45 %-иас хэтрэхгүй.

Хүснэгт 13-1: Портландцемент бүхий бетоны жижиг ширхэглэлт
чулууны ширхэглэлийн хязгаар

Шигшүүрийн хэмжээ	Шигшүүрээр өнгөрсөн жингийн хувь	
	Даац багатай бетон	Даацын бетон
9.5 мм	100	100
4.75 мм	95 - 100	95 - 100
1.18 мм	45 - 80	45 - 80
300μм	10 - 30	5 - 30
130μм	2 - 10	0 - 10

Жижиг ширхэглэлт чулуун материал нь техникийн шаардлагын зүйл 1031-ийн шаардлагыг хангасан байна.

(e) Том ширхэглэлт чулуун материал

Том ширхэглэлт чулуун материал нь зүйл 1030-ийн шаардлагыг хангасан буталсан чулуу, буталсан хайрга буюу тэдгээрийн холимог байна. Материал нь төмрийн шүлт, төмрийн гялтгануур, нүүрс, ялтаslag бодис, зөөлөн буюу сийрэг ба органик материалуудыг бетоны шинж чанарт нөлөөлөхүйц хэмжээгээр агуулаагүй байна.

Бетонд хэрэглэх чулуун материалын хамгийн том хэмжээ хийцийн бетонд 20 мм, хийцийн бус бетонд 40 мм байна. Том ширхэглэлт чулуун материалын ширхэглэлийн хязгаар (хүснэгт 13-2)-т үзүүлсэнтэй ижил буюу ойролцоо байна.

Хүснэгт 13-2: Портландцемент бүхий бетоны томширхэглэлт чулууны ширхэглэлийн хязгаар

Шигшүүрийн хэмжээ	Шигшүүрээр өнгөрөх жингийн хувь		
	Чулууны хэмжээ		
	10 мм	20 мм	40 мм
50 мм	-	-	100
37.5 мм	-	-	95 -100
25.0 мм	-	100	65 - 85
19.0 мм	-	90 - 100	35 - 70
12.5 мм	100	55 - 80	25 - 50
9.5 мм	85-100	20 - 55	10 - 30
4.75 мм	10-30	0 - 10	0 - 5
2.36 мм	0-10	0 - 5	
1.18 мм	0-5		

Аливаа 2 шигшүүрийн дунд тунаж үлдсэн жижиг ширхэглэлийн чулууны хэмжээ 45 %-иас хэтрэхгүй.

(f) Чулуун материалын шинжилгээ

(1) Зөвшөөрөл авах шаардлагатай шинжилгээ

Аливаа бетоны ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч чулууны дээжийг Инженерт өгнө. Гүйцэтгэгч дээжүүдийг AASHTO T2 стандартын дагуу бэлдэж, жижиг ширхэглэлт чулуунаас 50кг-ас доошгүй, том ширхэглэлт чулуунаас 100кг-аас доошгүй байхаар бэлдэж, Инженерийн шаардсан бусад дээжүүдийн хамт Инженерт ирүүлнэ.

Дээж бүрт эх үүсвэрийг тодорхой заасан хаяг нааж AASHTO T2 стандартад тодорхойлсон бусад мэдээллийг хавсаргана.

Гүйцэтгэгч материалыг техникийн шаардлагын 1303 (в)-(д) дэд зүйлүүдтэй нийцэж байгаа эсэхийг шалгах шинжилгээг Инженерийн зөвшөөрсөн лабораторид гүйцэтгэнэ. Хэрэв урьд нь зөвшөөрөгдсөн материал шаардлага хангахгүй байгаа нь илэрвэл уг материалыг хэрэглэхийг түр зогсоож, Гүйцэтгэгч ба Инженерийг байлцуулан шинжилгээг дахин хийнэ. Шинжилгээний дүнг үндэслэн материалыг зөвшөөрөх эсэхийг шийднэ.

Хэрэв 3-аас доошгүй дараалан хийсэн шинжилгээний дүн шаардлагад нийцвэл материалыг зөвшөөрнө.

(2) Байнга хийгдэх шинжилгээнүүд

Гүйцэтгэгч нь барилгын ажлын явцад чулуун материал нь техникийн шаардлага болон төслийн чанарын хяналтын төлөвлөгөөтэй нийцэж байгаа эсэхийг хянаж, өдөр тутмын шинжилгээ хийж байх ёстой. Өдөр бүр талбайд ирж байгаа чулуунаас эх үүсвэр тус бүрээр дээж авч иж бүрэн шинжилгээ хийнэ. Хайрга, дайрганы шинж чанарыг Инженерээр батлуулсан чанарын хяналтын төлөвлөгөөнд тусгагдсан давтамжийн дагуу (500-1000м³) тутамд Ингэхдээ чулууны дээж тус бүр нь 250 тн-оос багагүй жижиг ширхэглэлт чулуу, 500 тн-оос багагүй том ширхэглэлт чулууг төлөөлсөн байх ба чулуу нь нэг жигд чанарын үзүүлэлттэй байх ёстой.

Хэрэв чулууны шинж чанар өөр өөр байгаа бол шинжилгээний давтамжийг Инженер тодорхойлно.

Ширхэглэл	AASHTO T27
Хэврэгшлийн индекс	BS 812
Уян налархай хэсгүүд	AASHTO T176
Чийгийн агууламж	Түргэн тодорхойлогч ("Speedy") аппарат
Органк бодисын агууламж	AASHTO T21
Элэгдэх чанар	MNS 2998:2009
Үзүүрлэг, хавтгай хэсгийн хэмжээ	MNS 2998:2009
Ус шингээлт	MNS 2998:2009
Хувийн жин асгаасан нягт	MNS 2998:2009

Дээр дурдсан өдөр тутмын шинжилгээнүүдээс гадна гүйцэтгэгч дор заасан шинжилгээнүүдийг хийнэ.

Үүнд:

- Чийгийн агууламж: бетоны чийгийн агууламжийг техникийн шаардлагад заасны

дагуу хянахад шаардагдах давтамжаар.

- Хлорын агууламж: чулуулаг материал дахь хлорын харьцааг техникийн шаардлагын 1303-р дэд зүйлийн (d) ба (e)-д заасан хязгаар дотор барихад шаардлагатай давтамжаар.

Хэрэв хлорын агууламж өөр өөр гарч байвал Гүйцэтгэгч бетоныг бохирдуулдаг хлорын хэмжээг хэтрүүлэхгүйн үүднээс талбайд авчирсан чулууны ачаа бүрийг шинжилж үзэх шаардлагатай байж магадгүй. Ийм зориулалтаар Гүйцэтгэгч хариу нь шууд гардаг Куантаб (Quantab)-ын түргэвчилсэн аргыг хэрэглэж болох юм. Хэрэв энэ аргаар гаргасан дүнгийн талаар маргаан гарвал материалын хлорын агууламжийг BS 812 (Volhard-ын арга)-ын дагуу лабораторид тодорхойлно.

(g) Бетон хольцод хэрэглэх ус

Бетон хольц болон бэхжилтэд хэрэглэх ус нь тос, хүчил, шүлт, сахар, давс, органик бодис болон бусад сөрөг нөлөөтэй бодис агуулаагүй цэвэр байна. Бетон хучлагад хэрэглэх ус нь MNS 3821:85, ГОСТ 23732-2011 (Бетон болон барилгын зуурмагт хэрэглэх ус. Техникийн шаардлага-Вода для бетонов и строительных растворов. Технические условия) стандартын техникийн шаардлагыг хангасан байна. Ус нь зүйл 1033(g)-д заасан үзүүлэлтийг хангаж байх ёстой.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Техникийн шаардлагын үзүүлэлт
1	Усны өнгөний ялгарал	°C	≤ 70
2	Усны шүлтийн агууламж	pH	4-12.0
3	Усны исэлдэлд	мг/л	< 15
4	Усан дахь уусдаг хог хаягдлын агууламж	%	< 4
5	Усны үнэр	балл	< 2
6	Сулфатын ион	SO ₄	< 500
7	Хлорын ион	Cl ⁻	< 350

(h) Нэмэлт бодисууд

Техникийн шаардлагатай нийцүүлэх буюу бетон хольц цутгахад нэмэлт бодис ашиглахыг Гүйцэтгэгч санал болгож болно. Нэмэлт бодисыг ашиглахаас өмнө Инженерээр батлуулсан байна. Инженер өөрөөр заагаагүй бол агааржуулагч бодисыг бетоны хүйтэнд тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хэрэглэж болно. Гүйцэтгэгч бетон хольцод хэрэглэх гэж буй нэмэлт бодисын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, мөн яаж хэрэглэх тухай ажлын аргачлалаа Инженерт танилцуулна. Үүнд:

(1) Нэг удаагийн тун, тунлах арга, илүү тунгаар ашигласан тохиолдолд гарах сөрөг үр дагавар;

(2) Нэмэлтэд орох гол элементүүдийн химийн нэр томьёо;

(3) Жингийн хувиар илэрхийлэгдсэн хлорын агууламж;

(4) Үйлдвэрлэгчийн гаргасан зааврын дагуу хэрэглэхэд агааржуулах үйлчилгээ үзүүлэх хэмжээ;

(5) Нэмэлтийг урьд өмнө Монголд хэрэглэж байсан туршлага.

Бетон хольцод ашиглах буй химийн нэмэлтүүд нь “Бетоны химийн нэмэлт. Техникийн шаардлага MNS ASTM C 494-2011”, бетонд агаар оруулах нэмэлтэд тавигдах техникийн шаардлага ASTM C260 зэрэг стандартын шаардлагыг хангасан байх шаардлагатай. Нэмэлт бодисын үйлчилгээг Гүйцэтгэгч өөрийн хээрийн лаборатори болон бетон зуурмагийн үйлдвэрт Инженерийн хяналтан дор туршилтын хольц хийж туршиж үзнэ. Нэмэлт бодисууд нь бетоны шинж чанарт ямар ч сөрөг нөлөө үзүүлэх ёсгүй.

1304. БЕТОН ХОЛЬЦЫН ОРЦЫН НОРМЫГ ТОГТООХ

Хүснэгт 13-3: Цилиндр болон шоон дээжний 28 дахь өдрийн бат бэхээр илэрхийлсэн бетоны анги

Бетоны анги	Бетоны марк	Бат бэхийн үзүүлэлт	
		Цилиндр дээж, мм	Шоон дээж, мм
		(150x300)	150x150x150
B15	M200	15 МПа	20 МПа
B20	M250	20 МПа	25 МПа
B25	M350	25 МПа	32 МПа
B30	M400	30 МПа	38 МПа
B35	M450	35 МПа	45 МПа
B40	M550	40 МПа	51 МПа
B50	M600	50 МПа	64 МПа

(b) Ус/цементийн хамгийн их харьцаа

Барилгын ажилд хэрэглэх бетоны марк болон анги ус цементийн харьцаатай шууд холбоотой. Дараах хүснэгтэд (хүсн.13-4) ус цементийн харьцаанаас хамаарч бетоны авах бат бэхийн хэмжээг үзүүлэв. Бетоны анги өндөр байх тусам ус цементийн харьцааг бага байлгавал зохино. Үүний тулд бетоны химийн нэмэлтийг ашиглаж болно.

Хүснэгт 13-4: Бетоны бат бэх болон ус/цементийн харьцаа

Ус/Цемент	Бетоны бэхжилт, (хон.дараа)
-----------	-----------------------------

	1	3	7	28	90	360
0,4	0,24	0,48	0,70	1	1,15	1,38
0,5	0,17	0,43	0,66	1	1,19	1,47
0,6	0,11	0,37	0,64	1	1,21	1,55
0,7	0,08	0,33	0,64	1	1,35	1,67

(с) Бетоны орцыг төсөллөх

Гүйцэтгэгч нь бетон хольцын орцыг тогтоохдоо Инженерийн зөвшөөрсөн бүрэлдэхүүн материалаар дараах шаардлагад нийцүүлэн тодорхойлно. Үүнд:

(1) Чулуун материал нь хамгийн том тооцоот хэмжээнээс 130 мкм хүртэл ширхэглэлийн нарийн хуваарьтай байна.

(2) Бетоны бат бэхийг хангахад шаардлагатай цементийн хамгийн бага агуулга хүснэгт 13-5-д үзүүлсний дагуу байна. Бүтээцийн хэсгүүдийн ил гаралтын төвшинг Инженер тодорхойлно.

Хүснэгт 13-5: Цементийн хамгийн бага агууламж

Хийцийн төрөл	Цементийн хамгийн бага агууламж (нягтруулсан бетоны 1м ³ ногдох кг)
Энгийн бетон	300
Хүчитгэсэн бетон	400

(3) Бетон хольц нь арматур болон бусад бэрхшээлийг үл харгалзан цутгах болон нягтруулахад хялбар байхаар өтгөн байна,

(4) Агааржуулагч бодисыг хүснэгт 13-6-д үзүүлсэн агаарын агууламжийг хангах хэмжээгээр бетонд нэмж холино.

Хүснэгт 13-6: Хүйтэнд тэсвэртэй чанарыг хангах агаарын агууламж

Чулууны заагдсан хамгийн их хэмжээ	Агаарын агууламж
40 мм	5.5 %
20 мм	6.0 %
10 мм	7.5 %

(5) Ус цементийн харьцаа нь хольцтой ажиллахад хялбар байх нөхцөлийг хангахад шаардлагатай хамгийн бага хэмжээтэй, гэхдээ чулуун материал ус агуулдгийг харгалзан хүснэгт 13-4-д үзүүлсэн хэмжээнээс ихгүй байна,

(6) AASHTO T160 стандартын дагуу тодорхойлсон бэхэжсэн бетоны уртын өөрчлөлт 0.05%-аас илүүгүй байна,

(7) Цемент, ус ба нэмэлт бүхий хольцын хлорын ионоор илэрхийлэгдсэн хлорын нийт агууламж нь хольц дахь цементийн жингийн хувиар илэрхийлэгдсэн дараах хязгаараас хэтэрч болохгүй.

- Уураар бэхжүүлсэн бетон буюу сульфатад тэсвэртэй цемент агуулсан бетонд жингийн 0.05 %,

- бусад хүчитгэсэн бетонд: бүх туршилтын 95%-д 0.3%(0.5%-ээс дээш дүн гараагүй бол)

(8) Цемент, ус ба нэмэлт бүхий хольцын SO_3 -р илэрхийлэгдсэн сульфатын нийт агууламж чулууны жингийн 0.4%-иас ихгүй, ба цементийн жингийн 4.0%-иас хэтрэхгүй байна.

Хүснэгт 13-3-д Барилгын ажлын бетон цутгах ажлыг талбайд эхлэхээс 56 хоногийн өмнө Гүйцэтгэгч бетоны анги, марк болон өтгөрлийн түвшин тус бүрээр ИНЗ-д заасан бетоны ангиудын дагуу (хүснэгт 13-3) орцын норм боловсруулж Инженерт танилцуулна.

Орцын нормын төлөвлөгөө нь дараах мэдээллийг агуулсан байна.

Үүнд:

- Цементийн ангилал,
- Цементийн хэмжээ, кг/ м³,
- Чулууны ширхэглэлийн хуваарь,
- Норгоод хатаасан чулууны жин, кг/м³ ,
- Хольц дахь нийт усны хэмжээ, кг/м³ үүний дотор зуурах ус, нэмэлт дэх ус, чулуун материал дахь ус (норгоод хатаасан чулууны ус орохгүй),
- AASHTO T119-ийн дагуу хэмжсэн бетоны тооцоот суулт,
- Агааржуулагч бодисын үйлдвэрлэгчийн нэр, 1 м³ –д орох тун,
- Агаарын агууламжийн хязгаар,
- Зөөлрүүлэгч, тусгаарлагч бодис болон бусад нэмэлт бодисуудыг үйлдвэрлэгч ба, тэдгээрийн 1 м³ –д орох тун.

1305. ТАЛБАЙН ТУРШИЛТ

Бетон хольцын орцын нормыг Инженер баталсны дараа бетоны зэрэглэл тус бүрээр туршилтын хольцыг хийхээр бэлдэнэ. Гүйцэтгэгч талбайн туршилтыг барилгын ажилд ашиглахаар төлөвлөж байгаа завод дээр гурван удаа зууралт хийхээр зөвшөөрөгдсөн материалаа бэлдэнэ. Нэг удаагийн зууралтад орох материалын хэмжээ нь заводын бүрэн хүчин чадлаар ажиллуулахад орох хэмжээтэй ижил байна. Зууралт тус бүрээс дээж авч дараах тур шинжилгээнүүдийг хийнэ.

Үүнд:

- AASHTO T119 стандартын дагуу бетоны суултыг шалгах,

- Зууралт бүрээс 6 ширхэг шоо авч BS 1881 дагуу туршилт хийнэ,
- Зууралт бүрээс 6 ширхэг дээж авч 7 болон 28 хоног дахь бетоны бат бэхийн туршилт хийнэ,
- Бат бэхийн туршилт хийхээс өмнө бүх шооны нягтыг тодорхойлно,
- AASHTO T160 стандартын дагуу тодорхойлсон бетон бэхэжсэний дараах уртын өөрчлөлт 0.05 %-иас ихгүй байна.

Инженер зөвшөөрвөл бетоны суултыг тодорхойлогч конусын оронд бетоны хатуурлыг тодорхойлдог төхөөрөмжийг ашиглаж болно. Энэ тохиолдолд бетоны суулт ба хатуурлын илтгэлшүүрийн хоорондох харьцааг талбайн туршилт хийх явцад тодорхойлж өгнө.

Бетон шооны 28 дахь өдрийн дундаж бат бэх (хүснэгт 13-4)-д үзүүлсэн дундаж бат бэхээс багагүй байх ба нэг ч шооны бат бэх (хүснэгт 13-4)-д үзүүлсэн дундаж бат бэхээс 3 МПа-аас доогуур байж болохгүй. Хэрэв 28 хоногийн бат бэх дээр дурдсан бэхжилтээ авч чадаагүй бол тухайн өдрийн зуурмагаас авч хийсэн хийцүүдийг шаардлага хангаагүй тооцож, Инженерийн зааварчилгаагаар талбайгаас зайлуулна (БНБД 32-02-00 2010-07). Чанарын шаардлага хангаагүй (шинжилгээгээр нотлогдсон) хийцийг буулгах, дахин хийх ажлыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

Талбайн туршилтууд техникийн шаардлагын заалтуудыг бүрэн хангасан тохиолдолд туршилтын зууралтын орцыг тухайн ангилал болон өтгөрлийн зэрэгтэй бетоны орцын нормоор батална. Бетоны тусгай зэрэглэл дэх шаардлагыг хангаж байгаа төлөвлөсөн хольцыг зөвшөөрөгдсөн хольц гэх бөгөөд бетоны зэрэглэлийг тодорхойлсон үед Гүйцэтгэгч зөвхөн зөвшөөрөгдсөн хольцыг хэрэглэх ба Инженер бичгээр зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд хольцыг хэрэглэхгүй. Хэрвээ Гүйцэтгэгч материал, материалын эх үүсвэр болон материалын харьцаанд өөрчлөлт оруулахаар төлөвлөж байгаа бол Инженерээс урьдчилсан зөвшөөрөл авч, талбайн туршилт болон бүх холбогдох туршилтыг хийж, Инженерт танилцуулж зөвшөөрөл авна. Гэрээний дагуу гүйцэтгэгч ажлын хөтөлбөртөө туршилтын хольцыг бэлтгэх, талбайн туршилт хийх ба туршилт хийх дээжийг бэлтгэх зэрэг ажлуудыг оруулна.

1306. БЕТОНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ

(а) Дээж авах

Цаашид энэхүү техникийн шаардлагын болон BS 1881-д дурдсан аргачлалын дагуу барилгын ажилд ашиглагдах бетоны ангилал болон өтгөрөлтийн түвшин бүрээр хольц бэлтгэх үед буюу Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөнд заагдсан буюу Инженерийн зааварчилсан үед дээж авна. Дээж бүрээс 150 мм-ын хэвээр 6 ширхэг шоо хэвлэж, бэхжүүлээд 3 шоонд 7 хоног дахь, 3 шоонд 28 хоног дахь бетоны бат бэхийн туршилтыг BS 1881 Хэсэг 3-ын дагуу хийнэ. Дээж бүрийг сонгож авсан нэг зууралтаас таамгаар авах ба дээж бүр нь 50 м³ -аас ихгүй бетоныг төлөөлнө.

Инженер өөрөөр заагаагүй бол бетон хольц нь техникийн шаардлагатай нийцэж буй эсэхийг тогтоотол нэг дээж 20 тн-оос илүүгүй бетон төлөөлж байхаар шинжилгээг явуулна. Хиймэл байгууламжийн ажлын хийцлэл тухай бүрт дээж авч, 7, 28 хоногийн бат бэхийг тодорхойлно.

Гүйцэтгэгч дээж авах, шоо цутгах, арчлах, бэхжүүлэхэд Инженерийг байлцуулах ба хэрэв байлцуулаагүй бол тухайн шоо нь чанарын хяналтын туршилтад тэнцэхгүй гэж үзнэ.

(b) Шинжилгээ хийх

(1) Өтгөрөл

Бетоны суулт ба хатуурлын илтгэлцүүрийг Инженерийн зааварчилсан давтамжаар зууралт бүрт тодорхойлно. Бүх зууралтын бетоны суулт зуурч буй нь талбайн туршилтаар тогтоогдсон хэмжээнээс 20мм-ээс буюу аль их байгаа хэмжээний гуравны нэгээс илүүгээр зөрж болохгүй. (Бетоны суулт талбайд механик аргаар зууралт хийж байгаа үед 3-6 см, үргэлжилсэн ажиллагаатай үйлдвэрт тохируулсан үед 7-16 см байж болно).

Бетоны суултын оронд хатуурлын илтгэлцүүрийг ашигласан бол хатуурлын илтгэлцүүр нь дараах хязгаарт хэлбэлзэнэ:

- 0.9 түүнээс дээш ± 0.03
- 0.8 - 0.9 ± 0.04
- 0.8 ба түүнээс доош ± 0.05

(2) Ус/цементийн харьцаа:

Аливаа зууралтаас авсан дээжийн (1)-д гарсан дүнгээс тооцсон ус/цементийн харьцаа нь талбайн туршилтаар тогтоосон хэмжээнээс 5-аас илүү хувиар өөрчлөгдөх ёсгүй.

(3) Агаарын агууламж

Агааржуулах нэмэлт бодис хийсэн бол бетонд хольцын агаарын агууламж нь дэд зүйл 1304 (в) (5) -ийн 13-6-р хүснэгтэд үзүүлсэн хэмжээнээс 1.5 хувийн дотор хэлбэлзэх ба дараалсан дөрвөн хэмжилтийн дундаж үзүүлэлт нь заагдсан хэмжээний 1.0 хувийн дотор хэлбэлзэнэ (шинэхэн зуурсан хольцын эзлэхүүний хувиар илэрхийлэгдэнэ). Туршилтыг AASHTO T196 дагуу явуулна.

(4) Хэврэгшлийн индекс

Том ширхэглэлтэй буталсан чулууны хэврэгшлийн индекс нь батлагдсан хольцын чулууны дундаж үзүүлэлтээс 5-аас илүүгүй нэгжээр зөрж болох ба хэрэв ингэснээр хольцын хөдөлгөөнт чанарт сөргөөр нөлөөлбөл талбайн туршилтыг эхнээс нь дахин хийнэ.

(5) Бетон шоог шахалтад турших

Шооны шахалтын бат бэхийг BS 1881 бүлэг 4-ийн дагуу тогтооно.

Шооны шинжилгээний дүнг зөвшөөрөгдсөн маягт дээр үзүүлэх ба дараах мэдээллийг агуулсан байна.

Үүнд:

- шооны дугаар,
- шооны хэмжээ ба жин,
- шоог бэлтгэсэн огноо,
- шоог хийсэн бетоны ширхэглэл
- тухайн хийцийн бетоноос дээж авсан байршил,
- бетоны суулт,
- шоог туршсан огноо,
- туршилтын явцад хагаралтын үеийн нийт ачаалал,
- туршилтын явцад хагаралтын үеийн нийт даралт, МПа.

Дээр дурдсан мэдээллийг агуулсан гэрчилгээг 3 хувь үйлдэж 2 хувийг Инженерт

явуулж, 1 хувийг лабораторид үлдээнэ.

(с) Шооны туршилт хүчинтэй байх

Бетоны нэг зууралтаас авсан гурван шоог 28 дахь хоногт шинжлэхэд гарсан шахалтын бат бэхийг дунджаар тооцно. Хэрвээ гурван шоог туршиж үзэхэд шахалтын бат бэх нь тэдний дундаж шахалтын бат бэхийн 3МПа-аас бага байгаа тохиолдолд л туршилтыг хүчинтэйд тооцно.

Дээр дурдсан туршилтын хүчинтэй дүн гаргал техникийн шаардлагын дэд зүйл 1306 (г)-д тодорхойлсон хяналтын аргыг хэрэглэхдээ 28 дахь хоногийн бетоны бат бэхийг авч үзэх ба энэхүү тохиолдолд туршилтын бүх дүн бат бэхийн жишиг үзүүлэлтээс 3 МПа-аас бага байж болохгүй. Харин их бие, томоохон хийц эдлэлүүдийн дараалсан гурван туршилтын дундаж бат бэх нь бат бэхийн жишиг үзүүлэлтээс 2 МПа-аар их буюу түүнээс дээш байх шаардлагатай.

Хэрэв дараалсан гурван туршилтын дундаж бат бэх нь бат бэхийн жишиг үзүүлэлтээс 2 МПа-аар их байж чадахгүй хэдий ч бат бэхийн жишиг үзүүлэлтэй ядаж тэнцүү байвал ийм бетоныг зөвшөөрч болох боловч Гүйцэтгэгч орцын норм болон хяналтын стандартад тохируулга хийх хэрэгтэй. Инженер зөвшөөрвөл 7 хоног дахь бат бэхийг бат бэхийн эхний үзүүлэлт гэж үзэж болох юм.

(d) Бетоны бат бэхийг зөвшөөрөх шалгуур үзүүлэлтүүд

Ямар ч зэрэглэлийн, гэхдээ ижил өтгөрөлттэй бетоноор аливаа нэг зуурагчид зуурсан 30-аас доошгүй дараалсан зууралтын туршилтын дүн бүгд хүчинтэй гарвал бетоны дундаж бат бэх нь [бат бэхийн жишиг үзүүлэлт + 1.7х тэдгээрийн нормын хэлбэлзэл]-тэй тэнцүү байх ба шоо бүрийн бат бэх нь бат бэхийн жишиг үзүүлэлтийн 3МПа-иас их байна.

(e) Шаардлага хангаагүй туршилтууд

Хэрэв дараалсан гурван туршилтын аль нэгийн бат бэх нь бат бэхийн жишиг үзүүлэлтийн 3МПа-иас бага байгаа боловч энэ гурван туршилтын дундаж бат бэх техникийн шаардлагын дэд зүйл 1306 (в) буюу (г)-д заасан шаардлагад нийцэж буй бол зөвхөн нормд хүрээгүй шоо авсан зууралтыг шаардлага хангаагүйд тооцно. Шаардлага хангаагүй дээжинд нотолгоог үйлдэж, Инженер өөрийн эрх мэдлийн хүрээнд уг бетоныг хэвээр үлдээж болно.

Хэрэв дараалсан гурван туршилтын хоёрынх нь дүн бат бэхийн жишиг үзүүлэлтийн 3МПа-аас их байгаа буюу дундаж бат бэх нь бат бэхийн шаардлага хангаагүй бол гурван зууралтыг бүгдийг шаардлага хангаагүйд тооцож Гүйцэтгэгч нэн даруй Инженерийн зөвшөөрөлтэйгөөр орцын нормыг өөрчлөх арга хэмжээ авч, техникийн шаардлагын зүйл 1305-д нийцүүлнэ.

Гүйцэтгэгч шаардлага хангахгүй байгаа бетоныг сайжруулах талаар зохих арга хэмжээг авна. Үүнд:

- хяналтын туршилт амжилттай болтол туршилтын давтамжийг нэмэгдүүлэх,
- бетоноос өрөмдлөгөөр дээж авч AASHTO T24-стандартын дагуу турших,
- бетоныг бэхжүүлэх болон бусад сайжруулах арга хэмжээ авах,
- дам нуруун дээр ачаалал өгч эвдэхгүй туршилт хийх
- бетоныг солих буюу авч зайлуулах.

Хэрэв бетоноос дээжлэн авсан гурван дээжний шахалтын бат бэхийн үзүүлэлт

хоорондоо 85%-иас их зөрүүтэй байж болохгүй.

1307. БЕТОНЫГ ХОЛИХ

Гүйцэтгэгч хэрэглэх гэж байгаа тоног төхөөрөмжөө захиалах буюу талбайд авчрахаас өмнө өөрийн хэрэглэхээр төлөвлөсөн бетоныг зуурах, холих, тээвэрлэх, цутгах, нягтруулах ба тэгшилж засах зэрэг ажлууд болон авах арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Инженерт танилцуулна.

Бетоныг гараар зуурч болохгүй. Хэрвээ Инженер өөрөөр заагаагүй бол ажилд хэрэглэгдэх бетоныг нэг буюу түүнээс дээш төвлөрсөн, үргэлжилсэн үйл ажиллагаатай үйлдвэрүүдэд зуурч, холино. Хэрвээ Гүйцэтгэгч бэлэн хольсон бетон хэрэглэхийг хүсвэл уг бетон хольцын талаарх бүх мэдээлэл болон хийсэн шинжилгээний дүнгийн хамт Инженерт танилцуулж, зөвшөөрөл авна. Бетоны хольц дараах шаардлагыг хангасан тохиолдолд Инженер бэлэн хольц хэрэглэхийг зөвшөөрнө. Үүнд:

(a) тухайн хольцод ашиглах материал болон хадгалах ба зуурах аргачлал нь энэхүү техникийн шаардлагатай нийцэж байгаа,

(b) зуурах үед зохих хяналт тавих нөхцөл бүрдсэн

(c) бэлэн зуурмаг нь AASHTO M157 стандарт, (хүснэгт 13-4)-д шаардлагыг хангасан.

Хэрэв Инженер хольцод хэрэглэж буй материал, хольцын чанарын үзүүлэлт болон зууралтад тавьж байгаа хяналт хангалтгүй байна гэж үзвэл бэлэн зуурмаг хэрэглэхийг зогсоож болно. Зуурах ба холих завод нь орчин үеийн AASHTO M241-ийн жигдрэлийн шаардлагыг хангасан, нэгэн жигд өтгөрөлттэй бетоныг үйлдвэрлэж гаргах чадалтай байна.

Холигч машин нь BS 4251-ын шаардлагыг хангасан байх ба Инженерээс урьдчилан зөвшөөрөл авсан тохиолдолд л хэрэглэнэ. Бүх холих, зуурах ажиллагааг туршлага бүхий хяналтын ажилтнаар хянуулна. Чулуу хадгалах бункерүүд нь ус гадагшлуулах тоноглолтой байх ба гадагшлах ус нь жинлэх тасалгаа руу орохгүй байх арга хэмжээ авсан байна. Бункер бүрийг долоо хоногт нэгээс доошгүй удаа суллаж, тэнд хуримтлагдсан шавар, тоос шороо, бохирдлыг зайлуулна.

Цемент ба чулууг жинлэж хэмжинэ. Усыг жингээр буюу эзлэхүүнээр хэмжиж болно. Шингэн нэмэлтийг цахилгаан хяналттай шингэн хэмжигчээр хэмжин хийнэ. Жинлэх төхөөрөмжүүдийг байнга арчилж байх хэрэгтэй. Тэдгээрийн нарийвчлалыг AASHTO M241-т өгөгдсөн зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах ба Инженер шаардсан үед жин ба эзлэхүүний нарийвчлалыг байнга шалгаж байна.

Цемент, ус, нэмэлт ба чулуун материалын ширхэглэл бүрийн жин нь хүснэгт 13-7-т өгөгдсөн зөвшөөрөгдөх зөрүүгийн хэмжээнд байна.

Хүснэгт 13-7: Бетон хольцын орцын зөвшөөрөгдөх зөрүү

Материалын нэр	Орцын зөвшөөрөгдөх зөрүү, жингийн хувиар
Цемент	0-ээс + 4
Жижиг чулуу	-2-оос + 2

*ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН-ӨМНӨДЭЛГЭР ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС
БИНДЭР ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ТӨСӨЛ*

Том чулуу	-2-оос + 2
Нэмэлт	-2-оос + 3
Ус	-1-ээс + 1

Гүйцэтгэгч нь жин болон бусад хэмжилтийн туслах хэрэгслүүдийн найдвартай ажиллагааг шалгахдаа стандартын хамгийн хүнд ачаалал авдаг жин дээр хамгийн их ажлын ачааллаар жинлэж шалгана.

Шалгалтыг долоо хоногт нэгээс доошгүй удаа буюу Инженерийн зааварчилсан давтамжаар Инженерийг байлцуулан гүйцэтгэнэ. Энэ зорилгоор ажилтнууд жинлэх бункерт хялбар хүрч, ажиллах бололцоотой байх ёстой. Гүйцэтгэгч дээрх шалгалтын дүнг хоёр хувь үйлдэж инженерт хүргүүлнэ.

Цаашид техникийн шаардлагын дагуу найдвартай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор Гүйцэтгэгч жинлэх болон ус хэмжих төхөөрөмжийн шаардлагатай тохиргоо болон засвар үйлчилгээг хийнэ.

Жинлэж хэмжсэн материалыг холигч руу оруулах явцад салхи буюу бусад нөлөөллөөр жингийн алдагдал гаргахгүй байх аргаар холигчид хийнэ. Гүйцэтгэгч жигд өтгөн хольц үйлдвэрлэхэд шаардлагатай материалыг зуурагчид хийх хамгийн тохиромжтой арга болон дарааллыг талбайн туршилтаар тогтооно.

Холигчийг хүрд болон тогооны тооцоот хүчин чадлаас хэтрүүлж ачаалж болохгүй. Эргэлтийн хурд ба зуурах хугацааг үйлдвэрлэгчийн зааврын дагуу тохируулах боловч хэрэв усыг хамгийн сүүлд хийж байгаа бол ус хийсний дараа 1-ээс доошгүй минут хутгана. Материал сайн холилдож хольц нэгэн жигд өнгө өтгөрөлттэй болтол зуурна.

Зуурагч нь хэдэн зууралт хийснийг харуулдаг автомат тоолуураар тоноглогдсон байх шаардлагатай.

Хольцод нэмэх усыг том ба жижиг ширхэглэлтэй чулуунд агуулагддаг сул усны хэмжээгээр хасна. Энэ хэмжээг Гүйцэтгэгч Инженерийн зөвшөөрсөн аргаар өдөр бүр хольцыг зуурч эхлэхийн өмнө, зуурч байх явцад цагт нэг удаа мөн зууралтын явцад чулуун материал авчирч буулгах бүрт тодорхойлно. Техникийн шаардлагын дагуу тодорхойлсон хэмжээний усыг хольцод нэмж хийсний дараа холих үеэр ч, дараа нь ч ус нэмэхгүй.

Гүйцэтгэгч бетоны суулт техникийн шаардлагын 1306 (б) (1) дэд зүйлд заасан хүлцэх алдааны хүрээнд байхаар бүх шаардлагатай чийгийн тохиргоог хийнэ.

Зууралт дууссаны дараа холигчийг дараагийн зууралтын материалыг хийхээс өмнө сайтар суллана. 30-аас илүү минут сул зогссон холигчийг шинэ материал хийхээс өмнө сайтар цэвэрлэж дуусаад эхний зууралтын том ширхэгтэй чулуун материалыг ердийн зууралтынхаас 2 дахин бага хэмжээгээр хийж зуурна. Зууралтыг ердийнхөөс 1 минут илүү гүйцэтгэнэ.

Цементийн маркийг өөрчилж байгаа бол холигчийг шинэ материал хийхээс өмнө сайтар цэвэрлэнэ. Холигчийг угаасан усыг гол ба гадаргуун бусад усны эх үүсвэр рүү шууд хийж болохгүй. Ашигласан усыг техникийн шаардлагын 1303 (в) дэд зүйлд заасны дагуу

Инженерийн зөвшөөрсөн аргачлалаар зайлуулна.

1308. БЕТОН ХОЛЬЦЫГ ТЭЭВЭРЛЭХ

Гүйцэтгэгч бетон хольцыг зуурч байгаа газраас цутгах газарт нь хүргэж, тээвэрлэхдээ бетон бохирдох, хатах, материал ялгарах буюу урсахаас сэргийлэх бөгөөд бетоныг цутгаж эхлэхэд хольц хөдөлгөөнт чанараа алдаагүй байна. Бетон хольцыг явуут дундаа эргэлддэг битүү тэвш бүхий зориулалтын миксерээр зөөнө.

Холигчоос цутгалт хийх талбай руу тээвэрлэх явцад бетоны суултын хэмжээ 25мм-ээс илүүгээр багасаж болохгүй бөгөөд тээвэрлэх хугацаа аль болох богино байх ёстой ба түрүүчийн бетоны цутгалт болон нягтруулалт дуусахаас өмнө очсон байх ёстой. Хоцорч ирсэн бетоныг барилгын ажилд хэрэглэхийг зөвшөөрөхгүй.

Хольц ирэх хоорондын хугацаа 20 минутаас хэтрэхгүй байх ба хэвлэж буй бетон нь нэгэн жигд цутгамал байж, хийцийн дотор аливаа хүйтэн заадас гарахаас сэргийлнэ. Тээвэрлэлтийн явцад бетоныг нар, салхи, борооны сөрөг нөлөөллөөс хамгаалсан байх ёстой. Бетон хольцыг саяхан цутгасан шинэ бетоны хажуугаар буюу дээгүүр тээвэрлэж болохгүй.

1309. БЕТОН ХОЛЬЦЫГ ЦУТГАХ

(а) Цутгах зөвшөөрөл

Инженер бичгээр зөвшөөрөл өгтөл аливаа бетоны ажлыг эхэлж болохгүй. Гүйцэтгэгч нь бетон цутгах гэж байгаа тухайгаа 24 цагийн өмнө Инженерт бичгээр мэдэгдэнэ. Бетон цутгаж эхлэхээс өмнө цутгалт хийх талбайгаас өмнөх цутгалтын ажлаас үлдсэн хольцын үлдэгдэл болон бусад гаднын материал, хогийг гаргаж зайлуулна. Инженер зөвшөөрөл өгснөөс хойш 24 цагийн дотор бетон цутгах ажлыг эхлүүлнэ. Хэрэв Гүйцэтгэгч энэ хугацаанд цутгалтыг эхэлж чадахгүй бол Инженерийн зөвшөөрлийг хүчингүйд тооцож, Гүйцэтгэгч дахин зөвшөөрөл авна.

(b) Бетон дэвсэх гадаргууг бэлдэх

Бетон цутгах нүхийг энэ техникийн шаардлагын дагуу бэлдэнэ. Нүхэнд тогтсон усыг шуудуу татах буюу бусад тохирох аргаар зайлуулна. Гүйцэтгэгч шинээр цутгасан бетон болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг угаагдахаас хамгаална.

Ухмалын ёроолоос доош хийгдсэн аливаа ус зайлуулах хоолой буюу нүхийг шаардлагагүй болмогц Инженерийн зөвшөөрсөн аргаар бөглөж, шавардсан байна. Хуучин бетон гадаргууд шинэ бетон цутгахаас өмнө дараах арчлалтыг хийнэ.

Үүнд:

- Хуучин бетон гадаргууг чулуун материалыг нь ил гартал нугардаггүй хялгасан шүүрээр угаана.
- Хуурай, чулуун материал нь ил гарсан гадаргуу дээр шинэ бетон цутгана.
- Гадаргуу нь цэвэр, хатуу, хуурай ба бат бэх байна.

Хэрэв угаах явцад гадаргуун хагарлууд цэвэрлэгдэж ил гарвал тэдгээрийг шавар буюу бетон зуурмагаар дүүргэж бөглөнө. Нэг удаад дүүргэх зуурмагийн хэмжээг гадаргууд бетон дэвсэхэд дүүргэсэн зуурмаг хатаагүй байхаар тааруулна.

(с) Цутгах ажиллагаа

Бетон цутгах төлөвлөгөө батлагдмагц дэвсэх дарааллыг уг төлөвлөгөөтэй уялдуулна. Бетон цутгахад ашиглах бүх тоног төхөөрөмж нь сайн чанарын хийц, хүчин чадал бүхий байх ба хольцод материалын ялгарал үүсгэхээргүй ажиллана. Эдгээр тоног төхөөрөмж нь шинэ тавьсан бетоныг доргиож гэмтээхээргүй байна.

Мөн дээрх тоног төхөөрөмж нь бетоной урвалд орох хөнгөн цагаан материалаар хийсэн эд ангитай байж болохгүй. Дэвсэх төхөөрөмжид наалдсан хольцын аливаа үлдэгдлийг дараагийн цутгалт хийхээс өмнө цэвэрлэж зайлуулсан байна.

Бетон насоснууд үргэлжилсэн горимоор бетоныг нэгэн жигд урсгалаар, дундаа агаарын зай гаргалгүй шахаж ажиллана. Шахалт дууссаны дараа насосны хоолойд үлдсэн хольцыг шинэхэн дэвссэн гадаргууг бохирдуулалгүйгээр шахан гаргах хэрэгтэй.

Гүйцэтгэгч бетоныг 1,5 м-ээс дээш гүнд чөлөөт уналтаар цутгаж болохгүй. Чөлөөт уналтын өндрийг 1,5м-ээс доош болгох үүднээс уян хошуу хэрэглэнэ. Холигч машинд суурилуулсан байдаг хоолойноос өөр хоолойг хэрэглэхийг зөвшөөрөхгүй.

Хана, багана ба бусад нимгэн бөгөөд нэлээд өндөр хэсгүүдийг цутгахдаа бетоны төвшинээс дээш гарсан хэв хашмал ба арматур дээр хатуурсан бетон хуримтлагдах болон бетоны ялгарал үүсэхээс сэргийлж хэв хашмалд нээхийг гаргаж өгнө.

Хамгийн эхэнд цутгах бетоны чулуун материалын хэмжээ ердийнхөөс 2 дахин бага байна. Бетон хольцод цемент хольсноос хойш 2-оос хэтрэхгүй цагийн дараа цутгаж бэхжүүлнэ. Гүйцэтгэгч хольцод ус нэмж бетоныг шингэлж болохгүй.

Тэвэрлэх явцад хагас хатуурсан бетоныг ажилд хэрэглэхгүй. Бетоныг түүнийг цутгах газартай аль болох ойр авчирна. Бетоныг цутгахдаа материалын ялгарал үүсгэхгүй, хэв, арматур болон бусад суулгаж тогтоосон зүйлсийн байрлалыг өөрчлөлгүйгээр гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч хэвэнд цутгасан бетоныг хүрээр хутгах ба доргиураар хөдөлгөж болохгүй.

Гүйцэтгэгч нь бетон цутгах болон нягтруулах ажлыг гүйцэтгэх ажилчдаас бүрдсэн тусгай багийг ажиллуулна. Инженер өөрөөр заагаагүй бол бетоныг үе үеэр, бүтээцийн залгаасын хавтгайтай бараг параллелиар, 500мм-ээс илүүгүй зузаантай дэвсэнэ. Эдгээр үеүд нь буталсан чулууны хамгийн том ширхэглэлийн хэмжээг 4 дахин авсан хэмжээнээс нимгэн байж болохгүй.

Үеүдийн ирмэгийг тэгш гаргаж өгнө. Гүйцэтгэгч хийцийн хэсэг бүрийн бетоныг цутгахдаа зурагт үзүүлсэн хийц болон хэв гажилтын заадсын хооронд зогсолтгүйгээр үргэлжлүүлэн цутгана.

Хүргэлтийн хугацаа, дэвсэх дараалал ба аргачлал нь хүйтэн залгаас үүсэхээс сэргийлсэн байх ба ямар ч тохиолдолд урьд хийсэн, бэхжиж эхэлсэн материал дээр шинэ бетон хийхгүй. Бетоныг ямар ч залгаасгүй нэгэн жигд цутгамал үүсгэн тасралтгүй ажилбараар цутгана.

Бетоныг суурь дахь аливаа саад, гадаргуун гэмтлийг тойруулан бүх хэсгүүд нь ижил нягтрал авч чадахаар нямбай цутгана. Мөн угсарсан арматур, ган төмрүүд болон бетон

цутгасны дараа бетоны гадаргуугаас дээш гарах бусад хийцүүдийг тойруулан нямбайлан цутгах хэрэгтэй.

Цутгалт бүрийн бетоны бүх ажлыг бетон бэхжиж эхлэхээс өмнө дуусгасан байх ёстой. Бетоныг цутгах үед болон цутгаж дууссаны дараа бетоны гадаргууг гэмтээхгүй байх, арматур төмрийг зангилааг хугалахгүй байх талаар анхаарах хэрэгтэй.

Ажилчид шинэ тавьсан бетон дээр гишгэж болохгүй бөгөөд болон тоног төхөөрөмжид зориулсан тавцанг арматур төмөртэй хамт бэхэлж болохгүй. Бетоныг бэхжиж эхэлснээс хойш бетон гүйцэд сайн хатууртал бетоноос цухуйж гарах хэв болон арматур төмрийг хөдөлгөхийг хориглоно.

(d) Усан дор бетон цутгах

Усан дор буюу эрдэс шаврын дор бетон цутгах шаардлагатай бол Гүйцэтгэгч цутгах аргачлал болон ашиглах тоног төхөөрөмжийн талаарх саналаа Инженерт танилцуулна. Бетон хольцыг гарах амсартаа таглаа бүхий юүлүүр хэлбэртэй хоолойгоор, эсвэл бетоноор дүүргэх үед ус орохоос хамгаалсан тоноглол бүхий хоолойтой бетон шахагчаар цутгана. Бетон дамжуулах хоолой нь хэд хэдэн хэсгээс залгагдаж бүтсэн, ус нэвтэрдэггүй хоолой, оройдоо юүлүүртэй 250мм-ээс доошгүй голчтой, мөн ус нэвтэрдэггүй резинэн цагираг зэргээс бүрдэнэ.

Хоолойн гарах үзүүрийг нийт цутгах талбайд чөлөөтэй хөдөлгөх боломжтой ба хольц өгөх хурдыг огцом багасгах буюу зогсоох тоноглолтой байна. Хоолойг бетоноор дүүргэхээс өмнө ус орохоос сэргийлж гарах амсрыг хаалттай байлгана.

Хоолойг юүлүүрийн ёроолын төвшин хүртэл байнга бетон хольцоор дүүргэсэн байх ба бетоны устай харьцах талбайг аль болох багасгах үүднээс үзүүрийг бетон хольцод дүрсэн байна. Хэрэв бетон цутгаж эхэлсний дараа хоолой руу ус орвол хоолойг гарган авч суллаад гарах амсрыг дахин бөглөнө. Үүний дараа хоолойг шинэ хольцоор дүүргэж, ус руу дүрнэ. Цутгаж дуустал хольцын урсгалыг тасалж болохгүй.

Бетон шахаж байх үед дамжуулах хоолойн гарах амсар хольцоор үргэлж дүүрэн байх ба цутгалт дуустал хоолойн гарах амсрыг цутгаж буй бетонд дүрсэн чигт нь байлгана.

Аль ч нөхцөлд бетонд ялгарал үүсгэхгүй байх талаар анхаарах ёстой. Усан дор цутгах бетоны цементийн хэмжээ нь усанд угаагдсан алдагдлыг нөхөх үүднээс тухайн марк ба өтгөрөлттэй ердийн бетоноос 10 хувиар илүү байна.

Усан дор буюу эрдэс шаврын дор дэвссэн бетоныг дараах аргаар нягтруулна.

Үүнд:

(1) Бетон дамжуулах хоолойг хольцоор дүүргэхийн өмнө хоолойны ёроолд шилээгүүр доргиурыг оруулна,

(2) Хоолойн амсрыг хаана

(3) Бетон хольцыг юүлүүр рүү хийж хоолойг дүүргэх явцад доргиурыг хоолой дахь бетоны бүх агаарыг хөөж гаргахаар удаан сугалж авна,

(4) Доргиурыг, юүлүүрээс хоолой руу шинэ хольц өгөхөд дамжуулах хоолойн хана руу доргилт өгөлгүйгээр хольцоос агаарыг гаргах боломжтой тийм байрлалд байрлуулна,

(5) Цутгалт үргэлжлэх явцад зууралт хооронд хэт их доргилт өгөхгүйн тулд доргиурыг асааж унтраан зохицуулна.

(6) Бетоныг насосоор шахаж цутгах үед насос руу орсон бетоныг ижил аргаар нягтруулна.

Усан дор буюу эрдэс шаврын дор бетон цутгахдаа тасралтгүй үргэлжилсэн ажилбараар гүйцэтгэх ба цутгаж буй гадаргууг аль болох хэвтээ хэлбэрээр гаргана.

Насос болон хоолойнуудын гарах амсрын орчин тойрны усыг хөдөлгөөнгүй, тогтонги байлгана. Бетоны үеүдийг хооронд нь сайн барьцалдуулах үүднээс эхний үе бэхжиж эхлэхээс өмнө дараагийн үеийг цутгах хэрэгтэй.

Гүйцэтгэгч их хэмжээний хольцыг цутгахад энэ шаардлагыг хангахад хүрэлцэхүйц тооны машин тоног төхөөрөмжтэй байх ёстой. Хэрэв усан дор бетон цутгах үед буюу цутгаж дууссаны дараа цутгасан газрыг хүрээлсэн усыг шавхаж гаргах нь шинэ цутгасан бетоны гадаргууд сөргөөр нөлөөлөх бол ус шавхаж болохгүй.

Бетон цутгах ба бэхжүүлэх явцад гидростатик даралтыг тэнцвэржүүлж, бетон руу ус орохоос хамгаалах зорилгоор ус нэвтэрдэггүй, дотроо хуурай бөгөөд хөндий камер оруулна.

Техникийн шаардлагын зүйл 1306-д заасан туршилтад тавигдах шаардлагаас гадна Гүйцэтгэгч цутгалт хийснээс 7 хоногийн дараа бетоноос Инженерийн заасан цэгт хоёр дараалсан дээж өрөмдөж авна.

Дээжийг бетоны нийт зузаанаар өрөмдөж авах ба өрөмдлөгөөс гарсан нүхийг сайтар бөглөх арга хэмжээ авна. Дээж 50мм-ээс доошгүй голчтой байна.

Багана буюу тулгуур бүрийг хэт авианы багажаар шалгана. Хэрэв бетоны бат бэх шаардлага хангахааргүй байвал Инженер дахин өрөмдлөгөөр дээж авч нийт цутгалтын чанарыг шалгахыг шаардаж болно.

Гүйцэтгэгч нийт хийцийг даралтат хольцоор засах, хэврэг бетоныг зайлуулах буюу Инженерийн баталсан бусад аргаар засварлана. Дээж авах, туршилт шинжилгээ хийх, бат бэхийн шаардлага хангаагүй бетоныг засварлах, дээж авсан нүхийг бөглөх зэрэг ажлыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

(е) Цутгалтыг зогсоох

Хэрвээ бетоны ажил ямар нэг шалтгаанаас болж зогссон ба хэр зэрэг удаан зогсох нь тодорхойгүй буюу удаан зогсохоор бол Гүйцэтгэгч тэгш бус гадаргуу болон өнцөг үүсгэхгүй тулд ажлын залгаасыг яаралтай хийх арга хэмжээ авна.

Дэвссэн бетоныг техникийн шаардлагын зүйл 1311-ийн дагуу сайтар нягтруулна. Бетоны бүх ажлыг бетоныг налархай байхад нь амжиж хийж дуусгах ба дараа нь түүнийг ямар нэг эвдрэлийг эсэргүүцэх чадвартай болж хангалттай хатуурах хүртэл нь гар хүрэхгүй орхино.

Ийм тохиолдолд ашиглах машин тоног төхөөрөмж байнга бэлэн байх ёстой. Ийм зогсолтын дараа бетоны ажлыг дахин эхлэхэд Гүйцэтгэгч бүх эвдэрсэн буюу нягтруулагдаагүй бетон, барзгар ирмэг, эсвэл бусад тохиромжгүй зүйлсийг хуулж авч зайлуулаад, шинэ бетон хийх цэвэр, бат бэх гадаргууг техникийн шаардлагын 1309 (б) дэд зүйлийн дагуу бэлдэнэ.

Бетоны бүх ажлын турш туршлага бүхий хэв болон арматурын ажилчдыг ажиллуулна. Эдгээр ажилчид нь хэв хашмалыг техникийн шаардлагад нийцүүлэх, ажлын түр залгаасуудыг зөв гаргах, арматур төмрүүд ба бэхэлгээнүүдийг зөв байрлуулах зэргийг хариуцна.

Инженерийн зөвшөөрөлтэйгөөр техникийн шаардлагад нийцүүлэн бетоны ажлыг дахин эхлүүлэх боломжтой болбол ямарваа хүйтэн залгаас гаргалгүйгаар шинэ бетоныг хуучин бетон дээр цутгаж нягтруулна.

Бетоныг дараахь нөхцөлд цутгалт хийхийг хориглоно.

- Агаарын температур буурч байгаа үед +8°C-ээс доош байвал
- Агаарын температур өсч байгаа үед +5°C-ээс доош байвал

(f) Цутгах хэмжээ

Инженерээс өөрөөр заагаагүй бол цутгалтын өндөр 2м-ээс илүүгүй байна. Бетоныг цутгах нийт талбайд жигд зузаантайгаар цутгалтын нийт өргөнөөр цутгана. Гүйцэтгэгч цутгалтын хэмжээ болон дарааллыг дулааны өөрчлөлт буюу агшилтын улмаас хагарал үүсэхгүй байхаар төлөвлөх хэрэгтэй.

(g) Цутгах дараалал

Гүйцэтгэгч хэрэв бололцоотой бол бүтээцийн нэг хэсэг дэх босоо элементүүдийн цутгалтын хоорондох хугацааг ижил байлгах арга хэмжээ авна. Энэ хугацаа нь Инженер өөрөөр заагаагүй бол цаг агаарын таатай нөхцөлд 3-7 хоног байна.

Хэрэв Инженер бетоны агшилтын улмаас ажлын залгаасыг багасгахыг шаардвал шинэ бетон хольцыг 21 хоног болоогүй гадаргууд дэвсэхгүй. Хэрэв зурагт ажлын залгаас хийхээр үзүүлсэн бол тэдгээрийн өргөн ба урт нь зурагт үзүүлсний дагуу байх ба зурагт заасан хугацааг өнгөртөл тэдгээрийг дүүргэж болохгүй.

1310. БЕТОНЫГ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛӨӨС ХАМГААЛАХ

(a) Ерөнхий

Гүйцэтгэгч бетоныг хийх, арчлах явцад цаг агаарын ба орчин тойрны нөлөөллөөр эвдрэл үүсэхээс хамгаалж урьдчилсан сэргийлсэн арга хэмжээ авна. Цаг агаарын нөлөөллийн улмаас бетон хөлдсөн буюу эвдэрсэн тохиолдолд Инженерийн зөвшөөрөх хэмжээнд хүртэл засах буюу хуулан авч шинээр цутгана.

Бетоныг цутгаж эхлэхийн өмнөх температур нь техникийн шаардлагад өөрөөр заагаагүй бол 10°C-32°C-ын хооронд байна. Гүүрийн хавтангийн бетоныг дэвсэх үеийн температур нь 27°C байна.

(b) Борооноос хамгаалах

Хэрэв Инженерийн үзэж байгаагаар ширүүн буюу удаан орох бороо нь шинэ бетоны ил гарсан гадаргуугийн том ширхэгтэй чулууг угаан урсгаж болзошгүй байвал, Гүйцэтгэгч, хэрвээ цутгасан бетоны гадаргуу дээрх усыг зайлуулах буюу ус цугларахаас хамгаалж чадахааргүй бол бетон дэвсэх ажлыг зогсооно. Бетоныг ус тогтсон хэсгүүдэд буулгахгүй.

(c) Халуун агаараас хамгаалах

Хэрвээ орчны температур 32°C-ээс дээш байвал хэв хашмал, арматур төмөр, төмөр дам нуруу ба шинэ бетоной шууд харьцах бусад гадаргууг 32°C-ээс доош температуртай болтол нь ус шүрших буюу бусад зөвшөөрөгдсөн аргаар хөргөнө.

Бетоныг дэвсэх үеийн температурыг тогтоосон температурын хэлбэлзэлд барихад доорх аргуудыг хослуулан хэрэглэнэ. Үүнд:

- Материал хадгалах газрыг сүүдэрлэх,
- үйлдвэрийн төхөөрөмжийг сүүдэрлэх,

- чулуун материалыг ус шүршиж хөргөх,
- чулуун материалыг болон усыг хөргөгчид хийж хөргөх, эсвэл хольцод хийх усны заримыг буюу бүгдийг нь жижиглэж буталсан мөсөөр орлуулах,
- шингэн нитроген цацах.

Хуурайшил ихтэй нөхцөлд болон Инженерийн зааварчилсан үед шинэ бетон гадаргуугийн чийг ууршихаас сэргийлж доорх аргуудыг хослуулан хэрэглэнэ. Үүнд:

- тохирох материалаар бүтээх,
- нарны хаалт хэрэглэх
- салхинаас хамгаалах
- ус цацаж гадаргууг чийгтэй байлгана.

Инженер бетон дэвсэхийг хойшлуулж, өдрийн арай сэрүүн үед хийхийг шаардаж болно.

(d) Хүйтэн нөхцөлөөс хамгаалах

(I) Холих ба цутгах

Инженер шаардсан үед гүйцэтгэгч талбайд халуун, хүйтэн хэмжигч 2 термометрийг суурилуулна.

Доорх нөхцөлд бетоныг халаалт ба хөлдөлтөөс хамгаалалгүйгээр цутгаж болохгүй:

- ✓ агаарын температур буурч байгаа үед 7°C-аас доош байвал
- ✓ агаарын температур өсөж байгаа үед 3°C-доош байвал

Агаарын температур 5°C-аас доош байвал 300 мм зузаан бетоны цутгах үеийн температур 15°C-аас доош байж болохгүй. Агаарын температур ямар байгааг үл харгалзан мөстэй буюу хөлдсөн хэсгүүдтэй чулууг зууралтад оруулж болохгүй ба 0°C буюу түүнээс доош температуртай аливаа гадаргуу дээр бетон дэвсэхгүй.

Хэрвээ бетон дэвсэх үеийн орчны температур хасах хэмтэй байна гэж Инженер үзэж байвал, Гүйцэтгэгч ус ба чулуун материалыг халаах арга хэмжээ авна. Бетоныг цутгаж дууссаны дараа бүтэн 8 өдрийн турш хөлдөхөөс сэргийлж хамгаална. Дүүргэгчийг 20°C- 65°C, усыг 55°C- 65°C хэмд халаана.

Бетоны хольцын температур нь хэвэнд цутгах үед 15°C- 25°C хэмийн хооронд байна. Халаагч төхөөрөмж нь чулууг хэт халуун цэгүүд үүсгэлгүй нэгэн жигд халаах ёстой. Халаагч төхөөрөмж болон байр нь цутгалт дууссанаас хойш бүтэн 5 өдрийн турш шинэ бетоны орчны температурыг 20°C-30°C-ийн хооронд барих тоноглолоор хангагдсан байх ёстой.

Дараачийн гурван өдөрт бетоны температурыг 5°C хүртэл хөргөнө. Халаагч төхөөрөмжийг хэв хашмал ба бетон гадаргууг шууд халаахгүй байхаар байрлуулна. Агаарын температур 15°C-ээс доош байвал бетоныг гадаа цутгаж болохгүй бөгөөд түр байр дотор холигчоо оруулж цутгалт хийнэ.

Хэрэв холигч байрны гадна байх шаардлагатай бол хольцыг түр байрны бүтээлгийг цоолж суулгасан бункерээр дамжуулан цутгах байр луу өгнө. Агаарын температур 15°C-ээс дээш байвал гүйцэтгэгч түр байрны жижиг хэсгийг богино хугацаанд онгойлгож цутгалтын ажлыг гүйцэтгэж болно.

Орчны хасах хэмийн температурт бетон дэвсэхээс өмнө Гүйцэтгэгч, халаах төхөөрөмжийн ажиллагааг шалгах зорилгоор 20°C хүртэл халааж бетоны ажил эхлэхээс өмнө 24 цагийн турш энэ дулааныг хадгална. Гүйцэтгэгч халаах төхөөрөмж болон бүх шаардлагатай түлшээр хангана.

(2) Эхний арчлалт

Гүйцэтгэгч цутгасан бетоноо хуурайгаар арчлахаар төлөвлөж байгаа бол байран доторх чийгшлийг хангах ба бетоныг хуурайшлаас хамгаалах арга хэмжээ төлөвлөж Инженерээр батлуулна.

Хэрэв халаах төхөөрөмж нь утаа буюу хий ялгаруулдаг бол байрыг байнга агааржуулж байна. Байрны хэмжээ нь бетон зуурмаг цутгах болон хэв хашмалыг салгаж авахад хүндрэл учруулахгүй байх ёстой. Хэв хашмалыг салгаж авсны дараа бетоны зүлгэх өнгөлгөөг халаалт зогсоохоос 3 хоногийн өмнө дуусгасан байна. Гүйцэтгэгч халаах ажиллагааг байнгын хяналт ба удирдлагаар хангана.

Агаарын температур гэнэт унах буюу халаах төхөөрөмж эвдэрсэн үед хэрэглэх нөөц халаах төхөөрөмж болон түлшийг хангалттай хэмжээгээр бэлтгэсэн байна.

(3) Усан дор цутгах

Орчны хасах хэмийн температурт усан дор бетон дэвсэхээс өмнө гүйцэтгэгч коффердам дахь усны температурыг 5°C-аас доошгүй халаана. Бетон цутгаж дуусаад усыг шавхахаас өмнө Гүйцэтгэгч коффердам дахь усны температурыг 5°C-аас дээш хэмд барина.

(е) Сульфат ихээр агуулсан хөрс буюу уснаас хамгаалах

Гүүрийн тулгуур, тулгуурын бусад хэсгийг AASHTO M85 II ангиллын шаардлага хангасан портландцементээр хийнэ. Сульфат ихээр агуулсан хөрс буюу уснаас хамгаалах талаар Гүйцэтгэгч анхаарах ёстой. Ийм газраас авсан усыг бетон арчлахад хэрэглэж болохгүй. Хольцод хийх усыг сайтар шалгаж бетоны нэвчимхий чанарыг аль болох бага байлгах ёстой. Бетоныг хамгийн их нягт автал нь нягтруулна. Бетоны гадаргуугаас арматур хүртэлх хамгийн бага зай 60мм байна. Бетон цутгасны дараа 7-оос дээш хоносны дараа хэв хашмалыг салгаж болно. Гадаргуугийн нүх хонхорхойг шавхах, хэвийн бэхэлгээг авах зэргээс бусад тохиолдолд гадаргууд хүрч болохгүй. Урьдчилан цутгасан бетон хийцтэй ажиллахад аливаа хэв гажилтын хагарал гаргахгүйн тулд тусгай тоноглол хийнэ.

1311. БЕТОНЫГ НЯГТРУУЛАХ

Бетоныг дэвссэн үеийн нийт хэмжээнд сайтар нягтруулна. Хэв хашмал, арматур ба бусад суурилуулсан зүйлсийг хөндөлгүйгээр тэдгээрийн эргэн тойронд нь сайтар нягтруулж өгнө. Нарийхан болон бусад хязгаарлагдмал хэсгүүдэд болгоомжтой ажиллах хэрэгтэй. Нэг цутгалтаас дараалан нягтруулна. Гүйцэтгэгч гүүрийн хавтанг цутгахдаа гадаргуун өнгөлгөөг хийхэд дан ганц доргиулагч хангалтгүй тохиолдолд хос хөндлөвчтэй доргиур нэмж ашиглаж болно. Гүний доргиурыг 1 минутад 7,000-10,000 цохилттойгоор ажиллуулна. Сайн нягтруулахын тулд доргиурыг үйлдвэрлэгчийн зааварласан бүрэн даралт ба хүчдэлээр ажиллуулна. Хүснэгт 13-8-д гүний доргиулагчийн хэмжээ, ашиглалт болон хүчин чадлыг харуулсан болно.

Хүснэгт 13-8: Гүний доргиулагчийн хэмжээ ба ашиглалт

**ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН-ӨМНӨДЭЛГЭР ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС
БИНДЭР ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ТӨСӨЛ**

Гүний доргиулагчийн голч, мм	Үйлчлэх радиус, мм	Нягтруулах хурд, м /цаг	Ашиглалт
20 - 30	80 - 150	0.8 - 2	50мм ба түүнээс дээш суултууд болон маш нимгэн ба маш нарийн ба хязгаарлагдмал хэсгүүдэд
35 - 40	150 - 250	2 - 4	50мм ба түүнээс дээш суултууд болон нимгэн хана, багана болон дунд зэрэг хязгаарлагдмал хэсгүүдэд
50 - 75	180 - 350	3 - 8	50мм ба түүнээс дээш суултууд болон хийцийн их биеээс дээш хэсэгт

(Хүснэгт 13-8)-ийн дагуу нийт бетон хольцыг зохих хугацаанд нь нягтруулахын тулд гүйцэтгэгч нь доргиулагчийг хангалттай тоогоор бэлдэх шаардлагатай. Бетон дэвсэж буй газар бүрт хэдийд ч хэрэглэхэд бэлэн нөөц доргиулагчийг байлгана.

75мм-ийн болон үүнээс том чулуулаг агуулсан бетонд 100 буюу түүнээс дээш мм-ийн голчтой доргиулагч хэрэглэнэ.

Нягтруулалтыг бетон дэвссэн цэгт хийнэ. Хольцыг хэвтээ чиглэлд доргиулагчаар тарааж болохгүй. Доргиулагчийг босоогоор өөрийн жингийн даралтаар хольцод оруулна. Үелсэн байдал үүсгэхгүйн тулд гүний доргиулагчийг урьд нь дэвссэн бетоны гүн рүү хийж нягтруулна.

Бетон хольцын нягтралт зогсож, гадаргуу дээр хольцын шингэн үе гарч ирэх ба агаар ялгарахаа больтол нягтруулна. Доргиулагчийг хольцоос гаргахдаа үүссэн зай нь бөглөрөхөөр удаан гарган авна.

Нягтруулалт сайн хийгдтэл доргилтыг үргэлжлүүлэх ба материалын ялгарал үүстэл удаан доргиулж болохгүй. Мөн доргилтыг нэг цэг дээр шингэн зуурмаг ялгартал удаан үргэлжлүүлж болохгүй.

Доргиулагчийг нийт цутгалтын талбайд жигд ажиллуулах ба доргиулагч хийх цэгүүдийн хоорондох зай доргиурын ил харагдах үйлчлэх радиусаас 1.5 дахинаас илүү хол байж болохгүй.

Нягтруулалтыг шууд арматур дээр эсвэл арматураар дамжуулан хийж болохгүй бөгөөд доргиулагчийг арматур, хэв ба бусад суулгасан зүйлд хүргэхгүй.

Бага голчтой доргиулагчийг гадаргуун ба өнцөг тохойн гөлгөр байдлыг хангах зорилгоор хөнгөн цохигч хэрэгслээр хангаж өгнө.

Багана, доод бүтээц, хоолойн хана болон бусад босоо элементүүдийг цутгаад хэсэг байлгах ба 1-2 цагийн дараа нягтруулалт хийнэ. Энэ нь хэвтээ элементийг цутгахын өмнө суултын хагарал үүсэхээс сэргийлэх зорилготой юм.

Инженер нь цохилтын нүхийг багасгаж бетоны гадаргуугийн байдлыг сайжруулах буюу агшилтаас үүсэх хагарлаас сэргийлэх зорилгоор бетоныг дахин нягтруулахыг шаардаж болно. Гэхдээ бетон хатуураагүй, доргиулагч нь доорх үеийн бетон руу өөрийн жингээр шигдэж байвал мөн доргиулагчийг гаргаж авсны дараа нүх нь өөрөө дүүрч байгаа нөхцөлд дахин нягтруулалт хийж болно.

Гүйцэтгэгч бетоны марк, өтгөрөлтийн түвшин бүрээр хамгийн оновчтой хүлээх хугацааг талбайн туршилтаар тогтооно.

1312. БЕТОНЫГ АРЧЛАХ

а) Ерөнхий

Бетоныг арчлах нь бэхжих явцад бетон чийгшлээ алдаж хатуурах ба бетоны доторх температурын өөрчлөлтөөс болж дулааны хагарал үүсэх зэргээс хамгаална. Бетоныг арчлах арга нь бетоныг гэмтээхээргүй байна. Бэхжилт нь дээрх шаардлагыг хангатай үргэлжлэх боловч аль ч тохиолдолд 7 хоногоос багагүй байх ба дээр нь дараагийн бүтээц иртэл үргэлжилнэ.

Бетоны арчлалтыг арчлах ажиллагааг даах чадвартай болтол хатуурсан нөхцөлд эхлэх бөгөөд тасралтгүй буюу нэлээн том талбайд цутгаж байгаа бол түрүүчийн цутгалт нь дууссан газраас эхэлж хийнэ.

Шинээр дэвссэн бетон бүрийг энд дурдсан аргуудын аль нэгээр бетон хуурайшихаас сэргийлж арчилна. Арчлалт хийхээр сонгосон аргаа хэрэглэж амжаагүй байхад бетон хуурайшиж эхэлбэл бетоны гадаргууг гэмтээлгүйгээр ус цацаж чийгтэй байлгана.

Уураар болон туяагаар халаахаас бусад аргаар хүснэгт 13-9-т өгөгдсөн хугацаанд зогсолтгүй үргэлжлүүлэн арчилна.

Хүснэгт 13-9: Арчлалтын хамгийн бага хугацаа

Цементийн төрөл	Орчны дундаж температура-тур 15° C -ээс их	Орчны дундаж температур 5° C-15° C	Орчны дундаж температур 5° C -ээс бага
10%-аас бага пуццоллан нэмсэн портландцемент	7 өдөр	10 өдөр	14 өдөр
10%-аас их пуццоллан нэмсэн портландцемент	10 өдөр	15 өдөр	20 өдөр

Цаг агаарын халуун нөхцөлд Инженер шаардлагатай гэж үзвэл, шингэн мембран арчлалт хийгдэж байгаа бетон гадаргууд ус цацаж өгнө. Усыг, Инженер гадаргууг хөргөх шаардлагагүй болсон гэж үзэх хүртэл цацна.

Инженер зааварласан бол Гүйцэтгэгч дор дурдсан арчлалтын зарчмаас гадна нарны хурц туяа буюу салхи бетон гадаргууд хүрэхээс сэргийлж нар ба салхины хаалт зэргээр хангана.

(b) Материал

(1) Ус

Бетонд хийх ус нь 1303 (ё) зүйлийн шаардлагыг хангасан байх ёстой.

(2) Шингэн мембран

Бетоныг арчлах шингэн мембраны хольц нь AASHTO M148-ын шаардлагыг хангасан байна.

(3) Ус нэвтэрдэггүй материалаар хучих арга

Ус нэвтэрдэггүй цаас, полиэтилен хальсан материал, цагаан өнгийн тааран полиэтилен хулдаас нь AASHTO M171-ын шаардлагыг хангасан байна.

(c) Бетоныг арчлах аргууд

(1) Хэв хашлага ашиглах

Бетоны хэв хашмалыг нь авалгүйгээр шаардлагатай хугацааны туршид байлгаж арчилна.

(2) Усаар арчлах

Бетоны гадаргуу дээр ус тогтоох, усаар шүрших, эсвэл байнга нойтон материалаар хучих замаар гадаргууг үргэлж чийгтэй байлгана. Эдгээр материалуудыг хөвөн, зулхай, олон давхар таар буюу бусад зөвшөөрөгдсөн материалаар хийсэн байх ба будаг гардаггүй, бетонд ямар нэгэн байдлаар нөлөөлдөггүй байх ёстой.

(3) Шингэн мембранаар арчлах холимог арга

Гадаргууг зүлгэж өнгөлөх шаардлагатай үед болон ажлын залгаасны гадаргууд шингэн мембраны аргыг хэрэглэж болохгүй. Гэхдээ залгаасан дээр бетон тавихаас өмнө элсэн шүршигчээр мембраныг арилгавал энэ аргыг хэрэглэж болно.

Хоёрдугаар зэрэглэлийн цагаан пигментыг зөвхөн гүүрний хавтангийн гадаргуу, ажил дууссаны дараа ил харагддаггүй буюу Инженерийн зөвшөөрсөн бусад гадаргуу дээр хэрэглэнэ.

Шингэн мембраны аргыг хэрэглэх үед сул ус гадаргуугаас ууршмагц ил бетоныг мембраны уусмалаар богино хугацаанд бүрнэ. Хэвлэмэл гадаргуугийн хэв хашлагыг авч шаардлагатай өнгөлгөө хийж дуусмагц нэн даруй мембраны уусмалаар бүрнэ.

Уусмалыг цахилгаан үүсгүүрээр ажилладаг шүршигчээр нэг буюу хоёр удаагийн ажилбараар шүршинэ. Гар ажиллагаат шүршигчийг багахан хэмжээний газарт Инженерийн зөвшөөрөлтэйгөөр хэрэглэж болно.

Пигмент агуулсан мембраны уусмалыг хэрэглэхийн өмнө сайтар хольж хутгах ба хэрэглэх явцад хөдөлгөж сэгсэрнэ. Хэрвээ уусмалыг хоёр хувааж шүрших шаардлагатай гэж үзвэл эхний шүршилтийг хийсний дараа 30 минутын дотор хоёр дахь шүршилтийг хийнэ.

Шүрших төхөөрөмжийг Инженерээр батлуулсан байна. Гөлгөр гадаргуу дээр 1литр бэхжүүлэх уусмалыг 0.2 хавтгай дөрвөлжин метр талбайд, барзгар гадаргууд 1литр бэхжүүлэх уусмалыг 0.5 хавтгай дөрвөлжин метр талбайд тус тус ноогдохоор буюу Инженерийн зааварчилсан хэмжээгээр нэгэн жигд бүрхүүл үүсгэж шүршинэ.

Хэрвээ шинэхэн шүршсэн мембраны хальс хангалттай хатаж гүйцээгүй байхад бороо орох буюу арчлалтын явцад хальс ямар нэгэн байдлаар гэмтвэл тухайн газарт дээр дурдсантай ижил хэмжээгээр шинээр уусмалыг шүршинэ.

(4) Ус нэвтэрдэггүй материалаар хучих арга

Энэ нь бетоны гадаргуугаас чийг алдагдахаас сэргийлж ус үл нэвтрэх материалаар хучих арга юм. Энэ арга нь чийгийн алдагдлаас сэргийлж чадна гэж Инженер (хяналтын инженер буюу хяналтын зөвлөх багийн ахлагч)- үзсэн тохиолдолд л энэ аргыг хэрэглэнэ.

Гадаргууг хучих үед бетон гадаргуу нойтон байх ёстой. Уг материал нь хангалттай хэмжээний өргөнтэй байх ба материалын зэрэгцээ эгнээнүүдийг 300-аас доошгүй мм-ээр зөрүүлж залгааг цавуутай лент, мастик цавуу болон бусад зөвшөөрөгдсөн аргаар сайтар битүүлж нааж, гадаргууг нийтэд нь хучна.

Хучлагыг салхинд хийсэхгүй байхаар бэхэлж өгнө. Бетоны бэхжилтийн хугацаа дуусахаас өмнө хучлагын аль нэг хэсэг урагдвал нэн даруй нөхөж засварлана. Ус үл нэвтрүүлэх чанар нь алдагдсан материалыг хучлагад хэрэглэхгүй.

(5) Халаалттай байранд арчлах арга

Цаг агаарын хүйтэн нөхцөлд цутгасан бетоныг техникийн шаардлагын 1310 (г) дэд зүйлд заасны дагуу арчилна.

(6) Уур болон туяагаар халаах арга

Энэ аргыг зөвхөн үйлдвэрт цутгасан бетон элементүүдэд хэрэглэж болно.

Уур болон цацрагт туяаны дулаанаар арчлах ажиллагаа нь тохиромжтой камерт хийгдэнэ. Зөвхөн бага даралттай, нойтон уурыг хэрэглэнэ. Температур заагч багаж нь камер дахь температур тогтоосон хязгаарт жигд тархсан эсэхийг зааж байх ёстой.

Бетоныг цутгаж дууссаны дараа бетоны эхний бэхжилтийг эхлүүлэхийн тулд бетоныг 3-5 цаг байлгасны дараа уураар болон дулаанаар бэхжүүлнэ. Хэрвээ удаашруулагч бодис хэрэглэсэн бол уур болон дулаанаар арчлах арга хэрэглэх хүртэл хүлээх хугацааг Инженерийн заасан хугацаагаар хойшлуулна.

Эхний бэхжилтийн хугацааг AASHTO T197 стандартын дагуу тодорхойлсон бол хүлээх хугацааг ч үүнтэй уялдуулан тохируулна.

Хүлээх хугацаанд хатаах камерын температурыг 100°C-аас доошгүй байлгах ба үүнийг уур болон дулааны температураар тохируулж болно. Энэ хугацаанд бетоны гадаргууг чийгтэй байлгах шаардлагатай. Хэсэг газарт хэт халаалт үүсэж болзошгүй учраас уурыг шууд бетон болон хэв рүү чиглүүлж болохгүй. Уур болон дулааныг нэмэгдүүлэх үед камерт байх орчны температурыг цагт дунджаар 20-оос илүүгүй хэмээр өсгөж байх ёстой. Камерын хамгийн их температур нь 71° C-аас хэтрэх ёсгүй.

Төлөвлөсөн бат бэхийн хэмжээндээ хүртэл бетоныг хамгийн өндөр температурт байлгах ба туршилтын шоог урьдчилан хүчитгэсэн бетоны хамт ижил нөхцөлд арчилна.

Инженерийн баталсан агаарын температур хэмжигчийг бетон цутгаж дууссаны дараа хийцийн орой дээр байрлуулна. Нэмэгдүүлсэн дулаанаар бэхжүүлж дуустал дулаан хэмжигчийг хөдөлгөж болохгүй.

Орчны температур болон цаг хугацаа заасан графикийг хийц бүрээр хийж бэхжилт хийж дууссаны дараа Инженерт өгнө. Графикт дараах зүйлийг үзүүлсэн байна.

Үүнд:

- Хийцийн дэс дугаар;
- Цаг, огноо;
- Бетон цутгаж дууссан үе;
- Халааж эхэлсэн үе;
- Халааж дууссан үе;
- Бэхжилт дуусах үе.

Бэхжилт дууссаны дараа агаарын температурыг цагт 20-оос дээшгүй хэмээр аажмаар буулгах ба бетоныг камераас гаргахад гаднах температураас 6°C-аар их байх хүртэл бууруулна.

Бетон хийцүүдийг шаардагдах бат бэхийг автал хөлдөх температур хүртэл хөргөж болохгүй.

Дулаанаар арчлах аргад, уур, халуун ус, тос, усыг хоолойгоор дамжуулан, эсвэл цахилгаан дулааны элемент ашиглан хэрэглэж болно. Дулаанаар арчлах аргыг дулаанаа хадгалж чадах камерт явуулах ба чийгийн алдагдлыг багасгах зорилгоор бетоны бүх ил харагдах гадаргууг полиэтилен хулдаас буюу зөвшөөрөгдсөн шингэн мембранаар бүрнэ.

Бетон элементүүдийн өөр бетон хийц болон материалтай шууд харьцах гадаргууг бэхжүүлэх ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөг бетон цутгах аливаа ажлыг эхлэхээс өмнө Гүйцэтгэгч Инженерт танилцуулж батлуулна.

(е) Шинээр цутгасан бетоны температурын өөрчлөлтийг хязгаарлах

Гүйцэтгэгч бетон цутгасны дараа бетоны температурын өөрчлөлтийг хязгаарлах дараах арга хэмжээг нөхцөл байдалд тохируулан авна. Үүнд:

- зүйл 1310 б, в-ийн дагуу бетоны дэвсэх үеийн температурыг хязгаарлах;
- Инженер зөвшөөрсний үндсэн дээр дулаан бага ялгаруулах цемент ашиглах;
- Ил гарсан гадаргууг дулаан тусгаарлагчаар бүтээх;
- Салгаж аваагүй хэв хашмалыг дулаан тусгаарлагчаар хангах;
- Гадаргуу дулаанаа огцом алдахаас сэргийлж салхины хаалт хийх;
- Гадаргуу дээр ус тогтоох буюу ус шүршиж гадаргууг огцом хөргөж болохгүй.

1313. АЖЛЫН ЗАЛГААС

Өмнө нь цутгаж нэгэнт хатуурсан бетонд бетон залгаж цутгахад тэдгээрийн хоорондох харьцах гадаргууг ажлын залгаас гэнэ. Гүйцэтгэгч ажлын залгаасыг зурагт үзүүлсэн байрлалд хийнэ. Ажлын залгаасын байрлалыг Инженерээс урьдчилан зөвшөөрөл авсан байна. Налуу хавтан болон зурагт өөрөөр зааснаас бусад тохиолдолд ажлын залгаас нь хэвтээ буюу босоо хавтгайд байна.

Бүх төрлийн бетоны ажлын залгаасыг углуурга хэлбэрээр хийж сайн нягтруулна. Жижиг алгасалтай дам нуруу болон хавтангийн хүчитгэсэн бетон ба бэлэн цутгасан элементийн алинд ч залгаас байх ёсгүй. Ажлын залгаасыг бетоныг дэвссэний дараа агшилтын нөлөөг аль болох багасгахуйц хэлбэрээр, хийцэд ирэх ачаалал болон хөдөлгөөнт заадастай зохицох байдлыг харгалзан хамгийн тохиромжтой байрлалд хийнэ.

Ажлын залгаасны өнцгийг арзгар гаргаж болохгүй ба залгаасаар цухуйн гарч ирсэн арматурын төмрийг бетон бүрэн бэхэжсэний дараа тайрч авна. Бетоны хөндлөн ба бараг хөндлөн залгаасууд ба бетоны ил гарч байгаа гадаргуутай огтлолцох хэсгийг бетоны орой дахь хэвэнд бэхэлсэн чиглүүлэгчийн тусламжтайгаар буюу Инженерийн зөвшөөрсөн аргаар шулуун шугамаар гаргаж өгнө.

Бетоныг цутгаж дуусаад гадаргууг цэвэрлэхэд цемент ялгарахгүй болтол хатуурсны дараа шинэ бетоны хэвтээ буюу бараг хэвтээ залгаасуудын гадаргууг өндөр даралттай усаар шүрших ба агаараар үлээлгэх буюу хялгасан шүүрээр шүүрдэж цэвэрлэнэ. Хэрэв тухайн нөхцөлд хэв хашмалыг салгаж авах боломжтой бол хэвийг салгаж авсны дараа хэвтээ буюу бараг хэвтээ залгаасуудын гадаргууг ижил аргаар арчилна.

Хэв хашмалыг 72 цагийн дотор салгаж аваад бетоны гадаргууг чулуун материалыг ил

гартал угааж шүүрдсэн тохиолдолд босоо залгаасын хэвлэмэл гадаргууд удаашруулагч бодис түрхэж болно.

Ажлын залгаасыг дараах хэлбэрээр арчилна. Үүнд:

- Хуучин бетон гадаргуугийн чулуун материалыг ил гартал угааж нугардаггүй хялгасан шүүрээр шүүрдэнэ;
- Чулуун материал нь ил гарсан хуурай гадаргуу дээр шинэ бетон цутгана;
- Гадаргуу нь цэвэр, хуурай ба бат бэх байна.

Дээрх арчилгааг хийх үед бетон хэтэрхий хатуурсан байвал, хэвлэмэл буюу сул гадаргууг механик аргаар, эсвэл чийгтэй элсээр буюу агаарын шахалттай буугаар шүршиж боловсруулна. Ийм арга хэрэглэсний улмаас гадаргуу дээр үүсэх нүхнүүдийн гүн нь 10мм–ээс их ба өнгөлсөн гадаргууд 40мм–ээс илүү ойр байж болохгүй.

Ийнхүү хэвлэсэн гадаргууг бетоны ажил эхлэхээс өмнө сайтар угааж, хатаан орчин тойронд байгаа хайрга ба бусад сул материалуудыг зайлуулна. Гүйцэтгэгч хуучин бетон гадаргуугаас цухуйсан бэхэлгээ болон арматурын төмөрт наалдаж үлдсэн бетон ба бусад материалыг тэдгээрийн бетон дахь барьцалдалтыг алдагдуулалгүйгээр цэвэрлэж зайлуулна.

Дэвсэх төхөөрөмж, залгаас, арматур болон хэв хашмалтай харьцахад тэдгээрт наалдаж алдагдах шингэн хольцын алдагдлыг нөхөх зорилгоор хатуурсан бетон гадаргуу дээр дэвсэх эхний үеийн бетонд байх ёстой чулуун материалын зөвхөн хийнэ.

Инженер ажлын залгаас болон байрлалыг шалгаж үзээд зөвшөөрөл өгөхөөс нааш гадаргууд бетон дэвсэхгүй. Инженерийн зааварласан газруудад хуучин ба шинэ бетонуудыг хооронд нь сайн барьцалдуулах үүднээс ажлын залгаасанд эпокси резин хэрэглэнэ. Эпокси резин хэрэглэх болон гадаргууг бэлдэхдээ Инженерийн зааварчилгаа болон үйлдвэрлэгчийн зааврыг удирдамж болгоно.

Эпокси резиний төрөл болон үйлдвэрлэгчийг Инженер зөвшөөрсөн байх ёстой. Ажлын залгаас нь хоёр даацын элементүүдийг хооронд нь барьцалдуулалгүй залгах шаардлагатай бол Гүйцэтгэгч тэдгээрийн дунд хоёр үе ус нэвтэрдэггүй барилгын цаас хийж өгнө. Цаасыг нугалж үрчийлгэлгүй тааруулж хийнэ. Илүү гарсан ирмэгийг цавуутай туузаар нааж бэхэлнэ.

Хоёр үе барилгын хар цаасыг залгаасны нийт талбайд дэвсэнэ. Гүйцэтгэгч бетоны ажил хийх явцад цаасыг гэмтээхгүй байх талаар анхаарах ёстой.

1314. ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС

Хэв гажилтын заадас нь бетоны доторх дулааны болон бусад хөдөлгөөнийг хангахад зориулагдсан заадас юм. Хэв гажилтын заадас гэдэг нь бетоны агшилт болон тэлэлтийг зохицуулах зориулалтаар бетоны дунд гаргасан зай юм. Хэв гажилтын заадас нь бетоны агшилт болон тэлэлтийг хангах ба тусгай дүүргэгчээр дүүргэгдэнэ. Хэв гажилтын заадсын байршлыг ажлын зураг буюу техникийн шаардлагад заасны дагуу тодорхойлно. Хэв гажилтын заадсыг бетонд аливаа хагарал үүсэхээс өмнө, бетоны ирмэгийг үйрэх буюу бутралгүйгээр хөрөөдөх боломжтой болмогц хийнэ.

1315. УС ТОГТООГЧ

Ус тогтоогчийн тухай заалтууд нь шингэн зуурмаг тогтоогчид адил хамаарна. Ус тогтоогчийг ажлын зурагт үзүүлсэн материалаар хийнэ. Гүйцэтгэгч ус тогтоогчийн материалын тухай дэлгэрэнгүй мэдээлэл болон дээжийг Инженерт танилцуулж батлуулахаас нааш ус

тогтоогчийн материалыг талбайд авчирч болохгүй. Дээжийн урт нь туршилт хийхэд хүрэлцэхүйц байна.

Ус тогтоогч нь хлорид, сульфат болон барилгын ажлын орчин тойронд байж болох бусад хортой бодисын нөлөөнд ордоггүй материалаар хийгдсэн байна. Резинэн ус тогтоогч нь байгалийн болон хиймэл резинээр хийгдсэн байх ба 25°C-ын дулаанд хийсэн туршилтаар 500 хувиар сунах чадвартай ба залгаасын 50 мм-ээс доошгүй хөдөлгөөнийг даах чадвартай байна.

Поливинилхлорид (PVC)-р хийсэн ус тогтоогч нь PVC-ийн өөдөс агуулаагүй PVC-ин полимерээс гаргаж авсан материалтай байна. Ийм ус тогтоогч 25°C-ын дулаанд хийсэн туршилтаар 225%-аар сунах чадвартай ба залгаасын 10мм-ээс доошгүй хөдөлгөөнийг даана.

Бага модулийн ус тогтоогч нь 25°C-ын дулаанд хийсэн 6 N/мм² хүчээр татах туршилтаар 200%-аар сунах чадвартай ба залгаасын 50мм-ээс доошгүй хөдөлгөөнийг даах ёстой. Ус тогтоогч нь барилгын ажлын шаардлагын дагуу ажиллахад хялбар байхаар хангалттай урт байна.

Амлуулах залгааснаас бусад резинэн ба хуванцар материалтай залгаасыг үйлдвэрлэгчээс бэлэн хийснээр авчирна. Амлуулах залгаасыг талбай дээр үйлдвэрлэгчийн хангасан тоног төхөөрөмж болон заавраар хийнэ.

Ус тогтоогчийн материалыг тос болон бусад бодисоор бохирдуулж гэмтээхээс болгоомжлон талбайд хадгална. Резинэн болон хуванцар ус тогтоогчийг сэрүүн, агааржуулалт сайтай, нарны гэрэл шууд тусахааргүй газарт хадгална.

Резинэн болон хуванцар ус тогтоогчийг залгаасны нэг талд нөгөө талын бетон дэвсэхээс 1 сар ба түүнээс дээш хугацааны өмнө бэхэлсэн бол ус тогтоогчийг нарнаас хамгаална. Ус тогтоогчийг бетон цутгах үед хөдлөхгүй байхаар хэв хашмалд бэхлэн, бетон цутгахаас өмнө тэдгээрийг аливаа хог, шавар, тосноос цэвэрлэнэ.

Арматурын төмөрт сайтар уяж тогтоосон төмөр гогцоонд ус тогтоогчийг бэхлэх ба ямар ч тохиолдолд ус тогтоогчийг хадаасаар буюу бусад зүйлээр цоолж, тогтоож болохгүй. Бетон дэвсэх үед ус тогтоогчийг хөдөлгөлгүй тойруулан нямбай цутгаж сайтар нягтруулна.

Ус тогтоогчийг хэвтээ буюу бараг хэвтээ байрлалд бэхэлж байгаа бол түүний дор хоосон зай үлдээхгүй байх хэрэгтэй. Ус тогтоогчтой зэрэгцсэн хэв хашмалыг ус тогтоогчийг гэмтээлгүйгээр нямбай салгаж авна. Хэрэв талбайн нөхцөлд засварлах боломжгүйгээр эвдэрвэл Инженер ус тогтоогч бэхэлсэн бетоны хэсгийг зайлуулан шинээр хийхийг шаардаж болно.

1316. ХЭВЛЭМЭЛ БУС ГАДАРГУУН ӨНГӨЛГӨӨ

Хэв хашмалтай шууд харьцаагүй, хэвтээ буюу бараг хэвтээ гадаргууг зурагт заасан ангиллын дагуу дор тодорхойлсон аргаар өнгөлнө.

Үүнд:

(a) UF 1 өнгөлгөө

Зурагт заасан буюу Инженерийн зааварчилсан өнгөлгөөний ангиллаасдоогуур ангиллын өнгөлгөө шаардах бүх гадаргууд UF 1 өнгөлгөөг хийнэ. Бетоныг нягтруулсны дараа нэн даруй тэгшлэгч рейкээр илүүдэл бетоныг хусан авч гадаргууг нэгэн жигд болтол тэгшилж засна.

(b) UF 2 Өнгөлгөө

Энэ өнгөлгөөг дээвэр, шалны хавтан болон бусад хатуу өнгөлгөө шаарддаггүй гадаргууд хэрэглэнэ. Гадаргууг эхлээд UF 1 өнгөлгөөгөөр янзалж, бетоныг нэлээд хатуурсны дараа модон

буюу үйсэн хөвөгчөөр гадаргуугийн өнгөлгөөг зөвхөн тэгшлэгч рейкний мөрийг арилгах хэмжээнд тэгшилнэ.

(с) UF 3 Өнгөлгөө

Энэ нь түргэн урсгалтай усны үйлчлэлд өртдөг хэсгүүд буюу цаг агаарын үйлчлэлийг эсэргүүцэх чадвар болон гадаад үзэмж чухал байдаг даацын хэсгүүдийн гадаргууг нийвийгээр хатуу өнгөлгөө хийхийг хэлнэ. Эхлээд гадаргууг UF 2-ийн дагуу өнгөлнө. Гадаргуугаас чийгийн давхарга хатаж, алга болж бетон хангалттай хатуурсны дараа цахилгаан үүсгүүрт хөвөгчөөр нийвийн мөргүй, нягт, гөлгөр, жигд гадаргуу үүстэл өнгөлнө.

(d) Зорчих хэсгийн гадаргуун өнгөлгөө

Гүүрний хавтан болон дамжих хавтангийн гадаргууг төмөр замаар явдаг тараах төхөөрөмжөөр тэгшилнэ. Уг төхөөрөмж нь хавтангийн нийт өргөнд бэхлэгдсэн байна. Төмөр зам нь нэлээд бат бэх байх ба тараах ажилбарын явцад хотойхгүй байхаар ойр ойрхон зайнд бэхлэгдсэн байна. Төхөөрөмж болон төмөр замыг тэгшилгээний дараах бетон гадаргуу нь шаардлагатай дагуу болон хөндлөн хэвгийг хангасан байхаар тохируулдаг байх ёстой.

Бетон цутгаж эхлэхээс өмнө төмөр замыг газар дээр нь авчирч тэгшилгээ хийхээр төлөвлөсөн нийт уртын дагууд сайтар суулгаж бэхэлнэ. Төмөр замын урт нь тэгшилгээ хийхээр төлөвлөсөн уртын 2 үзүүрээс тараах төхөөрөмжийг бетоноо султгахад хангалттай зайгаар илүү гарсан байна.

Шаардлагатай бол хэв хашмалын суулт, хотойлт, овойлт зэргийг харгалзан төмөр замын өндрийн төвшинг тохируулж болдог байх ёстой. Тараах төхөөрөмж нь талбайн нийт уртад тасралтгүй ажиллах хүчин чадалтай байх ёстой. Мөн урьд нь төлөвлөөгүй, тараах төхөөрөмжийн ажиллагааны үед үүссэн суулт буюу хотойлтыг засахад төмөр замыг тохируулж болдог байх хэрэгтэй.

Бетон цутгах талбайд байрлаж байгаа төмөр замын тулгууруудыг хэрэггүй болмогц бетоны төвшингээс доош 50-аас доошгүй мм байхаар тайрч зайлуулаад, тулгуурын ороор гарсан зайг шинэ бетон хольцоор бөглөнө.

Гүйцэтгэгч бетон гадаргууг шалгах, засварын ажил хийх, тулгуураас үлдсэн нүхийг бөглөх, цахилгаан хөвөгч явуулах, арчлалт хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэх зорилгоор замын тэнхлэгийн дагуу ажлын хөдөлгөөнт гүүр хийнэ.

Гадаргууг тэгшилсний дараах бүх ажлыг энэ ажлын гүүрэн дээрээс гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч ажлын гүүрэнд хүрэх бололцоотой болгохын тулд аль аль талдаа аюулгүйн хашлага бүхий, бат бөх явган зам барина.

Гүйцэтгэгч бетон хольцыг авчрахаас өмнө тараах төхөөрөмжийг бетон цутгах нийт талбайгаар ажиллуулж, төмөр замын муруйлт, хавтангийн зузаан, арматурын төмөр ба гадаргуун төвшин хоёрын хоорондын зай зэргийг шалгаж, бүх тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг баталгаажуулна. Шаардлагатай тохиргоог бетон дэвсэхээс өмнө хийж дуусгасан байна.

Гүйцэтгэгч гүүрийн хавтан болон дамжих хавтангийн шинэхэн цутгасан хэсгээр бетон цутгаж дууссанаас хойш 48 цаг өнгөртөл хөнгөн даацын тоног төхөөрөмж явуулж болохгүй.

Хэрэв Инженер хавтан хангалттай бат бэхээ авч чадаагүй гэж үзвэл дээрх хугацааг сунгана. Бетон бат бэхийн 80% автал аливаа хүнд механизмыг гүүр болон дамжих хавтангаар явуулахгүй.

Тэгшлэх төхөөрөмж нь шаардлагатай дагуу болон хөндлөн хэвгийг гаргатал гадаргуу дээгүүр явна. Тэгшлэх төхөөрөмжийн урд талд бага зэргийн илүүдэл бетон байнга явж байх ёстой.

Энэ илүүдэл бетоныг дэвсэж буй бетон руу хийж болохгүй бөгөөд цутгалтын зах руу аваачиж хаяна. Өнгөлгөө хийх явцад илүү гарсан ус, шавар болон гаднын материалуудыг буцаан хавтан руу хийж болохгүй бөгөөд тэгшлэгч рейкээр хавтангийн төвөөс зах руу чиглүүлсэн хөдөлгөөнөөр гаргаж хаяна. Бетоныг өнгөлөх зориулалтаар гадаргуу руу ус хийж болохгүй.

Гадаргууг тэгшилсний дараа 1316 (в) дэд зүйлд дурдсан UF 3 өнгөлгөө буюу цахилгаанаар ажилладаг хөвөгчөөр өнгөлгөө хийнэ.

Талбайд өнгөлгөө хийсний дараа Гүйцэтгэгч 3 метрийн төмөр рейкийг гүүрийн тэнхлэгийн дагуу тавьж, нийт гадаргууг шалгана. Захуудын шугам, тэнхлэгийн шугам болон тэнхлэг ба захуудын дундах цэгүүдийг мөн шалгах хэрэгтэй.

25 мм ба түүнээс зузаан материал нэмж дэвсэх шаардлагатай гадаргуугийн төвшингийн зөрүү рейкний хэмжилтээс 10 мм-ээс илүү байж болохгүй.

Энэ хязгаараас илүү гарсан өөрчлөлтийг бетоныг бэхжихээс өмнө засаж залруулна. Талбайг урьд шалгасан талбайн талыг давхардуулан шалгаж явна.

Бусад бүх хэвлэмэл бус гадаргуу нь ажлын зурагт заасны дагуу байх ба (хүснэгт 13-10)-т тодорхойлсон хүлцэх алдааны хязгаар дотор хэлбэлзэх ба гадаргуугийн төвшин огцом өөрчлөгдөж болохгүй.

Хэрвээ ажлын зурагт хүлцэх алдаа өгөгдсөн бол тэдгээрийг (хүснэгт 13-10)-т үзүүлсэн хүлцэх алдаанаас илүү хүчинтэйд тооцно.

1317. ХЭВЛЭМЭЛ ГАДАРГУУН ӨНГӨЛГӨӨ

Бетон гадаргууг ажлын зураг дээр үзүүлсний дагуу дор заасан аргаар өнгөлж засна. Үүнд:

(а) Гадаргуун ердийн өнгөлгөө

Ажлын зураг дээр өөрөөр өгөгдөөгүй буюу Инженер өөрөөр заагаагүй бол бетоны ил гарсан бүх гадаргууд ердийн заслыг хийнэ. Энэ заслаар сийрэгжиж арзайсан, цухуйсан зүйлс, овойлт, элдэв өнгө хувиралт, зураас, гадаргуугийн бусад элдэв өө сэвийг арилгаж, гөлгөр тэгш гадаргуу бий болгоно. Стандартчилал, технологийн институтээс гаргасан PCI стандартын В-В дотор заслын I ангиллын наамал банз буюу усан онгоцонд хэрэглэдэг BS 1088 стандартын наамал банз эсвэл том хавтгайгаар үйлдвэрлэгддэг ижил төстэй материалаар хэв хашмалыг доторлоно.

Наамал банз нь нэгэн жигд батлагдсан ширхэгтэй байна. Боллоцотой бол хавтангуудыг хооронд нь уран барилгын элементээр холбох буюу гадаргуун чиглэлийн залгаасыг тааруулж өөрчилнө.

Хавтан буюу банзнуудын зузаан нь бетон цутгасны дараа бетоны даралтаар ямарваа нэг хэв мөр гаргахааргүй байна. Өөрөөр заагаагүй байвал хавтангуудыг хооронд нь хэвтээ буюу босоо байдлаар залгана.

Шаардлага хангасан гадаргуун ердийн өнгөлгөө гэдэг нь төмөр зангилааг салгаж авсны

улмаас гарсан нүхнээс бусад нүхийг бөглөх гэх мэт засвар хийх шаардлагагүй гэж Инженер үзсэн гадаргууг хэлнэ.

Сийрэгжиж арзайсан, цухуйсан зүйлс, овойлт, элдэв өнгө хувиралт, зураас буюу гадаргуугийн элдэв өө сэвийг Инженерийн зөвшөөрсөн аргаар арилгана. Цементээр угаах буюу гипс хэрэглэж болохгүй.

Хэвийг авсан даруй бетон гадаргуугийн согогыг Инженерт мэдэгдэнэ. Гадаргуугийн согогыг техникийн шаардлагын дагуу Инженерийн заасны дагуу засварлана.

Хөндий хэсэг буюу нүхийг тэр орчин тойронд хийсэн бетоной адил чанар, хольц бүхий гэхдээ 2,36 мм шигшүүр дээр үлдсэн чулуу агуулсан цемент элсний зуурмагаар чигжиж, нийт гүнд нь хүртэл дүүргэнэ.

Нүх цоорхойг шавахад хэрэглэх шавар зуурмаг нь зуураад 1-ээс илүү цаг болсон чигжээс байж болохгүй. Цементэн зуурмаг хатсаны дараа нөхөөс хийсэн хэсгийг бусад гадаргуугийн хамт засч тэгшилнэ.

Суларч хөндийрсэн бетон ба муу барьцалдсан чулууг гарган авч хаян, техникийн шаардлагын зүйл 1321-ийн дагуу бат бөх бетон буюу шавар зуурмагаар бөглөн тэгшилж өгнө.

Хэрэв Инженерийн үзэж байгаагаар бетоны гадаргуу ердийн өнгөлгөөний шаардлагад нийцэхгүй байгаа бол Гүйцэтгэгч зүлгэх өнгөлгөөг техникийн шаардлагын зүйл 1317 (б)-ийн дагуу өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

б) Зүлгэх өнгөлгөө

Зураг дээр өөрөөр өгөгдөөгүй бол энэ ажлыг засварын ажил гэж үзэх ба Гүйцэтгэгч өөрийн зардлаар гүйцэтгэнэ. Хэвийг салгаж авсны дараа зүлгэх өнгөлгөөг аль болох хурдан эхлүүлэх хэрэгтэй.

Гадаргууд эхлээд техникийн шаардлагын 1317 (а) дэд зүйлд заасан ердийн өнгөлгөө хийнэ. Шавар зуурмаг бэлэн болмогц бетон гадаргууг цэвэр усаар сойздож норгоно. Үүний дараа цахилгаанаар ажилладаг чулуу өнгөлөгчөөр гадаргууг зүлгэнэ.

Гадаргуу дахь хэв хашмалын мөр, хонхойж эсвэл овойж илүү гарсан хэсэг болон бусад согогууд арилж, гөлгөр гадаргуу үүстэл зүлгэнэ. Зүлгэх явцад нунтаглагдаж гадаргууд үлдсэн нялцгай материалыг нийт гадаргууд жигд тарааж хатаана.

Эцсийн өнгөлгөөг цахиурын карбид чулуугаар гадаргууг толигор, тэгш, жигд өнгөтэй болтол нь үрж хийнэ. Энэхүү өнгөлгөөг хийж дуусаад гадаргууг хатсаны дараа сул шаврыг тааран материалаар үрж зайлуулна.

Гадаргууд чанаргүй нөхөөс, шаваас, нунтаг ба элдэв ул мөр байх ёсгүй. Ямар ч тохиолдолд гадаргууг цементээр угаах буюу гипсыг хэрэглэж болохгүй.

1318. ТУЛАХ ТҮР БАЙГУУЛАМЖ БА ХЭВ ХАШМАЛ

(а) Тулах түр байгууламж

Тулах түр байгууламжийн зураг төслийг Инженерийн хүлээн зөвшөөрсөн, тулах түр байгууламж болон хэв хашмалын зураг төсөл хийх туршлага бүхий байгууллагаар хийлгэнэ.

Гүйцэтгэгч бетоны ажил эхлүүлэхээс өмнө 21 хоногийн дотор, түр байгууламжийн

нарийвчилсан ажлын зураг ба тооцоог Инженерт танилцуулна.

Ажлын зураг болон тооцоог мэргэжлийн зураг төслийн байгууллагаар баталгаажуулсан байх ёстой. Тооцоог хийхдээ бетоныг цутгах, нягтруулах, тэгшлэх, засварлахад шаардагдах тоног төхөөрөмж, дэвсэх дараалал ба хурдыг харгалзан үзсэн байх ёстой.

Гүйцэтгэгчээс ирүүлсэн түр байгууламж болон хэв хашмалын ажлын зураг болон тооцоог Инженер баталсан ба үүний дагуу Гүйцэтгэгч хэв хашмал болон түр байгууламжийг барьсан байсан хэдий ч хэв хашмал болон түр байгууламжийн шаардлага хангасан эсэх болон аюулгүй байдлыг Гүйцэтгэгч дангаар хариуцна.

Гүйцэтгэгч хэв хашмал болон түр байгууламжийн зураг төсөл, барилга болон арчлалттай холбоотойгоор хүн буюу эд хөрөнгөнд гарч болзошгүй аливаа хохирлоос Захиалагч ба Инженерийг сэргийлнэ.

Тулах түр байгууламж болон хэв хашмал нь тухайн дэвсэх хурд болон аргачлалаар бетоныг дэвсэх болон нягтруулахад бетон хатуурч бэхэжсэний дараа бетоны хэвлэмэл гадаргуу нь техникийн шаардлагын зүйл 1321-т заасан хүлцэх алдааны хязгаарт хэлбэлзэж, зурагт үзүүлсэн байрлалд байхаар, мөн ийнхүү тавьсан бетоны ачааллыг даах чадвартай байхаар тооцож баригдсан байна.

Инженер зургийг зөвшөөрсний дараа Гүйцэтгэгч зургийн дагуу тулах түр байгууламжийг барина. Ажлын зурагт үзүүлсэн тулах түр байгууламжид өөрчлөлт хийхээр бол зураг төслийг боловсруулсан этгээдээр батлуулж, Инженерт танилцуулахаас нааш өөрчилж болохгүй.

(1) Ачаалал

Хэв хашмалд ирэх тооцоот ачаалал нь босоо чиглэлийн тогтмол ба хөдөлгөөнт бүх ачаалал ба хэвтээ чиглэлийн ачааллын нийлбэрээс бүрдэнэ. Тогтмол ачаалалд барилгын ажилд хэрэглэж байгаа бүх материал болон хэв хашмалын нийт жин багтана. Бетон, арматур төмөр болон хэв хашмалын нийт жин нь ердийн бетоны жингийн 2.60 тн/м^3 -ээс багагүй байна.

Хөдөлгөөнт ачаалал нь аливаа тоног төхөөрөмжийн гадаргуутай харьцаж байгаа цэгүүдэд төвлөрч ирэх жин ба нийт талбайд ирэх 98 кг/м^2 -аас доошгүй жигд ачаа болон хавтангийн гадаад ирмэгт ирэх 112 кг/м ачаанаас бүрдэнэ.

Түр байгууламжийн холболтын системийг төсөллөхөд шаардлагатай хэвтээ ачаалал нь тоног төхөөрөмж, ажлын дараалал, шингэн бетоны тэнцвэргүй гидростатик хүч, урсалт, салхины хүч зэргээс үүдсэн хэвтээ ачааллын нийлбэрээс бүрдэнэ. Ямар ч чиглэлд ирж байгаа хамгийн бага хэвтээ ачаалал нь нийт тогтмол ачааллын 2 хувьтай тэнцүү байна. Хуучин, шинэ эсвэл хэсэгчлэн бэлэн болсон хийцэд тулах түр байгууламжаас ирэх ачаалал нь авто замын гүүрний AASHTO, II Бүлгийн “Ачааллын тухай 8.15-р зүйлд зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэхгүй байна.

(2) Суурь

Түр байгууламжийг суулт өгдөггүй, ирж байгаа ачааллыг даах чадвартай материалаар хийгдсэн бат бэх суурин дээр суурилуулсан байна. Хэрэв суурь норох магадлалтай бол суурийн материалд үзүүлэх усны нөлөөг бодолцох хэрэгтэй. Инженер шаардвал Гүйцэтгэгч нь ачааллын туршилт хийж түр байгууламжийн суурийг төсөллөхөд тооцсон хөрсний даах чадвар нь тухайн хөрсний даах чадвараас илүүгүй гэдгийг нотолно.

Хэрвээ тулах түр байгууламжийг шаардлага хангасан суурь дээр суурилуулах боломжгүй

бол түр байгууламжийг Инженерийн шаардлагад нийцсэн бат бэх, туршигдсан тулгууруудаар тулж өгнө.

(3) Хазайлт

Түр байгууламжийг, хэрэв Инженер шаардсан бол бэлэн болсон гадаргууд зохих хэвгий ба налуу гаргахын тулд түр байгууламжийн дам нуруу болон хэвийн хооронд янз бүрийн хотойлттой гүдгэр хавтанцруудыг бэхэлж барина. Гүйцэтгэгч тогтмол ачааллын улмаас үүсэх хазайлт ба бетон дэвссэнээр үүсэж болох бусад хэв гажилтыг тооцсон байна.

Газар дээр нь цутгасан бетон хийцүүдийн хувьд, гулзайлтыг зохих гүдгэр хавтанцруудаар зохицуулсан байсан хэдий ч түр байгууламжийн эд ангиудын гулзайлтын тооцоолсон хэмжээ нь тэдний уртын 1/240-өөс хэтрэх ёсгүй.

(4) Чөлөөт зай

Инженер өөрөөр заагаагүй бол барилгын ажлын үеэр тээврийн хэрэгслийн хөдөлгөөн явж байгаа үед түр байгууламжийн доторх чөлөөт зайн өргөн нь түр байгууламжтай нийлэх замын өргөнөөс 1.5 метрээр их харин өндөр нь 4.5 м байна.

(5) Түр байгууламжийг барих

Тулах түр байгууламжийг даацын ган материалаар барина. Даацын ган хоолой нь нимгэн байж болохгүй. Түр байгууламжийг зохих түвшинд угсрах, бетон цутгах үед бага зэргийн зохицуулалт хийх болон түр байгууламжийг бага багаар буулгах боломжтой болгох зорилгоор шон бүрт эрэг боолт, хос шаантаг болон бусад зөвшөөрөгдсөн тоноглолыг бэхэлж өгнө.

Үүнээс гадна Гүйцэтгэгч нь хэв хашмалд тоолуур суулгах, төвшин ба чиг заах хатуу цэгт уртасгагч холбох зэрэг зөвшөөрөгдсөн аргаар бетон цутгалтын үед түр байгууламжийн суултыг нарийн хэмжих хэрэгслээр хангана.

(b) Хэв хашмал

(1) Ерөнхий

Хэв хашмалыг мод, төмөр болон бусад зөвшөөрөгдсөн материалаар доторлож хийсэн хийц байна. Хэв хашмалыг түүнд ирэх аливаа даралтыг гажилтанд оролгүйгээр даахуйц, бат бөх байхаар хийнэ. Хэв хашмал нь бетоны нүүрэн талд эвдрэл үүсгэлгүйгээр амархан салахаар хийгдсэн байх ба, хэрэв шаардлагатай бол, бетоны нүүр талуудын зөв байрлалыг хангах үүднээс бетоны байрлалыг бага зэрэг өөрчлөх зориулалттай хэрэгслээр тоноглогдсон байна. Хэв хашмалыг угсрахдаа шинэхэн бетоны жингийн үйлчлэлээр бий болох аливаа хөдөлгөөн, хазайлт буюу суулт зэргийг харгалзан үзэх ёстой.

Бетоны нүүрэн талыг Инженерийн хүлээн зөвшөөрөх хэмжээнд нэгэн жигд бүтэц ба өнгө бүхий гөлгөр гадаргуутай байлгах зорилгоор хэв хашмалыг PCI стандартын В-В дотор заслын I ангиллын наамал банз буюу усан онгоцонд хэрэглэдэг BS 1088 стандартын наамал банзаар доторлоно.

Бетоны ил гарах гадаргуугийн хэв хашмалын залгаасууд нь хэрэв өөрөөр заагаагүй бол, хэвтээ ба босоо байдлаар тэгш байрлууллагдсан, үргэлжилсэн байх буюу эсвэл нэгэн жигд хээтэй байна. Хийцийн нийт хэсэг бүрт хэвийн доторлогооны ижил төрлийн материал хэрэглэнэ.

Хэрвээ хэв хашмал цухуйсан байвал агаарыг гаргаж тэр хэсгийг сайтар нягтруулагдсан бетоноор дүүргэнэ. 30°-ийн налууутай буюу түүнээс налуу байдлаар бетон гадаргуу цутгахаар бол хэв хашмал ашиглана.

Харин 20°-ээс бага налуутай хийвэл гадаргууг тэгшлэх аргаар налуу гаргана. 20°- 30° хоорондох налууг Гүйцэтгэгч, хэрвээ бетоныг нягтруулах үед бетоныг байранд нь байлгаж чадах тусгай тэгшлэгч хавтан хэрэглэн гадаргууг тэгшилж чадахаа Инженерт баталж чадахгүй бол хэв хашмал хэрэглэнэ.

Бетоны гадаргуу дээр хэвтээ ба налуу байдлаар хийгдсэн хэв хашмалыг шинэ бетоны хийн даралтын улмаас дээшээ өргөгдөхгүй байхаар сайтар бэхэлнэ. Бетоны их бие доторх нүхний хэв хашмалыг хөвөхөөс сэргийлж арга хэмжээ авна.

Эвдэрсэн хэв хашмалыг салгасны дараа энэ нь бетон гадаргууг гэмтээж болзошгүй бол дахин хэрэглэж болохгүй. Бэлэн бетон хийцийг барилгын ажилд байнгын хэв хашмалын зориулалтаар ашиглахаар Гүйцэтгэгч санал болгож болох бөгөөд Инженерээс зөвшөөрөл авна.

Эдгээр хийцүүдийг 1321 хэсэгт заасан хүлцэх алдааны хязгаарт зөв төвшин ба чигт суулгаж, бетон цутгах үед хөдлөхгүй байхаар бэхэлсэн байна.

Бетонтой харьцах хэв хашмалын бүх гадаргууг арматур байрлуулахаас өмнө сайтар цэвэрлэж, хэвийг бетоноос салгахад хялбар болгох зориулалттай зөвшөөрөгдсөн химийн буюу бусад эмульсийг түрхэж өгнө. Цэвэр эрдэс тос ба усанд уусдаг эмульс хэрэглэхгүй.

Гүйцэтгэгч нь төлөвлөсөн шингэн нэмэлтүүдийг тохирох эсэхийг батлах туршилтын хавтан цутгана. Дараах шинж чанар бүхий эмульсийг хэрэглэж болохгүй. Үүнд:

- хэвлэмэл гадаргуугийн дээр тавигдах аливаа материалын барьцалдах чанарыг бууруулдаг;
- хэвлэмэл гадаргуун бэхжилтийг удаашруулдаг;
- гадаргууг хэврэг болгодог;
- агаарын зай үүсгэдэг;
- толбо үүсгэдэг;
- гандуулдаг;
- өнгө өөрчилдөг.

(2) Хэв хашмалыг төсөллөх

Хэв хашмал нь АСІ стандарт, “Бетоны хэвийн практик зөвлөмж,” (АСІ 347) эсхүл Инженерийн зөвшөөрсөн олон улсад түгээмэл хэрэглэгддэг стандартыг хангасан байна. Хэв хашмалыг төсөллөхөд гидростатик даралтыг сонгохдоо доорх зүйлүүдийг анхаарна.

Үүнд:

- ✓ бетон дэвсэх үеийн тооцоолж буй хамгийн их хэмжээ;
- ✓ төлөвлөсөн хольцны өтгөрөлт ба хөдөлгөөнт чанар;
- ✓ доргилтын нөлөө;
- ✓ бетоны температур;
- ✓ орчны температур;
- ✓ бетон хольц дахь удаашруулагч буюу зөөлрүүлэх бодисууд.

(3) Хэв хашмалыг барих

Хэв хашмалыг дахин хэрэглэхээс өмнө цахилгаан хөдөлгүүрт механик багажаар цэвэрлэж эвдрэл, гэмтлийг шалгаж, шаардлагатай засварыг хийнэ. Хэрвээ бетон цутгах үеэр буюу цутгахаас өмнө ямар нэгэн согог илэрвэл Инженер(хяналтын инженер буюу хяналтын зөвлөх багийн ахлагч)- согогыг залруултал ажлыг зогсоож болно.

Гүйцэтгэгч хэв хашмалыг угсрахдаа хэвийн хажуугийн талуудыг буулгах үед доод

хэсгийн хэвийг хөндөхөөргүй хийнэ. Хэрэв тулгууруудыг үлдээж, доод хэсгийн хэвийг салгах шаардлагатай бол цохилтын үед тулгууруудыг хөндөж болохгүй. Гүйцэтгэгч хэв хашмалыг задлах зорилгоор тулгууруудыг түр зуур зайлуулаад дараа нь буцааж тавих ёсгүй.

Хэвэн доторх төмөр холбоос ба бэхэлгээнүүдийг бетоныг гэмтээлгүйгээр бетоны нүүрнээс хамгийн багадаа 60мм-ийн зайнд салгаж болохоор хийнэ. Төмөр холбогчийг авсны дараа бетонд үлдэх хонхор зай нь аль болох бага байхаар бэхэлгээг суулгаж өгнө. Хонхор зайг техникийн шаардлагын 1317 (а) дэд зүйлийн дагуу цементэн зуурмагаар шавж гадаргууг янзална.

Хэвийн тулгууруудыг өмнөх тавьсан бетоной нь Инженерийн хэрэглэхийг зөвшөөрсөн эрэг чагтаар холбож боож болно. Хэрвээ бетоны төмөр холбогч нь эрэг чагттай холбоотой бол байранд нь салгалгүй үлдээх төмөр нь бетоны нүүрэн талд 60мм-ээс илүү ойр байж болохгүй.

Хэв хашмалын дотор талыг нь цэвэрлэхэд түвэгтэй бол энэ зориулалтаар хэвэнд түр нээлхий гаргаж өгнө.

Бетоны дотор ба гадна өнцгүүдэд 20мм х 20мм-ийн шинэ хатуу банзны тусламжтайгаар ховил гаргаж өгнө. Инженер өөрөөр заавар өгөөгүй бол ил харагдах бетон гадаргууд цэвэр, тэгш, хэвтээ залгаас үүсгэхийн тулд хэвэнд шинэ 25 мм² -ийн дөрвөлжин хатуу банз суулгаж өгнө.

Хэвийг хийхдээ бетоны овор хэмжээ болон чиглэл нь бүх талаараа ажлын зурагт заасан бүх өгөгдлүүдийг нарийн баримталсан байхаар хольцтой нягт суух байдлаар хийнэ. Арматурын хэвнээс цухуйсан хэсгүүдээр цементийн сүүг гоожуулахгүйн тулд хэвийг арматуруудын эргэн тойронд маш нягт хийнэ.

(4) Хэв хашмалыг бетон цутгахад бэлдэх

Түр байгууламж ба хэвийг угсарсны дараа төмөр арматурыг байрлуулахаас өмнө Гүйцэтгэгч, түр байгууламж ба хэвийг сайтар шалгаж үзнэ. Хэмжээсүүдийг шалгаж, овор товонтой гадаргууг тэгшилж, ялангуяа эрэг чагт, холбоос чанга хийгдсэн эсэх ба суурийн бат бэх байдал зэргийг сайтар анхаарч үзэх ёстой.

Хэв хашмалд арматур суурилуулахаас өмнө хэв хашмалын дотор талыг сайтар цэвэрлэж, техникийн шаардлагын 1318(б) зүйлд заасны дагуу зөвшөөрөгдсөн эмульсээр түрхлэг хийнэ. Зэрэгцээ бетон гадаргуунуудын өнгө өөр өөр болохоос зайлсхийж нэг барилгын ажлын хэв хашмалд зөвхөн нэг төрлийн эмульс, шингэнийг хэрэглэнэ.

Хэв хашмалыг суулгахаас өмнө арматурыг байрлуулах шаардлага гарвал хэв хашмалын гадаргууг бэлдэх бүх ажлуудыг түүнийг эцсийн байршилд байрлуулахаас өмнө хийж гүйцэтгэнэ.

Арматурыг эмульс шингэнээр бохирдуулж болохгүй. Бетон цутгахаас өмнө хэв хашмалаас бүх хог, шороо, барилгын хаягдал болон бусад гаднын материалыг гарган хаяна. Гүйцэтгэгч бетон цутгаж эхлэхээс өмнө бүх шаантаг ба тохиргооны хэрэгслүүдийг бетон цутгах үед хөдлөхөөс хамгаалж бетоныг цутгах үед тэдгээрийг хөдөлгөөнгүй байлгах талаар байнга хяналт тавьж байна.

Гүйцэтгэгч, хэв хашмал, тулах түр байгууламж болон арматур төмрийг байрлуулсны дараа бетон цутгах гэж байгаагаа бетоны ажил эхлэхээс өмнө 24 цагийн өмнө Инженерт

бичгээр мэдэгдэнэ. Гүйцэтгэгч Инженерт ийнхүү мэдэгдэхээс өмнө өөрөө ажил нь энэхүү техникийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж баталгаажуулсан байна. Инженер Гүйцэтгэгчид ажил эхлэх зөвшөөрөл бичгээр өгөхөөс нааш бетон цутгах ажлыг эхлэхгүй.

(с) Түр байгууламж ба хэвийг задалж буулгах

(1) Ерөнхий

Гүйцэтгэгч, Инженерийн зөвшөөрлийг бичгээр урьдчилан авахаас нааш түр байгууламж ба хэвийг буулгахгүй. Түр байгууламж болон хэвийг буулгах хугацааг тухай хийцийн байршил ба төрөл, цаг агаарын нөхцөл, бетон хольцод орсон материал болон бетоны бат бэхэд нөлөөлж болох бусад хүчин зүйлүүдийг харгалзан тогтооно.

Хэвийг бетоныг цохиж хөндөлгүйгээр болгоомжтой буулгана. Бетон нь түр байгууламж болон хэвийг буулгах үед бетонд ирж болох аливаа ачааллыг даах хэмжээний хангалттай бат бэхтэй болтол хэвийг салгахгүй.

Бетонд хэт их ачаалал өгөх эсвэл гадаргууг гэмтээж болох аргаар хэвийг буулгаж болохгүй. Хийц нь жигд, аажмаар өөрийн жингийн ачааллаа авах боломжтой байдлаар тулгууруудыг буулгана. Инженер өөрөөр заагаагүй бол гүүрийн хашлагыг барихаас өмнө хэв хашмалыг буулгана.

(2) Хэв хашмалыг салгах хугацаа

Бетоныг цутгаж дуусах ба хэв хашмал, түр байгууламжийг буулгах хоёрын хооронд өнгөрөх хамгийн бага хугацаа 0°C - 25°C хэмийн орчны температурт ямар байхыг хүснэгт 13-11-т өгөв. Дээр зааснаас бага температурт буюу энгийн ба сульфатад тэсвэртэй портландцементээс бусад төрлийн цемент хэрэглэж байгаа бол Инженер өөр хугацаа өгч болно.

Хүснэгт 13–11: Хэвтэй нь байлгах хамгийн бага хугацаа
(энгийн болон сульфатад тэсвэртэй портландцемент бетон)

Хэв хашмалын төрөл	Орчны дундаж температур					
	Хэвтэй нь байлгах хамгийн бага хугацаа					
	25° С	20° С	15° С	10° С	5° С	0°
Багана, хана ба том дам нурууны босоо хэв хашмал	9 өдөр	0 өдөр	12 өдөр	15 өдөр	20 өдөр	30 өдөр
Хавтангийн хэвтээ хавтгай хэв хашмал	3 өдөр	3 өдөр	4 өдөр	5 өдөр	7 өдөр	10 өдөр
Дам нуруу болон дам нурууны тулгуурын хэвтээ хавтгай хэв хашмал	7 өдөр	8 өдөр	10 өдөр	13 өдөр	17 өдөр	25 өдөр
Дам нурууны тулгуурын хэв хашмал	10 өдөр	12 өдөр	14 өдөр	18 өдөр	24 өдөр	36 өдөр

Бетоноос авсан шоог эх бетоной адил арчилж, бэхжүүлсний дараа шооны бат бэх (хүснэгт 13-12)-т өгөгдсөн бат бэхтэй болсон хойно хэв хашмал ба түр байгууламжийг буулгаж болно.

Хүснэгт 13-12: Хэв хашмалыг салгахаас өмнөх бетон шооны бат бэх
(Энгийн болон сульфатад тэсвэртэй портландцемент бетон)

Түр байгууламж ба хэв хашмалын төрөл	Хэвийг буулгахаас өмнөх шооны 28 хоногийн бат бэх %
Багана, хана ба том дам нурууны босоо хэв хашмал	30
Хавтангийн хэвтээ хавтгай хэв	35
Дам нуруу болон дам нурууны тулгуурын хэвтээ хавтгай хэв	40
Props to beams	50

Эдгээр шаардлагыг биелүүлэх нь Гүйцэтгэгчийг бетоныг гэмтээлгүйгээр хэв хашмалыг хугацаанд нь салгах хариуцлагаас чөлөөлөхгүй.

Хэв хашмалыг буулгасны дараа дараагийн ажилд хэрэглэгдэхгүй, бетоны нүүрэнд байгаа эрэг чагтны нүхнүүдийг хольцоор сайтар бөглөж, техникийн шаардлагын 1317 (а) дэд зүйлийн дагуу өнгөлнө.

(3) Хязгаарлалт

Дор дурдсанаас бусад тулах түр байгууламж болон хэв хашмалыг буулгана. Үүнд:

- Замын далангийн хөлдөлтөөс хамгаалах үеэс доош 0.3 м-ээс илүү гүнд байгаа, эсвэл замын далангаас гадна ул хөрсний төвшнөөс 0.6 м болон урсгал залах сувгаас 0.6 м доош гүнд байгаа тулах түр байгууламжийн тулгуурын хэсэг;
- Хэв хашмалыг нь салгавал бусад хэсгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй суурийн хэв хашмалууд;
- Хүрч болохооргүй хаалттай хэсгүүдийн хэв хашмал;
- Зурагт үзүүлсэн бусад байгууламжийг нэмж угсрахад тэдэнтэй харьцдаггүй
- хайрцган дам нуруут гүүрнүүдийн хэв хашмал.

1319. ӨТГӨН БА ШИНГЭН ЗУУРМАГ (ЦЕМЕНТИЙН УУСМАЛ БА ЗУУРМАГ)

(а) Ерөнхий

Энэ хэсэгт бетон хийцэд ашиглах зуурмагийн тухай заасан байгаа. Тухайлбал чулуун бэхэлгээнд орох, гадаргуугийн нүх болон бусад гологдлыг засах, бэхэлгээний боолтын хөндийг дүүргэх гэх мэт ажлуудад хэрэглэгдэнэ.

Зуурмаг түрхэх гадаргуу дахь бүх сул ба гаднын материалыг цэвэрлэнэ. Дараа нь зуурмаг хийхээс өмнөхөн тэдгээрийг усаар урсган гадаргууг хатаана.

Бага хэмжээний зуурмагийг гараар зуурч болох боловч 0.5м³ -ээс их зуурмагийг зуурагчаар зуурна. Зуурсны дараа зуурмагийг усаар шингэлж болохгүй ба нэг цагийн дотор дэвсэх хэрэгтэй.

Зуурмагийг дэвссэний дараа техникийн шаардлагын дэд зүйл 1312 (в) (2)-ийн дагуу 5-аас доошгүй хоног усаар арчилна.

(b) Нийтлэг зорилгоор ашиглах зуурмаг

Зуурмаг нь техникийн шаардлагын дэд зүйл 1303 (г)-д заасан шаардлагыг хангасан нарийн чулуун материал болон AASHTO M85 стандартыг хангасан IA ангиллын портландцементээс бүрдэнэ. Зуурмагийн орцыг зурагт болон техникийн шаардлагад заасны дагуу орцлох ба хэрэв алинд нь ч заагаагүй бол цемент- чулууны жингийн харьцаа 1:2 байна.

Зуурмаг дахь усны агуулга нь аль болох бага байх ба ямар ч тохиолдолд ус/цементийн харьцаа нь 0,5-аас ихгүй байна. “Хуурай чигжээс” гэх зуурмаг нь хольцыг барьцалдуулахад хангалттай хэмжээний устай боловч гарт базах үед уян биш байна. Хуурай чигжээсийг хөндий рүү гар чигжигчээр дүүргэж, гүйцэд нягтралтай болгох үүднээс гар алхаар сайтар чигжинэ.

(c) Хонхор ба нүхийг чигжих

Хонхор ба нүхнүүдийг өндөр даралтын агаар болон ус шүршигчээр сайтар цэвэрлэнэ. Алмаазан хошуутай өрмөөр өрөмдсөн нүхнүүдийг барзгар болгоно. Цэвэр ус ба цементийг жингийн 1:2 харьцаагаар хольсон шингэн зуурмагаар хонхор, нүхнүүдийг дүүргэнэ. Бүх нүхийг дүүрэнгүүт шингэн зуурмаг хийхээ зогсоож, бетон суурь дээр гоожсон зуурмагийг сайтар цэвэрлэн дараагийн ажил хийгдэхээс өмнө гадаргууг хатаана.

(d) Суурийн хавтангуудын доорх чигжээс

Суурийн хавтангууд болон бетон дэвсгэр үеийн завсрыг портландцемент болон нарийн ширхэгтэй чулууг 1:1 харьцаагаар хольсон тусгай зуурмагаар дүүргэнэ. ASTM C845-ийн шаардлагад нийцсэн, Инженерийн зөвшөөрсөн агшилтын эсрэг үйлчилгээтэй нэмэлт бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу орцлон нэмж холино.

Тусгай зуурмагийн ус/цементийн харьцаа нь зуурмагийг хамгийн их нягт авахаар нягтруулж чигжихэд хангалттай боловч аль болох бага байна. Тусгай зуурмагийг суурийн хавтангийн доогуур хэвтээ чиглэлд дүүргэх ба нөгөө гурван талаар зуурмаг гарч иртэл алхаар чигжинэ. Зуурмагийг ямар ч агаарын зайгүй нягтруулах үүднээс шахагдан гарч ирсэн зуурмагийг алхаар буцааж чигжинэ.

1320. БЕТОН ЦУТГАЛТЫН АЖЛЫН БҮРТГЭЛ

Гүйцэтгэгч нь Инженерийн зөвшөөрсөн маягт дээр бетоны цутгалт бүрийн тухай бүртгэл хөтөлнө. Энэ бүртгэлд дараах зүйлүүдийг багтаана.

Үүнд:

- Бетоны төрөл;
- Бетоны суулт;
- Цутгасан байршил;
- Цутгасан огноо, цаг;
- Дэвсэх үеийн орчны болон бетоны температур;
- Чулуун материалын чийгийн агуулга;
- Хольцын найрлага;
- Зууралтын дугаар;
- Цементийн нийлүүлэлтийн дугаар;
- Бэхжих үеийн орчны температур;

- Туршилт, шинжилгээнүүдийн хариу;
- Туршилтын шоо авсан байршил ба шооны өгөгдлүүд;
- Өрөмдлөг хийсэн тухай тодорхойлолт.

Гүйцэтгэгч 7 хоног бүр өнгөрсөн долоо хоногт гүйцэтгэсэн ажлыг тусгасан эдгээр бүртгэлийн 4 хувийг Инженерт өгнө.

Үүнээс гадна 28 хоног дахь шооны бат бэх, нормоос зөрсөн хэлбэлзлийг сар тутмаар болон өссөн байдлаар (хяналтын инженер буюу хяналтын зөвлөх багийн ахлагч)-ийн шаардсан бетоны ажилтай холбоотой бусад мэдээллийг Инженерт гаргаж өгнө.

1321. СОГОГТОЙ БЕТОНЫГ ЗАСАХ

Хэвийг салгасны дараа бетоны гадаргуу элдэв согогтой байвал гадаргууг Инженерт үзүүлж заавар авахаас нааш Гүйцэтгэгч гадаргууг засварлах ёсгүй. Согогтой гадаргууг шаваасаар засаж болохгүй. Гадаргуун засварын ажлыг техникийн шаардлагын 1317 (б) дэд зүйлийн дагуу гүйцэтгэнэ.

Инженер засварлахыг зөвшөөрсөн сийрэгжиж, арзайсан гадаргууг бат бэх бетон гарч иртэл буюу 75 мм гүн ухаж авна. Хэрвээ төмөрбетон байгаа бол арматураас цааш 25мм гүн ухаж авна. Гарсан нүхний тал бүрийг тэгш өнцөгт болгож засна. Хөндийг даралтат ус шүршигч буюу агаараар үлээлгэж цэвэрлэсний дараа зөвшөөрөгдсөн резин, цавуу түрхсэний дараа нэн даруй их биед хийсэн бетоной адил ангиллын, гэхдээ 10 мм-ийн хэмжээтэй чулууг нь авсан бетоноор дүүргэнэ. Бетоноор хөндийн дээд ирмэгийн дээд цэг хүртэл дүүргэж өгнө.

Долоо хоногийн дараа бетоны ирмэгийг тайрч аваад гадаргууг тэгшилнэ.

Температурын өөрчлөлт, агшилт, гулсалт, гүүрийн хавтангийн болон тулгуурын хэв гажилтын үйлчлэлээр үүсэх хөдөлгөөнийг хангах зурагт үзүүлсэн зайг Гүйцэтгэгч баталгаажуулж, улмаар үйлдвэрлэгчид мэдэгдэнэ. Үйлдвэрлэх үеийн дулаан болон суурилуулах үеийн дулааны магадлалыг харгалзан уг зайг дахин тогтооно.

Гүүрийн хавтанд гаргах хэв гажилтын заадасны ховилыг зурагт үзүүлсэн буюу үйлдвэрлэгчийн зөвлөсөн хэмжээгээр гаргана. Хавтанд гаргасан ховилыг хог шорооноос сайтар цэвэрлэнэ. Ил гарсан арматурын төмрийг заадсыг саадгүй суурилуулж болохуйц тохируулж өгнө. Хуучин бетоны гадаргуу болон хэв гажилтын заадас хийгдэх шинэ бетоны хэв хашмалын хоорондох зайг бетон цутгах үед хольц урсаж орохооргүй болтол сайн чигжсэн байна.

Зайны хэмжээ нь заадсыг суурилуулах үеийн дундаж температурт тохирсон байх ба энэ температурыг Гүйцэтгэгч ба Инженерийн урьдчилан тохирсон аргаар тодорхойлно.

Суурилуулах үеийн температур нь тооцоолсон температураас өөр байвал бетон цутгахаас өмнө шаардлагатай тохиргоог хийнэ.

Заадсыг урьдчилан бэлтгэсэн ховилд суулгаж, заадасны нэг талын анкер гогцоог хавтангийн хамгийн дээд талын арматурт техникийн шаардлагад заасны дагуу гагнахаас өмнө тэгшилж чиглүүлнэ. Үүний дараа заадасны нөгөө талд мөн ажилбарыг давтаж хийнэ.

Заадсыг байрлуулсны дараа түр тулгуурыг нэн даруй салгаж авна.

Дараа нь ховилыг хавтангийн бетоной ижил бат бэхтэй, агшилт багатай бетоноор техникийн шаардлагын бүлэг 1300-д заасны дагуу дүүргэнэ. Заадсан доорх бетоныг цутгах ба бэхжих үед заадасны эд ангиуд болон тэдгээрийг бэхэлсэн тулгууруудын хооронд харьцангуй хөдөлгөөн орохоос сэргийлнэ. Ялангуяа заадасны хоёр талыг барих хэв хэрэглэж байгаа тохиолдолд тэдгээрийг нэгэн зэрэг хоёр талд суулгаж болохгүй. Шурагны хээг цэвэр байлгаж, зэврэхээс хамгаална.

Гүйцэтгэгч полихлоропрен чигжээсийг уртыг нь тааруулан тайрч, захын хөндлөн нуруунуудын завсраар чигжээсийг гэмтээлгүйгээр болгоомжтой хийнэ. Бетоныг хангалттай хатуурсны дараа заадсуудыг тээврийн хөдөлгөөний ачааллаас хамгаалах зорилгоор заадсан дээгүүр бат бэх тавцан тавина. Зорчих хэсгийн хучилтыг тавьж Инженер тавцангуудыг авахыг зөвшөөртөл тээврийн хэрэгслийг тавцан дээгүүр явуулахгүй.

Зорчих хэсгийн хучлагын гадаргууг захын төмөр нурууны оройн хэсэгтэй нэг төвшинд байхаар тавина. Хучлагын ирмэг болон захын төмөр нурууны завсрыг шаантаг хэлбэртэй зөвшөөрөгдсөн чигжих материалаар чигжинэ. Ил гарсан захын төмрийн гадна талыг чигжээс хийхээс өмнө сайтар цэвэрлэнэ.

(е) Зөвшөөрөл авах шинжилгээ

Полихлоропрен чигжээсийн зөвшөөрөл авах шинжилгээг зөвшөөрөгдсөн лабораторид авто замын гүүрийн AASHTO стандартын II хэсэг, 18.2.3.1A ба 18.2.3.1B хүснэгтэд заасны дагуу гүйцэтгэж баталгаажуулна. Гүйцэтгэгч шинжилгээний сертификатыг Инженерт өгч батлуулна.

Үйлдвэрлэгч нь Инженерийн зөвшөөрсөн лаборатори буюу байгууллагаас дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангасныг баталсан гэрчилгээг өгнө. Үүнд:

- Захын төмөр нуруу болон анкеруудын цуцалтын бат бэх нь илэрхий эвдрэлгүйгээр 2×10^6 ачааллын өөрчлөлтийн мөчлөгийг даах чадвартай,
- Заадас нь 4 бар даралттай усыг нэвтрүүлэхгүй байх чадвартай,
- Патентлагдсан заадас нь барилгын ажлын талбайд дийлэнх байх магадлалтад ижил төстэй нөхцөлд сайн ажилласан байх.

1427. ДҮҮРГЭГЧ БҮХИЙ ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС

Энэ төрлийн заадсыг дараах материалаар хийнэ. Үүнд:

- Доод тал нь 2мм-ийн зузаантай хэлбэржүүлсэн зэс ялтас;
- 20мм-ийн зузаан битум шингээсэн мяндсан банз ба бусад зөвшөөрөгдсөн заадас дүүргэгч;
- 20мм-ийн зузаан, зөвшөөрөгдсөн хэвэнд урьдчилан цутгасан заадас дүүргэгч;
- бусад зөвшөөрөгдсөн заадас дүүргэгч;

Урьдчилан хэвэнд цутгасан заадас дүүргэгч нь дараах стандартуудын аль нэгийг хангасан байна. Үүнд:

(a) AASHTO M33, Бетоны урьдчилан хэвлэсэн хэв гажилтын заадас дүүргэгч;

(b) AASHTO M153, Бетон хучилт болон даацын барилгад хэрэглэх урьдчилан хэвлэсэн резинэн болон үйсэн хэв гажилтын заадас дүүргэгч;

(c) AASHTO M213, Бетон хучилт болон даацын барилгад хэрэглэх урьдчилан хэвлэсэн хэв гажилтын заадас дүүргэгч.

Битум шингээсэн мяндсан банз ба бусад зөвшөөрөгдсөн заадас дүүргэгчийг бүрэн хэмжээт материалын хавтангаас хэлбэрт оруулан тайрч авна. Жижиг тайрдуудыг заадсын дүүргэгчээр ашиглахыг хориглоно.

Хэв гажилтын заадсын материалыг Гүйцэтгэгч нямбайлан арчилж, агуулах, сүүдрэвч буюу контейнерт газраас хөндий хадгална. Заадсын зайг зурагт үзүүлсний дагуу гаргана. Заадсын завсраас хог шороо, сул материалыг үлээлгэж буюу угааж цэвэрлэнэ.

Инженерээр шалгуулж зөвшөөрөл авалгүйгээр заадсыг дүүргэхийг хориглоно. Урьдчилан хэвэнд цутгасан заадас дүүргэгчийг зэрэгцээ материалыг дэвсэхийн яг өмнө байрлуулна. Хэрэв нэг заадсын хоёр талд байгаа гадаргууг өөр өөр хугацаанд хийхээр бол сүүлд хийгдэх гадаргуун материалыг дэвсэхийн өмнө дүүргэгчийг хийнэ. Дүүргэгч болон заадсын суурь өнгөлгөөг үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу хийнэ. Дүүргэгч бүхий хэв гажилтын заадсын дээгүүр хучих бетонд 100 мм өргөн ба 10 мм гүн ховил гаргаж өгнө. Ховилыг нягтруулсан 6%-ийн битум агуулсан том ширхэглэлт элсний хольцоор дүүргэнэ.

Гүүрийн зорчих хэсгийн гадаргуу дээр гарсан заадсын материалын ул мөр, үлдэгдлийг

цэвэрлэж, гадаргууг Инженерийн зөвшөөрөх хэмжээнд хүртэл засна.

ДЭД БҮЛЭГ Г ГҮҮРИЙН ХАШЛАГА

1428. ЕРӨНХИЙ

Гүүрийн хашлага нь явган зорчигч болон тээврийн хэрэгслийг хамгаалах зорилгоор явган замын гадна талаар баригдсан хийц юм.

Хашлагын бетон нь өөрөө өөрийгөө даах чадвартай болохоос нааш хашлагын хэв хашмалыг авч болохгүй бөгөөд энэхүү бетон нь энэ техникийн шаардлагын бүлэг 1300-ын шаардлагыг хангасан байна.

Гүүрийн хашлагыг зурагт үзүүлсэн хэмжээ, түвшин, чиглэл, төлөвлөгөөний дагуу угсарна. Ялангуяа гүүрийн хашлагын хэв гажилтын заадсыг зөв гаргах талаар Гүйцэтгэгч анхаарах хэрэгтэй. Хашлагын шонгуудын босоо хэмжээсийн хүлцэх алдаа 1м тутамд 2мм-ээс хэтрэхгүй байх ёстой. Хашлаганы материалыг тос буюу хог шороогоор бохирдохоос сэргийлэн газраас хөндий тавцан буюу тавиурууд дээр хурааж хадгална.

1429. ГАЗАР ДЭЭР НЬ ЦУТГАХ ХАШЛАГА

Газар дээр нь цутгах хашлагыг хамгийн том ширхэглэл нь 10 мм-ийн хэмжээтэй буталсан чулуу бүхий В30 ангийн бетоноор техникийн шаардлагын бүлэг 1300-д заасны дагуу цутгана. Газар дээр нь цутгах хашлагын хэв хашмал нь дан өргөнтөй банз буюу Инженерийн зөвшөөрсөн материалаар зэрэгцүүлж зүүсэн хэв байна. Хэвний зүүдлийг хашлаганы тэгш гадаргуу дээр ирэхээр тааруулахыг хориглоно.

Бүх хэв, хавтан, ховил, налууг зурагт үзүүлсний дагуу гаргаж угсарна. Цутгасны дараа бүх өнцгүүд тэгш, хагарал, хэлтэрхий болон согоггүй байна. Шонг нэг цутгалтаар цутгана.

1430. УРЬДЧИЛАН ЦУТГАСАН ХАЙС

Урьдчилан цутгах хайсыг хамгийн том ширхэглэл нь 10 мм-ийн хэмжээтэй буталсан чулуу бүхий В30 ангийн бетоноор техникийн шаардлагын бүлэг 1300-д заасны дагуу цутгана.

ДЭД БҮЛЭГ Д – ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

1431 РЕЗИНЭН ТУЛАХ ХЭСЭГ

Нэгж: ширхэг

Резинэн тулах хэсгийн ажлын үнэлгээнд дараах ажлууд багтана.

Үүнд:

- Ажлын зураг, тооцоог боловсруулан Инженерт танилцуулах;
- Материал;
- Үйлдвэрлэлт;
- Нийлүүлэх, тээвэрлэх, арчлах, хадгалах;
- Ажиллах хүч, тоног төхөөрөмж, тулах хэсгийг суурилуулахад шаардагдах бусад багаж хэрэгсэл;
- Туршилт;

- Лабораторийн туршилтын зардал;
- Лабораторийн ажилчдыг ажиллуулах;
- Үйлдвэрлэгчийн төлөөлөгчийг ажиллуулах;
- Техникийн шаардлагын 1400-р бүлгийн дэд бүлэг Б болон авто замын гүүрийн AASHTO стандартын II хэсэг, 18.2 зүйлийн шаардлагыг хангах.

1432 ДАВИРХАЙТ ЦААСАН ТУЛАХ ХЭСЭГ

Давирхайт цаасан тулах хэсгийг хавтгай дөрвөлжин метрээр хэмжинэ. Давирхайт цаасан тулах хэсгийн талбайг зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсан хэмжээний дагуу тооцно. Давирхайт цаасан тулах хэсгийн ажлын үнэлгээнд дараах ажлууд багтана.

Үүнд:

- Материал;
- Тээвэрлэх, арчлах, хадгалах;
- Ажиллах хүч, тоног төхөөрөмж, давирхайт цаасан тулах хэсгийг суурилуулахад шаардагдах бусад багаж хэрэгсэл;
- Туршилт;
- Аливаа урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд, хэрэв шаардлагатай бол;
- Техникийн шаардлагын зүйл 1425-ийн шаардлагыг хангах.

1433 ЧИГЖЭЭС БҮХИЙ ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС

Нэгж: м

Чигжээс бүхий хэв гажилтын заадсыг зурагт үзүүлсэн гүүрийн хоёр талын хашлагын шонгийн дотор хануудын хоорондох зайны урт метрээр хэмжинэ.

Чигжээс бүхий хэв гажилтын заадсын ажлын үнэлгээнд дараах ажлууд багтана.

Үүнд:

- Материал;
- Тээвэрлэх, арчлах, хадгалах;
- Ажиллах хүч, тоног төхөөрөмж, заадсыг суурилуулах ба чигжихэд шаардагдах бусад багаж хэрэгсэл;
- Туршилт;
- Заадасны ховил гаргах ба хэв хашмалыг бэлдэх;
- Үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу патентлагдсан хэв гажилтын заадас суурилуулах;
- Анкер гогцоог хавтангийн ховилд ил гарсан арматурт гагнаж анкер хавтанг тогтоох;
- Хэв гажилтын заадсын орчмын бетоныг цутгах, нягтруулах, арчлах;
- Цементобетон хучлага болон захын төмөр нуруунуудын хоорондох завсрыг чигжих,
- Аливаа урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд, хэрэв шаардлагатай бол;
- Техникийн шаардлагын зүйл 1426-ын шаардлагыг хангах.

1434 ДҮҮРГЭГЧ БҮХИЙ ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС

Нэгж: м

Дүүргэгч бүхий хэв гажилтын заадсыг метрээр хэмжих ба уртыг зурагт үзүүлсний дагуу тодорхойлно. Хэв гажилтын заадсын ажлын үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- Урьдчилан бэлтгэсэн зэс ялтас болон бусад материал;
- Тээвэрлэх, арчлах, хадгалах;
- Ажиллах хүч, тоног төхөөрөмж, заадсыг суурилуулах ба чигжихэд шаардагдах бусад багаж хэрэгсэл;

- Заадасны ховил гаргах ба хэв хашмалыг бэлдэх;
- Аливаа заадас дүүргэгч, урьдчилан хэвлэсэн заадас дүүргэгч, битум шингээсэн мяндсан дүүргэгч;
- Хэв гажилтын заадсын орчмын бетоныг цутгах, нягтруулах, арчлах;
- Техникийн шаардлагын зүйл 1427-ын шаардлагыг хангах.

1435 ГҮҮРИЙН ХАШЛАГА

Нэгж: м

Төмөр бетон гүүрийн хашлагыг урт метрээр хэмжинэ. Гүүрийн хашлагын уртыг зурагт үзүүлсэн хавтангуудын уртын нийлбэрээр тодорхойлно.

Гүүрийн хашлагын хэв гажилтын заадас буюу урьдчилан хэвлэсэн дүүргэгчийг тусад нь хэмжих буюу төлбөр хийхгүй.

Төмөр бетон гүүрийн хашлагын ажлын үнэлгээнд дараах ажлууд багтана.

Үүнд:

- Материал;
- Тээвэрлэх, арчлах, хадгалах;
- Хэв хашмал нийлүүлэх;
- Арматур төмөр;
- Ажиллах хүч, тоног төхөөрөмж, гүүрийн хашлагыг угсрахад шаардагдах бусад багаж хэрэгсэл;
- Аливаа заадас дүүргэгч, урьдчилан хэвлэсэн заадас дүүргэгч буюу хэв гажилтын заадас, хэрэв шаардлагатай бол;
- Техникийн шаардлагын 1400-р бүлгийн дэд бүлэг Г-ийн шаардлагыг хангах.

1436 УС ЗАЙЛУУЛАХ ЦОРГО БА СУВАГ

Хэмжих нэгж: м²

Гүүрийн хавтангийн ус зайлуулах цорго ба сувагт тусад нь хэмжилт буюу төлбөр хийхгүй. Энэхүү техникийн шаардлагын зүйл 1410-ын шаардлагыг хангахад хийгдэх төлбөр нь Гүйцэтгэгчийн төмөр бетон болон цементобетоны ажлын үнэ, нэгж үнэлгээнд суусан гэж үзнэ.

1437 УС ТУСГААРЛАГЧ

Хэмжих нэгж: м²

Гүүрийн ус тусгаарлагч үеийг ажлын зураг дээрээс хавтгай дөрвөлжин метрээр авна. Техникийн шаардлагын зүйл 1411-ийн дагуу хийж гүйцэтгэнэ.

1438 ЗӨӨЛӨН МАТЕРИАЛД БАЙГУУЛАМЖ БАРИХ УХАЛТ ХИЙХ

Нэгж: м³

Байгууламжийн зөөлөн материалын ухмалыг куб метрээр хэмжинэ. Ухмалын эзлэхүүнийг тооцоходоо, даац багатай (тэгшилгээний) бетоны зааварчлагдсан зузааныг хамруулаад, суурь буюу байгууламж газраас дээш босоо чиглэлд өргөгдөх үед үүсэх онолын хоосон зай хөндийгөөр тооцоолно. Эдгээр хязгаараас хэтэрсэн ажлын талбайд төлбөр хийгдэхгүй. Энэ онолын хоосон зайг тооцоолоходоо Инженер ба Гүйцэтгэгчийн тохиролцсон далангийн доорх ул суурийн төвшин буюу шороон далангийн төвшингийн аль илүү намханд нь болон ухмалын ёроолын зааварласан төвшин хоёрын хоорондох зөрүү дээр үндэслэн тооцоолно.

Байгууламжийн зөөлөн материалын ухмалын үнэлгээнд дараах ажлуудын зардал багтана.

Үүнд:

- Инженерийн зааварласан буюу зурагт үзүүлсэн гүн хүртэл ухах;
- Ухмалын бетон цутгах гадаргууг хэлбэржүүлж, тэгшлэх;
- Ухмалын суурь тавигдах гадаргууг нягтруулах;
- Ухмалаас гарсан буюу сонгон авсан материалаар буцааж дүүргэх;
- Ашиглахад тохиромжгүй буюу илүү гарсан ухмалын материалыг хаягдал материалын талбай руу зөөх;
- Энэ техникийн шаардлагын 1400-р бүлгийн дэд бүлэг А-г хангахтай холбоотой зардлууд.

Байгууламжуудтай залгаа газрын төвшнээс дээш өндөрлөгөө хийхэд зориулж далан барих үнэлгээ ба үнээс тусдаа төлбөр хийгдэхгүй.

1439 ЗӨӨЛӨН МАТЕРИАЛД ГОЛЬДРОЛ ЗАСАХ УХАЛТ ХИЙХ

Нэгж: м³

Зөөлөн материалд голын урсгалыг залах ухалт хийх ажлын хэмжих нэгж нь куб метр байна. Эзлэхүүн нь ухмал хийх талбайн тэнхлэгийн дагуу 10 м-ээс хэтрэхгүй зайд хэмжсэн талбайн дунджийг ухмалын уртад үржүүлсэн үржвэртэй тэнцүү байна. Талбайн хэмжээг ухмалыг эхлэхээс өмнө хэмжсэн газрын төвшин буюу одоо байгаа голын, эсвэл усны урсгалын огтлолоос ба зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварласнаар тооцон гаргана.

Зөөлөн материалд голын урсгалыг залах ухмалын ажил хийх үнэлгээнд дор дурдсан ажлын зардлыг тооцон оруулна.

Үүнд:

- Аливаа гүн ба гольдролын өргөн хүртэл хийх ухмал;
- Ухмалын хажуу талууд ба суурийг хэлбэржүүлж тэгшлэх;
- Ухмалын материалыг ашиглагдахгүй материалын талбайд зөөвөрлөх;
- Энэ техникийн шаардлагын 1400-р бүлгийн дэд бүлэг А-г хангахтай холбоотой зардлууд.

1440 ХАТУУ МАТЕРИАЛЫН УХАЛТ

Нэгж: м³

Энэ техникийн шаардлагын дэд зүйл 1443-д хамаарах хатуу материалын ухмалын ажлын хэмжих нэгж нь куб метр байна. Хатуу материалын ухмалын эзлэхүүн нь ухмалын дагуу Инженертэй зөвшилцсөн зайд хэмжсэн дундаж хөндлөн огтлолын талбайг хатуу материал гаргаж авах ухмалын уртад үржүүлсэн үржвэртэй тэнцүү байна. Хөндлөн огтлолын талбайг ухмал хийхээс өмнө хатуу материалын орой хэмжсэн төвшин ба хатуу материал гаргаж авсны дараах төвшин буюу тодорхойлсон төвшинд хүртэл хэмжсэн түвшнээс тооцоолно.

Эзлэхүүнээрээ 0.75 м³-ээс том хэмжээтэй чулуу бүхий ухмалаас гарах хатуу материалын эзлэхүүнийг түүнийг зөөх тээврийн хэрэгслийн сул эзлэхүүний 50%-иар бодож төлбөр хийнэ.

Хатуу материалын ухмалын нэмэлт ухмалын үнэлгээнд аливаа гүнд хийсэн ухмалын зардал ба энэ техникийн шаардлагын зүйл 1402, 1403-ийг хангахтай холбоотой зардлыг тооцож оруулна.

1441 ШҮҮРҮҮЛЭХ МАТЕРИАЛ

Нэгж: м³

Шүүрүүлэх материалыг хэмжих нэгж нь куб метр байна. Материалын эзлэхүүнийг шүүрүүлэх материалаар буцааж дүүргэхээр зааварласан талбайг уг материалыг тавих дундаж гүний хэмжээгээр үржүүлсэн үржвэрээр тооцоолж гаргана.

Шүүрүүлэх материалын үнэлгээнд дор дурдсан ажлуудын зардлыг тооцоолж оруулна.
Үүнд:

- Материалыг олборлох;
- Тодорхой гүнд буцаан дүүргэлт хийх;
- Бүх шаардлагатай тээвэрлэлт;
- Энэ техникийн шаардлагын 1400-р бүлгийн дэд бүлэг А-г хангахтай холбоотой зардлууд

1442 ЗОХИСТОЙ ШИРХЭГТЭЙ ДҮҮРГЭГЧ МАТЕРИАЛ

Нэгж: м³

Зохистой ширхэглэл бүхий дүүргэгч материалыг хэмжих нэгж нь куб метр байна. Материалын эзлэхүүнийг зохистой ширхэглэлтэй дүүргэгч материалаар буцааж дүүргэхээр зааварласан талбайг олохдоо уг материалыг тавих дундаж гүний хэмжээгээр үржүүлсэн үржвэрээр тооцоолж гаргана.

Зохистой ширхэглэл бүхий дүүргэгч материалын үнэлгээнд дор дурдсан ажлуудын зардлыг тооцоолж оруулна.

Үүнд:

- Материалыг олборлох;

- Тодорхой гүнд хүртэл буцааж дүүргэх;
- Бүх шаардлагатай тээвэрлэлт;
- Энэ техникийн шаардлагын дэд бүлэг А-г хангахтай холбоотой зардлууд.

1443 ЦЕМЕНТЭН ЗУУРМАГААР БЭХЖҮҮЛСЭН ЧУЛУУН БЭХЭЛГЭЭ

Нэгж: м²

Цементэн зуурмагаар бэхжүүлсэн чулуун бэхэлгээг хэмжих нэгж нь квадрат метр байна. Талбайг чулуун өрлөг хийхээр Инженерийн зааварласан налууд хэмжсэн талбайгаар тооцоолно.

Цементэн зуурмагаар бэхжүүлсэн чулуун бэхэлгээний үнэлгээнд дор дурдсан зардлыг оруулж тооцно. Үүнд:

- Ухмал хийх;
- Ухмалын материалыг хаягдал материалын талбайд зөөвөрлөх;
- Нэг шугам ба төвшинд тэгшлэх;
- Ухмалын хажуу талууд ба суурийг нягтруулах;
- Чулуун бэхэлгээнд ашиглах материалыг олборлох ба өрлөг хийх;
- Бүх шаардлагатай тээвэрлэлтүүд;
- Энэ техникийн шаардлагын зүйл 1412-г хангахтай холбоотой зардлууд

1444 ЧУЛУУН АСГААС

Нэгж: м³

Чулуун асгаасыг хэмжих нэгж нь куб метр байна. Хийхээр зааварласан чулуун асгаасын эзлэхүүнийг зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварласан хэмжээгээр тооцоолно.

Чулуун асгаасын үнэлгээнд дор дурдсан ажлуудын зардлыг оруулан тооцно. Үүнд:

- Хуурай чулуун өрлөгтэй хананы ухмал;
- Ухмалын материалыг тогтоосон хаягдал материал зайлуулах талбайд зөөвөрлөх;
- Чулуун асгаасын материалыг олборлох, дэвсэх, чулуун асгаасыг хийх;
- Бүх шаардлагатай тээвэрлэлтүүд;
- Энэ техникийн шаардлагын зүйл 1413-г хангахтай холбоотой зардлууд

БҮЛЭГ 1500 - ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭ

БҮЛЭГ 1500 - ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭ

1501. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
1502. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	2
1503. ГАДАРГУУГИЙН БЭЛТГЭЛ	2
1504. ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ УЛААН ШУГАМ ТАВИХ.....	2
1505. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯЗГААРЛАЛТ	3
1506. ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ	3
1507. ТУНГАЛАГ ЛАКААР БУДАХ.....	3
1508. ХҮЛЦЭХ АЛДАА.....	3
1509. ТЭЭВРИЙН ХӨДӨЛГӨӨНӨӨС ХАМГААЛАХ	4
1510. ЧАНАРГҮЙ АЖИЛ БА МАТЕРИАЛ.....	5
1511. ЗАМЫН ТЭМДГИЙН ГЭРЭЛ ОЙЛГОГЧ	
1512. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР.....	5

1501. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Замын тэмдэглэгээ нь Инженерээс өөрөөр зааварчлаагүй бол MNS 4759:2014 стандартын дагуу хийгдэнэ. Замын тэмдэглэгээний хэмжээ, хэлбэр дүрс нь зурагт үзүүлсний дагуу, эсвэл Инженерийн зааврын дагуу байна. Замын тэмдэглэгээний байршлыг Инженерийн заавраар тогтооно.

Тэмдэглэгээний өнгө нь тод цагаан, зарим хэсэгт шар байна. Замын тэмдэглэгээний халуунаар дэвсэх гэрэл ойлгогч пластик материал нь AASHTO M249 стандартын шаардлагын дагуу байна. Будганд ашигладаг тунгалаг лак нь AASHTO M247 стандартын шаардлагын дагуу байна.

1502. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Дараах тоног төхөөрөмжийг хэрэглэнэ. Үүнд:

- Замын гадаргууг цэвэрлэх механик ажиллагаатай шүүр,
- Механикжсан тунгалаг лак шүршигч бүхий замын тэмдэглэгээ хийх механик төхөөрөмж.

Замын тэмдэглэгээ болон тунгалаг лагыг зөвхөн механик аргаар тавина. Замын тэмдэглэгээний төхөөрөмж нь нэгэн жигд хэмжээ, зузаантай дэвсэх чадвартай байна. Эдгээр машинууд нь гадаргуу дээр тогтоосон хүлцэх алдааны хязгаарт тэгш ирмэгтэй, урсалт, барзгар болон үсэргээгүй жигд өргөнтэй шугам тавих чадвартай байна. Замын тэмдэглэгээ хийх төхөөрөмжийн цагаан шугам тавих өргөнийг тохируулах боломжтой байх ба 5км/цаг-аас багагүй хурдаар ажилладаг байх ёстой. Халуун пластик материалыг 3.2-4.8 мм-ийн зузаантайгаар механик аргаар тавина. Үсэг, цифр, тэмдгүүдийг хэв шаблон ашиглан зам дээр тэмдэглэнэ.

1503. ГАДАРГУУГИЙН БЭЛТГЭЛ

Тэмдэглэгээ тавих гадаргууг усалж, шүүрдэн, хийн даралтаар шаардлагатай хэмжээнд хүртэл нийтэд нь цэвэрлэнэ. Тэмдэглэгээ тавьж эхлэхээс өмнө хучлагын гадаргуу нь цэвэрхэн, хуурай ба шороо, тоос, тос, бензин болон бусад хортой бодисоор бохирдоогүй байна.

1504. ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ УЛААН ШУГАМ ТАВИХ

Үсэг, цифр, тэмдэг, шугам тавих байршлыг урьдчилан тогтоохдоо замын тэмдэглэгээтэй ижил өнгийн будгаар 10 мм-ийн голчтой цэгүүд тавьж тэмдэглэнэ. Энэ цэгүүдийн хоорондох зай нь замын тэмдэглэгээг нягт нямбай хийхэд хангалттай, гэхдээ ямар ч тохиолдолд 1.5 м-ээс илүү байж болохгүй. Өөр төрлийн шугамын эхлэл болон төгсгөлийг хучлага дээр тэмдэглэсэн байна.

Бусад тэмдэглэгээний байршил болон хэлбэр дүрсийг хучлагын гадаргуу дээр шохойгоор тавина. Замын тэмдэглэгээний тавигдсан улаан шугамыг Инженерээр шалгуулж зөвшөөрөл авсны дараа тэмдэглэгээний ажлыг эхэлнэ.

Замын гэрэл ойлгогч гэж (будган түрхэц, хуулга, хуудас, нимгэн үе) – Уян хатан, мөргөхөд

тэсвэртэй, уян харимхай шинж чанартай, замын хөдөлгөөнийг зохицуулах хэрэгслүүдэд холбох, хадах, түрхэх, наах зориулалтай ойлгох материалыг хэлнэ.

1505. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯЗГААРЛАЛТ

Дараах нөхцөлүүдэд Гүйцэтгэгч замын тэмдэглэгээний ажлыг зогсооно. Үүнд:

- Хучлагын гадаргуу чийгтэй, агаарын харьцангуй чийгшил 80%-иас их;
- Агаарын температур 10°C-аас доош;
- Салхины хурд нь замын тэмдэглэгээний ажилд сөргөөр нөлөөлөх.

1506. ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ

Халуун пластик материалаар үсэг, цифр, тэмдэг, үргэлжилсэн ба тасархай шугамыг зурагт үзүүлсний дагуу, эсвэл Инженерийн зааварчилгааны дагуу тавина. Пластик материалыг хайлуулж, тунгалаг лактай хамт гадаргуу дээр механик аргаар, нэг үеэр тавина. Тэмдэглэгээний машиныг хэрэглэхээс өмнө Гүйцэтгэгч нь тухайн машин нь Техникийн шаардлагын дагуу ажиллах хүчин чадалтайг нотолно. Хэрэв ямар нэгэн тохиргоо хийх шаардлагатай болбол Гүйцэтгэгч нь машинд зохих тохиргоог хийж, эцсийн үр дүн батлагдах хүртэл талбайн туршилтыг дахин хийж гүйцэтгэнэ.

Шаардлагатай гэж үзвэл өдөр бүр хучлагын тэмдэглэгээ дэвсэх орц хэмжээг шалгаж, тохируулна. Пластик материалыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хадгалж, бэлтгэнэ. Замын тэмдэглэгээний будгийг дэвсэх орц, хэмжээ нь будах талбайг 3.2 мм-ээс багагүй зузаантайгаар, зогсолтгүй будахад хангалттай байх ёстой. Дэвсэх орц, хэмжээ нь замын гадаргуугийн бүтцээс хамааран өөрчлөгдөж болох ба үүнийг Инженер талбайн туршилт хийх үеэр тогтооно.

1507. ТУНГАЛАГ ЛАКААР БУДАХ

Гүйцэтгэгч нь замын тэмдэглэгээний материалыг тавьсан даруйдаа тэмдэглэгээний машины нэг хэсэг болох шүршигчээр тунгалаг лагыг үргэлжилсэн ажиллагаагаар шүршинэ. Тунгалаг лагыг өөрийн жингийн хүчээр шүршдэг машиныг ашиглаж болохгүй. Тунгалаг лагыг пластик материалд 0.35кг/м² ногдох хэмжээгээр буюу Инженерийн зааварчилсан хэмжээгээр тавина.

1508. ХҮЛЦЭХ АЛДАА

Замын хөдөлгөөний тэмдэглэгээг дараах хүлцэх алдааны хэмжээнд нягт нарийн тохируулан хийж гүйцэтгэнэ.

(a) Өргөн

Цагаан шугам ба бусад тэмдэглэгээний өргөн нь заасан өргөнөөс 5%-аас илүү өргөн байж болохгүй.

(b) Байршил

Үсэг, цифр, тэмдэг, шугамуудын байршил нь зурагт үзүүлснээс эсвэл Инженерийн зааварчилснаас 20мм-ээс илүү зөрж болохгүй.

(c) Чиглэл

Замын тэнхлэгтэй параллель тавигдах аливаа шугамын ирмэг нь зурагт үзүүлснээс эсвэл

Инженер (хяналтын инженер буюу хяналтын зөвлөх багийн ахлагч)-ийн зааварчилснаас 15 м тутамд 10 мм-ээс илүү гажиж болохгүй.

(d) Тасархай шугам

Замын тэнхлэгтэй параллель тавигдах тасархай шугамын урт нь зурагт үзүүлсэн эсвэл Инженерийн зааварчилснаас 150 мм-ээс илүү зөрүүтэй байж болохгүй.

(e) Эргэлт дээрх цагаан шугам

Эргэлт дээрх тасархай болон үргэлжилсэн шугамыг хөвч хэлбэрээр бус зөв арк хэлбэрээр, түүнээс 20 мм-ээс илүү гажилтгүйгээр тавина.

(ё) Хэвтээ тэмдэглэгээг шалгах үзүүлэлт

Хүснэгт 15-1

№	Шлагах үзүүлэлт		Тогтоосон утга буюу хүлцэх алдаа	Шалгах арга ба давтамж
1	Тэмдэглэгээний шугаман урт (мм)	6000	±50	Эвхдэг төмөр метр: Санамсаргүй түүврийн аргаар 10%-ыг шалгана
		4000	±40	
		3000	±30	
		1000-2000	±20	
2	Тэмдэглэгээний өргөн (мм)	400-450	±15, 0	Төмөр шугам: Санамсаргүй түүврийн аргаар 10%-ыг шалгана
		150-200	±8, 0	
		100	±5, 0	
3	Тэмдэглэгээний зузаан (мм)	Хэвийн температур (0.12-0.0)	-0.03, +0.10	Нойтон хальсны зузаан хэмжигч: налуу хэмжигч, зузаан хэмжигч ашиглан санамсаргүй түүврийн аргаар 10%-ыг шалгана
		Халуун температур (0.2-0.4)	-0.05, +0.15	
		Халж хайлдаг төрөл (10-4.50)	-0.10, +0.050	
4	Тэмдэглэгээний хэвтээ хазайлт (мм)		±30	Төмөр шугам: Санамсаргүй түүврийн аргаар 10%-ыг шалгана
5	Тэмдэглэгээний босоо зай (мм)	9000	±45	Төмөр шугам: Санамсаргүй түүврийн аргаар 10%-ыг шалгана
		6000	±30	
		4000	±20	
		3000	±15	

- JT F80/1- 2004, JT/T280- 2004 Авто замын чанарын хяналт, үнэлгээний стандарт - Хэсэг1: Шаардлага ба үзүүлэлтүүд

1509. ТЭЭВРИЙН ХӨДӨЛГӨӨНӨӨС ХАМГААЛАХ

Хучлагын тэмдэглэгээний гэрэл ойлгогч пластик материал гүйцэд хатгал нь тээврийн хөдөлгөөнөөс хамгаална. Гүйцэтгэгч бүх шаардлагатай анхааруулах тэмдэг, хаалт, конус, самбар болон бусад хамгаалалтын хэрэгслүүдийг байрлуулах ба бусад шаардлагатай арга хэмжээг авна.

1510. ЧАНАРГҮЙ АЖИЛ БА МАТЕРИАЛ

Суурилуулсан шилэн гэрэл ойлгогч нь үйлдвэрлэгчээс тодорхойлсон үзүүлэлт болон Инженерийн шаардлагын хэмжээнд гэрэл ойлгохгүй байгаа нь батлагдсан, мөн зураг төслийн зөвшөөрөгдсөн хэмжээнд хийгдээгүй тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн зардлаар дахин хийж хяналтын багт хүлээлгэн өгнө.

1512. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

(а) Замын тэмдэглэгээний халуунаар дэвсдэг гэрэл ойлгогч пластик материал

1) Зүйл: 150 мм-ийн өргөнтэй үргэлжилсэн цагаан шугам

Нэгж : м

2) Зүйл: 150 мм-ийн өргөнтэй тасархай цагаан шугам

Нэгж: м

3) Зүйл: Цагаан үсэг, цифр, тэмдгүүд

Нэгж : м²

Замын тэнхлэгтэй параллель цагаан шугамын ажлыг километрээр хэмжинэ. Замын тэнхлэгийг хөндлөн огтлох шугамыг метрээр хэмжинэ. Инженерийн зааврын дагуу тавьсан шугамын хэмжсэн уртад төлбөр хийгдэнэ. Тасархай шугамын төлбөрт тасархай зайны хасалт хийхгүй. Үсэг, цифр, тэмдгүүдийг хавтгай дөрвөлжин метрээр хэмжинэ. Инженерийн зааврын дагуу тавьсан үсэг, цифр, тэмдгүүдийг хэмжсэн талбайд төлбөр хийгдэнэ. Дэд Зүйл 1511(а)-д заасан замын хөдөлгөөний тэмдэглэгээний ажлын нэгж өртөгт дараах ажлууд багтана.

Үүнд:

- Бүх шаардлагатай материалуудын хангалт, туршилт, тээвэрлэлт;
- Хадгалалт, замын тэмдэглэгээний тоног төхөөрөмж нийлүүлэлт;
- Шаардагдах ажиллах хүч;
- Улаан шугам тавих;
- Замын тэмдэглэгээ тавих ба тээврийн хөдөлгөөний хяналт;
- Материалыг дэвсэх хэмжээний өөрчлөлт;
- Хамгаалах арга хэмжээ;
- Техникийн шаардлагын бүлэг 200-т заасан шаардлагыг биелүүлэх;
- Бүлэг 1500-т заасан шаардлагыг биелүүлэх.

БҮЛЭГ 1600 – ЗАМЫН ТОНОГЛОЛ

БҮЛЭГ 1600 – ЗАМЫН ТОНОГЛОЛ

1601. ЗАМЫН ШОН	2
1602. ХАШАА	3
1603. ЗАМЫН БАЙНГЫН ТЭМДГҮҮД	3
1604. ХАМГААЛАЛТЫН ХАШИЛТ	5
1605. ЗАМЫН ГЭРЭЛТҮҮЛЭГ	7
1606. ЦАСНААС ХАМГААЛАХ ДАЛАН	7
1607. ТӨМӨР БЕТОН ХАШЛАГА	8
1608. ГЭРЛИЙН ТУСГАЛААС ХАМГААЛАХ ТОНОГЛОЛ.....	8
1609. ХУВАНЦАР ХӨДӨЛГӨӨН ТУСГААРЛАГЧ ХАШЛАГА	10
1610. ХӨДӨЛГӨӨН ТУСГААРЛАГЧ ХУВАНЦАР ТОРХ.....	10
1611. ШИЛЭН ГЭРЭЛ ОЙЛГОГЧ.....	11
1612. ЗАМ БАРИЛГЫН АЖЛЫН ЯВЦЫН ВИДЕО БИЧЛЭГ ХИЙХ КАМЕР	11
1613. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР.....	11
(a) Ажлын нэр: Дохионы шон.....	11
(b) Зүйл: Хашаа	11
(c) Замын байнгын тэмдгүүд	12

1601. ЗАМЫН ШОН

(а) Дохионы шон

Авто замын аюултай хэсэг, гүүрийн байгууламж, зөрлөг зэрэг газруудад анхааруулах, аргагүй нөхцөлд хамгаалах зориулалтаар дохионы шонг хэрэглэнэ.

Зурагт заасан буюу Инженерийн зааварчилсан хэсгүүдэд дохионы шонгуудыг, одоо мөрдөж буй стандарт ба зурагт заасан зай хэмжээний дагуу байрлуулна. Дохионы шонг замын хөвөөн дээр дохионы шонгийн орой зорчих хэсгийн төвшингөөс жигд өндөр байхаар байрлуулна.

Дохионы шон Инженерийн зөвшөөрсөн цагаан ба улаан өнгийн эпокси цавуутай будгаар хоёр давхарлаж зургийн дагуу будан, “Ажил хүлээж авсан тухай гэрчилгээ”-г гарах хүртэл хугацаанд цэвэрлэж арчилна. Хугарсан, гэмтсэн тохиолдолд шонг ижил шонгоор сольж байна.

Дохионы шонг үйлдвэрлэхдээ стандартаар тгтоосон хэлбэр хэмжээний өндөр нарийвчлалтай, чанарын шаардлаг бүрэн хангасан, шонгийн арматурын байршлын зөрүү зурагт заасан хэмжээнээс 2мм-ээс ихгүй, хамгаалх үеийн зузаан 20мм-ээс тус тус багагүй байна.

Шонгийн геометр хэмжээнийг 0.1 мм-ийн нарийвчлалтайгаар төмөр шугам, метр, штангенциркулаар хэмжих ба арматурыг байрлал тодорхойлогч баажаар тодорхойлно.

Төмөрбетон шонгийн гадаргуу дараахь гэмтэл, согог байхыг зөвшөөрөхгүй. Үүнд :

- 10 мм-ээс их голчтой, 5мм-ээс гүн хонхорхой, 5мм-ээс өндөр бетон зуурмагийн наалдац, 3мм-ээс гүн холцролт байж болохгүй
- Шонгийн 1 метр уртад 10мм-ээс гүн, нийлбэр нь 50мм-ээс урт эмтрэл
- Агшилтас үүссэн гадаргууд өнгөц жижиг ан цав бусад ан цавыг зөвшөөрөхгүй

(а) Гэрэл ойлгогч бүхий дохионы шон

Гол зам орон нутгийн болон салаа замуудтай огтлолцож байгаа уулзвар дээрх арлуудын төгсгөлд гэрэл ойлгогч бүхий дохионы шонг зурагт заасны дагуу байрлуулна.

Дохионы шонг тусгайлан бэлтгэсэн тэгш талбайд эгнүүлэн босоо чиглэлд завсар хооронд нь 50мм х 50мм огтлолтой модон дэр тавьж, 6 үеэс өндөргүйгээр давхарлан хурааж хадгална. Бетоны төслийн бат бэх 70%+аас ихих буюу 210кг/см²-аас багагүй бэхжилт авсан тохиолдолд талбай руу ачих, хэрэглэгчид нийлүүлнэ.

Төмөрбетон шонг автомашинаар тээвэрлэх ба ачихдаа тэвш шон болон давхарлан ачиж байгаа шонгуудын хооронд зориулалтын модон дэр тавьж, дээд үеийн шонгуудыг даруулж бэхэлсэн байна. Шонг ачих буулгах үед шидэх, унгаахыг хатуу хориглоно.

(b) Километрийн шон

Гүйцэтгэгч нь километрийн шонг зургийн дагуу хийж байрлуулна. Километрийн шонг замын тэнхлэгийн шугамаас зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварласан зай, чиглэлд байрлуулна. Километрийн шонг Инженерийн зөвшөөрсөн цагаан өнгийн эпокси цавуутай

будгаар хоёр давхар будсан байна.

Замын зайг гэрэл ойлгогч будгаар бичсэн заалт бүхий Км-ийн тэмдгийг шонгийн толгойн хэсгийн урд нүүрэнд Инженерийн зааснаар байрлуулна. Километрийн шонгууд болон тэдгээрийн заалтыг “Ажил хүлээж авсан тухай гэрчилгээ”-г гарах хүртэл хугацаанд цэвэрлэж арчилна. Хугарсан, гэмтсэн тохиолдолд шон болон тэмдгийг сольж байна.

(с) Хоолойны тэмдэглэгээ

Хоолойны ус гарах талын толгойн нүүрэн хэсэгт, дээд ирмэгээс доош 150 мм-г, нүхний тэнхлэгийн тушаа, замын зуут болон хоолойн дэс дугаар, нүхний тоо болон хэмжээг улаан өнгийн, усанд угаагддаггүй будгаар будаж тэмдэглэнэ. Хоолойны тэмдэглэгээг “Ажил хүлээж авсан тухай гэрчилгээ”-г гарах хүртэл хугацаанд цэвэр байлгана.

1602. ХАШАА

Гүйцэтгэгч зурагт заасан буюу Инженерийн зааварчилсан газрыг тойруулан зурагт заасан дагуу хашаа барина. Хашааг 5 м тутамд суулгах 110 мм голчтой хашааны шон, 200 метрээс ихгүй зайнд болон хашааны эхлэл, төгсгөлд буюу чиглэл өөрчлөгдөх цэгүүдэд байрлуулах 150 мм голчтой татах шонгууд, шон тус бүрээс 2.5 м зайд байх дундын гадсууд, AASHTO M280 стандартыг хангасан 12S SWG маркийн өргөстэй зэвэрдэггүй ган утас 5, шаардлагатай хадаас, хавчаар, зангидах утас болон бусад материалаар хийнэ. Хашаа барих мод нь Инженер зөвшөөрөгдсөн сайн хатаасан хатуу мод байна. Гүйцэтгэгч материалаа талбайд авчрахаас өмнө материалын дээжийг Инженерээр шалгуулж зөвшөөрөл авна.

1603. ЗАМЫН БАЙНГЫН ТЭМДГҮҮД

Харин авто замын дагуух км-ийн заалт, өгсүүр уруу, тахир огцом эргэлт зэрэг газарт анхааруулах зорилгоор шонд суурьлуулсан байнгын тэмдэгүүдийг байрлуулна.

Гүйцэтгэгч энэхүү зүйлийн ажлыг ажлын зурагт өгөгдсөний дагуу хийж гүйцэтгэнэ. Хэрэв Инженерээс өөрөөр зааварчлаагүй бол замын бүх тэмдгүүд нь MNS 4597 : 2014 стандартын дагуу үйлдвэрлэгдэж, MNS 4596:2014 ын дагуу тавигдсан байна. Гүйцэтгэгч нь Инженерийн зөвшөөрсөн үйлдвэрлэгчээс замын тэмдгийг авах ба замын тэмдгийн аливаа захиалгыг үйлдвэрлэгчид өгөхөөс өмнө Инженерт дараах мэдээлэл бүхий бичиг баримтыг хоёр хувь өгч танилцуулсан байна. Үүнд:

- (a) Үйлдвэрлэгчийн нэр, хаяг нийлүүлэх бүтээгдэхүүний тодорхойлолт;
- (b) Бүтээгдэхүүний чанар, зэрэглэл, жин ба бат бөхийн үзүүлэлтүүд бүхий үйлдвэрлэгчийн гэрчилгээ, тодорхойлолт;
- (c) Үйлдвэрлэгчийн Инженерийн зөвшөөрсөн байгууллага буюу лабораторид хийлгэсэн шинжилгээний гэрчилгээ буюу ижил төстэй зүйл төрөл дээр хамгийн сүүлд хийсэн туршилтын дүн;
- (d) Инженерийн зөвшөөрөл авахад үзүүлэх зорилгоор талбайд хураасан тэмдэг, шон ба бэхэлгээний дээж;

Гүйцэтгэгч нь үйлдвэрлэгч буюу ханган нийлүүлэгчээс дараах мэдээллийг гаргуулан авч Инженерт өгнө. Үүнд:

замын тэмдгийг угсрах заавар, байршил буюу ашиглалтад тавигдах хязгаарлалтууд, тэмдгийн ашиглалтын ба засвар арчлалтын заавар.

Үйлдвэрлэгч нь бараандаа 1 жилийн баталгааг Инженерийн зөвшөөрсөн маягтаар гаргаж өгнө.

Замын байнгын тэмдгийг гэрэл ойлгодог будгаар будсан байна. Гэрэл ойлгодог будаг нь Хэсэг 200-д заасан шаардлагыг хангасан байх шаардлагатай бөгөөд Инженерийн зөвшөөрлөөр механик вакуум халаах аргаар будна. Гэрэл ойлгогч материал нь үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу, тэмдгийн самбарыг тунгалаг лакаар өнгөлсөн байна.

Замын байнгын тэмдгийн хүрээ рам, шон ба бэхэлгээний урьдчилсан будалт болон хамгаалалтын будгийн чанар нь BS 873 стандартын Хэсэг 2, 6 ба 7-д заасан чанарын шаардлагыг хангасан байна. Өөрөөр зааварчлаагүй бол шон, рам, бэхэлгээ болон тэмдгийн арыг саарал өнгөөр будаж өнгөлсөн байна. Тэмдгийг угсарсны дараа боолт болон гайкийг алдагдахаас сэргийлж цэгэн гагнуураар гагнаж бэхлэх ба гагнаасыг саарал өнгийн эпокси цавуутай будгаар будсан байна. Суулгасан тэмдэг тэгш, тэмдэгийн өнгө үг үсэг ойлгомжтой, нэгэн жигд өнгөтэй, шөнийн гэрэлд жигд бус, сүүдэртэж харагддаггүй байх.

Гүйцэтгэгч нь замын тэмдгийн нүхийг ухаж В 20 маркийн бетоныг нүхний ёроол руу болон шонг тойруулан цутгана. Ухалтаас гарсан материалыг буцааж булна. Эдгээр ажлыг зурагт заасны дагуу буюу Инженерийн зааснаар гүйцэтгэнэ. Тэмдгийн суурийн 5м² -аас дээш талбайтай нүхийг Инженерт үзүүлж зөвшөөрөл авахаас нааш буцааж булахгүй.

Замын тэмдгийн гэрэл ойлгогч гөлгөр гадаргуутай цагаан болон бусад өнгөөр будсан нимгэн үеэс тогтох бөгөөд бүрэн гадаргуугаар гэрэл ойлгох шинж чанартай байна..

Өнгө үл алдах байдал – Тодорхой зохиомол цаг уурын туршилтын дараа сорьц нь MNS ASTM D 4956 : 2005 стандартын 10-р хүснэгтийн шаардлагуудыг хангах ёстой.

Агшилт – Туршилтыг 23±2°C температурт 50±5% харьцангуй чийгшилтэй орчинд 24 цагийн турш байлгана. 229х229мм хэмжээний гэрэл ойлгогчийг 1 цагаас багагүй хугацаанд хамгаалалтын хальстай байлгана. Хамгаалалтын хальсыг хуулж, гэрэл ойлгогчийг хавтгай гадаргуу дээр дээш нь (наалдах арыг дээш харуулж) харуулж байрлуулна. Хамгаалалтын хальсыг хуулсаны дараахь 10мин болон 24 цагийн дараахь 2 сорцын хэмжээг авч хэмжээсийн өөрчлөлтийг тодорхойлно.

Уян хатан чанар – Нугалаасны зузаан нь 3.2мм байхаар бэлтгэсэн хавтгай хатуу биетэд гэрэл ойлгогчийг наалдах хэсгээр нь 1 секундын дотор дарж нугална. Туршихад хялбар байх үүднээс гэрэл ойлгогчийн наалдах ар дээр талкин нунтаг цацаж хавтгай биет наалдахаас сэргийлнэ. Туршилтын сорьц нь 70х229мм хэмжээтэй, турших температур 23±2 байна.

Хамгаалалтын хальсыг хуулах – Хамгаалалтын хальсыг 17.2кПа ачаан доор 71°C-ийн хэмд 4 цагийн турш эрчимтэй хадгалахад амархан салж байх ёстой. Тэмдэгийн хальс наахдаа хөндлөн чиглэлд залгаас үүсгэх ёсгүй.

Цохилт даах чадвар - Туршилтыг 23±2°C температурт 50±5% харьцангуй чийгшилтэй орчинд байлгасан 76х127х1.016мм хэмжээтэй 6061-T6 тэгшхэн гөлгөр гадаргуутай хөнгөн цагаан туршилтын самбарт гэрэл ойлгогчийг наана. 0.91 кг жинтэй 15.8мм-ийн диаметртэй дугуй үзүүртэй ачааг гэрэл ойлгогч дээр 11.5см-кг хүчтэй цохилт үзүүлэх өндрөөс унагаана.

Гүйцэтгэгч замын тэмдгийн үзэгдэх орчинг хангахын тулд ойр хавийн бут, ургамлыг тайрахаас гадна тэмдгийн орчимд материал овоолж буулгахыг зөвшөөрөхгүй.

Гүйцэтгэгч баталгаат засварын гэрчилгээг гаргах хүртэл бүх тэмдгүүдийг арчилж, цэвэр байлгах ба хугарсан, гэмтсэн тохиолдолд шон болон тэмдгийг сольж байна.

Хүснэгт 16-1. Байнгын тэмдэгүүдэд тавигдах ерөнхий шаардлага

№	Шалгах үзүүлэгт	Тогтоосон утга буюу хүлцэх алдаа	Шалгах арга ба давтамж
1	Тэмдэгийн гадаад хэмжээс (мм)	Хажуугийн урт нь 1.2м-ээс их үед ± 5 ,зөвшөөрөгдөх хазайлт нь хажуугийн уртын $\pm 0.5\%$, гурвалжин дотоод өнцөг нь $60^{\circ} \pm 5$ байна	Төмөр метр, универсал өнцөг хэмжигч, зузаан хэмжигч: 100% шалгана
2	Тэмдэгийн доод ирмэгээс замын хучлага хүртлэх цэвэр өндөр ба тэмдэгийн дотоод өнцөг ба замын өнцөг хоорондын зай (мм)	+100	Нивлер, хуваарьт уртын хэмжүүр : толгойн хоёр хэсэгт шалгах ба дунд хэсгийн 1-2 хэсэгт утас татаж хэмжинэ
3	Баганын эгц байдал (мм/м)	± 3	Босоо шугам, шугам 100% шалгана
4	Тэмдэгийн төмөр бүрэлдхүүн хэсгийн бүрээсийн зузаан (μм)	Тэмдэгийн багана ба дам нуруу ≥ 78 , бэхэлгээ ≥ 50	Зузаан хэмжигч: 100% шалгана
5	Тэмдэгийн суурийн хэмжээс (мм)	+50, +100	Төмөр шугам, шугам: 100% шалгана

1604. ХАМГААЛАЛТЫН ХАШИЛТ

Гүйцэтгэгч зурагт үзүүлсэн буюу Инженерээс зааварчилсан байршилд зохих хэмжээ болон өгөгдлүүдийн дагуу хашилт барина. Хамгаалалтын төмөр хашлагийн бүтээцийн төрөл, түүхий эд материал, гадны үйлчлэлд тэсвэртэй байдал, гагнаасан холбоосын чанар зэрэг нь MNS 5614:2016 стандартын шаардлага хангасан байна.

а) Материал

(1) Нуруу төмөр

Нуруу төмөр нь AASHTO M180 стандартын дагуу А ангиллын 1 дүгээр зэргийн өнгөлгөөтэй байх ба Инженерийн баталсан үйлдвэрлэгчээс авна.

(2) Шон

Модон шонгууд нь AASHTO M168 стандартын шаардлагад нийцсэн байх ба зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсан урттай, оройн хэсгийн голч нь 200 мм-ээс доошгүй байна. AASHTO M133 стандартын дагуу хамгаалах бодис түрхэхийн өмнө шонгуудыг зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсны дагуу цоолж хэлбэрт оруулах бөгөөд нурууг тогтооход шаардлагатай боолт, гайка, хөндлөвч модыг бэлтгэсэн байна. Тэмдэгийн шон будаг урссан ховхорсон, хэт зузаан будагдсан байх ёсгүй ба гадаргууд ил гарсан төмөр байхгүй байна.

Хамгаалах бодис түрхсэний дараа шонг тайрах буюу хэлбэржүүлэхийг хориглоно. Хашилтыг төмөр буюу бетон шонд угсрах зааврыг Инженер өгч болно.

(3) Хөндлөвч мод

Хөндлөвчийг яргүй, ан цав багатай, сайтар хатаасан хатуу модоор хийнэ. Хэрэв модны цав нь 3 мм-ээс гүн байвал тийм модыг ашиглаж болохгүй.

(4) Хашилтыг угсрах

Хашилтыг үйлдвэрлэгчээс гаргасан зураг, зааврын дагуу, эсвэл Инженерийн зааварчилснаар угсарна. Хашилтын байршлыг замын зурагт ойролцоогоор тусгасан байж болох боловч, нарийвчилсан мэдээллийг Инженер нь Гүйцэтгэгчид тухайн үед нь өгнө.

Ер нь, зорчих хэсгийн захаас хашилтын дотор тал хүртэл, хөвөөний нийт өргөнийг зурагт заасан хэмжээнд байлгах үүднээс хашилт барих шаардлагатай газруудад далан ба хөвөөг Инженер зааварчилсан өргөнөөр хийнэ.

Гүйцэтгэгч хашилтын шон суулгах нүхийг ухаж, шонг зохих журмын дагуу суулгаж хөндлөвч болон хайсыг шонд бэхэлнэ. Хашилт угсрах үед гэмтсэн зэврэлтээс хамгаалах будгийг сэргээх ба шонгийн нүхийг буцааж булан сайтар жигжиж, илүүдэл материалыг зайлуулна.

Хашилтыг угсарч дуусаад Инженерээр батлуулсны дараа гайкуудыг хөдөлгөөнгүй болгох зорилгоор боолтонд буюу хайсны төмөрт гагнаж өгнө. Гагнуур хийсэн буюу тайрсны улмаас гэмтсэн зэврэлтээс хамгаалах будгийг бага температурт хайлдаг цайрын хайлшаар, эсвэл тусгай зориулалтын нунтгаар буюу AASHTO M300 шаардлагыг хангасан сайн чанарын органик бус, цайраар баялаг түрхлэгээр хоёр үе будаж засварлана.

Гагнуурын залгаас нь тэгшхэн, гагнуурын шаваасгүй, төвгөргүй байна. Бүрэлдхүүн хэсгүүдийн цайрдсан бүрээс нь нэгэн жигд үзэмжтэй, жигд өнгөтэй байх ба гадаргуу нь толигор, барзгаргүй, урссан будаггүй, хөндийрч ховхорсон будаггүй, нүдэнд мэдэгдэхүйц нүх сүв, зай завсар цууралт зэрэг доголдолгүй байх. Ус нэвтэрдэг ил гарсан төмөртэй, сэв зураастай бүрэлдхүүн хэсгээр хайс хийх ёсгүй.

Мөн хайсны шулуун хэсэгт илт хүнхэр, гүдгэр, цууралт үүссэн зэрэг хэлбэрийн доголдолгүй байна. Долгионт хайсны чиглэл эгц, огцом эргэлтгүй боолт шаайбууд хөдөлгөөнгүй байна. Долгионт хайс болон багануудыг талбай дээр гагнах буюу өрөмдөж холбож болохгүй.

Хайсны их бие, бэхэлгээ, ирмэгүүд зургийн төслийн дагуу байрлалтай, илт үзэгдэх хэв гажилт, мушгиралт, хазайлтгүй. Багана болон баганын орой хөдөлгөөнгүй холбогдсон, оройн хэсэг нь илт үзэгдэх муруйсан өнцөггүй, хэв гажилтгүй, цууралт эвдрэлгүй байх ёстой.

(5) Хүлцэх алдаа

Хашилтыг замын тэнхлэгээс заагдсан зай буюу түвшинд +20 мм-ийн нарийвчлалтайгаар угсарна. Зэрэгцээ залгагдах нуруу төмрийн хоорондох хэвтээ ба босоо түвшин 5мм-ээс илүүгээр зөрж болохгүй.

Хүснэгт 16-2. Долгионт төмөр хайсыг шалгах үзүүлэлтүүд

№	Шалгах үзүүлэт	Тогтоосон утга буюу хүлцэх алдаа	Шалгах арга ба давтамж
1	Долгионт төмөр хайсны үндсэн материалын зузаан (мм)	± 0.16	Ялтасны зузаан хэмжигч: Санамсаргүй түүврийн аргаар 5%-ыг шалгана
2	Баганын ханын зузаан (мм)	4.5 ± 0.25	Зузаан хэмжигч микрометр: Санамсаргүй түүврийн аргаар 5%-ыг шалгана
3	Холбогч боолтны (№45 ган) суналтын бат бэх	≥ 600	Дээж авч суналтын туршилт хийнэ: нэг багцаас 3 хэсгийг шалгана
4	Баганын булагдсан гүн	Зурагт зааснаас баггүй	Ажлын явцын шалгалт, шугам: Санамсаргүй түүврийн аргаар 10%-ыг шалгана
5	Баганын гадаад ирмэг ба хөвөөний ирмэг хоорондын зай (мм)	± 20	Шугам: Санамсаргүй түүврийн аргаар 10%-ыг шалгана
6	Багана хоорондын зай (мм)	± 50	Метр: Санамсаргүй түүврийн аргаар 10%-ыг шалгана
7	Баганын эгц байдал (мм/м)	± 10	Отвес, шугам: Санамсаргүй түүврийн аргаар 10%-ыг шалгана
8	Хайсны төвийн өндөржилт (мм)	± 20	Шугам: Санамсаргүй түүврийн аргаар 10%-ыг шалгана
9	Хайсны шулуун байдал (мм/м)	± 5	Чиг хэмжигч, шугам: Санамсаргүй түүврийн аргаар 10%-ыг шалгана

1605. ЗАМЫН ГЭРЭЛТҮҮЛЭГ

Гүйцэтгэгч зурагт тусгагдсан буюу Инженерээс зааварчилсан, захиалагч зөвшөөрсөн тохиолдолд замын гэрэлтүүлгийг бэлтгэж угсарна. Гүйцэтгэгч гэрэлтүүлгийг суурилуулахын өмнө түүний бүтцийн эд ангиуд, хэмжээ, суурилуулах өндөр болон байршил, гэрлийн төрөл, хүчин чадал, суурь, цахилгааны утас, угсрах аргачлал гэх мэтийн нарийвчилсан төлөвлөгөөг Инженерт танилцуулж батлуулна. Цацруулах гэрэл нь гялбадаг байж болохгүй.

1606. ЦАСНААС ХАМГААЛАХ ДАЛАН

Гүйцэтгэгч нь цас, элснээс хамгаалах даланг зурагт үзүүлсний дагуу барина. Хамгаалалтын даланд хэрэглэгдэх материал далан барих аргачлал зэргийг Инженерт танилцуулж зөвшөөрөл авсан байна.

1607. ТӨМӨР БЕТОН ХАШЛАГА

(1) Хашлага тавих

Замын тэнхлэгийн дагууд бетон хашлагыг зурагт үзүүлсэн байршлуудад байрлуулна. Хашлага тавих хэсгийн ул хөрсийг 90%-иас багагүй болтол нягтруулах шаардлагатай. Хашлаганы доод улны болон ар манаасанд 15/20 маркийн бетон хэрэглэх ба уг бетон бэхжилтээ бүрэн авсаны дараа арын хэсгийн шороон дүүргэлтийг хийж, Инженер зөвшөөрөх хэмжээнд хүргэнэ.

(2) Хүлцэх алдаа

Хашлаганы хоорондын зай зурагт зааснаас ± 2 мм-ээс илүү байж болохгүй. Зэрэгцээ тавигдсан хоёр хашлаганы нүүрэн талын гадаргуу болон дээд талд хэмжсэн төвшин нь 1 мм-ээс илүү зөрүүтэй байж болохгүй.

1608. ГЭРЛИЙН ТУСГАЛААС ХАМГААЛАХ ТОНОГЛОЛ

Энэ төсөлд хэрэглэгдэхгүй

(1) Гэрлийн тусгалаас хамгаалах тоноглол

Гэрлийн тусгалаас хамгаалах тоноглол нь замын нийт уртад төлөвлөгдсөн бөгөөд зөвхөн хөдөлгөөний урсгал тусгаарлагч түр хашлага байрлуулах хэсгүүдэд тавигдахгүй.

Төлөвлөж буй замын тэнхлэгээр зааглах төмөрбетон хашлага тавина. Энэхүү төмөрбетон хашлага дээр эсрэг урсгалын машины гэрлийн тусгалаас хамгаалах тоноглолыг байрлуулна. Гүйцэтгэгч нь гэрлийн тусгалаас хамгаалах тоноглолыг үйлдвэрлэгчээс гаргасан заавар, техникийн шаардлагыг хангахаар мөн ажлын зурагт өгөгдсөн байрлал болон Инженерийн зааварласан хэсгүүдэд тавина. Гэрлийн тусгалаас хамгаалах тоноглол нь дараах 2 стандартыг хангасан байна.

- BS EN 12676-1: 2000 Замын гэрлийн тусгалаас хамгаалах систем- Хэсэг1: Шаардлага ба үзүүлэлтүүд
- BS EN 12676-2: 2000 Замын гэрлийн тусгалаас хамгаалах систем- Хэсэг1: Туршилтын арга

(2) Хүлцэх алдаа /Гэрлийн тусгалаас хамгаалах тоноглол/

Гэрлийн тусгалаас хамгаалах тоноглол хоорондын зай зурагт зааснаас ± 2 мм-ээс илүү байж болохгүй. Зэрэгцээ тавигдсан хоёр гэрлийн тусгалаас хамгаалах тоноглолын нүүрэн талын гадаргуу болон дээд талд хэмжсэн төвшин нь 1 мм-ээс илүү зөрүүтэй

(3) Гялбалтас хамгаалах хаалт

Гялбалтаас хамгаалах хаалтын материал зураг төсөл, техникийн шаардлага стандартад (JT/T333) нийцсэн байх ба ерөнхийдөө замын чиглэлтэй параллель байж зориулалтандаа нийцсэн гоо зүйн шаардлага хангасан байна. Хаалтыг хөдөлгөөнгүй суурьлуулж, хавтгайн хазайлтын өнцөг нь хаалтын уртын 0.3%-аас хэтрэх ёсгүй. Хаалтны өнгө нэгэн жигд, гадаргууд хөөсний ором, цуурхай, сэв зураас, ховхролт зэрэг доголдолгүй байх.

Хүснэгт 16-3. Гялбалтаас хамгаалах хаалтыг шалгах үзүүлэлтүүд

№	Шалгах үзүүлэт	Тогтоосон утга буюу хүлцэх алдаа	Шалгах арга ба давтамж
1	Суурилуулах өндөр (мм)	±10	Эвхдэг төмөр метр: Санамсаргүй түүврийн аргаар 5%-ыг шалгана
2	Бүрэлтийн бүрээс үеийн зузаан	Зурагт зааснаас багагүй	Зузаан хэмжигч: Санамсаргүй түүврийн аргаар 5%-ыг шалгана
3	Гялбалтаас хамгаалах хаалтын өргөн (мм)	±5	Шугам: Санамсаргүй түүврийн аргаар 5%-ыг шалгана
4	Гялбалтаас хамгаалах хаалтын хоорондын зай (мм)	±10	Эвхдэг төмөр метр: Санамсаргүй түүврийн аргаар 10%-ыг шалгана
5	Эгц байдал (мм/м)	±5	Чиг баригч шугам, шугам: Санамсаргүй түүврийн аргаар 10%-ыг шалгана
6Δ	Баганын гадаад ирмэг ба хөвөөний ирмэг хоорондын зай (мм)	±8	Чиг баригч шугам, шугам: Санамсаргүй түүврийн аргаар 10%-ыг шалгана

Δ Баганын гадаад ирмэг ба хөвөөний ирмэг хоорондын зай стандартад тогтоосон хэмжээнээс хүлцэх алдааг тооцно.

(4) Замын хажуугийн гэрэл цацруулагч тэмдэг

Замын хажуугийн гэрэл цацруулагч тэмдэгийг хөдөлгөөнгүй суурилуулах ба эгнээ нь замын чиглэлтэй нийцсэн байх. Мөн гадаргуу тэгш толигор, элдэв хэв гажилтгүй, нүдэнд харагдах элэгдэлт, цууралт, хажуу тал гэмтсэн, эмтэрсэн булан зэрэг доголдолгүй байх.

Хүснэгт 16-4. Замын хажуугийн гэрэл цацруулагч тэмдэгийг шалгах үзүүлэлтүүд

№	Шалгах үзүүлэт	Тогтоосон утга буюу хүлцэх алдаа	Шалгах арга ба давтамж
1	Баганан хэлбэрийн замын хажуугийн гэрэл цацруулагч тэмдэгийн хэмжээс (мм)	Гурвалжин хөндлөн огтлолтой: суурийнх нь зөвшөөрөгдөх хазайлт: ±5, гурвалжны зөвшөөрөгдөх хазайлт ±5, баганан хэлбэрийн гэрэл цацруулагч тэмдэгийн нийт уртын хазайлт ±10	Төмөр шугам: Санамсаргүй түүврийн аргаар 10%-ыг шалгана
2	Суурилуулах өнцөг (°)	0-5	Хэмжигч саваа, хэрээс, эвхдэг метр, өнцөг хэмжигч: Санамсаргүй түүврийн

			аргаар 10%-ыг шалгана
3	Гэрэл цацруулагчийн төвийн өндөржилт (мм)	± 20	Шугам: Санамсаргүй түүврийн аргаар 10%-г шалгана
4	Гэрэл цацруулагчийн гадаад хэмжээс (мм)	± 5	Зай хэмжигч, шугам: Санамсаргүй түүврийн аргаар 10%-г шалгана

- JT F80/1- 2004, JT/T388- 2004 Авто замын чанарын хяналт, үнэлгээний стандарт - Хэсэг1: Шаардлага ба үзүүлэлтүүд

1609. ХУВАНЦАР ХӨДӨЛГӨӨН ТУСГААРЛАГЧ ХАШЛАГА

Энэ төсөлд хэрэглэгдэхгүй

(1) Хуванцар хөдөлгөөн тусгаарлагч хашлага

Гүйцэтгэгч зурагт тусгагдсан буюу Инженерээр батлуулсан хуванцар хөдөлгөөн тусгаарлагч хашлагыг хэрэглэнэ. Зураг төсөлд өгөгдсөн хуванцар хөдөлгөөн тусгаарлагч хашлагын өндөр нь 106,7 см, урт нь 200 см, өөрийн жин 45 кг байна.

Хашлаганд ус (эсвэл элс) хийж, 612 кг хүртэл жинтэй болгож зурагт заагдсаны дагуу байрлуулна. Улбар шар, шар, улаан өнгийн хуванцар материалаар хийгдсэн байна. Хуванцар хөдөлгөөн тусгаарлагч хашлага нь дараах 2 стандартын туршилтын дагуу туршигдсан байх ёстой.

- National Cooperative Highway Research Program /NCHRP 350/-ийн туршилт AASHTO MASH –т заагдсан туршилтын аргаар туршсан байна.

(2) Хүлцэх алдаа

Хуванцар хөдөлгөөн тусгаарлагч хашлагыг хоорондын зай +10 мм-ийн нарийвчлалтайгаар зурагт заасан байршилд байрлуулна. Зэрэгцээ тавигдах хашлагуудын хоорондох хэвтээ ба босоо түвшин 5мм-ээс илүүгээр зөрж болохгүй.

1610. ХӨДӨЛГӨӨН ТУСГААРЛАГЧ ХУВАНЦАР ТОРХ

Энэ төсөлд хэрэглэгдэхгүй

(1) Хөдөлгөөн тусгаарлагч хуванцар торх

Гүйцэтгэгч зурагт тусгагдсан буюу Инженерээр батлуулсан хуванцар хөдөлгөөн тусгаарлагч хашлагыг хэрэглэнэ. Гүйцэтгэгч зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсан байршилд зохих хэмжээ болон өгөгдлүүдийн дагуу хөдөлгөөн тусгаарлагч хуванцар торхыг байрлуулна.

Хөдөлгөөн тусгаарлагч хуванцар торх нь National Cooperative Highway Research Program /NCHRP 350/-ийн туршилт хийгдсэн байх ёстой. Энэ төрлийн хуванцар торх нь HDPE (0.948 g/cm³) авес anti-UV хуванцар материалаар хийгдсэн байх бөгөөд өөрийн жин 10кг, элсээр дүүргэж, 640кг жинд хүргэж зам дээр байрлуулна.

(2) Хүлцэх алдаа

Хуванцар хөдөлгөөн тусгаарлагч торхуудыг зурагт заасан байршилд байрлуулна.

1611. ШИЛЭН ГЭРЭЛ ОЙЛГОГЧ

Энэ төсөлд хэрэглэгдэхгүй

